



Төвийн МЭДЭЭ

сонны мэл аж ахуйн холбогдолтой
мэдээ, нийтлэлүүдийн эмхэтгэл
/1957-1990/



Өмнөговь аймгийн Төвномын сангийн сан хөмрөгт аймгийн орон нутгийн “Говийн мэдээ” сонины 1957-1990 он хүртэлх дугаарууд архивлагдан хадгалагдаж байдаг.

Өмнөговь аймаг 2019 оныг Хөдөө аж ахуй үйлдвэржилтийн жил болгон зарласантай холбогдуулан малчид, хөдөө аж ахуйн мэргэжилтэнүүдэд гарын авлага болгох зорилгоор Говийн мэдээ сонинд нийтлэгдсэн мал аж ахуйтай холбоотой мэдээ, баримт, нийтлэлүүдийг эмхэтгэн гаргаж байна. Энэхүү эмхэтгэлд тэргүүний малчдын туршлага, мал аж ахуйтай холбоотой түүхэн тэмдэглэлт үйл явдалууд, сайн малчдын хөрөг, фото зураг зэрэг олон баримт, нийтлэлүүд орсон болно.

Өвгөд дээдсийн малч ухаан, дурсамж дурдатгал түүх өгүүлэх энэхүү эмхэтгэл та бүхний мэдлэг оюуныг мялаах лавлагааны чухал материал болно гэдэгт итгэлтэй байна.

Сайн үйлс дэлгэрэх болтугай!

ГАРЧИГ

1. 1957-1960 он.....	3-25
2. 1961-1966 он.....	25-48
3. 1967-1970 он.....	48-77
4. 1971-1976 он.....	77-126
5. 1976-1979 он.....	126-205
6. 1980-1989 он.....	206-225

1. Шинэ нэгдлийн хурал // Говийн мэдээ.- 1957 оны 1-р сарын 1.- №1.- 2-р нүүр.

Шинэ нэгдлийн хурал

Ханбогд сум

Есөн ес наян нэг хоногийг ид хүйтэн эхлээд байсан боловч хавар морилоод ирсэн юм шиг урьхан салхи үлээсэн нарлаг дулаан 25 орой сумын төв их л хөл хөдөлгөөнтэй байлаа. Орчмын газрын хаанаас нь ч харсан онц тод гялалзаж байдаг олон цагаан байшингуудын нэгний уужим саруул тасалгаанд хүмүүс пиг дүүрэн цугларчээ. Тэр бол тус аймгийн хөдөө аж ахуйн хамгийн шинэ нэгдлийн нэг Ханбогд сумын Хамтын хүч нэгдлийн гишүүд хуралдахаар цугларсан нь тэр билээ. Байгуулагдаад сар гаруйхан болж байгаа энэ нэгдлийн ерөнхий хорооны дарга Чулуунбаатар бүх гишүүдийн 70-аад хувь нь ирснийг мэдэгдэж хурлыг нээсний дараа хурлын тэргүүлэгчдэд нэгдэл байгуулахыг санаачлагчдын нэг хашир малчин өвгөн бууч, эмэгтэй Хоньхүү нарын зэрэг 5 хүнийг сонгов.

Шинэ нэгдэл цаашид улам өрнөлт бадралттай хөгжих нь зөвхөн энэ хурал дээрээс харахад ч тодорхой байлаа.хуралд хэлэлцэх хэргийн төлөвлөгөө ёсоор хамгийн түрүүнд нэгдэлд шинэ гүшүүн элсүүлэх асуудал хэлэлцлээ. Ялангуяа хурд тундас багатай говь нутагт нүүдлийн тархай будархай аж ахуй дээр ганц нэгээрээ саланга будархай ажилласнаас хүчээ нэгтгэн хамтарч ажиллах нь үлэмж их ач тустайг ойлгосон Гочоо, Шаравдорж,Цэрэндорж, Тогтох нар нэгдлийн гишүүнээр элсүүлж авахыг хүсэж бүх гишүүдийн хуралд өргөдлөө бичигцгээжээ. Тэд өргөдөлдөө нэгдэлд элсэх чин санаа ба гишүүний үүргийг нэр төртэй биелүүлж чадахаа

илэрхийлсний хамт, дүрмийн шаардлагад зохицуулан бүгд 270 гаруй толгой мал нийгэмчлэхээ тодорхойлжээ.

Нэгдлийн бүх гишүүд гишүүнд элсүүлэхийг хүсэгч хүн бүр дээр тодорхой хэлэлцээд гишүүнд элсүүлж авахаар санал нэгтэй баталсан бөгөөд энэ нь Хамтын хүч нэгдлийн гишүүд нь 152 болсон буюу 2,7 хувь мал нь 5888 болсон буюу 4,9 хувь өсч байгаа хэрэг юм. Бүх гишүүдийн хурал дараа нь нэгдлийн мал аж ахуйд гүйцэтгэх ажлын нормууд хөдөлмөр өдрөөр гаргасан ажлын хөлсний хэмжээг батлаад, 1957-оны үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөг хэлэлцэж баталлаа. Тус нэгдэл 1957 онд бүх малаа 11 хувиар өсгөх төлөвлөгөөг 278 толгой малаар түүний дотроос хээлтэгч малыг 11,5 хувиар өсгөх төлөвлөгөөгөө 458 толгой малаар тус тус давуулан өсгөхөөр төлөвлөжээ. Энэ төлөвлөгөөнөөс үлдэж байгаа малаас зохих тооны малыг улсын бэлтгэлд өгөхөөс гадна 230 гаруй толгой малыг нэгдэл өөрийн хэрэгцээнд зарцуулахаар үлдээжээ.

Мөн цаг улирлын хатуу бэрхшээлийг саадгүй давж малаа онд бүрэн мэнд оруулахын тулд 72 тн өвс, 10 гаруй тн хүчит тэжээл бэлтгэх, 400 гаад малын багтаамжтай боловсон саравч нэгийг барих, худаг нэгийг шинээр гаргах зэрэг ажлууд төлөвлөсөн байна. Үүнээс гадна нэгдлээ үлэмж их ашиг орлоготой ажиллуулахын эх булаг нь малыг өсгөх ба түүний ашиг шим, хүч чадлыг сайн ашиглах явдал мөнийг анхаарч 11 тн ноос ашиглах, 53 тн сүү сааж болвсруулах болон ердийн хөсгөөр 3500-иад км газар тээвэр хийхээр төлөвлөжээ. Хамтын хүч нэгдэл дээр дурдсан ажлууд дээр арьс шир, ангийн үс зэрэг орлогын янз бүрийн эх булагыг бодолцон бүгд 32000 орчим хөдөлмөр өдөр зарцуулж 74000 орчим төгрөгийн орлого оруулах, хөдөлмөр өдрийн хөлсөнд 40000 төгрөг, 3200 аад кг мах олгох ажээ.

Хурлын төгсгөлд нэгдлийн гишүүн бүр хороо бууц худгаа бүрэн сайн засаж дулаалах, төл хүлээн авах бэлтгэлийг хангах, мал тэжээх, малын хариулга маллагааг сайжруулах ажлыг үлгэртэй сайн хийж гүйцэтгэхээр шийдвэрлэсний гадна ойрын өдрүүдэд нэгдэлдээ тэмээний хом 25ыг хийх, сумын бага сургууль ба бусад газартай гэрээлсэн 98000кг заг, 400 л сүүг тушаах, аймгийн төвөөс 40 тэмээ овъёос ачиж ирэх, Өвөрхангай ба Улаанбаатараас 36 тэмээгээр 400 шургааг, 300 банз татаж авчирах зэрэг ажлуудыг хувиарлан авч бүрэн биелүүлэхээр тогтоцгоов.

Т.Намжилдорж

2. Туршлагатай малчин // Говийн мэдээ.- 1957 оны 2-р сарын 9.- №12.- 2-р нүүр.

Туршлагатай малчин

/Тэргүүн туршлагын булан/

Ханбогд сумын 7-р багийн малчин Бадамсэд малаа онд тарган сайн оруулахын төлөө үргэлж тэмцэж малдаа хүрэлцэх хэмжээний өвс бэлтгэдгээс гадна сүүлийн 4 дараалан 4 бууцанд өвөлжихдөө өвөлжсөн бууц бүр дээрээ 20-40 бог мал багтах тохилог дулаан пүнз 4 ийг барьж хэнз муу төл, хээлтэй хөгшин малуудаа шөнө бүр хийж дулаан байраар хангаж байна. Эдгээр пүнзийг барихдаа өмхөрч унасан хайлсаар гадарлаж нуруу тавиад хатсан хөрсөнгөөр доторлож зарим үед сартай шөнийг ашиглан гэргий Жагзмаагийн хамтаар мод татах, хөрсөн зөөх ажлыг хийж байжээ. Эднийх сүүлийн 4 жил зудаар нэг ч мал үхүүлсэнгүй онд бүрэн оруулжээ.

Жишээ нь 1955-оны 04-р сарын дундуур болсон 3 өдрийн цасан шуурганаар нилээд ардын аж ахуйтны хэдэн мянган мал үхсэн байхад эднийх дулаан пүнзтэй, тэжээл

сайн бэлтгэснээс малаа үхүүлээгүй онд бүрэн оруулжээ. Энэ өвөл улам ч дулаан пүнз нэгийг барьж төлөг шүдлэнгээ бараг цөмийг хийжээ. Энэ туршлагаар дулаан тохилог сайхан пүнз барих ажил 7 дугаар баг дээр өрнөж, багийн депутат Гэндэнпэл, ахлах ухуулагч Батаа нараар удирдуулсан шалган туслах бригад дулаан тохилог пүнз барьж дулаалж, төл хүлээн авах галгүй дулаан байр болгон ашиглах гэж байна. Малчин Бадамсэдийн туршлагаар ажиллацгаая.

Наран / Сумын ХДХГ захиргааны дарга/

3. Зүтгэлтэй малчин // Говийн мэдээ.- 1957 оны 2-р сарын 9.- №12.- 2-р нүүр.

Зүтгэлтэй малчин

Туршлагатай малчин /Тэргүүн туршлагын булан/

Манлай сумын 7 дугаар багийн малчин эмгэн Сономоогийн Ханд малч хичээнгүй ажиллагааныхаа үрээр 1950 онд байсан 4 төрлийн малаа 1956-онд төрөл бүр дээр 30 гаруй хувиар өсгөжээ. Ноднин 200-250 кг нарийн өвс,хужир, 25 кг овъёос бэлтгэж авчээ.Би өнгөрсөн хавар хүнээс ихрийн өрөөсөн 13 ишиг,6 хурга авч ингэний сүүгээр тэжээгээд мал болгосон юм.

11-р сараас хойш бэлчээрт ч гаргахгүй өдөрт нар салхинд гаргаж биеийн чилээг гаргаад, гэртээ ногоон өвсөөр тэжээж байна. Багцаараа бодоход би өдөрт 24 кг өвс түүдэг. Зарим хүн намайг өвс түүх донтой юм шиг болж гэдэг .Би нээрээ ч аргал түлээ өвс 3-ыг түүхгүй явж чаддаггүй юм гэж Ханд гуай ярилаа. Уудаг усаа дулаалж,малаа 2 өнжөөд тогтмол усалдгаас гадна бүлээн усаар 50-иад бага мал усалж, бүх малаа тогтмол хужирладаг байна. Нутгийн хүмүүс Ханд мөн эцэж

Говийн мэдээ сонин

ядархыг мэдэхгүй хүн юм, ажил хийж сурахаар ийм байдаг байхдаа гэж ярилцдаг.

Ц.Пүрэв

4. Туршлагатай малчин // Говийн мэдээ.- 1957 оны 2-р сарын 9.- №12.- 2-р нүүр.

Туршлагатай малчин

/Тэргүүн туршлагын булан/

Баяндалай сумын Лениний зам нэгдлийн хоньчин Залуу эмэгтэй Лүгсэр 1956 оны 7дугаар сард нэгдлийнхээ 100 эм хонь авч малласан ба одоо төл хүлээн авах бэлгэлийг сайн хангаж байна. Лүгсэр соргог сайн бэлчээрт хонио хариулж хэвтэр бууцыг додомдон сайн ус хужраар хангаж муудсан малаа тэжээж байна. Лүгсэр нарийн зөөлөн өвс, хужир хэдэн зуун кг таана хөмүүлийн зоодой, хэдэн төлийг эх барих хэрэглэл 2 ээлж, хүйний даруулга, дэвсгэрийн даавуу зэргийг хүрэлцээтэй бэлтгэсний дээр одоо 2 жижиг гэрийг төл хүлээн авах галгүй дулаан байр болгон засаад байна. Түүнчлэн төл хүлээн авч бойжуулах үер хэрэглэгдэх түлш хоргол зэргийг бэлтгэжээ.

Энэ залуу 1956 онд нэгдэлд элсэхийн өмнө 120 эм хониноосоо 140 хурга 70 ямаанаасаа 85 ишиг бойжуулжээ. Энэ жил нэгдлийнхээ малын төлийг өнгөрсөн жилийнхээ туршлагаар бойжуулахаар ийнхүү чармайн ажиллаж байна. Лүгсэр малч хичээнгүй ажиллагаагаараа орон нутгийнхандаа магтагдан, багаасаа баярын бичиг хүлээн авчээ.

Лувсан-Осор

5. Онгийн голоор явахад // Говийн мэдээ.- 1957оны
8-р сарын 28.- №65.- 3-р нүүр.

Онгийн голоор явахад
/ Сурвалжлагчийн тэмдэглэл/

Мандал-овоо сум

Нэгдлийн сүүний тасаг дээр: Хоёр хөвөөгөөр нь дөрөө зурам өндөр, өтгөн ногоо ургаж салхины аясаар найган халиурсан Онгийн үзэсгэлэнт гол мяралзан, намрын цэнхэр манан суунаглана. Цэцэг ногоо дэлгэрсэн цэлгэр уудам хөндийд нь олон үхэр сүрэг налайн бэлчээрлэн цагаан гэрүүд оройн жаргах нарны доогуур ярайн харагдаж байгаа нь Мандал-овоо сумын хөдөлмөр нэгдлийн сүүний тасаг байрлаад байгаа нь энэ ажээ. Энэ тасаг саалийн 73 үнээ сааж байгаа юм байна. Нэгдлийн дэргэдэх намын үүрийн дарга

Эрдэнээ ярихдаа :

Үнээ тугалын бэлчээрийг тохируулж үнээ тугалаа услах, идэшлүүлэх, саах сүүгээ тушаах зэрэг тасгийн бүх ажилд цагийн хуваарь тогтоосон нь ажилд үр дүн гарч байгаа гэж ярьлаа. Энэ тасаг үнээг өдөрт 2 удаа саадаг бөгөөд үнээгээ эхлэн сааснаас хойш 25 хонгийн дүнгээс үзэхэд үнээ бүрээс өдөрт 2 л сүү саасан ба 25 л сүүнээс 1 кг масло тос 8 л шингэн сүүнээс 1л архи тус тус авчээ. Шинэ нэгдэлд шинэ шинэ бүтээл гаргасан тэргүүний хүн олон бий. Ийм хүмүүсийн эгнээнд залуу саальчин эмэгтэй Цэенпил багтаж байна. Цэенпил бол хөдөлмөрт эцэж цуцдаггүй ажилд зоримог, бүтээл гаргахын төлөө эрчимтэй ажиллаж алхах бүрдээ амжилт олж байгаа шаламгай бүсгүй юм.

Энэ эмэгтэй саалийн эхний 25 хоногт нэг үнээнээс дундчаар 2,6 л сүү сааж өөрийнхөө хариуцсан 15 үнээнээс 686 л сүү сааж, 149 төгрөгийн хөдөлмөр хөлс

хийжээ. Одоо энэ тасгийнхан 2920 л сүү сааж 110 кг масло 527 л архи авч 3635 төгрөгийн орлого нэгдэлдээ оруулаад байна. Хоньчин залуу: Хөдөлмөр нэгдлийн хоньчин Лочин бол манай урган өсч яваа залуу үеийнхний дотроос малч хичээнгүй ажлаараа шалгаран тодорч байгаа цогтой залуусын нэг юм.

Лочин Хөдөлмөр нэгдэл байгуулахыг анх санаачлагдын нэг бөгөөд түүнийг 1955-онд байгуулагдахад гишүүнээр элсчээ. Хоньчин Лочин 1955-онд нэгдлээсээ 264 эм хонь, 24 эм ямаа авч маллаад 1956-онд 264 хониноос 290 хурга, 24 ямаанаас 28 ишиг мөн 1957-онд 195 хониноос 203 хурга, 30 ямаанаас 30 ишиг тус тус бойжуулан авчээ. Лочин төлийг эх барьж аваад, өдөрт 2-3 удаа хөхүүлж эхийг нь овъёос зэрэг нэмэгдэл тэжээлээр тэжээдэг байна. Бэлчээрийг зөв ашиглахад, нарийн хуваарь гаргаж ажилладаг байна. Ямар нэг шалтгаанаар хонь оройтож бэлчихэд нөөцлөн ашиглах бэлчээр байдаг. Хавар цагт хонь хариулахдаа нөмөр газар ба ойрын бэлчээрийг гамнаж мал төллөх үеэр ашигладаг. Зуны цагт нар битүү байхад хонио өндөрлөг хяр газрын бэлчээрт гарган үдийн халуунаар голд оруулж услаад хотлуулж, саагаад үдээс хойш бэл сүүдэр газраар бэлчээдэг юм байна. Эзэн хичээвэл заяа хичээнэ.

Мандал-овоо сумын 1-р багийн малчин эмгэн Жаалынх 1953 онд тэмээ 20, адуу 2, хонь 207, ямаа 60, бүгд 289 толгой малтай байсан бол 1957 онд тэмээ 28, адуу 2, хонь 300, ямаа 76 бүгд 466 толгой малтай болж энэ онд 95 хониноос 130 хурга, 20 ямаанаас 24 ишиг тус тус бойжуулан авчээ. Эмгэн Жаал өөрийн зүтгэлт хөдөлмөрийн үрээр 1953 онд байсан малаа 1957 онд төлийн цэвэр өсөлтөөр 103 хувиар өсгөж 177 толгой мал цэврээр нэмэгдүүлсэн нь сумын мал өсөлтөнд эмгэн

Жаалын оруулсан сайхан хувь нэмэр нь юм. Эмгэн Жаалын мал ингэж жил дараалан өсч ирсэн нь түүний арчилгаа ажиллагаатай шууд холбоотой юм. Эдний малд зохих цагт нь хүрэлцэхүйц өвс хадаж малаа сайн бордож, тарга хүчтэй онд оруулдаг юм. Иймээс улсын бэлтгэлд тушаасан хонь 45 кг аас доошгүй жинтэй байдаг. Малын арчилгаа маллагааг сайжруулсаны үндсэн дээр малаас гарах ашиг шимийг дээшлүүлж болохыг Жаал өөрийнхөө ажиллагаанаас үзэж мэджээ. Эднийх 1955-онд 4 эсгий хийсэн, энэ онд 3 эсгий хийх гэж байгаа ба хоршоондоо сайн дураар хонины ноос 30 кг, ноолуур 5 кг, тэмээний ноос 60 кг ийг сайн дураар худалдсан байна.

Түүсэн өвсөө хамгаал : Сум даяр мал сүрэгтээ тарга хүч авахуулж онд сайн оруулах гэж бэлчээрийн соргог, усны тунгалагийг сонгон, тэжээлийн ихийг базааж, хадаж авсан өвсөө хамгаалан хямгадаж байна. Доройтож ядарсан малаа тордож тэжээхийн тулд хүч хөдөлмөрөө гаргаж байж бэлтгэсэн тэжээлийнхээ ач тусыг үзэх гэж малчин ардууд мэрийж байна. Хадлан авах нь чухалын гадна хадаж авсанаа хамгаалах үр ашигтай зарцуулах нь хамгийн чухал. Хадлангаа хамгаалах талаар харилцан адилгүй явдал орон нутагт үзэгдэж байна.

Мандал-овоо сумын 1-р багийхан цаг улирлын байдал тэр хавдаа одоогоор сайхан байгаад санаа амраад хадаж авсан өвсөө хамгаалах ажлыг хараанаасаа гаргажээ. 1-р багийн хадланг одоо үхэр адуу тэмээ аль дуртай цагтаа чөлөөтэй идэж сүйтэгсээр хураасан өвс нь дороосоо ялзарч тал талаасаа багасаар байна. Харин хорогдсон өвсний оронд үхэр тэмээний аргал эргэн тойрон овойж байна. Гэтэл хаяанд нь байгаа багийн захиргааны нөхөд нүд балай, чих дүлий гэгчээр

Говийн мэдээ сонин

ажигч үгүй сууж байна. Иймд мал сүргийг онд сайн оруулахын нэг нөхцлийг хангахын тулд хадлан өвсөө маш сайн арчилж арвилан ашиглахад анхаарал тавиуштай байна.

Ц.Ванчиндорж

6. Малчин Цэвэг // Говийн мэдээ.- 1958 оны 2-р сарын 20.- №14.- 3-р нүүр.

Малчин Цэвэг

Эднийх 2 дугаар багийн нутаг Эхэн гүн гэдэг газар тохитой өвөлжиж байна. Энэ айл жил бүр өвөлжөө хороо бууцаа засч додомддог сайхан туршлагатай, өнгөрсөн онд өөрийн хүчээр 200 төлийн багтаамжтай пүнз барьжээ. Одоо цэвэг гуай, малаа онд бүрэн мэнд оруулах, төлийг хорогдолгүй бойжуулан авахын тулд эцэж доройтсон, хэнз мал хийх байр, мөн төллөх шахсан эх малаа шөнийн цагт тусгаарлан хийж байх 20-иод малын багтаамжтай байр бэлтгэж, хэвтрий нь хөх бууцаар хангасан байна. Эднийх малынхаа толгой нэг бүрт тэмээ 79, адуу 5, хонь 91, ямаа 196, 15кг өвс түүж бэлтгэжээ. Одоо 30 гаруй бог малыг өвс, овъёос, хайлсны навчаар тогтмол тэжээж байна. Өвгөн Цэвэг аж ахуй дээрээ шинийг санаачлахын зэрэгцээ багийнхаа эд аж ахуй, барилга байшин засах зэрэг нийгмийн ажилд идэвхтэй оролцдог байна.

Д. Лхамцэрэн

7. Малчин Лувсандаваагийнх // Говийн мэдээ.- 1958 оны 3-р сарын 17.- №21.- 2-р нүүр.

Малчин Лувсандаваагийнх

5 дугаар багийн малчин Лувсандаваагийнх хороогоо хөрсөнгөөр 1м.80 см өндөрлөснөөс гадна

Говийн мэдээ сонин

тэжээгдвэл зохих хонь 14, ямаа 17, тэмээ 4-ийг овъёос, бусад шимт тэжээлээр тогтмол тэжээж байна. Төл хүлээн авах бэлтгэлд зориулан нарийн зөөлөн өвс, зоодой, хөх бууц, хужир зэргийг хангалттай бэлтгээд түүнээ сайн ашиглан, мөн 4 тасалгаатай тохилог байр засчээ. Ингэж идэвх чармайлттай ажилласныхаа үрээр зудын нэрийдлээр нэг ч мал хорогдуулаагүй, 33 хонь хургалснаас 34 хурга, 21 ямаанаас 21 ишиг бойжуулж байна. Малын хариулга, маллагааг тогтмолжуулж, хотны дежур, манааг шөнө бүр тогтмол гаргаж, гэр орны ба хот, бууцынхаа ариун цэврийг сайн сахиж байна.

Д. Базарсад

8. Малчин залуу // Говийн мэдээ.- 1958 оны 3-р сарын 17.- №21.- 3-р нүүр.

Малчин залуу

Баяндалай сумын 2 дугаар багийн малчин, ХЗЭ-н гишүүн Дашлхагвынх Зурамтайн ууланд ус бэлчээр сайтай Цагаан-Овоо гэдэг газар тарган тавтай өвөлжиж хаваржиж байна. Эднийх энэ жил 60-аад бог мал төллүүлэх бөгөөд гарах төл бүртээ 10-аад кг нарийн зөөлөн өвс, мөн янз бүрийн хольцтой зоодой бэлтгэжээ. Дашлхагва, төл бүрийг эх барьж аваад сайн арчилж байгаагаас гарсан төл бүрэн мэнд бойжиж байна. Би хээлтэй малыг овъёос, махны шөл, цайгаар, төлийг тарианы гурил, хуурай сүүгээр тэжээдэг. 1957 онд 176 толгой мал тоолуулсан, энэ жил 200 гаруй болгож өсгөөд малаас гарах ашиг шимийг бүрэн авч улсдаа тушааж нэгдэлд элсэн орохоор ажиллаж байна гэж Дашлхагва ярилаа.

Д. Дооров

9. Малчин охины сэтгэгдэл // Говийн мэдээ.- 1958 оны 3-р сарын 21.- №22.- 3-р нүүр.

Малчин охины сэтгэгдэл

Төрөлх эх орны нийслэл Улаанбаатар хотынхоо хөгжилтэй танилцаж, тэргүүний олон залуучуудтай нүүр учран уулзаж, тэдний ажлын туршлагыг дуулж мэдсэн явдал надад мартагдашгүй баяр бахдал төрүүлээ. Би эх орныхоо том том үйлдвэрийн газрууд, тэнд малаас гардаг түүхий эдийг боловсруулж ард түмний хэрэгцээт зүйл хийж байгааг нүдээр үзэж, бас тэргүүний ажилтай хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуйн ажиллагаатай танилцсан. Түүнчлэн хөдөлмөрийн баатар Даваажав, партизан Содномдаржаа болон нийслэлийн зарим сургуулийн пионер сурагчид, оюутнуудтай уулзалт хийж, туршлагаа харилцан ярилцсан. Хөдөө аж ахуйн тэргүүний залуучуудын анхдугаар чуулганд оролцсон маань нам, засгийн хайр халамж, ХЗ Эвлэлээр хүмүүжсэний ач гавъяа юм гэж Баяндалай сумын 2 дугаар багийн малчин охин Халтар ярьлаа.

Д. Дооров

10. Тараг бүрж, шар тос авах арга // Говийн мэдээ.- 1958 оны 4-р сарын 18.- №30.- 2-р нүүр.

Тараг бүрж, шар тос авах арга

10 литр болсон сүүг 100 грамм ааруулын шимүүстэй халааж самран хөөсрүүлнэ. Хэрэв ааруулын шимүүсгүй бол шар будааны шимүүс хийж болно. Түүхий сүүний таргийг бүрэхэд 10 литр түүхий сүүнд 500 граммаас 1 литр орчим тараг хийж бүрнэ. Үүнийг бүрэхдээ түүхий сүү 30 гадус халааж маш сайн самрна. Тэгээд хөөсөргөж уудлаад зун бол сэрүүн газар тавих ба хүйтэн улиралд бол дулаан юмаар сайтар хучих

хэрэгтэй. Тос авах арга нь түүхий сүүний таргийг хөхүүрт хийгээд 10 литр тараг тутамд 3-4 орчим литр усыг буцалгаж хийгээд айргийг бүрж үзвэл түүний дээгүүр хэрэв халуун бол шар тос гүйлгэнэн үзэгдэнэ. Хэрэв хүйтэдсэн бол тос огт үзэгдэхгүй. Тохирсон бол том томхон хөөс харагдана. Харин халуудсан бол хүйтэн ус хийж болох ба тос унахгүй бол тогоонд дахин хийж халаах хэрэгтэй. Хангай нутгийн малчдын энэ туршлагаар ажиллаж түүхий сүүний таргаар шар тос боловсруулан авах ажлыг манай малчид туршиж үзэх нь чухал. Энэ ажиллагааг хийж чадвал 10 литр сүүнээс 1-2 кг буюу түүнээс илүү тос авч чаддаг байна.

Ц.Занахүү

11. Мал тооллогын бэлтгэл ажил // Говийн мэдээ.-
1958 оны 8-р сарын 12.- №53.- 1-р нүүр.

Мал тооллогын бэлтгэл ажил

Мал өсгөх 1958 оны төлөвлөгөөний биелэлтийн шалгалт малын биечилсэн тооллого 9-р сарын 1-3 ний дотор явагдана. Малын тоо бүртгэлийг үнэн зөв явуулснаар бид мал аж ахуйг хөгжүүлэх гүйцэтгэсэн хөдөлмөрөө дүгнэн, мал аж ахуйн ажиллагаанд оршиж байгаа дутагдлыг уудлан илрүүлж тэр дутагдлаас дүгнэлт хийж мал аж ахуйг цаашид хөгжүүлэх ирээдүйн төлвийг урьдаас харах бололцоог олж авна. Хөдөө аж ахуй дахь социалист салбарт тайлан тоо бүртгэлийг нэвтрүүлэх замаар түүнийг улам бэхжүүлэх том зорилт тавигдаж байгаа энэ үед малын тооллогыг урьд урьдаас илүү сайн бэлтгэлтэй, нягт нямбай явуулах нь бүр чухал юм. Мал тооллого хир зэрэг түргэн шуурхай, үнэн зөв явагдах нь түүнд хэрхэн бэлтгэснээс шууд шалтгаалдаг. Хүрмэн, Аргалант сумдын АДХГ захиргаад өнгөрсөн оны мал тооллогод муу бэлтгэж хариуцлагагүй явуулснаас

Хүрмэн суманд 222 мал, Аргалант суманд 172 мал тооллогод ороогүй орхигдож байв. Номгон сумын “Шинэ амьдрал” нэгдлийн ерөнхий хороо, нэгдлийн гишүүдээс нийгмийн өмчид нийлүүлэх малыг тооллогоос хоцроох, заримыг давхар тоолуулах зэргээр будлиантуулж байв. Бас Аргалант сумын Цэцэрлэг нэгдэл 9-р сарын нэгний өдөр малаа тоолуулахад бэлтгээгүй байсан. Аймгийн төвийн 10 жилийн дунд сургууль ноднин мал тооллогыг их саатуулсан. Мал тооллогын ач холбогдлыг хөдөлмөрчдийн дотор ухуулгын олон хэлбэрээр таниулж нэгдлийн гишүүд, малчин ард бүрийг тооллогын өдөр малаа бүрэн бэлэн байлгах, өнгөрсөн оны тооноос хойшхи бүх хорогдол нэмэгдэл, тоологдох бүх малын нас хүйсийг бүрэн ялгаж цэгцэлсэн байх, мал тооллогыг гардаж хийх бүх хүчийг урьдаас сайтар зохион байгуулж тооллого ба дүн товчоо нэгтгэн гаргахад хэн юу хийх үүргийг тодорхой мэдүүлэх ажлыг одоогоос эхлэн шургуу сайн зохиох хэрэгтэй байна.

12. Малыг тохитой өвөлжүүлье // Говийн мэдээ.- 1958 оны 11-р сарын 13.- №75.- 1-р нүүр.

Малыг тохитой өвөлжүүлье

Мал сүргийн өсөлтийг шийдвэрлэх нэг чухал нөхцөл бол малыг тохитой өвөлжүүлэн онд бүрэн оруулах явдал мөн. Хөдөө аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг явуулах тухай АХДХГ Захиргаа, нам хорооноос 9-р сард гаргасан тогтоолыг нэлээд сумд чуулганаараа хэлэлцэн айл өрхүүдийг өвөлжүүлэх зураг төлөвлөгөө гарган ажиллаж байна. Тост, Ноён, Номгон сумдын нэгдэл, ардын аж ахуйнууд өвс түүвэрлэлтийн талаар нилээд ахицтай ажиллан дарш, шим тэжээл бэлтгэн хангайгаас овъёос өвс татах хөсөг хөдөлгөх, малын хашаа хороо барих, засварлах төлөвлөгөөг биелүүлж өвөлжилтийн нарийн төлөвлөгөө гаргаж

нэгдлийн гишүүд ардын аж ахуйтны хурлаар хэлэлцэн өвлийн бэлтгэлийг нэлээд хангажээ. Гэвч малыг тохилог өвөлжүүлэхтэй холбогдсон бэлтгэл ажилууд маань зарим сум нэгдлүүдэд зохих ёсоор чанартай хийгдэж чадаагүй цаг алдахад хүрч байна.

Цогтцэций, Ханхонгор, Мандал-Овоо сум, мал өвөлжүүлэх төлөвлөгөө ч гаргаагүй бууц усны хүрэлцээг судалж үзээгүй, хашаа хороо барих, худаг ус дулаалах, өвс, төлийн бэлтгэл зэрэг аж ахуйн төлөвлөгөөг маш хангалтгүй биелүүлсэн байна. Нам засгийн үнэн сонин Өмнөговь аймагт ардын аж ахуйтны мал аж ахуйн өвлийн бэлтгэл тун оройтож тус аймгийн хэмжээгээр бог малын саравчтай хашаа барих төлөвлөгөөг 74хувь, засварлах төлөвлөгөөг 79 хувь, төлийн пүнз барих төлөвлөгөөг 63 хувь, Худаг гаргах төлөвлөгөөг 56 хувиар биелүүлэн өвс бэлтгэх төлөвлөгөөг үлэмж тасалдуулаад байгаа нь энэ аймгийн нам улсын байгууллагын удирдлагууд ирэх өвөл хаврын хатуу хахир цагт тулгарч, мал сүргийн зүй бусын хорогдлыг их болгож, мал өсгөх төлөвлөгөөг тасалсан урьдахь дутагдлаа дахин давтахад хүргэж магадгүй гэдгээ ойлгоснгүйг гэрчилж байна. Өвөлжилтийн ажил дээр оршиж байгаа дээрх дутагдлыг арилган малыг тохитой өвөлжүүлэх бэлтгэл ажлыг ойрын хугацаанд гүйцээж хөдөө аж ахуйтныг өвөлжөө бууцанд нь түргэн буулгаж тохижуулах явдал манай одоогийн чухал зорилт болж байна.

Баг нэгдэл тус бүрийн өвөлжилтийн нарийн төлөвлөгөөтэй болгон, өвөлжөө бууцийг дулаан хороотой болгох, төлийн бууцийг бог мал төллөхийн өмнө бүр барьсан байх, малаа отролж тарга хүч тогтоох, чулуун хороог хөрзөнгөөр доторлох ажлыг энэ сард багтаан дуусгах хэрэгтэй юм. Бүх бололцоотой аргаар малын тэжээл бэлтгэн өвөлжөө бууцандаа татаж авах,

Хангайгаас авах хувиартай овъёос өвсөө татан авч малыг доройтхоос нь өмнө тэжээж эхлэх нь чухал. Бод малын төл, тором бяруу, шүдлэнгийн нэмнээг хүрэлцээтэй бэлтгүүлэн, худаг усыг дулаалбал зохино. Айлуудыг бууц усны байдлаар айлсуулан буулгаж малаа тохитой өвөлжүүлэх ажилд тэдний хамтын ажиллагааг өрнүүлэх нь зүйтэй.

13. Гэрийн тэжээвэр зарим малын ашиг // Говийн мэдээ.- 1958 оны 11-р сарын 17.- №76.- 2-р нүүр.

Гэрийн тэжээвэр зарим малын ашиг

Гэрийн тэжээвэр малын дотроос хамгийн богино хугацаанд хамгийн сайн чанартай их мах өгдөг мал бол гахай юм. Цэвэр махны гаралтаар гахай нь бусад ямар ч малаас давуу юм. Үхэр хонины цэвэр махны гаралт 44-60 хувь байхад, гахайнх 75-85 хувь байдаг байна. Гахай идэш их хэргэлэдэг боловч тэжээл голдоггүй, нэг килограмм тарга хүчний нэмэлтэд хамгийн бага тэжээл хэрэглэдэг юм. Нэг кг жингийн нэмэлтэд гахай барагцаалбал 5 кг үр тариа буюу үүнтэй тэнцэх тэжээл хэргэлэдэг бол үхэр хонь ийм тэжээл 12-16 кг –ыг хэрэглэдэг. Гахай жилийн дотор 2 удаа төллөж 26-28 зулзага гаргадаг учраас богино хугацаанд хямд өртгөөр их мах бий болгодог.

Тус аймгийн Тост сумын “Оч” нэгдэл, Номгон сумын “Шинэ амьдрал” нэгдлүүд 1953 оноос эхлэн 10 орчим гахайг тэжээж эхлээд одоо 30 гаруй гахайтай болжээ. Оч нэгдэл 1957 онд 2 гахай борлуулсан нь 2000 орчим төгрөг болжээ. Энэ нь одоогоор өргөн хэмжээтэй дэлгэрч чадаагүй байгаа боловч ирээдүйд олон тоотой өргөн сүрэг болох нь эргэлзээгүй.

Манай хөдөө аж ахуйн чухал салбар өндөр ашиг шим өгдөг гэрийн тэжээвэр амьтдын нэг нь тахиа юм.

Тахиа сайн чанартай мах, өндөг, өд зэрэг үнэт зүйлийг өгдөг. Тахианы өндөг бол хүмүүсийн хамгийн сайн чанартай тэжээл мөн. Хотын хоршооны тахиачин эмэгтэй Гаваа 1950 онд 50 орчим тахиа хүлээн авч тасралтгүй малласан хугацаандаа жил бүр 70 дэгдээхийг тогтмол бойжуулснаар одоо 193 толгойд хүргэжээ. Өндөглөгч нэг тахианаас жилдээ 69-76 өндөг авдаг нь манай улсын зарим аж ахуйн гүйцэтгэж байгаа хэмжээнээс ч багагүй. Сүүлийн 3 жилийн тооцооноос үзэхэд Гаваагийн маллаж байгаа тахианы мах, өндөг, өднөөс 13000 гаруй төгрөгийн орлого оруулсан нь 5000 шахам төгрөгийн цэвэр ашигтай байна.

14. Малын ашиг шимийг дээшлүүлье // Говийн мэдээ.-
1958 оны 11-р сарын 17.- №76.- 1-р нүүр.

Малын ашиг шимийг дээшлүүлье

МАХН-ын 13-р их хурал мал сүргийг өсгөхийн зэрэгцээгээр мал нэг бүрээс авах ашиг шимийг нэмэгдүүлэхэд их анхаарал тавь гэж заасан билээ. Ард түмний амьдралын шаардлага өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж, тус улсад ноос, мах сүү, арьс шир зэрэг үйлдэхүүн боловсруулах үйлдвэр хөгжиж байгаатай уялдан малын ашиг шимийг дээшлүүлэн түүний чанарыг сайжруулах асуудал, малын тоо толгойг өсгөхөөс дутуугүй ач холбогдолтой болж байгаа учраас нам засаг энэ талаар чухал арга хэмжээ авсаар байна. Манай таван хошуу мал бол байгалийн эрс тэс нөхцөлд дассан олон талын ашиг шимтэй мал. Маллагаа додомдлого сайтай малын ноос, сүү, махны гаралт их, чанар нь мэдэгдэхүйц сайн байдаг. Малын арчилгаа маллагааг сайжруулж тарга хүч сайн авахуулан дулаан байр, сайн өвс тэжээл, бэлчээрийг хангаж байх нь малын ашиг шимийг нийтэд нь дээшлүүлж болох гол арга зам мөн.

Манай аймгийн “ Хөдөлмөр” “35 жил” нэгдлүүд, мөн нэгдлийн олон арван гишүүд, ардын аж ахуйтнууд малынхаа ашиг шимийг сайн ашиглаж байгаа нь цөм малч хичээнгүй ажиллагаатай холбоотой юм. Малын ашиг шимийг дээшлүүлэх бас нэг арга бол малын үүлдэр угсааг сайжруулах явдал мөн. Тус аймгийн “Туяа” “Соёл” “Оч” нэгдлүүд 1952 оноос эхлэн нутгийн хонинд орхны эрлийз, перекос хуцаар зохиомол хээлтүүлэг хийж байгаа ба “Туяа” нэгдэлд цыгай үүлдрээр монгол хонийг эрлийзжүүлэх ажил явагдаж одоо 3300 орчим эрлзийжсэн хоньтой боллоо. Нутгийн хонийг ингэж эрлийзжүүлсний үрээр хонины ноосны гарц чанарыг дээшлүүлэх амьдын жингий нь нэмэгдүүлж байна. Тус аймгийн цөлөрхөг нутагт монгол хонийг каракуль хуцтай эрлийзжүүлж нутгийн нөхцөлд зохицсон сайн чанарын арьстай хурга өгдөг хонь бий болгох, мөн ямааны ноолуур сүүний гаралтыг нэмэгдүүлэх зорилгоор нутгийн ямааг шилэн сонгох замаар үржлийн ажил зохиохын хамт энэ жил Доны үйлдвэрийн 50-аад ухныг ирүүлж нутгийн ямаатай эрлийзжүүлэх ажлыг хийж эхлэв. Бас тэмээний ноосны гаралт, ачаа даацыг нэмэгдүүлэх чиглэлээр үржлийн ажил зохиох гэж байна.

Энэ жил 10 гаруй мянган хонинд орхны эрлийз, цыгай үүлдрийн ба нутгийн шилмэл хуцны үрээр зохиомол хээлтүүлэг явуулсны дээр нэгдлүүдийг түшиглүүлж шилмэл ингэ, эм хонь, ямааны 20 гаруй үржлийн хэсэг байгуулж байна. Шилэлт сонголтыг сүргийн дотор явуулах нь малын үүлдэр угсааг сайжруулах хамгийн наад захын бөгөөд өргөн дэлгэр хийж болох ажил мөн. Тус аймагт мал үржлийн ажил нь мал аж ахуйгаас гарах үйлдэхүүнийг нэмэгдүүлэх одоогийн шаардлагаас хоцорч байна.

Гадаадын ба сүргийн шилмэл хээлтүүлэгчээр зохиомол ба ердийн хээлтүүлэг явуулж байгаа боловч түүнийг судлаж ийм үр дүнд хүрлээ гэсэн тодорхой дүгнэлт судалгаагүй байна. Малын ашиг шимийг дээшлүүлэх нь амьдралын бодит шаардлага учраас нам улсын байгууллага, хөдөлмөрчдийн анхаарлыг үүнд чиглүүлж тодорхой ажил зохиох нь чухлаа. Бид малын үүлдэр угсааг сайжруулаж ашиг шимийг нь дээшлүүлэхдээ гадаадаас авчирсан малыг ашиглахаас гадна өөрийн малын дотроос ноос, ноолуур, сүү шим, өөх тос их ашиглаж болох бие томтой, тэсвэр сайтай тийм малыг шилэн сонгож түүнийг улам олон болгох замаар ажиллах нь чухал юм. Манай хөдөө аж ахуйн социалист байгуулалт хөдөө аж ахуй нэгдлийг ашиг орлого арвинтай тааварлаг аж ахуй болгох асуудал нь өөрийн гол үйлдвэрлэл мал аж ахуйнхаа ашиг шимийг дээшлүүлж түүнийг чадмаг сайн ашигласнаар шийдвэрлэгдэх болно.

15. Ажилсаг залуу малчин // Говийн мэдээ.- 1958 оны 12-р сарын 11.- №83.- 2-р нүүр.

Ажилсаг залуу малчин

Баруун сайхны сахлаг хонгор өвстэй саруулхан талын дунд 2 метр шахам өндөр хороотой бууц алсаас тодхон харагдаж, түүнийг чиглэж явсаар очвол хот хороо, гэр орон, бэлтгэсэн өвс түлшнээс нь эхлээд энд өвөлжиж байгаа айлын хүмүүсийг ажилч хичээнгүй байдал илхэн байв. “Алдарт эх одон” гялалзуулсан ахимаг настай эмэгтэй намайг угтан авч мэнд амрыг мэдэлцэн гэртээ оруулж цай идээгээр зочлов. Би энэ зочилолтын дараагаар тэдний ажилтай танилцав. Энэ айл Булган сумын “Туяа” нэгдлийн Даржаагийнх ажээ.

Даржаагийн гэргий Намжил ярихдаа: Манай нөхөр баг нэгдлийн ажилаар яваад гэрийн бараа бараг хардаггүй. Би хүүхэд багачуудад орооцолдоод гадагш гарах завдал муутайхан байдаг юм. Манай бүх ажлыг энэ маань л бараг ганцаараа хийдэг юм гэж багашигхан хүүхнийг заалаа.

Би түүний нэр ажлын туршлагыг асуувал: Нэрээ Равжир гэдэг гээд ажлынхаа тухай танилцууллаа. Равжир эвлэлийн гишүүн хүн юм. Эднийх нэгдлийн ба амины 500 шахам бог мал маллаж 1958 онд нэгдлийн 57 хониноом 57 хурга, 32 ямаанаас 32 ишиг бойжуулж малын ноос, ашиг шимийн төлөвлөгөөг төрлөөр нь цөмийг давуулан биелүүлжээ. Эвлэлийн гишүүн Равжир энэ жил бараг ганцаараа ажиллаж 1500 кг өвс түүж 6 сав дарш, 182 ш зоодой болон аги таана 100кг сонгино 15 кг, овъёос 150 кг, хужир 1400 кг, хөх хоргол 20 шуудайг бэлтгэжээ. Эдний өвөлжөө эргэн тойрондоо нөмөргүй зүг бүрээсээ жавралдаг, талын бууц учир хороогоо зөвхөн хонь цувж орох үүдтэй, төлийн дулаан пинтэй барьжээ. Саяхан энэ багт тэргүүний малчдын зөвөлгөөн болж түүнд Равжир оролцож, дулаан өвөл бууц хөлдөхгүй байх бууцы нь хамт зайлуулаад 3-4 хуруу хөлдөх үед нь ховхолж хороо тавьдаг туршлагаар ботго тормондоо хороо барьж ба өвс нэмж түүх гэнэ. Равжир мал хариулахдаа үргэлж номтой явдаг. Шөнө номоо уншиж мэдлэг боловсрол мэдлэгээ дээшлүүлэхийн төлөө идэвхтэй ажилладаг байна. Равжирыг нутгийн ардууд үе дотроо хамгийн ажилсаг залуу гэж магтан ярилцдаг аж. Равжир 1958 оны 7-р сард аймгийн бүх малчин залуучуудын төлөөлөгчөөр Дорноговь аймагт “Фестивалийн буухиа” элчээр явжээ. Бас аймгийн эвлэлийн 9-р бага хурлаас аймгийн эвлэлийн хорооны бүгд хурлын гишүүнд сонгогджээ.

Юндэн

- 16.** Төл хүлээн авах бэлтгэлийг сайн хангая // Говийн мэдээ.- 1958 оны 12-р сарын 15.- №84.- 1-р нүүр.

Төл хүлээн авах бэлтгэлийг сайн хангая

Малыг өсгөхөд түүний төлийг гарздалгүй бүрэн бойжуулж авах явдал асар их ач холбогдолтой. Төл бойжуулах бэлтгэлийг сайн хийснээр төлийг бүрэн бойжуулж авна. Малын төл бойжуулах бэлтгэл ажлыг 1957 онд маш хангалтгүй хийснээс тус аймаг 1958 онд 60 гаруй мянган төлийг гарзадсан байна. Булган, Сэврэй, Цогтцэций, Номгон, Хүрмэн, Ханхонгор, Баяндалай сумд 5308-11498 төлийг өвчин ба арчилгааны муугаар үхүүлжээ. “Гурван сайхан” “Шинэ амьдрал” “Гуяа” “Туг” “Оч” нэгдлүүд ч төлийг олон мянгаар хорогдуулжээ. Бид 1957-1958 онд төл бойжуулах бэлтгэл ба бойжуулах ажлыг муу хийснээр барахгүй 20 гаруй мянган малыг сувайруулж 43 гаруй мянган малыг хээл хаяулжээ. Үүний уршгаар ч манай аймаг мал өсөх 1958 оны төлөвлөгөөг тасалдуулсан.

Мал өсгөх 1958 оны төлөвлөгөөг улсын хэмжээгээр биелүүлэхэд саад учруулсан манай аймгийнхны энэ ноцтой дутагдалыг МАХН-ын Төв Хорооны 11-р сарын бүгд хурал зүй ёсоор буруушаасан билээ. Бид 1957-1958 онд гаргасан энэ ноцтой дутагдлаа 1959 оны төл бойжуулах ажил дээр шууд засах ёстой. Төл бүрийг малаас 1959 онд хүлээж авах төлийг бүрэн бойжуулахад бэлтгэх нэг сарын ажил энэ 12-р сарын 15 наас эхлэн манай орон даяар зохиогдож эхлэв.

БНМАУ-ын Сайд нарын зөвлөл, МАХН-ын Төв Хороо, төл бойжуулах бэлтгэлийг 1959 оны 1-р сарын 15 дотор бүрэн хангахаар заажээ. Малын төл бойжуулах бэлтгэл ажил ийнхүү зориуд зохиогдож байгаа нь бидэнд бүр ч их завшаантай хэрэг бөгөөд бид үүнийг дүүрэн

ашиглах ёстой. Манай аймгийн нэлээд сум багт бог малын хээлтүүлэг эрт явагдсанаар хонь ямаа хэзээ хэзээгүй төллөх гэж байгаа нь төл бойжуулах бэлтгэлийг яаралтай түргэн хангахыг шаардаж байна. Төл бойжуулах сарын ажилд амжилт олох гол нөхцөл нь уг ажилд бүх хүмүүс, албан байгууллагуудын хүчийг нэгдэлтэйгээр чиглүүлэх явдал мөн. Төл бойжуулах сарын ажилд амжилт олох гол нөхцөл нь уг ажилд амжилт олох гол нөхцөл нь уг ажилд бүх хүмүүс, албан байгууллагуудын хүчийг нэгдэлтэйгээр чиглүүлэх явдал юм. Энэ ажилд оролцохоос татгалзсан хоргоших хүмүүс, албан байгууллага нэг ч байж болохгүйгээр үл барам сарын ажилд аль болох үр дүнтэй ажлыг өөрсдөө санаачлан зохиох ёстой. Сарын ажлын хугацаанд хээлтэй малыг арчлан хамгаалах, ядарч доройтсон малыг тэжээх, бэлчээр нутгийг сонгон тохируулах, хүчит шим тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх, өвөлжөө бууцандаа татаж авах, төлийн пүнз, эх барих хэрэглэл, хучлага уут нэмнээг хүрэлцэхээр төхөөрч авбал зохино. Мал эмнэлгийн байгууллагууд хээлтэй малын эрүүл мэндийг шалгаж эмчлэх, төлийг эх барьж авахад хэрэгэлэгдэх эмээр айл өрх бүрийг хангаж, төлийн өвчнийг анагаах эм хэрэглэлийг сайн базаах ёстой. Төл бойжуулах бэлтгэл ажил дээр гарах үр бүтээлтэй арга туршлагыг цаг тухайд нь нийтэд дэлгэрүүлж байхын хамт дутагдлыг хайр найргүй илрүүлэн шүүмжилж байх нь аймаг сумдын хэвлэл, радионы газрын үүрэг мөн. Төл бойжуулах бэлтгэлийг хангах сарын ажилд хүн бүр үр бүтээлтэй зүйлийг гүйцэтгэхэд өдөр бүрийнхээ ажлыг чиглүүлцгээе.

17. Хоньчны туршлага // Говийн мэдээ.- 1959 оны 1-р сарын 1.- №1.- 4-р нүүр.

Хоньчны туршлага

/Сурвалжлага/

Элч нь буурсан өвлийн цагаан нар огторгуйн уудамд туяанаасаа тэлүүлсэн шиг өчигдрийнхөөс өнөөдөр арай урдуур даялсаар баруунаа жаргахад Ахар уулын орой улбар шаргал туяанаас салж ядан хоцрох мэт. Удалгүй бүдэг үдшийн өвлийн дунд сарын сүүн цагаан сар туяарсаар гийгүүлэв. Хүйтэн жавар гялалзаж , явган шуурга үлээж байсан тэр үдэш Ахар уулын энгэрт байгаа хот айлын гадаа очиход нүүр чимчигнүүлж байсан жавар мэдэхээ болж салхи ч үгүй байх нь энэ бууц гойд дулаахан ажээ. 40 орчим насны эр малчин хүнийхээ эелдэг заншлаар биднийг угтаж мэндлээд зочлов. Энэ бол Хөдөлмөр нэгдлийн хоньчин Дашдэлэг юм. Дашдэлэг гуай Хөдөлмөр нэгдлийн хашир малчны нэг бөгөөд эднийх1958 оны зун Ахар уулын араар зузаж говийн шимтэй ногоон сөл барагдтал малаа оторлож бэлчээр усыг сэлж байснаас хонь нь гоц сайн таргалжээ. Дашдэлэг гуайгаас хонь малладаг арга туршлагаасаа ярьж өгнө үү гэхэд ингэж ярьлаа. Жилийн дөрвөн улиралд хонь маллах арга харилцан адилгүй өөр өөр байдаг. Би нэгдлийн 150 хонийг сүүлийн хэдэн жил маллаж ноос үс, ашиг шимийг нь бүрэн ашиглаж нэгдлийнхээ орлогод нэмэгдүүлж байна. 1958-онд хурга бүрээс 390 гр эм ноос,1,5 кг ноос авч 150 хониноос 144 хурга , 50 ямаанаас 40 ишиг бойжуулсан. Мөн нэгдэлдээ ааруул 45 кг, архи 28 летрийг өгсөн. Би хонийг жилийн 4 улиралд бэлчээрийн хуваарьтай маллахыг хичээдэг. Ялангуяа өвөл хаврын хүнд үед малаа бэлчээрлүүлэхэд зориулж нөмөр сайтай ойрын нам газрын бэлчээрийг нөөцөлдөг дулаан өдрүүдэд алсын бэлчээрийг малын хээл хөнгөн байхад хяр өндөрлөгийн бэлчээрийг ашиглах нь сайн байдаг. Хаврын цагт хоньчин хүнд их хөдөлмөр шаарддаг. Өглөө дулаахан байснаа оройдоо

хүчтэй шуурга гэнэт тавьж сандраадаг. Иймд малыг нөмөр газар, салхи өөд сөргөх ойрын бэлчээрт хариулвал ашигтай. Төлийн байрны хөх хорголыг 7 хоногт 2-оос доошгүй сольж гисколороноор ариутгаж байвал төлд ямар нэгэн өвчин тусах нь бага байдаг. Нялх хургыг эхээс гараад 7 хоногоос нь эхэлж бударгана, зөөлөн өвсөөр сэвэслүүлж 10 иад хоногийн дараа ойрын бэлчээрт гаргаж хариулвал торнилт нь амархан байдаг билээ.

Т.Хүүхэнжимээ

18. Малын таргыг зузааруулж бэхжүүлэх үе // Говийн мэдээ.- 1962 оны 9-р сарын 6.- 1-р нүүр.

Малын таргыг зузааруулж бэхжүүлэх үе

Энэ жил хангай говьгүй хур бороорхог өнтэй сайхан зун болж малыг бэлчээрээр таргалуулах аятай сайхан нөхцөл болж байна. Мал таргалуулах ажил эдийн засгийн олон давхар ач тустай учир нам засаг энэ талаар онцгой анхаарал тавьж байна. МАХН-ын төв хороо БНМАУ-ын сайд нарын зөвлөл малчдад хандаж бичсэн захидалдаа мал таргалуулахын ач холбогдол арга замыг яруу тодорхойлсоныг бид мэднэ. Малыг өвчин эмгэггүй товир чийрэг болгох ашиг шимийг нь нэмэгдүүлэх таваарлаг чанарыг нь нэмэгдүүлэх хээлтэгч мал бүрээс төл хүлээн авах зэрэг гол гогцоо нь малын тарга хүчнээс хамаарагдана. Малын тоо толгой ашиг шимийн өсөлтийн шийдвэрлэгч үндсэн зүйл болж байгаа малын тарга хүчний асуудлыг хайхрахгүй байх буюу зоргонд нь тавих явдал мал аж ахуй үйлдвэрлэлийг эрхлэн явуулдаг бид бүхэнд цээртэй хэрэг.

Булган аймгийн хоньчин хөдөлмөрийн баатар Очироос эхлээд тус аймгийн Ханхонгор сумын хоньчин Пэлжээг хүртэл олон арван шилдэг малчид яагаад

амжилтанд хүрч алдар цуутнууд болж чадав. Тэд мал аж ахуйн үйлдвэрлэлийн хамгийн чухал хүчин зүйл тарга тэвээргийн асуудалд онцгой анхаарч түүний төлөө зүтгэн мэрийдгийнх гэдэг нь хэн бүхэнд тодорхой байна. Манай аймгийн хувьд авч үзвэл мал таргалуулахаар намын төв хороо засгийн газраас заасан зорилтыг биелүүлэх бүх бололцоо дүүрэн байгаа бөгөөд хэрэгжүүлэх гол нөхцөл нь зохион байгуулалтын бүтээлч тодорхой ажил мөн. Говь нутагт малын тарга хүчийг улам зузааруулж таргыг бэхжүүлж тогтоох ажлын ид үе одоо болж байна. Ногооны шүүс ид өтгөрч үр шим нь боловсорч гүйцэж байгаа энэхэн хугацааг алдалгүй ашиглаж мал бүхэндээ ирэх оныг туулах бүрэн тэвээрэг авахуулахын төлөө бүх нийтийн хүч анхаарлыг дайчлах хэрэгтэй. Юуны өмнө бэлчээрээс алс зайдуу бэлчээрийг сайн ашиглаж малын бэлчээрлэх хугацааг уртасгах хэрэгтэй. Ялангуяа сөл сайтай бэлчээрийг товшин нүүж отрын журмаар ашиглах нь чухал. Манайхан ган гачигтай тэмцэж алс нүүдэг туршлагатай хир нь цагийн сайнд ойр зуур байнгалан нүүж дадаагүй байгааг анхаарууштай.

Малчин бүр малынхаа тарга хүчний байдалд байнгын шинжилгээ хийж анхаарч байвал зохино. Зөвхөн хэмээний бөх ширээлэх хонины сүүл томрох төдийд хууртаж болохгүй Өөхөн таргын хамт махан тарга нь хир нэмэгдэж байна вэ гэдэгт анхаарал тавьж ажиллах ёстой. Олон жилийн ган зудад ёвшрогдсон малыг дутуу таргалуулбал муудах нь ямар байдаг гэсэн хашир малчдын санамж байдгыг санаж хэрэгжүүлэх хэрэгтэй.

Малын тарга хүчний өсөлтөнд хариулага маллагааны роль маш их байдгыг мартаж болохгүй. Бод малыг хариулбал таргалдаггүй гэсэн залхуурлын шалтаг заасан дутагдал багагүй гарч байгаатай шийдвэртэй тэмцэл явуулах хэрэгтэй. Одоо үе малын тарга хүч

тогтож байгаа үе учраас ихээхэн хэврэг байдгийг анхаарахгүй байж болохгүй. Малын ус хужрыг тааруулах явдал малын тарга тэвээргийг бэхжүүлэх хамгийн чухал зүйлийн нэг мөн. Бог мал нийлүүлгийн кампанийг зохиохдоо Функт хэсгийн бэлчээрийг зохистой ашиглах цагийн нарийн хуваарьтай ажиллаж малыг ширүүн хөөж туух явдалыг цээрлэн тун хянамтгай ажиллах хэрэгтэй байна. Малаа таргалуулж он цагийг өнөтэй давдаг хашир малчдын туршлагыг олон түмний хүртээл болгох нь чухал. Мал нэг бүрийнхээ таргыг зузааруулж хамгаалан бэхжүүлэх замаар 1963 онд мал сүргээ өсгөн нэмэгдүүлэх эрхэм зорилтын нэг бололцоог бүрдүүлэх явдал одоо үеийн чухал зорилтын нэг боллоо.

19. Малыг зуны ногоон бэлчээрээр таргалуулах асуудал // Говийн мэдээ.- 1962 он.- №50.- 3-р нүүр.

Малыг зуны ногоон бэлчээрээр таргалуулах асуудал

/Бэлчээрийн ногооны тухай асуудал/

Шүүст тэжээлийн зүйлд багтдаг говь нутгийн зун цагийн ногоон ургамал нь ус, уураг, нүүрстөрөгч, тослог шорвогийн зүйлээр хангалттай юм. Шүүст тэжээлийн дотор 1% уураг, 1-2% бүх хуурай бодисын 20% нүүрстөрөгч байдаг байна. Нүүрстөрөгч нь малыг таргалуулж, өөхлүүлэхэд маш их чухал зүйл мөн. Хуурай бодисууд нь витаминь зүйлээр баялагаас гадна саахар ихтэй учир шүүст тэжээл уусан боловсруулахдаа бусад тэжээлээс хурдан юм. Түүнээс гадна бэлчээрийн ногоо нь зөөлөн чийглэг амтархаг учраас ямар ч мал дуртай идэж түүнээс тэжээл авах нь гойд хурдан байдаг байна. Төрөл бүрийн мал тэжээлийн ногоог идээд түүнийг боловсруулах чадал харилцан адилгүй.

ЖИШЭЭ НЬ: Хивэгч мал тэмээ, үхэр, хонь, ямаа 85% - ий нь, адуу 70% нь, гахай 50% нь боловсруулан шингээдэг байна. Бэлчээрийн ногоо малын хүч тарга ашиг шимийг зөвхөн нэмэгдүүлээд зогсохгүй түүний чанарыг нэгэн адил сайжруулан янз бүрийн өвчин эсэргүүцэх чадалтай болгож өвөл хаврын улиралд шаардлагатай төрөл бүрийн бодис эрдэсийн зүйлийн нөөцийг өгдөг байна. Бэлчээрийн ногоон ургацыг ашиглан малыг таргалуулах ашиг шимийг нэмэгдүүлэх явдал нь эдийн засгийн маш том ач холбогдолтой юм. Малыг зуны ногоон бэлчээрээр таргалуулахад аль болох эртнээс ажиллах нь ашигтай байдаг. Эрт идсэн ногоо малын биед шингэж, сайн таргалуулан удаан хугацаагаар амьдарч чадах тослог хар мах суулгахдаа илүү байдаг.

Манай говьд голдуу 7-8-р сард орсон борооны чийгээр ногоо гарч тэр нь амт чанар сайтай байдаг боловч жинхэнэ үр идээ нь орой боловсорч түүнийг мал идэх хугацаа богино байдаг учраас малд зөвхөн өөх суухаас биш алсын даацтай тослог хар мах сууж хүч чадал бүрэн авч чаддаггүй байна. Иймд өнгөц таргалсан мал эцэж турах нь амархан байдаг. Тарган мал ган зуд, өл хоол даах, амьдрах чадал сайтаагаас гадна мах ноос нь аль ч талаараа туранхай малынхаас арвин янз бүрийн өвчин тусах хээл хаях нь бага хээл авах нь сайн гарсан төл нь амьдрах чадвар сайтай байхаас эхлээд аж ахуйн талаар нэн их ашигтай билээ. Бэлчээрийн ногооны ургац янз бүрийн бүс районд харилцан адилгүй га газарт намгийн ногоо 187-24 центер тал газрын ногоо 12-13 центнер говь талын агь хазаар өвстэй газарт 1,5-5 центнер ургадаг жишээтэй юм. Гэвч энэ нь газрын хөрсний байдал, нарны илч, бороо чийгийн байдлаас шалтгаална. Бэлчээрийн ногоо шарлаж гандаж байгаа үед тэжээлийн чанар нь доройтсон байдаг. Ийм учраас

Говийн мэдээ сонин

төрөл бүрийн мал сүргийг таргалуулах ажлыг бэлчээрийн ногоо нялх соргог байгаа үеэс эхлэх нь чухал юм.

Б.Лувсанжав

20. Ямаачин намын гишүүн Түмэн гуай // Говийн мэдээ.- 1963 оны 1-р сарын 20.- №6.- 3-р нүүр.

Ямаачин намын гишүүн Түмэн гуай

/Сурвалжилсан тэмдэглэл/

Ноён богд уулын хэцэд хүйтний эрч нэмэгдэж малчин хүний сэтгэлд юм бодогдмоор болж байгаа энэ үед Ноён сумын Гучин таван жил нэгдлийн 3-р багийн ямаачин намын гишүүн Түмэн гуайнд очиж ажил байдалтай нь танилцахад Түмэн гуай: Мал төллөх ирмүүн үе ойртож байна. Манайх энэ жил Нийгмийн 340 ямааныхаа хагас төлийг хөрөвжилтийн аргаар бойжуулахаар төлийн байр, уут хучлага, нэмнээ, тэжээл зэрэг бүх бэлтгэлийг урьдах жилүүдийнхээс илүү хүрэлцээтэй бэлтгэсэн. Төлийн бэлтгэлд нэн анхаарууштай зүйл бол төлийн байранд дан хөх цэнхэрдүү хоргол 60-70 см зузаан дэвсэж өгөх нь: яагаачгүй чигжиршихгүйн гадна төлд элдэв өвчин тусдаггүй, сэргэлэн цовоо торнидог юм. Төлийн гэдэс өвдөх нүд нь нуухдах явдал ганцхан байрны ариун цэвэр дулаан хоолноос шалтгаалдаг. Иймд төлийн байрыг ариун цэвэр байлгаж, дулааныг хэвийн байлгадаг. Төлийн хөхүүлэлтийг нэг хэмжээ хугацаанд жигд хөхүүлдэг юм.

Төлд нэмэгдэл тэжээл болгож гоёо, хайлсны навч загасгал зэргийг хандлан чанаж сүлээд өгөхөд төл нь махалж торних нь хурдан байдаг. Манайх сая гарсан төлөө амлуулахын өмнө керолиний уусмалыг хоолны халбагаар нэг өгдөг. Энэ нь хоолны шингээлтэнд сайн үр дүн өгөх шиг болдог. Энэ аргыг манайх гурван жил

Говийн мэдээ сонин

дараалан хэрэглэсэн нь зохих үр дүнгээ өгсөн. Бид малаа төллөх үед ээлжлэн жижүүрлэдэг. Малаа төллөхөөр нь нөөж байсан ойр бэлчээрт хариулдаг. Гэр дотроо мал тэжээх төлөө хөхүүлэх гэх зэргээр ажлын нарийн хуваарьтай ажилладаг гэж Түмэн гуай ярилаа. Эднийх ямаагаа нэг бүрчлэн саалийг ашиглахын тулд эх төл хоёрыг гэрийнхээ хоёр талд хотлуулж сургадаг байна. Түмэн гуайнх сүүлийн 5-6 жилд нэгдлийн үйлдвэрийн даалгавараар өгөгдсөн ноос, үйлдэхүүн, 100 эхээс бойжуулах төлийнхөө хэмжээг давуулж ирсэн ажээ.

Д.Нанзай

21. БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Жижээгийн малч ажиллагаанаас сурцгаая // Говийн мэдээ.- 1964 оны 3-р сарын 5.- №19.- 3-р нүүр.

**БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Жижээгийн
малч ажиллагаанаас сурцгаая
/Баатар Жижээ 1963 онд/**

Өгөөмөр баян амжилтаараа Өмнөговьчууд дотроо анх удаа төрж гарсан БНМАУ-ын хөдөлмөрийн баатар тэмээчний өнгөрсөн нэг жилийн дүнг мэдэх хүсэл бараг хүн бүхэнд байгаа биз ээ.



Баатар Жижээ өнгөрсөн онд баггүй амжилт олжээ. Ботголох ингэ 25, торомтой ингэ 19, ат 12, бага тэмээ 18-ыг хариуцан малласан нэг жилийн дотор ганц ч малын

хорогдол гаргасангүй. Харин өнгөрсөн онд байсан 74-н тэмээгээ 100-толгой болгож 35,1%-иар өсгөжээ. Жижээ

гуйн хариуцаж малласан тэмээ цөм дундаас дээш тарга хүч авч энэ жилийн зуд гачигтай үед ч гэсэн өөг сайтай өвөлжиж хаваржиж байна. Ботголох 25 ингэн тэмээ нь насанд хүрээгүй гунжин ингэ нэг ботголж ингээд 26 ботго эсэн мэнд бойжуулжээ. Баатар Жижээ малч сайн ажиллагаагаараа баатар Жижээгээс онцын дутахгүй туслагч нөхөр Доржийнхоо хамт зун намрын цагт байнга отрын байдалд орж ургацын соргогийг даган нүүдэлсээр тэмээндээ тарга хуч авахуулжээ. Тарган мал тал бүрийн ашигтай билээ. Баатар эмэгтэй Жижээ 1963-онд улсдаа 394 кг 800 гр ноос бэлтгэж авах байснаа 496кг ноос бэлтгэж тушаасан нь тэмээ бүрээсээ 6кг 100гр ноос авсан хэрэг юм аа. ЖИЖЭЭ гуай тэмээнийхээ эр ноосыг авахдаа аль болох угаар нь хадаж хяргаж авдаг байна.

Их биений нь ноосыг авахдаа урьдаар ямааны самаар самнаж хөндийрүүлээд хялгасыг угаар нь хяргаж авбал байгаа бүх ноосыг бүрэн авч болдог хэмээн ярьж байна. Бас тэмээнийхээ тойг,борви, сагагны хялгас, сахал, өрөвлөгийг сайн хяргах хэрэгтэй гэж зөвлөж байна. Баатар Жижээ өнгөрсөн онд ингэ бүрийн 80л сүүгээр бодож 2000л сүү ба түүний төлөөний сүүн үйлдэхүүн нэгдэлдээ тушаах үүрэгтэй байлаа. Гэтэл 134 кг ааруул , 50 кг шар тос, 111 кг 300 г цагаан тос, 67 кг аарц 86 л сүү тушаажээ. Үүнийг нь уг ноогдлын дагуу бие сүүнд оруулан бодвол 4161 л сүү болжээ. Энэ нь ингэ нэг бүрээс 166 л сүү авсан хэрэг юм. Оторлон нүүдэллэж буудал хуучирч бэлчээр дартагдашхаас өмнө сэлгэж идээшилсэн ингэний сүүний гарц илэрхий сайн гэнэ. Шинэхэн буудалд ботготой ингэ түргэн түргэн эргэж ирж олон саалгадаг сайн талтайн гадна холын бэлчээрт туус туус явахгүй учраас тарга хүчээ авахад нь хүртэл ашигтай ажээ. Сааль сүүг шамдаж авахад анхаарах нэг зүйл бол ингийг ид ивэлгээн дээр нь маш түргэн саах

явдал гэнэ. Ивэлгээн дээр түргэн сааж чадахгүй атлаа учгыг нь шувтраад байх нь тэмээний хөхийг өвтгөж ярдагшуулаад ингийг муухай зантай болгоход хүргэдэг байна.

Жижээ гуайн өнгөрсөн онд хариуцан малласан тэмээгээ тарга хүч авахуулан онд оруулж ашиг шимийг нь авч тушаасанаар ажил нь төгссөн хэрэг биш ээ. Эднийх уяа, сойлго, бурантаг зэрэгт ноос хэрэглэсэнгүй. Хаягдал даавууны өөдөс ашиглах ногт бурантаг тэмээний хаягдал шир /түүхий эдийн хэрэгцээ хангаж чадахгүй болсон/ ашиглаж түүнийг зүсэж гандаад зэл томож хийх зэрэг санаачилга гаргаж ажилласан нь үр дүнгээ өгч байна. Ганц баримтыг хэлэхэд 50 ногт 50 бурантагнаас 20 кг ноос машины хаягдал резин дугуйны хөвөө зүсэж хийсэн 50 уяанаас 25 кг ноос хэмнэх жишээтэй байгаа нь өөрийн ботго торомны уяанаас л 500 төгрөгний хэмнэлт гаргахаар болж байна. Мал маллагааны эдгээр ажлаас гадна мал аж ахуйн туслах чанарын ажил сум нэгдэл бригад хэсгээс зохион байгуулж байгаа ажлуудад онц идэвхтэй ажилладаг байна.

Зөвхөн өнгөрсөн онд нөхөр Жижээ төлийн пүнз 3, саравчтай хашаа 1-ийг барилцжээ. Эднийх нэг худгийг шинээр гаргаж 4 худгийг засварлажээ. Бас 15 хүн хамтарч 34 тонн цагаалж өвс тээж бэлтгэжээ. Хөдөлмөрийн баатар Жижээ гуай нэгдлийнхээ дотоод журмын шаардлагын дагуу 1963 онд 120 хөдөлмөр өдөр бүтээх шаардлагатай байлаа. Энэ нь Мандал-овоо сумын Хөдөлмөр нэгдэлийн хөдөлмөр өдрийн хөлсний нэгчээр 480 төгрөг ажээ. Гэтэл Жижээ гуай өөрөө өнгөрсөн онд дээрх ажлуудаараа 802 хөдөлмөр өдөр бүтээж түүнийхээ хөлсөнд 3208 төгрөг 57 мөнгө авчээ. БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Жижээ ийнхүү 1963

Говийн мэдээ сонин

оныхоо ажлыг 6 дахин биелүүлжээ. Өөрөөр хэлбэл Жижээ шиг 6 эмэгтэйн үүрэгт ажлыг Жижээ гуай ганцаараа хийжээ. Баатар тэмээчин эмэгтэйн малч сайхан ажиллагаанаас сурцгаая.

Ц.Бат-очир

22. Зүтгэл бүтээл // Говийн мэдээ.- 1964 оны 10-р сарын 23.- №81.- 2-р нүүр.

Зүтгэл бүтээл



Ханхонгор сумын Өлзийт нэгдлийн нэгдүгээр бригадын ямаачин Сономын Дугар зудыг зунаар давж зун намрыг амжилтаар давдаг хашир туршлагатай малчин юм. Дугар гуай нэгдэлжих хөдөлгөөн ид өргөж байсан үе 1957 онд 14 өрхийн хамтаар Мандах нэгдлийг үүсгэн байгуулахаар санаа сэдэж тэр нэгдлийн тулгын чулууг тавилцсан хүний нэг билээ. Тэгээд

ХАА-н нэгдэлүүдийг нэгтгэж томруулах ажил зохиогдоход Өлзийт нэгдлийн гишүүн болжээ. Дугар гуай нэгдэлд орсон цагаасаа хойш 7 жилийн турш нэгдлийн дан ямаан сүрэг маллаж төлөө бүрэн бойжуулж төлөвлөгөөт үүргээ ямагт давуулан биелүүлж сум нэгдлийнхээ тэргүүний малчдын эгнээнд яваа хүн юм. Эднийх 1963 онд 150 ямаанаас 165 ишиг бойжуулж нэг ямаанаас 270гр ноолуур 230 гр ноос авч сумын 1963 оны ноолуурын аварга болсон байна. Энэ амжилтаа бататгаж хэдийгээр 1964 онд зудын хүнд аюул тохиолдсон боловч 1000 эм ямаанаас 94,7 төл хүлээн авч 70кг ноолуур тушаахаас 80 кг-ыг авч 75кг-ыг 1-р зэрэгт тушаажээ.

Тэрчлэн 2145 литр сүү тушаахаас 2650 литр сүү буюу 500 литр сүү илүү тушаагаад байна. Эдгээрээс зөвхөн 1964 онд 9764 төгрөгийн орлогыг нэгдэлдээ оруулжээ. Дугар гуайнх 1961 онд хөдөлмөрийнхөө хөлсөнд 1200-аад төгрөг авч байсан бол 1964- онд 4000 гаруй төгрөг авч байна. Ийнхүү амжилт бүтээл нь нэмэгдэхийн хамт амьдрал бүтээл нь дээшилж сүүлийн хэдхэн жилийн дотор гэр орноо 2 дахин шинэчлэн томруулж, ариун цэвэр тохижилтын талаар бригадын хэмжээний үлгэр жишээ сайн айлын нэг болжээ. Дугар гуайн зүтгэл бүтээлийг сум нэгдэл нь өндөрөөр үнэлж хайр шагналаа хүртээсээр байдаг ажээ.

Н.Дамбий

23. Амжилт бүтээлээрээ шалгарт аваргын болзол хангасан төлчид // Говийн мэдээ.- 1966 оны 2-р сарын 21.- №15.- 2-р нүүр.

**Амжилт бүтээлээрээ шалгарт аваргын болзол
хангасан төлчид**

Цэвэлийн бал хүү:

Цогт-овоо сумын жаргалант нэгдлийн 1-р бригадын хоньчин Цэвэлийн Балхүү 1957 оноос нийгмийн хонин сүрэг маллаж сүүлийн жилүүдэд малын хариуллага, төл бойжуулалт ашиг шим ашиглалтаараа нэрд гарч яваа тэргүүний хоньчин юмаа.

Хоньчин Балхүүгийнх 1964 онд суурь сүргийн зохион байгуулалтаар хоёр өрхийн хөдөлмөрийн чадвартай 3 хүн нэг суурь болж нийгмийн 410 төллөх хонь хариуцан маллажээ. Хоньчин Балхүү хонийг зун, намрын улиралд отроор маллан сайн тарга хүч авахуулж, хонины хээлийг хамгаалахад онцгой анхаарч ширүүн туух, үргээж цочоох, зэргийг болгоомжилж ажилладаг ажээ. Мөн өвлийн улиралд хонио услахдаа

Говийн мэдээ сонин

худгийн мөсийг байнга цэвэрлэх, өвөлжөөгөө үргэлж хуурай байлгах, хужир тогтмол тавьж өгөх зэргээр ажилладаг нь малын хээл хамгаалах нэг нөхцөл болдог байна. Хоньчин Балхүү ийнхүү шаргуу ажиллагаагаараа 1965 онд 410 хониноос 450 хурга, зориуд хээл авхуулсан 25 төлөгнөөс 25 хурга бойжуулснаар бүгд 79 хурга илүү бойжуулжээ. 1965 онд 410 хонин дээрээ эр охин нийлсэн 200 төл нэмэн авч маллаж байна. Хоньчин Балхүү сүүлийн жилүүдэд төлийг хагас эхлээр бойжуулж, өвөлжөөндөө тохилог дугуй хороо барьж, өвс тэжээл хүрэлцэх хэмжээгээр бэлтгэн авч, ядарч доройтох төлөвтэй буюу тарга хүч дутуу авсан хонийг зутрахаас нь өмнө байнга тэжээж хариуцсан хонин сүргээ хорогдолгүй онд бүрэн оруулахын төлөө чармайн ажиллаж иржээ. МАХН-ын гишүүн, хоньчин Балхүүгийн суурь энэ бүх амжилтаараа 1965 онд улсын аврага төлчний болзол хангаж 5 ханатай гэр, мянган төгрөгөөр шагнагдав.

Галбын говийн хоньчин:

Ханбогд сумын “Галбын хөнжил” нэгдлийн 1-р бригадын хоньчин Сономын Төмөр 10 жил дараалан төллөх хонь маллаж, Галбын говиор нутаглаж байна. Хоньчин Төмөр 1965 онд сууриараа 404 хониноос 470 хурга бойжуулж 100 эхээс бойжуулах төлийг 116,5%-иар бойжуулжээ. Түүнчлэн нэг хониноос 1721гр, хурганаас 228 гр ноос ашиглаж саалийн хонь бүрээс 2,4 литр сүү авсан байна. Мөн 600 бог малын багтаамжтай 2 пүнз бүхий саравчтай хашаа тус бүр нэгийг барьжээ. Хоньчин Төмөр эдгээр амжилтаараа 1965 оны улсын аварга төлчний болзлыг хангаж шагнал хүртэв.

Лувсандоржийн суурь:

Манай сумын /Хоёр өлзийт/ нэгдлийн 1-р бригадын ямаачин Хувын Лувсандорж ахлагчтай суурь

1961 оноос, төллөх ямаан сүрэг маллаж, хөдөлмөрийн нарийн хувиартай ажиллаж жил дараалан төлийг нь бүрэн бойжуулж, ноос ноолуур, сааль сүүний даалгаварыг ямагт давуулж иржээ. Ямаачин Лувсандоржийн суурь 1965 онд 633 ямаанаас 707 ишиг бойжуулж 100 эх тутмаас бойжуулах төлийг 111,7%-иар биелүүлжээ. Мөн 600 бог малын багтаамжтай задгай хороо, 400 бог малын багтаамжтай, саравчтай хашаа тус бүр 1, төлийн пүнз 2-ыг барьсан байна. Тэрчлэн 5 өрхийн 2 суурь нийлж СХТБ байгуулан бүгд 1200 гаруй ямаа маллаж тохилог өвөлжиж байна. МАХН-ын гишүүн, сумын депутат Х.Лувсандоржийн суурийн хамт олон нэгдэл бригадынхаа малчдын дундаасаа ажлаараа шалгарч, 1965 оны улсын аварга төлчний болзол хангасан бахдам амжилтаар нэгдэлчдийн сайн өдрөө угтлаа.

Б.Сүхбаатар

24. Баян-овоо сум-100 ботготой айл // Говийн мэдээ.-
1966 оны 7-р сарын 4.- № 52.- 2-р нүүр.

Баян-овоо сум-100 ботготой айл

“Их говийн зоригт хүмүүс гэж хэлсэн үг” говьчуудад оножээ. Хэн нэг хүн “говийн хөгжил” нэгдлийн тэмээчин Гомбынд очиж ажил байдалтай нь танилцвал: Олдсон Цавчир, Эслэг цагаан цав, Гом долоон мод, Босого таван хороотын уудам өргөн тал тэмээн сүрэгт тохиромжтой нутагдаа. Манайх 1963 оноос эхлэн одоог хүртэл тэмээн сүрэг маллаж байна. Энэ жил 316 тэмээ хариуцан маллаж 100 ингэнээс 100 ботго бойжуулаад байна. Тэмээ маань бүрэн эмгэг өвчингүй байна. Манайх энэ жил тэмээний ноос 1500 гаруй кг-ыг тушаахаас 1520 кг-ыг тушааж үйлдвэрийн даалгавраа давуулан биелүүлсэн гэж ярихыг нь сонсоно байх. Ер нь Гаажид

Говийн мэдээ сонин

эмгэн төрүүлсэн 7 хүүхдээ ажилч хичээнгүй үнэнч шудрага сайхан хүмүүжил олгосон алдарт эх хүн юм. Бага хүү Цэвээн нь залуу малчны сургууль төгсөөд сурснаа амьдралд амжилттай нэвтрүүлж байна. Охин Насандэлгэр нь ахаасаа дутуугүй сайн тэмээчин төдийгүй сайн тэмээчин төдийгүй сайн тамирчин, уран сайханч юм шүү.

25. Үхэрчин Цэрэннадмид // Говийн мэдээ.- 1966 оны 7-р сарын 4.- № 52.- 2-р нүүр.

Үхэрчин Цэрэннадмид

Хар заг бригадын үхэрчин, сумын депутат Цэрэннадмид 1960 онд нэгдлийн үхэр сүрэг хүлээн авч мал маллаад жил дараалан төлийг нь бүрэн бойжуулж хөөврийн даалгаврыг давуулан биелүүлж өвөл хаврын улиралд Заг, Сүж, Зээмгийн говьд, зун намарт хь Хачигийн уулын ар Задгад, Булаг зэрэг задгай устай тохиромжтой билчээрүүдийг сонгон нутгалдаг хүн юм. Үхэрчин Цэрэннадмид 1964 онд 110 үнээнээс 110 тугал, 1965 онд 140 үнээнээс 140 тугал бойжуулж сумын 1965 оны тугал бойжуулалтын аварга болсон юм. Эднийг энэ онд урьдын нэгэн адил сайн ажиллаж байна.

26. Аварга төлчний туршлага // Говийн мэдээ.- 1966 оны 8-р сарын 1.- № 58.- 2-р нүүр.

АВАРАГА ТӨЛЧНИЙ ТУРШЛАГА

Бичихонгор аймгийн Буянобулаг сумын Социализмын төлөөдлийн гишүүн БНМАУ-ын андга төлчин Д.Вятэ 10 шөхрэм жид их дэвний хонь асгаж, зун намрын цэгт отгор сайн байдаг гэжээ. 11-р сард бичихээр хонийг таргалдуулж авсан тэрт хүнийг нь сайн хамгаалдаг ч, цуу хурьга хэргийн аргатай бойжуулж тавьга сайн гэж нэрлэж хонь чин билээ. Д.Вятэ гуайн гэж ажлаж байв.

Отгодоходоо учир бий Хонин сүргийг зунд цагт өглөө эрт бичээр тарган ногооны шим тогтодог. Бийх үед цэвэр нана амьтат ургамал ихтэй сурсаг бичээрт бичээрдуулж өгөвчийг сэрүүн дэрвээдэгт ивэрнэцүүлж нь шингэж байдаг. Харин дэлгэн халуунд усалж оройн сэрүн унах үед мөн бичээрт гэрлэж байгад ивэрээ орой хотлуулдаг нь сайн.

Хотыг тургивгаж байх шаардлагатай Шаврай ихтэй хотонд хонь удаан хэвгэрэх буюу өгөлөн оройгож бичээлд хонь чийгтэж долоодог, ус их шидэх үрэг мүү тэгтэй байдаг. Ер нь хонийг хот-

гуй бичээрийн аргаар мөлдөх нь хонийн таргад тогт байв. Учир нь нэгдүгээр хонь байнга шинэ хэвэрт амарч шинэ сурсаг өмс, ногооны шим сор иддэг. Хондугаарт тогтоор явах хонь өвчлөгч хонь дурвар чөлөөтэй амарч иддэгшээг чаддаг юм. Тэгэхээр хонийг 7 хоногт 1-ээс доошгүй удаа лавалж хэвгэрж байх нь сайн байдаг.

Зулаан тарга тогтоох Хонин сүргийг зун отгорлож тарга хүнийг нь бүрэн авчухуулаад намрын цагт сайн хамгаалах хэрэгтэй. Наврхонхойг хэрвүүлж хоньд хонийн нь байнга тогтоож маш зөвлөн тогтуулан харилжж үргэжж илчлүүлж, хөөрөгж халуун хуулуугийг соргог бичээрт харуулж усвар тогт мөж хангаж байх нь сайн.

Мөн сэл хоньж атоглох хонийг тогтоодог өгч байх, намар ивэрээ орой болсон үед 11-р сарын орчим өвчлөгчөөд оруулах ивэрнэцүүлж байгад Намрын хонийг ширүүн тусваллах, усвар гэнцгүүрлэж эрт өвчлөгчөөд орох зэрэг нь хонийг хайлгаж турвадаг гэжтэй, өдөнийг замсонноос

27. Аварга төлчин ингэж ярилаа // Говийн мэдээ.- 1966 оны 8-р сарын 4.- № 59.- 2-р нүүр.

Аварга төлчин ингэж ярилаа

Ханбога сумын Галбан хөгжил нэгдлийн тэмгэрчигч Ялуу У. Цагаанхүү — Би 1950 оноос ахаж явдаг. Дундаж 300 гаруй тэмгэрчигчид хурал өгч, ажилласан юм. Төвч муулаг тэмгэрчигчид ажилладаг ажиллагааг ярихад эхэлв. Тэмгэрчигчид тэмгэрчигчид ажилладаг ажиллагааг ярихад эхэлв. Тэмгэрчигчид тэмгэрчигчид ажилладаг ажиллагааг ярихад эхэлв.

10-15 хонгоос ажилласан нь ч дэсгээвэл хугацаа байдаг. Ингэ бүрийн сурвалжид ажиллаж байгаа тэд суу муулаг тэмгэрчигчид ажилладаг ажиллагааг ярихад эхэлв. Ингэж ажилласан үеэр 1950 оноос хойшны 2 бүтэц хонгодоодой бүрэн байгуулаж 1964 оны 2 бүтэц хонгодоодой хүндэт аадарыг хүртэв. Одоо би ажилласан нь сурвалжаа ашиг шинийг нь ашиглаж ажилласан бүрэн байгуулахын төдийгүй хонго дайчдын ажлааг дахин зорилт авчгаж ирв.

Р. Хайдав



Ханбога сумын Галбан хөгжил нэгдлийн тэмгэрчигч Ялуу У. Цагаанхүү 1966 оны 8-р сарын 4-д ингэж ярихад ажилласан ажиллагааг ярихад эхэлв.

28. Говийн мэдээ.- 1966 оны 9-р сарын 22.- №73.- 2-р нүүр.



Баидалай сумын «Гурвансайхан» нэгдлийн үхэрчин Гүндсамба сууцнаарваад жил сарлаг малаж үр төл, үс ноосыг нь гарзгүй авч ирэв.

Жигмидийн...

29. Хоньчин Төмөр // Говийн мэдээ.- 1966 оны 10-р сарын 5.- №76.- 2-р нүүр.

Хоньчин Төмөр



Ханблгд сумын Гаабын их говмор нутаглан хуи цагаан хонно үржүүлэн яваа хоньчин Төмөр 1965 онд улсын аврага төлчин болжээ. 1968 онд эдийнх 427 хурга бэйжуулсны нилдээ нь эхээс илүү бэйжсон аж.

(МАНЯЙ СУРВАЛЖЛАГЧ)

30. Говийн мэдээ.- 1966 оны 10-р сарын 13.- №77.- 1-р нүүр.



Их эмч Гончигсүрэн бага насны тэмээнд үзлэг хийж байна.

31. Ямаачин туршлага ярьж байна // Говийн мэдээ.- 1966 оны 10-р сарын 20.- №73.- 1-р нүүр.

Ямаачин туршлагаа ярьж байна

Ямаачин Жамбалцэрэн 1958 онд нэгдэлд орсноос хойш ямаа маллаж байгаа туршлагатай ямаачин юм. Тэрээр өнгөрсөн хугацаанд нэгдлээс өгсөн Үйлдвэрийн даалгаврыг жил бүр давуулан биелүүлж, сүүлийн 2—3 жилд хариуцсан ямаан сүргийн хээ төлийг хорогдоогүй бойжуулж иржээ. Жамбалцэрэн мал ажиллагааныхаа арга туршлагаас ярихдаа: Мал маллах төлийг хорогдоогүй бойжуулах, ашигшмийг бүрэн авахад ганцхан уйгагүй оролдлого, чармайлт шийдвэрлэдэг юм. Би өвлийн бэлтгэлийг эртнээс хүрэлцээтэй хийж авдаг. Өвс тэжээл сайн бэлтгэж авбал өвлийн хатуу ширүүн улирлыг тавтай өнгөрөөж чадна. Харин ишгийг бойжуулахдаа хагас эхлээр аргаар бойжуулж, төлийн өвчинд хэрэглэгдэх өмийг төлөдөхийг хүлээлгүй урьдчлан сөргийлэх зорилгоор тогтмол өгдөг. Төлийн байр саруулхан, халуун хүйтэн нь тохирсон байвал төлд тохиромжтой байдаг юм. Билчээрийг зөв ашиглах, өвөлжөөгөө хамгаалан, намар орой өвөлжөөндөө буух, хавар эрт хөнгөн маягаар ойр зуур оторлон нүүж малдаа сайн тарга хүч авахуулж эхлэдэг. Төлийн би нийлүүлгийн журвал тогтмол хөтөлдөг. Энэ жил манайх төллөвөл зохих 168 ямаанаас 168 ишиг бойжуулан авч төлийн штабаас тэргүүний суурьт шилжин явах цалинг дардлаг хүлээж авсан. Манайх одоо өвөлжөөндөө 3,5 тонн өвс, өвлийн улиралд хүрэлцэх хэмжээний түлш татаж авч байна гэж Баяндалай сумын Баян бригадын тэргүүний ямаачин Жамбалцэрэн ярьж байна.

Ч.Т.Өмөр
(Малын эмч)

32. Говийн мэдээ.- 1966 оны 11-р сарын 21.- №86.- 1-р нүүр.



10 гаруй жил адуун сүрэг маллаж арга туршлага хуримтлуулсан энэ хүн бол булган сумын Туяа нэгдлийн дөл бригадад адуучинаар ажилдаг О.Гомбодорж билээ. Адуучин Гомбодорж одоо нийгмийн 300 гаруй адуу маллаж байна. Эдний суурь энэ жил 2000 литр гүүний айраг бэлтгэгч тушаах даалгавараа өмөн бригадынхаа нийт адуучидын хамгийн түрүүнд биелүүлж малын тэжээлд зориулж 150 литр айраг бэлтгэнэ адуугаа дундаас дээш тараг хүч авхуулсан байна.

Говийн мэдээ сонин

Зураг дээр адуучин О.Гомбодорж

Гэрэл зурагчин Ч.Цэндоо

- 33.** Тэргүүний ямаачин Пунцагдаржаа // Говийн мэдээ.- 1966 оны 11-р сарын 24.- №87.- 1-р нүүр.

Тэргүүний ямаачин Пунцагдаржаа

Сэврэй сумын “Социализмийн зам” нэгдлийн Тэргүүний ямаачин Пунцагдаржаагийнх энэ жилийн өвөлжилтийн бэлтгэлийг сайн хангаад тохитой өвөлжиж байна.



Зургийг Ч.Цэндоо

- 34.** Зөвөлгөөнд шалгарсан ямаачин // Говийн мэдээ.- 1966 оны 11-р сарын 21.- №86.- 2-р нүүр.

Зөвөлгөөнд шалгарсан ямаачин

Говь нутагт алдартай нэмэгт, гэлбэнт, сэврэйн сүрлэг уулын цармаар үе улиран нутаглаж ямаа маллах

ашиг шимийг нь авч ашиглах талаар үлэмж туршлага хуримтлуулсан малчны нэг бол Сэврэй сумын социализмын зам нэгдлийн Сайн шанд бригадын ямаачин А.Санж юм. Тэрээр ярихдаа би нийгмийн олон зуун ямаан сүргийг 8 жил дараалан маллаж ирлээ. Тэгэхдээ



ноос, үс, сааль сүү, төлий нь бараг дутааж үзээгүй. Харин сүүлийн хэдэн жил манай нутагт ган зуд болж малчин бидэнд байгалийн нэлээд бэрхшээл тулгарсан юм. Гэвч тэр бэрхшээлийг нам засгийнхаа хайр ивээлээр мал сүрэгтээ осол эндэгдэл багатай давлаа. Харин өнөө жил оройхон боловч ган тайлж мал сүрэг маань тарга хүч сайн авч өвөл хаврын улиралд айлтгүй боллоо. Одоо малчин бидний гол зорилт бол намынхаа 15-р их хурлын шийдвэр 4-р таван жилийн төлөвлөгөөнд тавьж байгаа зорилтыг биелүүлэхэд л бүх бололцоогоо дайчлан нам засгийнхаа ачийг тусаар хариулах болж байна. Би ч нэг их арга туршлагатай сайн малчин хүн биш дээ. Гэхдээ яахав түмний тус олны дэмжлэгээр нутаг усандаа тийм ч доогуур ажиллагаатай малчны тоонд ордоггүй юм.

Ямааны ноолуурыг хугацаанд нь хаяагдалгүй авч нэгдлээс өгсөн даавгаврыг биелүүлэхийн тулд хавар ноолуурын самналтын үе эхлэхтэй зэрэг ямар ямааны ноолуур илүү хөөрч байгааг сайн ажиж хөндийрсөнийг нь дахин самнахгүйн тулд сайн самнадаг. Ямааг дахин дахин самнах нь тэнхэл тамирт муу байдаг юм. Ямааг ноос ноолуурыг нь бүрэн авсны дараа худгийн хүйтэн усаар өдөр бүр угааж байвал үс хялгас нь түргэн ургаж тарга хүч авахдаа илүү байдаг. Нөгөө талаар хүйтэн усаар угааж шүршиж байсан ямаа гэнтийн хүйтэн бороонд бээрч даарах нь бага байдаг юм. Эднийх өнөө жил сууриараа 570-аад ямаа маллаж ямаа бүрээс 260гр ноолуур авах даалгавраа давуулж суурийнхаа хэмжээгээр 27кг ноолуур илүү авч бүх ноолуурынхаа 80 хувийг 1-р зэрэгт тушаажээ. Ямаачин А. Санжийнх Түймэрт гэдэг өвөлжөөнд 10 жил дараалан өвөлжиж өвөлжөөгөө сайн тохижуулжээ.

Энэ суурь өнөө жил нийгмийн 393 ямаа төллүүлэх бөгөөд өвөлд сайн базааж өвс 20 тн гаруй таанаа зоодой

100 ш, шимт тэжээл 60 кг-ийг зун намрын таатай нөхцөлд өвөлжөөндөө нөөцлөн татжээ. Ямаачин А.Санж түрүү отор нүүдэлд гэр бараагаа хөнглөн гарч зөөлөнгийн ар дагаж 12 удаа нүүдэл хийж 600 шахам ямаандаа тарга хүч авхуулсан байна. Одоо удахгүй болох Аймгийн Хөдөө аж ахуйн тэргүүний сайчуудын зөвөлгөөнд ямаачин А.Санж зочилон ирж ямаа малладаг арга туршлагаа ч ярина. Ажил амьдрал нэгт сайчуудаасаа ихийг ч сонсож мэднэ.

Зураг дээр: Сэврэй нутгийн тэргүүний ямаачин А.Санж
Зургийг Ч.Цэндоо

35. Ямаачин Дорж // Говийн мэдээ.- 1966 оны
11-р сарын 24.- №87.- 3-р нүүр.

Ямаачин Дорж

Ямаачин Дорж нутаг усандаа тэргүүний малчин гэж нэрлэгддэг нь аргагүй юм. Эднийх 7 жил дараалан нийгмийн олон зуун ямаан сүрэг маллаж үлэмж туршлага хуримтлуулсан төдийгүй жил дараалан ноос, сүүний даалгаврыг давуулж төлийг нь бүрэн бойжуулж ирсэн билээ. Ямаачин Доржийнх өнөө жил 400 гаруй ямаа төллүүлэх бөгөөд өвөлжилтийн бэлтгэлээ бүрэн хангаж нэг тоон гаруй өвс түүж түүнийгээ өвөлжөөндөө татаж Гүлжингийн ихэр хэмээх бууцанд тохилог өвөлжиж байна.



Зураг дээр: Сэврэй сумын социализмын зам нэгдлийн Сайран бригадын ямаачин Дорж
Гэрэл зурагчин Ч.Цэндоо

- 36.** Ямаачин Дугар, тэмээчин Чулуунхүү нар // Говийн мэдээ.- 1966 оны 12-р сарын01.- №90.- 3-р нүүр.

Ямаачин Дугар, тэмээчин Чулуунхүү нар

Ханбогд сумын “Галбын хөгжил” нэгдлийн тэмээчин МХЗЭ төв хорооны алтан медалт улсын аварга төлчин Чулуунхүү Ханхонгор сумын “Өлзийт” нэгдлийн тэргүүний ямаачин Дугар нар ажил бүтээлээрээ шалгарч аймгийн хөдөө аж ахуйн тэргүүний сайчуудын зөвөлгөөнд оролцоонд арвин их туршлагатай буцацгаав.



Зураг дээр: Баруун гараас ямаачин Дугар, тэмээчин Чулуунхүү нар Гэрэл зурагчин Ч.Цэндоо

- 37.** Говийн мэдээ.- 1966 оны 12-р сарын 1.- №90.- 4-р нүүр.



Говийн мэдээ сонин

Зураг дээр: Баруун гараас Цогтцэций сумын “Их шанхай” нэгдлийн тэргүүний хоньчин Найдан, Мандал-Овоо сумын “Хөдөлмөр” нэгдлийн тэмээчин БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар Жижээ, Номгон сумын “Сангийн далай” нэгдлийн тэмээчин БНМАУ-ын Ардын их хурлын Депутат Гомбосүрэн нар зөвөлгөөний завсарлагаагаар туршлагаа ярилцаж байна.

Гэрэл зурагчин Ч.Цэндоо

38. Тэмээчин Чүлтэм // Говийн мэдээ. - 1966 оны 12-р сарын 1. - №90. - 4-р нүүр.

Тэмээчин Чүлтэм



Даланзадгад сумын “Гэрэлт Зам” нэгдлийн тэмээчин Чүлтэм гуай хэдийгээр нийгэмд хөдөлмөрлөх нас хэтэрсэн боловч улсдаа ихийг бүтээхийн төлөө 1963 онд нийгмийн зуугаад тэмээн сүрэн хүлээн аваад мал маллагаандаа амжилт олж яваа малчин юм. Тэрээр 1963 оноос хойш жил бүр 18-37 ингэ ботоглуулж төлий нь бүрэн бойжуулж саалийн ингэ бүрээс 90-96 литр сүү ашиглаж тэмээ бүрээс 4820-5320 гр ноос ашиглажээ. Ийнхүү Чүлтэм гуай ажил хөдөлмөрөөрөө шалгарч Аймгийн Хөдөө аж ахуйн тэргүүний сайчуудын зөвлөлгөөнд оролцож ахмад малчны хувьд үнтэй зөвөлгөөнөө өглөө.

39. Говийн мэдээ. - 1966 оны 12-р сарын 12. - №92. - 1-р нүүр.

Говийн мэдээ сонин



Баруун гараас Цогт-Овоо сумын “Жаргалант” нэгдлийн тэмээчин Дашцэрэн Манлай сумын “Хоёр өлзийт” нэгдлийн тэмээчин ардын их хурлын Депутат Содов, Цогтцэций сумын “Их шанхай” нэгдлийн ямаачин Жамъяншарав нар туршлага ярилцаж байна. Эд нар хөдөлмөр бүтээлээрээ шалгарч аймгийн ХАА-ийн Тэргүүний сайчуудын туршлага солилцох зөвөлгөөнд оролцсон юм.

Гэрэл зургийг Ч.Цэндоо

40. Хоньчин Мисрэн // Говийн мэдээ.- 1966 оны 12-р сарын 12.- №92.- 3-р нүүр.

Хоньчин Мисрэн

Манлай сумын “Хоёр өлзийт” нэгдлийн гишүүн Мисрэн гуай ажил бүтээлээрээ нэрд гарч яваа хоньчин юм. Тэрээр сүүлийн хоёр жил хонин сүрэг маллаж 1966 онд 195 хониноос 195 хурга бойжуулж хонь бүрээс 1822гр ноос ашиглаж нэгдэлдээ 20 гаруй кг ноос илүү тушаасан байна. “Хоёр өлзийт” нэгдлийн гишүүн Мисрэн гуайн зүтгэлийг үнэлж саяхан Даланзадгад хотод болсон



Аймгийн ХАА тэргүүний сайчуудын зөвөлгөөнд оролцуулжээ. Хоньчин Мисрэн гуай одоо Аймгийн ХАА тэргүүний сайчуудын зөвөлгөөнөөс гарсан уриалгийг биелүүлж хонин

Говийн мэдээ сонин

сүргээ онд бүрэн оруулахын төлөө чармайн ажиллаж байна.

Зураг дээр: хоньчин Мисрэнгийн суурь
Зурагчин Ч. Цэндоо

41. Хоньчин Д. Аюурзана // Говийн мэдээ.- 1966 оны
12-р сарын 16.- №93.- 4-р нүүр.

Хоньчин Д. Аюурзана

Булган сумын “Туяа” нэгдлийн хоньчин Д.Аюурзана, мал маллах, төл бойжуулах, сүү, ноос ашиглах талаараа нэрд гарч яваа малчин юм. Хоньчин




Д.Аюурзана энэ онд саалийн эм хонь бүрээс 14 литр сүү сааж хариуцан маллаж байгаа хонь бүрээсээ дунджаар 1770 гр ноос авч сүү ноос ашиглах үйлдвэрлэлийн даалгавраа давуулжээ.

Хоньчин Д.Аюурзана ийнхүү хөдөлмөрөөрөө нутгийнхаа хоньчидын дотроос шалгарч саяхан болж өнгөрсөн Аймгийн ХАА тэргүүний сайчуудын туршлага солилцох зөвөлгөөнд оролцов.

Зураг дээр: хоньчин Д. Аюурзана

42. Говийн мэдээ.- 1967 оны 4-р сарын 3.- №26.- 2-р нүүр.



Сэврэй сумын «Социализмын ам» нэгдлийн тэмээчин Дарамбаазарынх энэ жил сууриараа 68 ингэ бутголуулах бөгөөд одоогийн гараад байгаа бутгонууд нь сайхан боджиж байна. Зураг дээр тус суурийнхан сая гарсан бутго амлуулж буйгаа нь.
Манай сураалжлагчийн авсан гэрэл зураг

43. Говийн мэдээ.- 1967 оны 4-р сарын 3.- №26.- 3-р нүүр.



44. Говийн мэдээ.- 1967 оны 4-р сарын 3.- №26.- 3-р нүүр.



Хүрмэн сумын «Сүхбаатарын зөм» үзгдлийн тэргүүний ямаачин Нямзуу, мал сүргээ тогтмал тэмдэг тарган тавтай хаваржиж байна. ЗУРАГ ДЭЭР: Ямаачин Нямзуу.
Манай идэвхтэй сурвалжлагчийн авсан гэрэл зураг.

45. Говийн мэдээ.- 1967 оны.- 4-р сарын 6.- №27.- 3-р нүүр.



Тус аймгийн хэмжээгээр өнөө жил дон монголын эрлийз ишиг 10000 шахныг хүлээн авах бөгөөд тус аймгийн Булган, Баяндалай, Сэврэй зэрэг олон суманд дээрх эрлийз төлийг хүлээн авч байна. ЗУРАГ ДЭЭР: Булган сумын «Туня» нэгдлийн дарга Отгончулуун ямаачин Норов нар өнөө жилийн хүлээн авч буй эрлийз ишигний талаар ярилцаж байна.

Манай сурвалжлагчийн авсан гэрэл зураг

46. Говийн мэдээ.- 1967 оны.- 4-р сарын 6.- №27.- 3-р нүүр.

Ямаачин Аюуш

Хурмэн сумын «Сүхбаатарын зам» нэгдлийн Тулгат бригадын нутаг Тулгын булаг хэмээх газарт тус бригадын ямаачин эмгэн Аюушийнх тавтай хаваржиж байна. Аюуш гуай, 1956 онд энэ нэгдлийг байгуулагдахад гишүүнээр орж, түүнээс хойш нэгдэл нийгэмдээ хүчин зүтгэж байгаа хүн юм.

Аюуш гуай: Би анх нэгдэлд ороходоо өндөр настай над шиг хүнч юу л бүтээх вэ дээ гэж боддог байлаа.

Гэвч нэгдэл маань ямаа маллуулъя гэ-

хэд тун баяртай хүлээн аваад одоо 11 дэх жилдээ нэгдлийн ямаа маллаж байна.

Би ер нь мал маллаж л байвал сэтгэл тэнүүн байдаг хүндээ гэв. Аюуш гуай энэ жил 110 ямаа маллаж одоогоор 50 ямаа ишиглэж төл нь бүрэн бойжиж байна.

Насан өндөр болсон боловч нэгдэл нийгэмдээ ихийг бүтээж байгаа жирийн нэгэн ямаачин эмгэний ажил бүтээл манай залуу үед хөдөлмөрч үлгэр дууриал болж байна.

Н.Бүүвэй

47. Адуучин Ц.Халтар Өвгөн // Говийн мэдээ.- 1967 оны.- 5-р сарын 18.- №38.- 2-р нүүр.

Адуучин Ц.Халтар Өвгөн



Номгон сумын „Сангийн далай“ нэгдлийн Эмгэн булаг бригадын адуучин, МХЗЭ-ийн гишүүн Ц.Халтар-өвгөн 10 гаруй жил адуу маллаж төлөвлөгөөт даалгавараа жил дараалан биелүүлж иржээ. Энэ онд нийгмийн 450 гаруй адуу хариуцан маллаж хялгасны төлөвлөгөөг хугацаанд нь 104 хувиар биелүүлэв.

Адуучин Ц.Халтар-Өвгөн одоо Октябрийн их хувьсгалын 50 жилийн ой, нэгдэлчдийн 31 их хурлыг өрнүүн амжилтаар угтахар чармайн ажиллаж байна.

48. Ямаачин Ж.Буянтогтох // Говийн мэдээ.- 1967 оны.- 5-р сарын 22.- №39.- 1-р нүүр.

Ямаачин Ж.Буянтогтох



49. Уураг ихтэй тэжээл // Говийн мэдээ.- 1969 оны 1-р сарын 13.- №4.- 4-р нүүр.

Уураг ихтэй тэжээл

Малын төрөл бүрийн тэжээлүүд дотроос хамгийн шим сайтай тэжээлийн нэг бол эрүүл малын цэвэр цус юм. Мал аж ахуйн практик ажиллагаанаас үзэхэд цусыг янз бүрийн аргаар боловсруулан малын тэжээл болгон хэрэглэж ирсэн уламжлал байна. Манай ахуйн нөхцөлд цусыг хатааж агшаасан ба хэвийн шингэн байдлаар хэрэглэж болно. Хүйтэн сэрүүн улиралд цусыг авч удаан хугацаагаар хадгалах бололцоотой юм. Ийм учраас одоогийн улирлын байдал бол малыг сайн тэжээх цаг үе нь мөн учраас цэвэр цусаар сайн чанарын тэжээл бэлтгэж боловсруулах нь зүйтэй юм. Цусыг хатаахдаа

төмөр тэвшинд нимгэн нялж хатаагаад дараа нь нунтаглана. Мөн цусыг уусдаггүй болгох арга бол бүлэгнүүлэн бяслаг шиг шахаж хатаагаад нунтаглахад уусдаггүй чанар сайтай болно. Хатаасан цус бол уургаар маш элбэг байдаг.

Жишээ нь: Цусны 74 % нь шингэц сайтай уураг байдаг байна. Нэг кг цус бэлчээрийн өвснөөс 10-15 дахин уурагтай юм. Мөн цусыг шингэнээр нь малд уулгах журмаар тэжээж болно. Тэрчлэн 10кг цусанд 100грамм хоолны давс хольж, хагас борлуулан нунтагласан цусыг хивэгтэй найруулж, ядарч доройтсон малд өгч байвал сайн тэжээл болно. Малын цусыг авахдаа эрүүл ба эрүүл бусыг нь сайн шалгаж үзсэний үндсэн дээр авч хэрэглэх нь зүйтэй юм.

50. Ажилаараа шалгарсан бүсгүй // Говийн мэдээ.-
1969 оны 1-р сарын 16.- №5.- 3-р нүүр.

Ажилаараа шалгарсан бүсгүй

Мандал-Овоо сумын бага сургуулийг 1954 онд төгсөөд хөдөө нутагтаа очиж байгаа 14 настай цовоо сэргэлэн охин Адъяадорж: Би хөдөө гарч мал маллана



гэхэд эх нь охин минь мал маллана гэдэг тийм ч хялбар ажил биш шүү дээ гэхэд яахав мал маллах сайхан миний сонирхож байгаа ажил энэ гэж хариулжээ. Ингээд Дэжээгийн өргөмөл охин Адъяадоржийн хүсэл биелэж малчин болхоор зорьжээ. Дэжээгийнхэн 1954 онд нэгдэлд элсэн ороод Адъяадорж хоньчин болж анхны гурван жил нэгдлийн

400-500 хонь, 1958-1967 он хүртэл ямаа маллаж 1968 онд өөрийн хүсэлтээр тэмээ маллажээ. Хана, Цохиогийн

хэц, Халзан, Цахирийн уудам тэнэгэр бэлчээрт тэмээн сүрэг багшран идээшиж түүний дэргэд Адъяадорж говийн өндрөө дуулан явна.

Адъяадорж сайн тэмээчин болохын тулд олон удаа отор нүүдэл хийсний үр дүнд 28 ингэнээс 28 ботго бойжуулж ноос сүүний үйлдвэрлэлийн даалгаврыг 114-160 хувиар биелүүлсэн сайхан амжилт анх удаа түүний нэрийг алдаршуулжээ. Тэмээчин Адъяадорж 1968 онд 1200 литр сүү тушаахаас 1903 литр сүү тушааж ноос өвс шимт тэжээл бэлтгэх үйлдвэрлэлийн даалгавруудыг хугацаанд нь давуулан биелүүлсэн. Тэмээг өвөл уул толгодын нөмөр хонхорт, говь цагаалж жигд газраар зун намар гашуун шаваг таана багалуур, бут модлог ургамалтай газар маллавал тарга хүч сайн авдаг. Би

БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Жижээ гуайн туршлагыг бүрэн эзэмшхээр зорилт тавин ажиллаж байна гэж Мандал-Овоо сумын Хөдөлмөр нэгдлийн Баянхошуу Бригадын Тэргүүний тэмээчин Адъяадорж ярилаа.

Ж.Бадам

51. Аймгийн ХАА-н аваргууд шалгарсан // Говийн мэдээ.- 1969 оны 3-р сарын 3.- №17.- 2-р нүүр.

Аймгийн ХАА-н аваргууд шалгарсан

Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны хурал болж нутгийн үүлдэрийн эм хонь бүрт 21 кг эр хурганд 27,7 кг тарга хүч нэмэгдүүлж 100 эхээс 110 төл бойжуулсан Цогтцэций сумын Их шанхай нэгдлийн Билгэх бригадын хоньчин Ц.Ууш, 68 ингэнээс 68 ботго бойжуулсан Номгон сумын сангийн далай нэгдлийн Дэрсэн ус бригадын тэмээчин Д.Пүрэв 150 ямаа нэг бүрээс 30,1 литр сүү саасан Булган сумын “Туяа” нэгдлийн Хавцгайт бригадын ямаачин А. Долгор нутгийн үүлдрийн 230 эр төлөг нэг бүрээс 1,5кг ноос ашигласан,

Ноён сумын “Гучин таван жил” нэгдлийн сайран бригадын хоньчин Аймгийн АДХ-ын депутат В.Пүрэв Донын эрлийз 415 эм ямаа нэг бүрээс 0,460 гр ноолуур ашигласан Булган сумын “Туяа” нэгдлийн хавцгайт бригадын ямаачин

З.Ламжав нутгийн үүлдрийн 360 эм ямаа бүрээс 0,360 гр ноолуур ашигласан Цогцэций сумын “Их шанхай” нэгдлийн Сийрст бригадын ямаачин И. Хамбаа нарыг Аймгийн ХА-н 1968 оны аваргаар шалгаруулж Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны диплом мөнгөн шагналаар шагнав.

Б.Лувсанж

52. Адуучин эмэгтэй // Говийн мэдээ.- 1969 оны 3-р сарын 7.- №18.- 2-р нүүр.

Адуучин эмэгтэй

А Д У У Ч И Н Э М Э Г Т Э И

(Тэмдэглэл)

Манай говийн хүүхдүүд үнэхээр ажилсаг. Тэдний дунд нэртэй сайн тэмээчин хоньчин ямаачин ч бий. Ухирчин адуучин ч бий. Эдний нэг нь Булган сумын «Туяа» нэгдлийн Дэн бригадын адуучин МХЗЭ-ийн гишүүн, МАХН-ын орлогч гишүүн аймгийн депутат эмэгтэй, Даржаагийн Равжир юм.

— Тэрээр сүүлийн 8 жил нийгмийн адуун сүрэг хариучин маллажадуу маллах ашиг шимийг нь нэмэгдүүлэх талаар багагүй туршлага хуримтуулж чадсаанаараа алар нуутай ахмад адуучидаас дутахгүй хашир адуучны нэг болжээ. Равжир адууны ус бэлчээрийг зөв тохируулж байгнын хариуцагч маллагчид байлгаж жил бүр тарга хүч сайн авахуулж байгаагаас адууны нь ашиг шим нь сайжирч оид бүрэн мэнд орж байна.

Эднийх 1968 онд 700 гаруй адуу маллаж хөөвөр хялгасны төлөвлөгөөг 100,4-101,5 хүндр биелүүлж 60 гүүнээс 60 унага бойжуулан авч зун адуундаа отроор тарга хүч сайн авахуулжээ.

— Адуучин эмэгтэй Равжир ярихдаа: “Адуу таргалах үед өдөрт нэг хоёр удаа эргэн үзэж адууг тогтвортой байлгах нь унагыг гарзгүй бойжуулах үндэс болдог. Мөн адууны савь гомьд 7 дугаар сарын нэгнээс 10 дугаар сарын нэгэн хүртэл элбэгддэг тул энэ үед л унагыг уах хэрэгтэй. Зуншлага сайн байвал унагыг эрхтэн барих хэрэгтэй. Гүүг өгтөөр цагаас эхлэн хураагаад өдөрт 4—5 удаа сайж оройн 21 цагаас хэтрүүлэхгүй тавьж унагыг сайн услана. Эхлэх нь савхгүй ч байсан унага бүрийг заавал уух нь унага номхорч цанашлаа эвчлээгээ саалинд сургахаа номхон, бие балдар чийрэг, үе хялгас нь арвин адуу болдог. Манайх 1938 онд адуугаа тарга хүч сайн авахуулсан. 1969 онд нэгч адуу хорголдуулаггүй авч илж адууны савь, дэл, сунд хөөврийн төлөвлөгөөг 100-105 хүндр биелүүлж төлийг бүрэн бойжуулах зорилготой байна гэж ярихад.

Равжир 1968 онд 34 гүүт саалинд сургасан бөгөөд Равжийн нөхөр МХЗЭ-ийн гишүүн Сэд 40 адууг уналга эвчлэгэнд сургажээ.”

Д. Хүүхэнгаа

53. Таван ханатын эзэн // Говийн мэдээ.- 1969 оны 4-р сарын 7.- №26.- 2-р нүүр.

Таван ханатын эзэн



БНМАУ-ын аварга толчин Г. Өлзий

Тэмээчин Өлзий Ханхонгор сумын “Мандах” нэгдлийг 1956 онд санаачлан байгуулалцаж 800 гаруй толгой малаа нийгэмчлэн түмэн олонтойгоо хүчээ нэгтгэн хөдөлмөрлөж эхэлжээ.

Тэр цагаас хойш ажил амьдрал нь жилээс жилд өөдлөн дэгжиж нэгдэлч олныхоо дотроос хөдөлмөр бүтээлээрэй алдаршсан тэргүүний тэмээчин болжээ.

Тэрээр олон жил ингэж ярьж байна. Тэмээчин хүний хамгийн эрхэмлэх зүйл бол бэлчээрийг зөв сонгож тогтмол хариулагатай байлгах явдал юм. Өвлийн улиралд говь цагаажтай нөмөр сайтай бэлчээрт зуны улиралд багалуур, таана элбэгтэй бэлчээрийг сонгож тэмээг хариулах нь чухал. Би БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар тэмээчин Жижээ, Гомбосүрэн нарын ингэ нэг бүрээс арвин их сүү саадаг туршлагыг ажилдаа хэргэлснээр сүүлийн 7 жил дараалан үйлвэрлэлийн даалгаврыг 100-150 хувиар биелүүлж ирлээ. Өнгөрөгч жил сууриараа 126 ингэнээс 126 ботго бойжуулж БНМАУ-ын аварга төлчин болсон.

Ботго бойжуулахын тулд эртнээс сайн хангах нь нэн чухал. Ингэ ботголхоос 2 сарын өмнө ботголох ингийн сувиа тэмээнээс ялгаж нам дор газрын бэлчээрт байнгын хариулагатай байлгадаг юм. Ингэснээс ингэний хээл сайн хамгаалдаг. Нөгөөтэйгүүр сувай тэмээнээр хамт байлгавал хээлтэй ингэ ботгоо харамлаад шилрэх

явдал байдаг учраас тусгаарлаж хариулсан ингэ шилэрдэггүй юм. Ингэ ботголсны дараа нялх ботгыг амлуулахын өмнө эхийнх нь хөхийг буцалгасан цэвэр усаар сайн угааж хөхний бөглөөг аваад амлуулбал сайн юм.



Өлзийт суурийн тэмээчин Г.Цэнд Ялангуяа тумай гунж ботгоо хөхүүлэхгүй тийрэх хазах явдал байдаг хэрэв ийм байдал гарвал аргалын утаагаар эхийг нь утаж ботгоноос нь салгахгүй нэг хоног байлгавал ботгоо

голохгүй амархан хөхүүлж сурдаг. Ботгыг эхээс гарсны дараа 10-15 хоног хөлөөс нь уяад дараа нь нэг сар урт уяанаас ногтлон уяж байгаад дараа нь хөгнөж уявал ашигтай байдаг.

Жишээ нь: Ботго хэрж орооцолдохгүй ингэ саахад тэмээ хорих гэж илүү ажил ордоггүй ботгыг өвсөнд орохоор өглөө эрт тавьж идээшлүүлж байвал тарга хүч сайн авдаг. Зуны улиралд ботготой ингийг өдөрт хоёр удаа уславал сүү сайтай ботго нь торнилт хурдан байдаг юм. Ингийг саасныхаа дараа дахин иргэж саавал их сүү сааж болдог. Учир нь бэлчээрт удаан явсан ингэний хөх милчирсэн байдаг учираас анхны саамаар сүү бага гардаг юм.

Ботгыг 5-р сараас эхэлж худаг дээр оруулж дураар нь байлгаж ус уулгаж сургах нь илүү ашигтай, мөн таана, бударгана баглуурын багсармал гүүний цагааг хөмүүлтэй хольж дарш хийх зэрэг говийн шимт ургамалуудыг хүрэлцээтэй бэлтгэж авбал хаварт торомтой ингэ эцэж зутарсан тором тэжээхэд сайн байдаг. Ингэж шаргуу

Говийн мэдээ сонин

хөдөлмөрч ажиллагаагаараа Ханхонгор сумын “Өлзийт” нэгдлийн Г.Өлзий 1967 онд тэмээний сүү ашиглалтын аймгийн аварга болсон бөгөөд 1968 онд сууриараа 126 ингэнээс 126 ботго бойжуулан суурийн ахлагч Г.Өлзий БНМАУ-ын аварга төлчин гэдэг алдар цолыг хүртэж таван ханатай гэрээр шагнуулжээ.

54. Ямаачин И.Хамбаа // Говийн мэдээ.- 1969 оны 5-р сарын 7.- №34.- 1-р нүүр.

Ямаачин И.Хамбаа

Цогтцэций сумын “Их шанхай” нэгдлийн Сийрст бригадын ямаачин, МХЗЭ-ийн Төв Хорооны “Тэргүүний малчин залуу алтан медальт, МХЗЭ-гийн гишүүн И.Хамбаа 1968 онд 360 ямаанаас 30,1 кг ноолуур илүү авч ноолуурын төлөвлөгөөг 128,4 хувиар биелүүсний дотор бүх ноолууринхаа 96 хувийг 1,2-р зэрэгт тушаажээ. Ямаачин Хамбаагийн энэ ажилтыг үнэлж 1968 оны ямааны ноолуурын аймгийн хөдөлмөрийн аваргаар шалгаруулсан байна.



Зураг дээр:

Ямаачин И.Хамбаа

Гэрэл зурагчин:

Ж.Баатарцэрэн

55. Бэлтгэл сайтай суурь // Говийн мэдээ.- 1969 оны 5-р сарын 8.- №35.- 1-р нүүр.


Бэлтгэл сайтай суурь



Мандай сумын «Хоёр-өзгийт» нэгдлийн Өехий бригадын хоньчин, МХЗЭ-ийн гишүүн .Оргодо 114 каракуль хонь төлдүүлж төлийн нь бүрэн бойжуулж байна.
Зураг дээр; Оргодоа хурганд өвс өгч байгаа нь.

56. Хоньчин А.Цэвээнчимэд // Говийн мэдээ.- 1969 оны 7-р сарын 17.- №53.- 1-р нүүр.

Хоньчин А.Цэвээнчимэд



Булган сумын «Туяа» нэгдлийн Дэн бригадын хоньчин А.Цэвээнчимэд сүүлийн 3—4 жилд хонины уртын ноос бэлтгэлийн төлөвлөгөөг тогтмол биелүүлж иржээ. Энэ жил 84 кг уртын ноос илүү тушаасан.
Зураг дээр: А.Цэвээнчимэд ховно хяргаж байгаа нь

Гэрэл зургийг Ц.Ханд

57. Бэлтгэл сайтай суурь // Говийн мэдээ.- 1969 оны
11-р сарын 13.- №83.- 1-р нүүр.

Бэлтгэл сайтай суурь

Булган сумын “Туяа” нэгдлийн 3-р бригадын ямаачин Жамбалдавгынх сүүлийн 10 жил нийгмийн эрлийз ямаан сүрэг маллаж үлэмж туршлагажсан малчных юм.

Эднийх хөдөө аж ахуйд нэгдэлжих хөдөлгөөн ялсны 10 жилийг ойг угтаж өнөө жил нэгдлийн үйлвэрлэлийн даалгавраар өгөгдсөн ноос ноолуур сүүн үйлдвэрлэлийн даалгавруудыг хугацаанд нь төрөл бүр дээр давуулан биелүүлжээ. Мөн өвлийн ба төлийн бэлтгэлээ урин дулаан улиралд бүрэн хангаж өвс нэг тонн, таана зоодой 700 ш бэлтгэж 8 жил дараалан өвөлжсөн Баян гэдэг өвөлжөөндөө хийвэл зохих бүх бэлтгэлийг сайн хийж хариуцсан 430 ямаан сүрэг дундаас дээш тарга хүч авахуулсан байна. Эдний суурьт өнөө жил 300 ямаа төллөх учир төл хүлээж авах бэлтгэлээ сайн хангаж байгаа амжилтаар хөдөө аж ахуйд нэгдэлжих хөдөлгөөн ялсны 10 жилийн ой угтаж байгаа билээ.



Зураг дээр: ямаачин
Жамбалдагвын гэргий Бадам

58. Галба нутгаас төрсөн аваргууд // Говийн мэдээ.-
1970 оны 2-р сарын 5.- №10.- 1-р нүүр.

Галба нутгаас төрсөн аваргууд

Ханбогд сумын “Галбын хөгжил” нэгдлийн хоньчин Жамбал сүүлийн 5 жил дараалан хариуцсан хониныхоо төлийг 105,2-147,5 хувиар бойжуулж хонин сүргээ 102-109 хувиар өсгөж, ноос сүүний төлөвлөгөөг 100,7-109 хувиар биелүүлж ирсэн байна. Хоньчин Жамбал хариуцсан хонио бэлчээрийн сайныг дагуулан оторлож тарга хүч авахуулдаг заншилтай учир хонины нь дундаж жин 63 кг хурганы нь дундаж жин 33 кг-д хүрдэг байна. Өнгөрсөн жил хоньчин Жамбал 329 бойжуулж ноос, сүү ашиглалт, хадлан бэлтгэх зэрэг ажлаараа шалгарч БНМАУ-н аварга төлчин болзлыг биелүүлж улсын аварга төлчин диплом, медаль бүрэн хэрэглэлтэй 5 ханатай гэр 1000 төгрөгөөр шагнагдав. Далантайн Тангадыг энэ жил 54 нас хүрлээ гэхэд зарим хүмүүс үнэмшихгүй ч байж магад. Галба нутагт анх 1956 онд ХАА-н нэгдэл байгуулахад ууган гишүүнээр нь элсэж тулгын гурван чулууг тулалцсан энэ хүн өнөөдөр удмын аварга төлчины болзол биелүүлж 5 ханатай өргөө цагаан гэрт тухлан сууж сар шинийн баяраа сэтгэл дүүрэн тэмдэглэж байгаа нь эргэлзээгүй.

Үхэрчин тангад сүүлийн 4 жил дараалан үхэр өсгөх төлөвлөгөөг 100-100,9 хувиар биелүүлж 294 үнээнээс 294 тугал бойжуулж саалийн төлөвлөгөөг 100-116,5 хувиар биелүүлсэн байна. Ажилч хичээнгүй зүтгэлээрээ алдаршсан энэ үхэрчин БНМАУ-н аварга төлчны энэ болзлыг 2 жил дараалан хангаж у 1969 оны улсын аварга төлчний диплом, медаль, бүрэн хэрэглэлтэй 5 ханатай гэр 1000 төгрөгөөр саяхан шагнагдлаа.

/Т.Бойцонхүү/

59. Тэмээчин Д.Балжинням // Говийн мэдээ.- 1970 оны 2-р сарын 19.- №14.- 3-р нүүр.

Тэмээчин Д.Балжинням

Булан сумын “Туяа ” нэгдлийн Дал бригадын тэмээчин Д.Балжинням 1963 онд анх ботголох 75 ингэ хүлээн авч маллаад 75 ботго бойжуулж үйлдвэрлэлийн бусад бүх даалгаварыг биелүүлж иржээ. Одоо эдний 253 тэмээний 90 шахам нь ингэ бөгөөд 1969 онд 25-ыг ботголуулж 23 гунжин ингэ саалинд, 36 тэмээг уналганд сургаж, үйлдвэрлэлийн даалгавраас ноос 53кг, сүү 25литрийг илүү тушаажээ.

Эднийх зун намарт ус, говь, бэлчээр сайтай газраар олон удаа нүүдлэн тэмээгээ байнгын хариуллагатай байлгаж дээд зэргийн тарга авахуулж үс ноосыг нь сайн ургуулж 3 дугаар сарын 15-наас эхлэн эр ноосыг авч хүзүү их биеийг шууж хяргаад 4 мөчний ноосыг бүрэн ашиглаж, жил бүр ноосоо давуулдгаас 1969 онд тэмээний ноос ашиглалтын аймгийн аварга болжээ. Ингэ ботголж эхэлмэгц ботгоо давс, шар тостой бараан цайгаар амлуулан уургий нь хөхүүлж 7-8 хоног уясны дараа эхлээр тавьж 5 дугаар сард дахин уяж ботгоо сайн махалмагц ингээ сааж эхэлдэг байна. Эднийх одоо зарим тарга хүч муутай тормоо эхтэй нь хамт байлгаж зоодой гүүний цагаа бусад төрөл бүрийн тэжээллээр тэжээж байна. Тэмээчин Д.Балжинням түүхт ойнуудыг угтаж ботгоо бүрэн бойжуулж ноос сүүний үйлдвэрийн даалгаврыг урьд оныхоосоо давуулж биелүүлэн аваргын амжилтаа бататгах зорилготой ажиллаж байна.

/Д.Цэвэгмэд/

60. Ямаачны туршлага // Говийн мэдээ.- 1970 оны 3-р сарын 5.- №18.- 3-р нүүр.

Ямаачны туршлага

Цогтцэций сумын “их шанхай ” нэгдлийн сийрст бригадын ямаачин Идэрийнх 1957 онд анх нэгдэлд орж 13 жил төллөх ямаа хариуцан маллаж байна. Энэ хугацаанд ямааны ашиг шим ашиглалт, төл бойжуулалтаар нэгдэлдээ нэртэй ямаачин болжээ. Эднийх өвлийн цагт цастай гэж найдахгүйгээр малыг байнга ус хужраар хангадгаас мал нь хөрч даарч зутардаггүй байна. Түүнчлэн хүйтэн салхи шуургатай буюу өглөө эртийн жавартайд хот хороондоо утаа тавихад утааны үнэрээр тургих, хөлөөрөө газар цавчлах суниах зэргээр малын бие нь тавирч дулаацдаг учир энэ нь нилээд сайн арга юм. Гэхдээ их утааны хэрэггүй гэнэ. Мөн их хүйтэн салхи шуургатай өдөр ямааг салхи сөргөөж бэлчээхэд амархан зутраадаг. Иймд салхины ташуу бэлчээн тогтоож хариулаад орой нь мөн салхи ташуулж хотлуулахад зутралт бага байдаг гэж ярьж байна.

Идэрийнх малын тэжээл бэлтгэхдээ хомоол, зоодой, сондуул, өвс, хужир, хивэг, гоёо, овъёос, төрлийн нарийн холимог тэжээл гэх зэрэг 5-9 төрлийн тэжээлийг бэлтгэж хэрэглэдэг байна. Төлийн нарийн холимог тэжээлдээ багалуур, бударгана, таана хөмүүл бусад нарийн өвсийг бэлтгэдэг ажээ. Эдгээр тэжээлээ хадаж авсаны дараа хольж саравч пүнзнийхээ сүүдэрт хатаагаад хурааж авдаг ба энэ нь шимт чанараараа сайн, ямар ч мал дуртай идэх, тэр дундаа төлд хамгийн тохиромжтой сайн тэжээл болдог байна. Сондуулын хандаар эцэж доройтсон малыг тэжээдэг бөгөөд энэ тэжээлийг бэлтгэхдээ сондуулын ил байгаа салмайтай хэсгийг авч хэрчиж жижиглээд барагцаалбал 10 литр усанд 1кг хиртэйг хийж чансаны дараа шүүж шүүсээ боллоцгоо байвал сүү айрагны аль нэгтэй нь хольж өгдөг

байна. Ямааг төллөх үед нь төллөсөн төллөөгүй ямаа хонь гэж хэсэгчилж бэлчээрт гаргадаг ба 2 пүнзтэй ба 3 хороог ашигладаг. Хоёр пүнзний нэгэнд нь тэжээлээ төрөлжүүлж хураагаад нөгөө пүнзэнд нь 35-40 см өндөртэй, урт нь 2 м өргөн нь 1 метрийн хэмжээтэй хэд хэдэн жижиг хашлагнуудыг хөх хорголоор дэвсгэрлэж дээд талыг нь хана буюу бусад төмөр модоор дамнуурга хийж дээр нь цонх гаргаж бүрээсээр бүтээгээд цас шуургатай өдөрт нялх ишигээ хийдэг байна.

Ийм намхан хашлаганд хэдэн ч ишиг хийсэн бие бие нь дээрээ гарч дарагдах аюул гардаггүй ажээ. Ямаачин Идэр ярихдаа ямааг төллөж ишигээ долоосны дараа хуурай өвс бууц аль нэгээр нь нойтон үсийг нь эгштэл үрж дулаацуулсны дараа хөл дээрээ тэнцэх хүртэл бараг 30 минут болдог. Энэ үед эхийн уураг сүүгээр цадтал нь сайн амлуулаад эхтэй нь хамт хороонд байлгах нь сайн. Ер гарсан дараагаа сайн уураг сүүгээ амалсан ишиг барагтай бол даарч осгохгүй. Ишиг эхлээд борог хоолонд орох үедээ элс шороо долоох дуртай байдаг. Энэ үед нь долооц хужир тавьж өгөх , өвс хорооны гадуур тавьж өгч байгаад орой эхий нь ирэхээр нь хөхүүлээд задгай хороонд хамт хонуулбал сайн байдаг ишиг эрт ч орой ч гарсан заавал чацга алддаг. Гэхдээ орой гарч байгаа хаврын ишиг чацга алдах нь их харин өвөл эрт гарч байгаа ишиг чацга алдах нь бага байдаг. Ерийн чацга биш ямар нэгэн эмгэгийн улмаас алдаж байгаа чацгыг тогтооход нүүрсийг нунтаглаад тунгааж өгөхөд, мөн хөөсөрсөн чацга алдахад тосгүй бүлээн шөл өгөхөд зүгээр болдог гэлээ.

61. Ямаачин Жамъяншарав // Говийн мэдээ.- 1970 оны 3-р сарын 19.- №22.- 2-р нүүр.

Ямаачин Жамъяншарав

Цогтцэций сумын “Их шанхай ” нэгдлийн сийрст бригадын ямаачин Жамъяншарав туршлагатай малчны нэг юм. Эднийх өвлийн ба төлийн бэлтгэлийг хангах үлгэр жишээч бэлтгэдэг. Өвлийн бэлтгэлээ зунаас эхлэн хийдэг бөгөөд зөвхөн энэ жилийн өвлийн бэлтгэлд зориулан 2,4 тонн өвс, 24 шуудай хужир, 11кг гоёо,

140 шуудай хөх бууц, 120 литр айраг, 24 шуудай аргал бэлтгэж авчээ. Ингэж бүх зүйлийг эртнээс бэлтгэх нь ид ажлын дундуур бусад ажилд самгарддаггүй байна. Одоо эднийх өвөөлжөөндөө тэжээлийн 2 ерөөтэй агуулахтай, тэндээ бүдүүн ба хүчит тэжээлийг төрөлжүүлэн хадгалдаг. Бууц нь 3 хос хороотой тэндээ малаа төллөсөн төллөөгүйгээр нь ялгаж хийдэг байна. Ямаачин жамъяншарав ишигийг гарсанаас нь хойш 30 минут болгоод цадтал нь хөхүүлвэл хүйтэнд барагтай даардаггүй. Зарим малчид амлууллахгүй удааснаас болж төл бээрч өвчин тусахад хялбар болгодог гэм бий. Ер нь төлийг онц хүйтэнгүй үед төлийг пүнзэнд оруулаад байх шаардлагагүй, гарсан орчин нөхцөлд нь байлгаж дасгахан илүү сайн. Харин зусаг ямааг бол ишиглэсэн дараад нь ишигтэйн пүнзэнд цөөн цөөнөөр хийх нь ашигтай. Учир нь зусаг ямаа ишигээ голох буюу өөр ишиг авч хөхүүлээд байдаг. Төллөсөн ямааг 1-3 хоног гаднаа байлгаж өвс, ус өгсний дараа бэлчээрт явуулж орой хотлоход нь ишигийг нь хөхүүлээд эхлээр хонуулна. Их хүйтэнд гарсан ишигний үс нь эгшиж завдалгүй хөлддөг.

Иймд ишгийг гарангуут нь хөвсгөр шар хомоолын үнгүүшээр арчихал үс нь амархан хатаж эх нь ч голдоггүй юм. Ишгийг хагас эхлээр бойжуулахад ажил хөнгөн төл нь өсөлт торнилт сайтай. Хорогдох нь бага байдаг. Төлийг байранд үргэлж хийгээд байвал бие нь давжаа болдог. Эх нь муу цатгаж байгаа ишгэнд загсгалын ханд

бэлтгэж угжаар өгч сургах нь сайн байдаг. Энэ хандыг бэлтгэхдээ 10 литр усанд 1кг загсгал хийнэ. Тэгэхдээ навч, мөчир, үндсэний аль нь ч болдог юм. Үүнийгээ буцалгаад өтгөн ханд болмогц нь цэвэрхэн маарлаар шүүж авна.

Түүндээ яльгүй айраг ба сүү хольж өдөрт нэг удаа угжихад сайн тэжээл болдог. Харин 4 дүгээр сарын дунд үеэс хойш өгч болохгүй төлийг бүрэн бойжуулах бас нэг үндэс ямааг бүрэн хээл авхуулж, хээлийг хамгаалах ажил байдаг. Үүний тулд хээлтүүлэгч хээлтэгчийн тохироог сайн тохируулан хангах явдал чухал. Хээлтүүлгийн үед ухна их цангадаг учраас өдөр бүр усал байх хэрэгтэй гэж ярьж байна. Ямаачин Жамъяншарав ингэж уйгагүй чармайн ажлсаны үрээр 1969 онд 329 ямаанаас 366 ишиг бойжуулан 1969 оны энх сүрэгтний болзлыг хангасан ба энэ жилийнхээ төлийг сайн бойжуулж байна.

/Л.Сүхээ, Цэрэнцэцэг/

62. Төл бүрэн бойжиж // Говийн мэдээ.- 1970 оны 3-р сарын 30.- №25.- 3-р нүүр.

Төл бүрэн бойжиж

Сэврэй сумын “Соцлизмын зам” нэгдлийн Хоолт бригадын хэмжээгээр энэ онд төллөвөл зохих бүх бог малын 70 гаруй хувь нь төллөж гарсан төл нь 98,1 хувиар бойжиж байна. Тус бригадын малчин С.Банзрагч, Б.Шарав, Л.Норовсамба улсын аварга төлчин хоньчин Шархүү, Бадамцэрэн, Дамба нарын олон сууриуд төлөө 100 хувиар бойжуулж цалинт дарцгийн болзол хангаад байна. “Соцлизмын зам” нэгдлийн Сайншанд бригадын ямаачин Цэрэн, Дамбадаржаа нарын суурийн төллөх ямааны 72-78,2 нь төллөж гарсан төл нь 100 хувь бойжиж байна. Мөн бригадын тэмээчин Лувсаншарав, Пунцаг

нар ботго торомын уяаг машины хаягдал дугуйг ашиглаж хийжээ.

Нэг ботгоны уяанд дунджаар 300-400 грамм ноос ордог гэтэл машины хаягдал нэг дугуй 30 ботгоны уяа болж байна. Хэрэв 30 ботгоны ноосоор хийвэл 9-12 кг ноос орно. Үүнээс үзэхэд үлэмж хэмжээний ноос хэмнэгдэж байна. Даланзадгад сумын “Гэрэлт зам” нэгдлийн Балгас бригадын хоньчин улсын аварга төлчин Бага төлөө 101 хувиар бойжуулж байна. Ханхонгор сумын Өлзийт нэгдлийн Өгөөмөр бригадын хоньчин ХЗЭ-гийн гишүүн Х.Аюуш 250 гаруй хонь хариуцан маллаж одоо гараад байгаа 120 шахам төлөө бүрэн бойжуулж байна. Мөн нэгдлийн Мандах бригадын ямаачин СХ-ийн бригадын гишүүн Даваагийн 150 ямаанаас 164 ишиг 54 хониноос 58 хурга бойжуулж Лениний мэдэлсний 100 жилийн ойг угтаж байна.

63. Төлчний сууриар // Говийн мэдээ.- 1970 оны 4-р сарын 9.- №28.- 2-р нүүр.

Төлчний сууриар

Ханбогд сумын Галбын хөгжил нэгдлийн Гавилууд бригадын хоньчдын сууриар ороход хаврын уянга болсон төлийн дуу малчдын сэтгэлийг баясгана. Намхан толгодын энгэрт нэгэн тохиолог бууцанд тус бригадын хоньчин Ваанчигийнх малаа төллүүлж тавтай сайхан хаваржиж байна. Их хөрвийн хургууд эхтэйгээ хамт хотондоо нарлан тонгочиж, нял хөрвийн байраар ороход хургыг гарсан хоног, их багаар нь хуваарилан жижигхэн хашаанд тус тус хийсэн нь малчин эзний сайн ажиллагааг харуулна. Хоньчин Ваанчиг гэргий Цэвэлмаатайгаа хамт хотондоо нялх хургануудыг эхэд нь хөхүүлэх, төлийн байр нь гэрэл гэгээ сайтай дулаан, цэвэрхэн хөх бууц зузаалан дэвссэн байв.

Хоньчин Ваанчиг гуайтай ярилцахад: Манайх ам бүл гурвуулаа байдаг. Нийгмийн хонийг 8 жил тасралтгүй маллаж энэ жил 335 хонь төллүүлэхээс одоо 200 гаруй хонь хургалж төл бүрэн, мал тарган, эх нь жилбэ сайтай. Жил жилээс энэ жил илүү сайхан байна. Манайх төлөө хөрвийн аргаар бойжуулж байна. Тэдний гадна төлийн нарийн өвс бусад хүчит ба шим тэжээл, хужир шүү хүрэлцээтэй, хонь, хурагаа тэжээж байна. Ваанчигийнх хургыг эхээс гармагц ам хамрын салиасыг цэвэрлэж эхэд нь хаттал долоолгож, стрептомицин буюу биомицин, эсвэл ренгер зэрэг эмийн уусмалаар амлуулсаны дараа уургийг нь цадтал нь хөхүүлээд нялх хургаа эхтэй нь хамт тусгай байран 24 цаг байлгадаг ажээ. Өвс тэжээлийг тааруулж чадвал төлийн өсөлт нь түргэн бойжилт нь сайн байдаг ажээ. Олоон жил хурга бойжуулж дадлага туршлага суусан хашир хоньчин Ваанчиг гуайг хургыг хагас эхлээр хөрвийн аргаар бойжуулах аргыг сүүлийн 3-4 жилд хэрэглэж нэгч төлийн хорогдолгүй байж болох шилдэг сайн арга мөн гэдгийг амьдрал дээрээ нотлон үзүүлж байна. Тэгээд ч үүний урьд жилүүдэд аймаг сумын аварга хоньчин төлчин болж байсан бол энэ жил улсын аварга төлчний барианд орох боломжтой болж энэ зорилтоо биелүүлэхээр чармайн ажиллаж байна.

Хоньчин Ваанчиг хурга бойжуулахдаа өдөрт 2 удаа тогтмол хөхүүлж, эхтэй нь хамт нөмөр дулаан ээвчинд нарлуулах дулаан шөнө эхтэй нь хамт нөдөө хонуулдаг. Гавилууд бригадад Ваанчигийн жишгээр төлөө бүрэн бойжуулж байгаа БНМАУ аварга төлчин Жамбаа болон хоньчин Тогоо, Равданцэрэн, Сэр-Од, Бямаа, Пүрэв зэрэг олон арван суурийн малын 60-80 хувь нь төллөж төл нь 100 хувь бүрэн бойжиж байна.

Энэ бригадын хэмжээгээр төллөх малтай 15 суурь 5300 гаруй хонь, ямаа төллүүлж 100 хувь эхээс

бойжуулах нь төлийн төлөвлөгөөг давуулан биелүүлэх боломжтой ажиллаж байна. Төл бойжуулах энэ үеэр нийт малчид суурийн хооронд социалист уралдаан өрнүүлж мэдээ судалгаа гарган дүгнэж төлийн штабуудаас мал төллүүлж байгаа өрх сууриар тогтмол явж төлийг тэжээл, эм хэрэглэлээр хэрхэн хангаж байгаа байдалтай танилцаж, заавар зөвөлгөө өгөх, туслах ажлыг сайн зохиож байна.

/Б.Ишжамц/

64. Аваргын бариа ойрхон байна // Говийн мэдээ.- 1970 оны 4-р сарын 16.- №30.- 3-р нүүр.

Аваргын бариа ойрхон байна

Манай бригадад О.Дорж, Х.Аюуш, Д.Цэрэндулам намрын 3 төлчин “ЭНХ ТӨЛЧИН” дарцаг хүлээн авч бригаддаа төл бойжилтоороо тэргүүн байранд яваа. Харин эдний дарцагийг булаацалдах “Мэнд сүрэгтэн ” Гомбоцэрэн гэж нэг сайн хоньчин бий гэж өгөөмөр бригадын дарга Гэлгээ ажлаа танилцуулахдаа хэлсэн юм. Бидний тэргүүний хоньчин Гомбоцэрэнгийн очиход орой хонь хотолж Гомбоцэрэн гэргий Санчир нар хургаа тавьж эхэд нь хөхүүлж байв. Хургыг пингээс бөөнөөр нь зэрэг гаргаж нийлүүлэхэд хэд хэдэн муу тал бий гэнэ.

1-рт пин буюу илүү гэрээс нэг зэрэг бөөнөөр нь гаргахад чихцэлдэж бие биеэ дайрч унагаах буюу гишгэж гэмтээдэг.

2-рт олон хурга зэрэг нийлэхээр эхээ бүрэн олж хөхөж чадахгүй зарим хурга нь эхээ олоогүй байхад зарим нь ихэрлүүлж хөхүүлэх зэргээр самуурдаг.

3-рт аль хурга эхээ сайн хөхөж байгаа аль нь сүүндээ дургүй байгаа зэргийг нарийн ажиглаж

болдоггүй. Ер нь хургыг эхэд нь тавьж өгөөд ажиглаж байхад ямар нэг байдлаар бие нь сулдаж доройтсон бол андашгүй байдаг. Манайх хургаа 50 орчим болхоор нь ялгаж сургадаг хургыг ялгаж сургахгүй барина гэвэл маш их хөдөлмөр цаг зардаг нөгөө талаар хургыг барих гэж үсийг нь урах, цатгалан хургыг тэвэрч гэдсийг шахах муу талтай байдаг учраас заавал олон болгож гүйцэт торниулж ялгаж сурган гэхийн хэрэг байхгүй. Харин хургаа ялгаад хороондоо өвс тавьж өгч нарлуулж, цэвэр агаар дураар нь тонгочуулж байх нь хоолны шингэц сайн, торнилт түргэн байдаг. Одоо гарсан төл маань сайн байна. Хураглаагүй байгаа хониныхоо төлийг бүрэн бойжуулж өнгөрсөн оныхоо амжилтыг хадгална гэж бодож байгаа тайвширах ч яагаачгүй байна. Малчин хүний хамгийн хариуцлагатай мэрийж ажиллах цаг бол хавар байдаг. Гэвч манайх бэлтгэл сайн хангасандаа найдаж байна гэж Гомбоцэрэн ярьж байв.

Өнгөрсөн жил эднийх 370 гаруй хонь хураглуулж төлөө бүрэн бойжуулж сумын аварга төлчин болсон. Өнөө жил 600-гаад хонь маллаж, онд бүрэн мэнд орсон, үүнээс 374 хонь хураглах юм. Одоо 324 нь хургалсан. 334 хурга бойжиж байна. Энэ бүгдээс үзэхэд хоньчин Гомбоцэрэнд аваргын бариа ойрхон байна.

65. Хөдөө аж ахуйн тэргүүн туршлагыг бүтээлчээр нэвтрүүлье // Говийн мэдээ.- 1970 оны 6-р сарын 11.- №46.- 2-р нүүр.

Хөдөө аж ахуйн тэргүүн туршлагыг бүтээлчээр нэвтрүүлье

Хуурай сүү тус аймагт Цэрэнпунцагийн санаачилгаар 1962 онноос эхлээд хуурай сүү бэлтгэх хөдөлгөөн өрнүүлсэн юм. Малын төрлийг харгалзалгүй 10 литр 2 кг шар будаа хийж зөөлөн галаар агштал

чанаад бөөгнөрсөн хэсгийг бутлаад тусгай бэлтгэсэн бандан дээр дэлгэн тавьж сүүдэр газар байлгаж хатаана. Сүүнд чанасан будааг хатаж гүйцмэгц нүдэж нутаглаад цэвэр хүүдий саванд хийж хадгална. Ингэж бэлтгэсэн сүүг 11 сар хүртэл хугацаагаар хадгалж болно. Энэ аргаар хуурай сүү бэлтгэхдээ галыг нь ихдүүлэн түлэх буюу наранд хатааж болохгүй. Ингэж бэлтгэсэн сүүгээ 3 литр усанд 250 гр-аар бодож найруулан төл малд өгөхөд тохиромжтой болно. Цаг уурийн хүнд байдалд байдаг говийн нөхцөлд ийм тэжээлийг бэлтгэж хэрэглэснээр төл мал сүүн тэжээлээр дутагдаж үхэх явдлаас хамгаалах сайн арга болсон билээ.

Ийм учраас 1970 онд ХАА-н үйлдвэрлэлд заавал нэвтрүүлэх туршлагын жагсаалтанд оруулан аймгийн нарийн хорооны товчоогоор баталсан юм. Мал төллүүлэх өрх бүр их хэмжээний сүүн тэжээлийн нөөцтэй байхын тулд зун, намар сүү цагаан идээ элбэг байх үеэс эхлэн хуурай сүү бэлтгэх ажил хийж байхын хамт нэгдлүүдээс бригад суурийн үйлдвэрлэлийн даалгаварт оролцуулан өгч байхын хамт саалийн фермүүдэд нэгдсэн журмаар бэлтгэх нь чухал байна.

Ботгоны төмөр утсан уяа Цогт-Овоо сумын тэмээчин Цэвэг ботгоны төмөр утсан уяа санаачлан хийсэн юм. Хаягдал төмөр утсыг галд улайтган уяраагаад 15 см уртай огтолж, 2 үзүүрийг нь дотгош эргүүлэн нугалж ороогоод үзүүрүүдийг нь ороолтон завсар далдлана. Ингээд гинж бүрийг хооронд нь холбоно. Нэг уяанд 30 орчим гинж орно. Гинжин уяаны 2 үзүүрт 20-30 см сур ба нийтгэсэн дээс байна. Үүний нэг талыг зэлэнд нөгөө үзүүрийг ботгоны ногтноос уяна. Гинжин уяаны дунд орчимд эргүүлэг хийнэ. Энэ уяаг хийсэнээр нэг уяанд 200 гр ноос орж байсныг хэмнэсэн төдийгүй эдэлгээний хувьд бөх бөгөөд энэ төмөр гинжин

уяаг сайн хийж чадвал 3-аас дээш жил эдлэнэ. Ийм үр ашигтай чухал санаачилга тул тэмээчин бүрт нэвтрүүлэх нь зүйтэй.

/С.Ваанчиг/

66. Малыг хатгаж эмчлэх арга // Говийн мэдээ.- 1970 оны 9-р сарын 17.- №71.- 4-р нүүр.

Малыг хатгаж эмчлэх арга

Сүүлийн үед анагаах ухаан хөгжиж малын үхэл хорогдол жилээс жилд мэдэгдэм багассаар байгаа юм. Мөн үүний хашир малчдын аргаар малыг хатгаж эмчлэх, ургамал ургамлын үндсээр эмчлэх практикийн арга хэрэглэгдсээр байгаа юм. энэ талаар цөөн зүйлийг дурдая.

1.Мориор ширүүн давхиж ирээд амьсгаан дээр нь услах буюу услаад ширүүн давхиснаас морь ханиадаг үүнийг хатгаж эмчлэхдээ тагнайны 13 дахь үеийг хатгаж эмчилнэ.

2.Тарган мориор хэтэрхий давхиж цус бөглүүлбэл буйлны судасыг нэвт хатгана.

3. Адууны нүдийг улайж өвчлөхөд нүдний цахилгаан судсыг хатгана.

4. Байнгалан авдаг хар нурууг хатгаж эмчлэхдээ нойтон тохом тохож нэг хоноод өглөө тохмыг авахад нурууний хоёр судас илэрсэн байдаг үүнийг хатгахдаа хэдмээс доош 4 нь хуруу зайтай судсыг хатгана.

5. Хар сэрээний сиймхийд хий хавчуулахыг толгой догolon гэж нэрлэдэг. Үүнийг хатгахдаа сээр хүзүүний засварын гурвалжин зайны голд цаанаас нь мод тулж байгаад нэвт хатгаж модонд тулгана.

6. Дотуур маханд хий хавчуулж хойд хойт хөл оринго доголлон болох үед сээрний 3 нурууны араасаа 3 дахь сэртэнгийн дотуур бүдүүн адуунд сөөм хатгуураар ясыг хусч нурууны гүдгэрт тултал хатгана.

7. Дэлүү хөөх үед адуу олон дахин хөрвөөж гэдсээ эгц дээш нь харуулан дөрвөн хөлөө дотгош нь нугалж байна. Үүнийг эмчлэхдээ адууны сүвээний 3 дахь хавирганы урд чөлөөнд бүдүүн адууг нурууны хэдмээс доош 18-20 см халз уруу нь 4 хуруу хатгана. Хатгасны дараа хатгуурыг аваагүй харж байтал хатгуур хөдөлж байвал уул хатгалт зөв болжээ гэж үзнэ.

8. Цус бөгөлсөн буюу дэлссэн үед сүүлийн гол судсыг хатгана.

9. Адууг хэтэрхий цус бөглөж гэнэт ойчих үед яаралтай арга хэмжээ авхын тулд хэлийг үзүүрээс нь 2 хуруу огтоолж авна.

10. уушигны вена судсанд муудсан цус хуримтласнаас морь огцом огцом ханиагаад байгаа үед богтоосны дотор талын онгон судсыг яс булчингийн сиймхий дээр хатгана.

11. Морины өмнө хөл доглохдоо бэлбэрэг бэлбэрэг гэсэн маягтай цохидог үүнийг цээж авсан нэрлэдэг, хатгахдаа хөх махын доод талаас ороо хар гэдэг судсыг хатгана.

12. Морины шөрмөсөн сиймхийд Цус буусан үед сиймхийд нь хуруугаа хэлбэж зай гаргаж дотор талаас нь нэвт хатгана. Энэ үед шөрмөсөн сиймхийг барьж үзэхэд хүйтэн байвал хатгаж болохгүй, халуун жин тавина.

13. Морины тавагт цус буух үед морь байнгалан хөлөө зөөж тавьж зогсоно. Энэ үед өсгий буюу туурайг нь хатгана.

14. Хөөсөн ханд хий хавчуулсан үед адуу цочир доголдог. Үүнийг дал бугалганы сиймхийд эрхий хуруугаар сайн хонхойлгож дарж байгаад өндөг хумс хоёрын зааг чигээр 2 хуруу хатгана.

15. Урин дулаан цагт адуу, тэмээний нүднээс нь нулимас их гарч голхи нь хөөж улайх, нүд нь бүрхэх үед дөрөөлөх судсыг хатгаж эмчилнэ.

16. Мориор хэтэрхий давхиснаас дэлсч өвчлөхөд гуяны дотор талын өнгөн судсыг хатгана.

УРГАМЛЫГ АШИГЛАН МАЛЫГ ЭМЧЛЭХ АРГА

1. Тэмээний ханиад өвчин дэлгэрэхэд лидэр, хотир, морин шарилж өмхий ногооны үндэс эдгээрийн аль нэгийг сайн хандалж 2-3 өдөр дараалан өгөхөд уул өвчнийг сайн эдгээнэ.

2. Ямар нэг малд задгай шархыг тарна гэдэг сүүт ногоог сайн хандалж шархыг сайн угааж шавшвал бүрэн эдгэрч чадна.

3. Адуу тэмээнд чийг нар цохихыг жилбэн гэж нэрлэдэг. Энэ үед омрууны арьсыг хөндлөн хагалж, 3 хуруу орчим далан түрүүг хөндлөн хавчуулж утсаар тогтооно.

4. Алтан үндсийг яс бэртэх буюу төл мал халуурахад сайн хандалж өгнө.

5. Малын халуунд ар сэрүүн газрын монгол /харгана/ өвсний үндсийг сайн хандалж өгнө.

6. Төл мал удаанаар чацга алдаж ходоод нь өнгөргүй болох үед ортууз ба үхрийн хөх аргалын үнсийг өгнө.

7. Төлд эхийн сүү багасч витамин дутагдах үед нохойн хушуу, сорслон хатаасан таана хандлан бага хэмжээгээр өгнө.

8.Шээс нь хаагдсан малд зэрлэг цагаан гоёо хандалж өгнө.

9.Төл мал цагаан нустах үед ганга өвс буюу хар шавгийг төлийн пинд уугуулж утна. Мөн үхэр өвсийг ямар ч малын ханиадад хандалж хэрэглэнэ.

10.Ботго чацрайлж зунгаг нь гарахгүй байхдаа буурын бохийг усанд чанаад шингэн хар цайрхуу болоход 50 граммаар өдөрт 3 удаа өгнө.

11.Төл малд эхийн сүү зохихгүй байвал гоёо хандалж өгнө.

12.Энэ намар нь ногооноороо хөлдсөн гашуун ургамал ирэх хавар гэсч гашилсан хойно нь мал идэж чацга алдвал тэр ургамлыг өөрий нь хандалж өгнө. Эдгээр нь практикийн дагуу сайн нөлөө үзүүлж байна.

/Б.Чүлтэм/

67. Говийн мэдээ.- 1970 оны 11-р сарын 12.- №84.-
3-р нүүр.

Цогтцэций сумын “Их шанхай” нэгдлийн Сийрст бригадын адуучин МХЗЭ-ийн гишүүн Д.Нүрзэд энэ залуу 1962 оноос хойш адуу маллаж амжилт олж яваа адуучин юм. Эднийх өнөө жил 273 адуу хариуцан маллаж хөөвөр хялгас бэлтгэх үйлдвэрлэлийн даалгавраа хугацаанд нь 100 гаруй хувиар биелүүлж 47 гүүнээс 47 унага бойжуулж үйлдвэрийн даалгавраас 5 унага илүү бойжуулсан байна.

68. Амалсанаа биелүүлэх малчин // Говийн мэдээ.-
1970 оны 11-р сарын 16.- №85.- 2-р нүүр.

Амалсанаа биелүүлэх малчин

Номгон сумын “Сангийн далай” нэгдлийн Дэрсэнэ ус бригадын ямаачин МХЗЭ-ийн гишүүн Б.Адъяа 1969, 1970

онуудад өөрийн хариуцсан малдаа хүрэлцэх хэмжээний тэжээл бэлтгэж өнгөрсөн оны өвөл хаврын улиралыг мал сүргийн хорогдолгүй сайн давжээ. Ямаачин Адъяа 1969-1970 онд төллөвөл зохих эм ямаанаасаа бойжуулах төлийн үйлдвэрлэлийн даалгаврыг 35-78 ишгээр давуулж ноос ноолуур сүүн үйлдэхүүний даалгаврыг 100,1-100,4 хувиар биелүүлсэн байна.



Ямаачин Адъяа ярихдаа би МАХН-ын Ардын хувьсгал МХЗЭ-ийн 50 жил, өөрийн аймаг байгуулагдсаны 40 жил зэрэг түүх ойнуудыг угтаж өөрийн хариуцан маллаж байгаа ямаагаа онд бүрэн оруулж 1971 онд төллөх 226 ямаанаас 229 ишиг бойжуулж ноос ноолуур сүүн үйлдэхүүний үйлдвэрлэлийн даалгавраа хугацаанаас нь 10 хоногийн өмнө 100-103 хувиар биелүүлнэ. Мал ажиллагаандаа сумын тэргүүний ямаачин Ж.Бат-Очир, Наваацэрэн нарын ямаа малладаг арга туршлагыг нэвтрүүлж ноолуурын чанарыг сайжруулж нэг ямаанаас авах ноолуурын хэмжээг эхэсгэнэ.

Соёлжилтын талаар шат ахиж гэр орныхоо соёлжилт тохижилтыг сайжруулан. Өөрийн мэдлэг боловсролоо дээшлүүлэхийн тулд 30-аас доошгүй ном уншиж шинэ дуу хоёр, шүлэг 3-ыг сурч суурийн хүмүүжлийн ажлыг тогтмол болгож нэг хүнд 4-р ангийн боловсрол эзэмшүүлнэ. Одоо 1970, 1971 оны мал сүргийн өвөлжилтын бэлтгэлийг үндсэн нь хангаж өвс 1600 кг, шимт тэжээл 250 кг –ийг түүж, хүчит тэжээл хөмүүл таана зоодой гоёо зэргийг хүрэлцээтэй бэлтгэж аваад байна.

Ч.Цэндоо, Ж.Гантөмөр

**69. Говийн мэдээ // 1970 оны 11-р сарын 16.- №85.-
3-р нүүр.**

Баян-Овоо сумын “Говийн хөгжил ” нэгдлийн Налих бригадын ямаачин МХЗЭ-ийн гишүүн Рэнчинханд 1970 онд хонь 108, ямаа 73-ыг төллүүлж 131 хурга, 85 ишиг бойжуулж авчээ тэр энэ онд нэгдэлдээ төрөл бүрийн бүтээгдэхүүнийхээ даалгаврыг бүрэн биелүүлсний дотор ноолуурынхаа 80 хувийг нэгдүгээр зэрэгт тушаажээ. Эднийх өвлийн ба төлийн бэлтгэлээ сайн хангаж 300 кг өвс бэлтгэж өвөлжөөндөө татаж авчээ.

**70. Гэрэлмаагийн жишээгээр // Говийн мэдээ.- 1971
оны 1-р сарын 14.- №85.- 3-р нүүр.**

Гэрэлмаагийн жишээгээр

Ханбогд “Гадбын хөгжил” жавхлант бригадын ямаачин эмэгтэй 1970 онд 50 шахам эмнэг тэмээнүүдийг уналга эдэлгээнд сургаж сумын эмнэг хангалын аварга болж улмаар БНМАУ-н эмнэг сургалтын спортын нэгдүгээр зэргийн нормыг биелүүлж цаашдаа эмнэг сургалтын спортын мастер зэрэгт хүрэх зорилготой ажиллаж байна. Эмнэг хангалын уналга эдэлгээнд сургаж номгоруулах талаар туршлагжиж яваа

Энэ эмэгтэй ярихдаа: Манай өвгөн аав ээж маань тэмээг хоёр настайгаас нь эхэлж унаж сургавал төрөлхийн хамгийн үнэн номхон тэмээ болдог юм гэж хэлдэг байсан. Би өөрөө ямаачин хүн манай зэргэлдээ тэмээчин Өлзийбадрах гуйнх нутагладаг. Тэдний суурь 90 гаруй эмнэг тэмээтэй байсан ихэнхийг би гэрийхэнтэйгээ эвсэж унаж сургаад одоо тэднийх эмнэг хангалгүй суурь болж байна. Эмнэг тэмээг анх барьж буйллахаас нь эхлээд зөөлөн барьж тавих хэрэгтэй. Ширүүн гараар хандаж толгой хүзүүрүү нь гуядаж шавхрахыг цээрэлдэг анх тавхайлж хэтрүүлэхдээ их


хэмжээний сул элсэнд сөхөргөж, хэд хэд эргүүлэхэд тамирдаад аяндаа хэвтдэг. Харин зарим бүдүүн 3-4 насны атанцар тэмээд нь тэнхээ чадал ихтэй учир зөөлөн газар тэр бүр хэвтэхгүй байдаг.

Тийм тэмээг хатуу хайрагтай газар тавхайтай нь хэд сайн сөхөргөвөл амархан хэвтдэг тал бий. Гэхдээ хатуу газар олон хэвтүүлэхийг цээрлэх хэрэгтэй юм. Хатуу газар хэвтүүлсэнээс болж өвдөг нь шалбарах эсвэл хэвтэх бүрийдээ газрын зөөлөн хатууг шилдэг болоход хүргэдэг юм. Унаж сургаж байгаа тэмээг сайн идүүлж, усалж өлсгөж цангаахгүй байвал орилоо ярдаг болдоггүй юм. Өлсгөж цангаах буюу нимгэн тохиштой унаснаас болж орилоо ярдаг болдог. Унасан тэмээгээ 10 орчим хоногийн дараа дахин хоёр дахь удаагаа унавал сайн байдаг гэж Гэрэлмаа ярьж байна.

/Б.Ишжамц/

71. Тэргүүний ямаачин Ц.Батмөнх // Говийн мэдээ.- 1971 оны 1-р сарын 11.- №03.- 1-р нүүр.

Тэргүүний ямаачин Ц.Батмөнх



72. Туршлагатай малчин // Говийн мэдээ.- 1971 оны 1-р сарын 11.- №03.- 1-р нүүр.

Туршлагатай малчин

ТУРШЛАГАТАЙ МАЛЧИН

—Танайх төл хүлээн авах бэлтгэлд юу хийж, ямааны хээлийг хамгаалах талаар яаж ажиллаж байна.

—Манайх төлийн бэлтгэлд зориулж нарийн өвс 4000 кг, бусад шимт тэжээл 500 гаруй кг, хөх хоргол 50 гаруй шуудайг бэлтгэсэн. Бас гоёо, зоодой зэрэг тэжээлийг хүрэлцээтэй бэлтгэсэн. Төлийн уут хучилга нэмнээ элгэвч, хушуувч цөм бэлхэн бий. Ихэр гурван хороотой, 2 пүнзтэй эдгээрийг цөмийг засч сэлбэсэн. Одоохондоо цаг дулаан учраас ямаагаа хорооны гадна бууцны хормойд хэвтүүлж, хороогоо хуурай хадгалж байна. Мал төллөхөд хороондоо оруулна. Малчин хүний анхаарах зүйл нь малын хээл хамгаалах ажил байдаг. Манайх ямааны хэвтрийг үр-

ямаачны нэг болж сумын депутатаар сонгогдсоныг ташрамд дурдалтай. Бэлчээрийг хуваарьтай ашигладаг тухайгаа Цэвээндорж цааш нь ингэж ярилаа:

—Манай ямаа 2 дугаар сарын сүүлчээс эхлэн төллөнө. Энэ үеэс эхэлж өвөлжөөний баруун, баруун хойт, хойт хэсгийнхээ бэлчээрийг ашиглахаар нөөцөлж байна.

Цаг дулаан, мал зутраагүй, сайн байгаа учраас талархаг газраар зүүн, өмнө хэсгээрээ бэлчээрлүүлж, бүх бэлчээрийнхээ тавны гурван хувийг мал төллөхөд зориулан нөөцөлж байгаа.

—Ямааг нөмөр дулаан, хад халтиргаа багатай газар хариулж, ширүүн туух, үргэж цочоохоос сэргийлж аль болох зөөлөн тогтуун идээшлүүлэх нь

73. Мал аж ахуйн аваргууд // Говийн мэдээ. - 1971 оны 1-р сарын 18. - №05. - 3-р нүүр.

Мал аж ахуйн аваргууд

Ханхонгор сумын өлзийт нэгдлийн задлал 1970 онд мал аж ахуйн үйлдвэрлэлийн даалгаварыг хугацаанд бүрэн давуулж биелүүлсэн малчдын дотроос сумын аварга шалгаруулав.

Үүнд: Адуучин Хоргол, МХЗЭ-гийн гишүүн Цэвэргравжаа, ямаачин Банди, тогооч МХЗЭ-гийн гишүүн Цогдэлгэр, хоньчин Б.Ваанчиг МАХН-гийн гишүүн Цэрэнжаа, МХЗЭ-гийн гишүүн Аюуш тэмээчин Самбуу, Нямжид, Манхай, үхэрчин Эрэнгоо, Цэдэндамбаа нар Мал аж ахуйн ашиг шим ашиглалт төл бойжуулалтаар аварга болов.

Булган сумын туяа нэгдлийн Дал бригадын тэмээчин Р.Балжинням 241 тэмээ хариуцан үйлдвэрийн даалгавраас 140 гаруй кг ноос, Дэн бригадын хоньчин

намын гишүүн Гэлэгнамжил хариуцсан малласан 306 хонь бүрээс 1712 гр ноос ашиглан хонь тэмээний ноос ашиглалтаараа сумын аварга болов.

Хавцгайт бригадын ямаачин Ц.Авирмэд 444 маллан үйлдвэрийн даалгавраар өгөгдсөн ноолуураа 1.2 дугаар зэрэгт тушаан 20 гаруй кг ноолуур илүү тушааж, Дал бригадын адуучин Н.Дорж 360 адуу маллаж хөөвөр ашиглалтын үйлдвэрлэлийн даалгаврыг 131 хувиар биелүүлж ноолуур хөөвөр ашиглалтын сумын аварга болцгоов.

Мөн төллөх хонь маллан 100 эхээс 111 хурга бойжуулсан дэн бригадын хоньчин С.Тогоо, үйлдвэрлэлийн даалгавраар 1045 литр сүү ашиглахаас 1478,2 литр сүү тушаасан Дал бригадын хоньчин Д.Аюурзана нар төл бойжуулалт хонины саалийн аваргаар шалгарав.

Хавцгайт бригадын ямаачин Д.Цэвэгмэд үйлдвэрлэлийн даалгавраар 2600 литр сүү тушаахаас 3560 литр сүү тушааж ямааны сааль ашиглалтаар, Дэн бригадын адуучин Д.Сэд сумнаас зарласан болзлын дагуу 47 хангалыг уналганд сургаж эмнэг хангал сургалтаар сумын аварга болцгоов.

74. Аваргын арга туршлага // Говийн мэдээ.- 1971 оны 1-р сарын 28.- №08.- 2-р нүүр.

Аваргын арга туршлага

Хандын Шархүү гэвэл Сэврэй нутгийнхан байтугай баруун сумдын ихэнх малчид андахгүй. Сум аймагтаа алдартай энэ хоньчны мал ажиллагааны олон

Говийн мэдээ сонин



сайхан арга туршлага нь олонд үлгэр дууриалал болно. Өглөөний нар уулын толгойд тусахад өвгөн Шархүү дээлээ бүслэнгүүт гарч хорооны үүдээ нээхэд хонь нь тайван босч биеийнхээ чилээг гарган

шилгээгээд хашааны гадна гарч шээнэ. Тэр хоньчин хашааны тасалгаа бүрт орж, малын байдлаа ажиг явснаа. Хөгшөөн нөгөө хөвөнтэй даавуугаа аваад ир! Гэхэд эмгэн Жигдэр утас зүү, эсгэж зэхсэн эд барьсаар гарч ирэв.

Энэ муу зусаг сүүлнээсээ даардаг бололтой гээд сүүлий нь хөвөнтэй даавуугаар ороож үсэнд нь шидэв. Өнөөдөр хүйтэн байна. Орой тийшээ жаварлаж магадгүй, хотолохоос өмнө хотны салхин дээд талд хэд хэдэн газар утаа уугуулаарай гэж эмгэндээ захиад нар ханын толгойд ормогц хонио бэлчээж явлаа. Энэ бүхнийг лавлабал өглөө бүр хонио хэвтрээс нь босгож гадаа гаргаж шээлгэвэл хот бууц хөлддөггүй, хонь сүүлнээсээ даарч эцэж зутардаг тул сүүлийг нь боож дулаалдаг, хотонд жавар оруулахгүйн тулд утаа тавьдаг.

Энэ мэтчилэн ариун арга туршлагатай малчин Шархүүгийн сүүлийн арван жил хариуцан маллаж буй хониныхоо төлийг жил бүр хорогдолгүй бойжуулсанаар 2200 –гаад хурга нэгдэлдээ бойжуулж өгчээ.

Сэврэй сумын “Социализмын зам” нэгдлийн Хоолт бригадын хоньчин, аймгийн АДХ-ын депутат Хандын Шархүү:

Манайхыг 1967 онд төлөө сайн бойжуулсан гэж улсаас энэ сайхан гэрээр шагнаж, улсын аварга төлчин гэдэг цол хүртээсэн юм даа. Түүнээ хойш улсын шанд хүрэх амжилт гаргаагүй ч 1969 онд төл бойжуулалтаар, 1970 онд хонины ноос авалтаар сумын аварга боллоо. Одоо даанч нас өндөр болж, чадал тэнхээ мөхөсдлөө гээд идэр залуу насаа эргэн санах мэт түр дуугүй сууснаа:

Манайх 1957 онд нэгдэлд орж, одоо хүртэл хонь маллаж байна. Хонь төллөх дөхлөө. Малчин бидний гол ажил одоо л эхлэнэ. Зарим зусаг хонь хургаа голдог учир уураг сүүгий нь сааж хужиртай хольж , эхий нь ам, хамар, хурганы сүүлэнд түрхэхэд голхоо больдог гэлээ. Эдний 1957 онд барьсан хороогоо өөрөөр нь 2 метр шахам өндөрлөж, дотор нь 4 тасалгаа гаргасныг үзэхэд аргагүй л ажилч хүн юм гэж бодогдов. 1970 онд Сэврэй сумын намын үүрийн бүх гишүүд 400 бог малын багтаамжтай саравчтай тохилог хашаа барьж өгөснөөр хот хороо нь улам тэлж тохилог болжээ.

Баян бор нурууны баруун өвөр Нарангийн Цагаан хороотын бууцанд өвөлжиж байгаа эднийг өвс 1,5 тонн, таанан зоодой 170 ширхэг, гоёо 10 кг, хужир 14, хөх хоргол 70, бууц 130 шуудай байгааг үзэхэд хариуцан маллаж байгаа 387 хонин сүргээ онд оруулах энэ жил төллөх 140 хониныхоо төл хүлээж авах бэлтгэлээ сайн базааж авсан нь тодорхой ажээ. Хоньчин Шархүү гуайн хонь жил бүр цатгуур сайтай төллөдөг. Энэ нь отор нүүдэл сайн хийдэгт байгаа ажээ.

Өнгөрсөн жил 4-р сараас 11-р сар хүртэл Даравгай, Баян-Овоо, Хонгорын гол, Хар дэл зэрэг соргог ногоотой нутагт хонио оторлосон нь үр дүн өгч тарга хүч сайн авсан байна.

Аварга хоньчин Шархүү гуайн ардын хувьсгалын 50, аймгийнхаа 40 жилийн ойд өвлийг өнтэй даваж мал сүргээ онд бүрэн оруулж төлөө бүрэн бойжуулсан амжилтаар бэлэг барих зорилттой ажиллаж байна.

Ч.Цэндоо

**75. Бэлтгэл сайтай ямаачин // Говийн мэдээ. - 1971
оны 2-р сарын 1.- №09.- 2-р нүүр.**

Бэлтгэл сайтай ямаачин

Бид говь нутагт алдартай 80 км үргэлжлэх хонгорын голын элсэн уулын уужмын даваагаар давж Сэврэй сумын “Социализмын зам” нэгдлийн Сайншанд бригадын ямаачин Д.Нямынд очив. Нямын гэргий Пүрэв өвлийн ба төлийн бэлтгэл малын тэжээлийн талаар ярихдаа: Энэ жил цаг дулаан цас бага болохоор мал сайн зутрах турах нь бага байна 440 гаруй ямаа малладаг. Энэ жил 194 ямаа төллөнө. Нэгдэл маань 50 шуудай багсармал тэжээл, 20 шуудай хивэг, 4 тонн өвс буулгаж өгсөн. Бид хоёр тонн өвс түүж, хужир 30, хөх хоргол 50, шуудай хужир хивэг таанын холимог зоодой 50 ш, 70 литр сүүнд будаа агшааж сүү цагаа 100 литрийг бэлтгэж авсан гэлээ. Эднийх ямаачин А.Санжийн туршлагаар мал тэжээх уутан хушуувч 160-ийг хийж мал тэжээхдээ хэрэглэдэг болжээ. Мөн төллөх ямаагаа ишиглэхээс нь нэг сарын урьдаас эхлэн ногоо гартал тэжээдэг ажээ. Ямаачин Д.Ням, Г.Пүрэв нар гурилийг загсгалын бүлээн усанд самарч найруулан нэг ишигэнд өдөрт нэг удаа 250 гр аар өгдөг байна. Энэ нь төл чацга алддаггүй хоолны шингэц сайн байдаг ажээ. Малч ажиллагаагаараа алдаршиж яваа энэ ямаачных өнгөрсөн жил 193 ямаанаас 208 төл бойжуулж саалийн нэг ямаанаас 21 литр сүү саасан зэрэг амжилтаа бататгаж түүхт ойнүүдыг

Говийн мэдээ сонин

ажлын арвин бэлэгтэй угтахаар зориг эрмэлзлэл дүүрэн
ажиллаж байна.



Зураг дээр: Г.Пүрэв ямаагаа тэжээж
байгаа нь

Гэрэл зурагчин: Ч. Цэндоо

76. Тэмээчин Я.Муухүү // Говийн мэдээ. - 197 оны 2-р
сарын 11.- №11.- 1-р нүүр.

Тэмээчин Я.Муухүү



—Манайх 366 тэмээ маллаж байна. Өнгөрсөн онд 28 ингэнээс 28 ботго бойжуулж, нэг
тэмээнээс дунджаар 5464 гр ноос авч ноосны баалгавраа 133 кг-аар давуулж биелүүлсэн.Энэ
жилд 225 ингэ ботголж 32 ингэ хээд авна. Манайд жилд 14,5-17,5 кг ноос өгдөг буур бий гэж
Нодн сумын «Гучин таван жил» нэгдлийн Ганзагад бригадын тэмээчин Я.Муухүү яриа.
ЗУРАГ ДЭЭР: Тэмээчин Я. Муухүү тэмээгээ услаж байна.
Ч. ЦЭН ДООГИЙН авсан гэрэл зураг

77. Өнтэй нутгийн шинэ төл // Говийн мэдээ. - 1971
оны 2-р сарын 15.- №12.- 1-р нүүр.

Өнтэй нутгийн шинэ төл

Хоньчин П.Ванчиг гуайн суурийнхан цөм Аймаг сумын Депутатаар удаа дараа сонгогдож, хонины ноос авалтаар аймаг сумын аваргын болзлыг 1966 оноос хойш жил дараалан биелүүлж аварга болцгоосон хүмүүс юм. Хариуцан маллаж байгаа 400 гаруй хонин сүргийнхээ өвөлжилт, энэ жил төллөх 250 гаруй хониныхоо төлийг хүлээж авах бэлтгэлийг сумандаа тэргүүн сайн базааж авсан суурийн нэг ажээ. Эднийд 100 гаруй хонь төллөж төл нь сайн бойжиж байна.

Хоньчин П.Ваанчигийнх өнгөрсөн жил 311 хониноос 334 хурга бойжуулж хонь бүрээс 1521 гр ноос авч нэгдлийн үйлдвэрлэлийн даалгавраар өгөгдсөн үүргүүдийг хугацаанд нь давуулж биелүүлсэн ажээ. Манай хонь жилбэ сайтай төллөж байна. Хэрэв Жилбэ муутай төлөө цатгахгүй байвал эх төлд нь нэмэгдэл тэжээл өгдөг юм. Хургыг дулаан байрнаас цочмог гаргаж болохгүй, халуун байрнаас цочмог гарсан төл салхи цохиулж хатгалгаа тусдаг. Хургыг дааруулахгүй байх нь хамгийн чухал. Хэрэв дааруулах юм бол хоолны шингэц муудаж уураг зангирах, чацаг алдах зэргээр өвчилдөг. Хургны уураг зангирвал шимийн архи бүлээсгээд хоолны жижиг халбагаар өдөрт нэг удаа өгвөл сайн байдаг гэж Хүрмэн сумын Сүхбаатар зам нэгдлийн Жанжин бригадын хоньчин П. Ваанчиг гуай ярьж байна. Малч аав ээжийнхээ арвин туршлагыг өвлөн авч яваа охин Цэндсүрэн сайн малчин болох их сууриа тавьж сумын АДХ-ын депутат, 1970 оны ноос авалтын сумын аварга болсон байна. МХЗЭ-ийн гишүүн В.Цэдэвсүрэн алдарт хоньчин БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Очир гуайн мал ажиллагааны туршлагаас суралцхаар захидал бичжээ. Нийгмийн хонин сүргийг арав гаруй жил хариуцан

маллаж амжилт гаргаж яваа энэ хоньчдын арга туршлага амжилт бүтээлээс дурдхад ийм байна.



Зураг дээр: хоньчин МХЗЭ-ын гишүүн Цэдэвсүрэн төлд өвс өгч байгаа нь

78. 60 ямаа 70 ишигтэй // Говийн мэдээ. - 1971 оны 3-р сарын 29. - №24. - 1-р нүүр.

60 ямаа 70 ишигтэй

60 ЯМАА 70 ИШИГТЭЙ

Намын гишүүн Норовсамба гуайн мал хэзээний ихэрлэдэг. Жил бүр олон ихэр гарч илүү төл бойжуулдаг хүн дээ. Барагтай бол зутрахгүй одооч мөн илүү төлтэй л бий байх. Ихэр төл гардаг чинь малын хүч таргатай; холбоотой байдаг гэж ярьдаг юм.

Малаа ч сайн таргалуулдаг хүн гэж Дэлэнзадгад сумын 4-рээтэг "Эм" нэгдлийн намын үүрийн нарийн бичгийн дарга Цэдэндорж гуай ярьж явсан юм.

Үнэхээр Цэдэндорж даргын таавар зөв байлаа. Биднийг очиход Норовсамба гуай хотондоо төлөө хөхүүлж байв. Эднийх төлөх хонь ба ямаатай. Үүнээс биднийг очиход 50 гаруй хонь, 60 ямаа төлөөд төлийн хоргодолгүй, харин 63 ямаа 70 ишигтэй байлаа.

Манай мал ихэрлэх дуртай цагийн сайханд ихэр төл сөөнгө төл хоёр юугавраа ч ялгагдах юм байдаггүй. Ихэр төлийг мал болгоно гэдэг тийч амаргүй илүү тэжээл, арчилгаа шаардагдана. Цаг зүтгэвэл бүр ч хэцүү. Одоогоор том оа төл малын хоргодолгүй ихэр 10 ишиг гарвад байна. Нэмж хэд гарах юм мэдэхгүй байна. Үүнийгээ л хоргодуулахгүй бойжуулах

зорилт над байгаа юм. Энэ зорилтоо биелүүлж чадснаар МАХН-ын Төв Хорооноос төл бойжуулах талзар өгсөн даалгаврыг давуулан биелүүлж намынхаа ХVI их хурал, ардын хувьсга-

галын 50, аймаг байгуулагдсаны 40 жилийн ойд барих бэлэг болно гэж МАХН-ын гишүүн өвгөн Норовсамба гуай ярьж байв.

Б. ТОГТОХ



ЗУРАГ ДЭЭР. Норовсамба хурга амлуулж байгаа нь **ЗОХИОГЧИЙН** авсан гэрэл зураг

79. Тэргүүний тэмээчин // Говийн мэдээ. - 1971 оны
5-р сарын 6. - №34. - 3-р нүүр.

Тэргүүний тэмээчин

ТЭРГҮҮНИЙ ТЭМЭЭЧИН

Дэрсэнэ ус бригадын тэмээчин Цогбат 1958 онд нэгдэлд элссэнээс хойш нийгмийн тэмээн сүргийг 13 жил тасралтгүй маллаж сүү, төл, ноосны даалгаврыг жил дараалан 100-гаас дээш хувиар биелүүлж иржээ.

Зөвхөн сүүлийн гурван жилд 200—300 тэмээ маллаж 118 ингэнээс 118 ботго бойжуулан эмнэг хангал тэмээ 100 гаруйг уналга, саалинд сургасан байна.

Н. Цогбат жилийн дөрвөн улиралд тэмээг тогтмол байнгын хариулагатай байлгаж ашиг шимийн үйлдвэрлэлийн даалгаврыг жил бүр тогтмол биелүүлдэг. Тэмээчин Цогбат ярихдаа:

— Манайх 1966 онд амлалт үүргээ биелүүлж СХ-ийн бригадын мандатыг хүлээн аваад одоо «Хөдөлмөрийн алдар» медалийн төлөө ажиллаж байна.

Би БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар, Ардын Их Хурлын депутат Гомбосүрэн-

гийн ботго махлуудлаг туршлагыг ажилдаа нэвтрүүлж ажиллаад үр дүнд хүрч байна. Бид гэртээ гурвуул, нийгмийн 300 тэмээг хариуцан малладаг, энэ жил 60 ингэ ботголоно, 44 нь ботголоод байна.

Энэ онд үйлдвэрлэлийн даалгавраар 4200 литр сүү тушаана. Одоо 2100 литр сүү тушаагаад байна. Эмнэг тэмээ 40 шахамыг уналганд сургалаа. Их ойнуудыг угтаж төл бойжуулалт, сүү, ноос авах үйлдвэрлэлийн даалгавраа бүрэн биелүүлж эмнэг сургалтын аваргын болзлыг хангах зорилттой ажиллаж байна.

Манайх Дэрсэнэ ус бригадын тэмээчин Өлзийхоролынтой уралдаан байгуулаад ажиллаж байгаа гэлээ. Тэмээчин Цогбатын хариуцан маллаж байгаа тэмээ бүгд дундаас дээш тарга хүчтэй онд бүрэн орж байна.

ШАРХҮҮ (тэмээчин)

80. Бор тээг бригадын хоньчин Ч.Батбуян // Говийн мэдээ. - 1971 оны 6-р сарын 17. - №45. - 3-р нүүр.

Бор тээг бригадын хоньчин Ч.Батбуян

Бор тээг бригадын хоньчин Ч. Батбуян



Бор тээг бригадын хоньчин Ч. Батбуян 12 жил нийгмийн хоньчин сүрэг маллаж, сүүлийн 3 жилд төл лөх 100 эхээс 100—110 хурга бойжуулж, ноосны үйлдвэрлэлийн даалгавраа 100—105 хувиар биелүүлсэн юм.

Тэр ардын хувьсгалын 50 жилийн ой угтаж энэ жил төл лөх 101 эм хоньноос 104 хурга бойжуулаад байна.

Х. БАДАМГАРАВ

81. Ямаачин Найдансамба // Говийн мэдээ.- 1971 оны 7-р сарын 5.- №49.- 3-р нүүр.

Ямаачин Найдансамба

Ямаачин Найдансамба

Бандалай сумын «Гурвансайхан» нэгдлийн ямаачин Найдансамба 1955 онд анх нэгдэлд элсээд 15 жил ямаа маллаж байгаа туршлагатай малчин билээ.

Ямаачин Найдансамба ярихдаа: Би нэгдэлд орж ямаа малласнаас хойш үйлдвэрлэлийн даалгавраар өгөгдсөн сүүн үйлдэхүүн төл бойжуулах ноос ноолуур ашиглах даалгавраа жил бүр давуулан бие түлэж байгаа юм.

Төлөвлөгөөт даалгаврыг тогтмол биелүүлэхэд суурийн анхан шатны бүртгэлийг сайжруулах нь чухал гэж үздэг. Жишээ нь социалист урдалаанд авсан үүргийнхээ биелэлтийг байнган үзэж гүйцэтгэлийг гарган хэдийд биелүүлэх бололцоотойг судалж байдаг.

Ингэснээрээ ч төлөвлөгөөт даалгавар цагтаа бүрэн биелэгддэг юм. Тэрчлэн малан ноос ноолуур сүү ашиглахад нарийн график хийж аваад түүнийг хатуу мөрдөх нь илүү ашигтай юм шиг байдаг.

Манайх СХ-ийн бригадад орсноос хойш хамтарч сулч соёлжих ажиллах амьдралын давуу талыг үзэж байна. Одоо манайх отор нүүдэл сайн хийж малдаа сүүн тарга хүч авахуулах зорилготой ажиллаж байгаа. Энэ жил ямаачинхаа ноолуурын төлөвлөгөө хугацаанд нь 119 хувиар биелүүлсэн. Малаас авах ашиг шинийн даалгаврыг жил бүр давуулж биелүүлж байгааг маань манай нэгдэл хамт олон өндрөөр үнэлж амьтнын баяр наадамд төлөөлөгчөөр оролцуулах болсонд би хязгааргүй байрлаж цаашдынхаа ажилд улам их амжилт гаргах зориг төгөлдөр хөдөлмөрлөж байна гэж яриц.

Д. ДОРЖ

82. Ажигч малчин // Говийн мэдээ.- 1972 оны 1-р сарын 1.- №1.- 3-р нүүр.

Ажигч малчин

АЖИГЧ МАЛЧИН
(Сурина, Ямайка)

Бид Тэнгисийн тал орох замдаа Цогцэций сумын «Их Шанхай» нэгдлийн Сийрт бригадын ямаачин Ж. Нэврийнд очлоо.

Ж. Нэвэр бид 1966 оноос ийнхүү ямаан сүргэ малаж байгаа туршлагатай малчин хүн. Эднийх Бичигтэйн харан Американын Хамна бууцанд өвөлжиж байна.

«Их Шанхай» нэгдлийн ууган гишүүдийн нэг Ж. Нэвэр гаруй. Б. Ценгөлээр хадийвэр нас жаргарсан боловч малч сайн ажилтай хүмүүс юм.

Бичигтэйн ямаан сүргийн малаганд голлож өвчин Идэр гуйн ямаа маладаг ажилын арга туршагаагаар явн. Эднийх зуны улиралд Сийрт, Бэни толгой, Улаан өрөг хавиар нутагладаг ажээ.

Ямаан сүргээ зуны улиралд галина барг хураадаггүй, хэрийн малаганд байлдаг. Ногооны гарц сайжранд ирэхтэй зэрэг бэлчээр нь, эхийн үед ажиг оромж барьж дасгаад сүр нь мэдэж болдог.

Хүч таргаа ялдаж, зугарч байгаа ямааны хорго нь жижгэрч, хатуу, хар өнгөтэй байдаг юм. Ман бэлчээрт их бутрах, орой хотондоо ирээд хэвтэхгүй, дуулан жаварт эрж түлддэг, майж шуугаад байх зэргэ шинж тэмдэг нэлддэг. Ийм байдал мэдэгдсэн өмс хоол сайтай, нарын энэч бэлчээрт хариулах, хэвтрэг нь дуулаж-огтөн оройн жаварт хотныхоо салхин дээд гайд утга уугуулах зэрэг арга хэмжээ авч худгийн усар тогтмод усалж байх зэрэгтэй гэж ямаачин Идэр гуй ярьж байна.

Энэ туршлагаас үзэхэд малчин хүн хариуцан малаж байгаа малдаа бичигтэйн ямаачин Идэр гуйн туршлага хариулаж байна. Эдний ямаан сүргийн өсөлт тогтвортой зүй бүхэн хосгодог галдаггүй, ашиг шим нь арин, үйлдвэрлэлийн даалгавар нь жил дарагдан биелж байдаг ажээ.

Ч. ЦЭНДОО



83. Эхий нь сайн тэжээх хэрэгтэй // Говийн мэдээ.-
1972 оны 2-р сарын 7.- №11.- 2-р нүүр.

Эхий нь сайн тэжээх хэрэгтэй



Манайх сүүлийн 9 жил эрлийз эм хонь маллаж байна. Одоо манайх нийгмийн 272 хонь маллаж байгаагийн 130 нь төллөх хонь энгийн хороотой хоёр өвөлжөөтэй.

Өвөлжөөндөө өвлийн бэлтгэлээ сайн хийсэн. Би төл бойжуулдаг зарим ажиллагаанаасаа дурьдая. Эрлийз хонины төл бойжуулахад хамгийн түрүүнд хоол

тэжээлийг нь тохируулах хэрэгтэй байдаг. Төлд сүүтэй өтгөн цай мөн намар түүсэн ногоон агь бор шавагийг нэг цагаан тогоо усанд сайн атгыг хийж буцалгаад өдөрт гурван удаа литрийн шанагны тэг дундуур өгөхөд сайн тэжээл болдог. Цайхгүй төллөсөн хонийг цайгаар тэжээхэд сүү амархан орно. Цайхгүй шахуу тах уурагтай төллөсөн хонинд уургийг нь амлуулаад хэрэггүй. Сүүтэй өөр хонинд амлуулж байж эхэд нь хөхүүлдэг. Манайх өвөлжөөндөө төл хүлээж авах 6-н тасалгаатай пүнтэй үүнээс гадна ихэр хурганы байр гэж зориуд тусгай байртай ихэр хургыг эхнээс нь сайн тэжээх хэрэгтэй. Хамгийн гол нь хурганы эхийг тэжээх л хэрэгтэй юм билээ гэж Манлай сумын хоёр Өлзийт нэгдлийн Өехийн бригадын хоньчин 71 настай С.Мисрэн ярьж байна.

Ж.Рэнчин

84. Амжилтаа бататгана // Говийн мэдээ.- 1972 оны
2-р сарын 28.- №17.- 1-р нүүр.

Амжилтаа бататгана

Цогтцэций сумын “Их шанхай” нэгдлийн Сийрст бригадын Ц.Мандарваа 1964 онд бага сургууль төгсч өөрийн хүсэлтээр мал аж ахуй дээр гарч эх эцгийн хамт

Говийн мэдээ сонин

төллөх хонь маллах хугацаандаа үйлдвэрийн даалгаврыг тогтмол бүрэн буюу давуулан биелүүлж зөвхөн

1971 онд 200 хонь төллүүлж 200 хурга бойжуулан 20кг ноос илүү тушаажээ. Энэ жил 400 гаруй хонь хариуцан маллаж байна. Бүх хонь нь дундаас дээш тарга хүч авч 200 гаруй хонь төллүүлж төлөө хорогдолгүй бойжуулахын тулд өөрсдийн хүчээр 1500кг өвс түүж 1000 кг хужир татаж 30 гаруй литр айраг сүү нөөцөлж авжээ. Одоо төлөө хөрөвжилтийн эхний үе шатаар



бойжуулахын тулд хоёр пүнзийг доторлон дулаалж өнгөрсөн жилийнхээ амжилтыг улам бататгахаар чармайн ажиллаж байна.

Ч.Цэндоо

Зураг дээр:

Хоньчин Ц.Мандарваа

85. Амлалтаа биелүүлнэ // Говийн мэдээ.- 1972 оны 3-р сарын 6.- №19.- 3-р нүүр.

Амлалтаа биелүүлнэ

Цогтцэций сумын “Их Шанхай” нэгдлийн Сийрст бригадын ямаачин Ө.Жуумаа 10 гаруй жил нийгмийн ямаа хариуцан маллаж 1971 онд 210 ямаанаасаа нэгийгч хорогдуулалгүй онд оруулсан. Ер нь сүүлийн арван жил зүй бусаар хорогдуулаагүй ажээ. Энэ нь төлийн болон өвлийн бэлтгэлийг сайн хангадагт байгаа юм. Эднийх сайн тохижуулсан 3-н хос хороо, гурван Пүнзтэйн өөрсдийн хүчээр 2000 кг нарийн өвс, хатаасан таана, таанан зоодойг хүрэлцээтэй бэлтгэжээ. Ингэж ажилдагаас мал нь хүч тарга сайтай онд бүрэн орж

түрүүчийн 2 жил БНМАУ-ийн аварга малчин цолыг хангажээ.

Одоо ишиглэсэн ямаагаа ойрын нөөцөлсөн бэлчээрт Жуумаа өөрөө хариуцан сувай ямаагаа гэрийн бусад хүмүүст хариуцуулан маллуулж байна. Эднийх жил бүр ноолуур, сүү ашиглах үйлдвэрлэлийн даалгаврыг давуулан биелүүлж отор нүүдэл сайн хийж мал таргалуулах талаар сум бригаддаа нэртэй ямаачин болжээ. Энэ жил 217 ямаа төллүүлж МАХН –ийн төв хорооны 9 –р бүгд хурлын заалтаас 5–аас доошгүй ишиг илүү бойжуулах амлалт үүрэг аваад биелүүлэхээр чармайн ажиллаж байна.



Зураг дээр: Тэргүүний ямаачин Ө.Жуумаа

Гэрэл зурагчин Ч.Цэндоо

86. Ямаачин Должин // Говийн мэдээ.- 1972 оны 3-р сарын 23.- №24.- 1-р нүүр.

Ямаачин Должин

ЯМААЧИН ДОЛЖИН	
<p>Баяндай сумын "Гурван сайхан" нэгдлийн Төхөм бичигчид ямаачин Шоохорын Должин малч хичээнгүй ажиллагаагараа нутгад усмалдаг нэрэв гарсан ямаачин юм. Должин охинтойгоо хамт нэгдлийн 380-гад ямаа маллаж энэ жил 170 ямаа төлдүүлэх юм. Одоо 153 ямаа төлдүүлж төл нь 140 хувь болжж байна. Ямаачин Должин: Миний ямаа сүү жилбэ сайтай төлийн цагцац, өсөлт торилд сайн байгаагийн гол нь өнгөрсөн зун намрын улиралд малдаа тарга хүч сайн, авахуусна үрдү юм. Бид малынхаа тарга хүчинг алдахгүйн тулд өвөл хаврын бэлчээрийг нарийн хувиартай ашигладаг. Минийх бэлчээр ашиглагчдын зурагтай байдаг. Нэгээс хоёр өнжөөд малдаа хулгийн усар тогтмол усалдагийн дээр хотондоо баинга хужиртай байдаг. Өнөл хаврын улиралд малдаа аль болохоор эрт бэлчээж, нар жаргатад илгээгдүүлдэг. Энэ бүхний үрээр мал</p>	<p>тарга хүч сайтай онд өрж, сүү жилбээр сайн төлдөж байна. Хүн тарга нимгэнтэй хижээл ямаа, төлөх зүсэг ямаадыг 12 дугаар сардас эхлэн өдөр тутам 200 гр багсармал тэжээлээр тэжээж төлдүүлээд одоо ч үргэжэжн тэжээж байгаагас төлөн сайн цагцац сүүтэй байна гэж ярьв. Эднийх одоо төлдөсөн ямаа борлон 40 гаруй цагцацар, дэвтээсэн багсармал тэжээлээр өдөр бүр тогтмол хэмжээгээр тэжээж байна.</p> <p>Должин гуай ингэж уйгагүй ажилладаг учир өнгөрсөн онд маллаж байсан 162 боронгоо бүрэн онд оруулж нэгдлээс зарласан нэг настай мал онд оруулах бэлдэл хангаж шагнав эмчээ. Энэ жилч дээрх амжилтаа бататгаж одоо байгаа 100 гаруй борлонгоо онд бүрэн оруулахаар чармайн ажиллаж байна. Должин гуай өнгөрсөн онд төл бойжилт, мал онд оруулах ашиг ним ашигдал таараа сумандаа шалгарч</p>

87. Настны зүтгэл // Говийн мэдээ.- 1972 оны 3-р сарын 6.- №19.- 3-р нүүр.

Настны зүтгэл

Баян-Овоо сумын “Говийн хөгжил” нэгдлийн Могой бригадын гишүүн Ц.Гааран эмгэн Дуламсүрэн нар насны тэтгэвэрт гарсан боловч нийгмийн 600 шахам хонин сүрэг малласаар байна. Тэд энэ жил 233 эм хониноос 233 хурга хүлээн авч бойжуулсаны гадны ноос бэлтгэх үйлдвэрлэлийн даалгавраа бүрэн биелүүлжээ. Хариуцсан маллаж буй хониндоо хүч тарга авхуулхаар орон гэрээ хөнгөлж оторт гарч ус бэлчээр сайтай нутаг дагаж нүүдэлж хониндоо онгийн тарга хүч авхуулсан байна. Эмгэн С.Дуламсүрэн ярихдаа бидний чадал тэнхээ хэдийгээр муудсан боловч ган гачигтай байгаа энэ хүнд нөхцөлд чадлийнхаа хэрээр ажиллаж нэгдлийнхээ сүргийг онд бүрэн оруулж төлийг нь хорогдолгүй бойжуулна. Малчин бид урьд хувийн аж ахуйтай байхдаа малаа онд оруулах гэж өвс тэжээлээ өөрсдөө л бэлтгэдэг байлаа одоо чинь улс аймаг нэгдлээс их анхаарч машин машинаар л өвс тэжээл буулгаад өгөх юм. Манай аймгийн нутаг бүхэлдээ гандаж хүнд л болж байгаа юм байна.

Нам засгаас анхаарал тавьж сайхан туслалцаа үзүүлэж байна. Нэгдэл маань өвс тэжээл их л өгөх сурагтай түүнд нь нэмэр хачир хийх санаатай жаал гоёо ухаж өвс шимт тэжээл бэлтгэж байна. Эдний хонины хүч тарга өнгө зүс сайтай байна.



Зураг дээр: Хоньчин
С.Дуламсүрэн

Гэрэл зургийг Ч.Цэндоо

88. Хоньчин Лувсанноров // Говийн мэдээ. - 1973 оны
1-р сарын 11.- № 3.- 2-р нүүр.

Хоньчин Лувсанноров



Ханхонгор сумын Өлзийт нэгдэлийн Өгөөмөр бригадын хоньчин Лувсанноров МХЗЭ-ийн илгээлтээр 1971 онд мал ахуй дээр гарчээ. Лувсанноров эх Жаргалын хамт нийгмийн 218 төллөх хонь хүлээн аваад 2 жил маллаж байна. Энэ хугацаанд БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар Д.Аюурзана, тэргүүний хоньчин Цэрэнжаа, Мядаг нарын хонь малладаг арга туршлагаас суралцаж ахмад малчдынхаа үлгэр жишээгээр ажиллаж байна. Өнгөрсөн 2 жил үйлдвэрлэлийн даавгавраа 100-110 хувь биелүүлж, 1972 онд 218 хониноос 234 хурга бойжуулж сумын хамгийн залуу аварга болжээ. Өнгөрсөн зун тус сумын нутагт хур бороо бага орсноос нилээд гандуу, малд хүч тарга авахуулах ажил бэрхшээлтэй байсан боловч илгээлтийн эзэн Лувсанноров мал сүрэгтээ тарга хүч авахуулахын тулд Дөрвөлж, Хөх эрэг, Гашуун зэрэг нутгаар 10-аад удаа отроор нүүж хониндоо дундаас дээш хүч тарга авахуулсан байна.

Одоо эднийх Хонгор-Овоогийн Гэээгийн бууцанд тохилог өвөлжиж байна. МАХН-ын Төв Хорооны 4 бүгд хурлын шийдвэрийн дагуу өвөл хаврын бэлтгэлээ хугацаанд нь бүрэн хангаж авс 3000 кг, таана, хөмүүл зоодой 300 ширхэг, хужир 1000-аад кг, хөх хоргол хүрэлцээтэй бэлтгэж хороо бууцаа дулаалжээ. Хоньчин Лувсанноров тарга хүч дутмаг авсан төллөх 90 гаруй хонийг 10 дугаар сараас эхлээд хүчит тэжээлээр тогтмол тэжээж байна. Малаа хушуувчаар тэжээдэг. Малыг хушуувчаар тэжээхэд тэжээл үрэгддэггүй, тэжээж байгаа мал жилгд тэжээгдэж тэжээл авахдаа сайн байдаг. Шинээр төллөх зусаг хонийг байнга тэжээж байвал төллөхдөө сүү жилбэ сайтай хургаа голохгүй, барьж тавихад номхон төлөв байдаг. Манайх хонио байнга усалдаг. Ус дутагдсан мал зутрахдаа амархан их даараг байдаг юм. Хониныхоо бэлчээрийг хуваарьтай ашиглаж, ойрын бэлчээр нөөцлөн, өглөө хонио алсын нөмөр сайтай бэлчээрт шууд тууж гарган хариулж байгаад орой шууд хотлуулдаг. Иймд төлийн бэлтгэлээ бүрэн хангасан

Ч.Цэндоо

89. Сүрэг тарган // Говийн мэдээ.- 1973 оны 1-р сарын 18.- №5.- 3-р нүүр.

Сүрэг тарган



Ханын хэцийн
энгэрийн Өндөр шарын
бууцанд Ханхонгор сумын
Өлзийт нэгдэлийн
тэмээчин, улсын аварга
төлчин

Г.Өлзий, Мандал овоо
сумын Хөдөлмөр

нэгдлийн тэмээчин Д.Хамарынхтай айсан тохилог

Говийн мэдээ сонин

өвөлжиж байна. Долоон жил нэгдлийн тэмээн сүргийг маллаж байгаа Д.Хамарынх хөдөлмөрийн баатар Д.Жижээгийн тэмээ малладаг туршлагаар ажиллаж байна. Эднийх өнгөрсөн онд ээлжийн 30 ингэнээс 30 ботго бойжуулж, энэ жил ботголох 39 ингэнийхээ төлийг хүлээж авах бэлтгэлээ хангаж, хээл авах 44 ингээ нийлүүлгэнд оруулаад байна. 1972 оны ноос, сүүний үйлдвэрлэлийн даалгавраа хугацаанд нь давуулж, бэлчээр, ус тэгш нутаг сонгон 8 удаа нүүдэл хийснээр хариуцан маллаж байгаа 210 тэмээ нь хүч тарга сайн авчээ. Эднийх бэлтгэж авсан морин шарилж, гоёо, хайлсны навч, гар тэжээлээр 30 гаруй тором тэжээж байна.

Тэмээчин Д.Хамарынх өвөл хаврыг өнтэй давж мал сүргээ онд мэнд оруулж, МАХН-ын Төв Хорооны 4 бүгд хурлын шийдвэрийг биелүүлэхээр ажиллаж байна.

Ч.Цэндоо

90. Ямаачин С.Дугар // Говийн мэдээ.- 1973 оны 1-р сарын 25.- №7.- 2-р нүүр.

Ямаачин С.Дугар



Ханхонгор сумын Өлзийт нэгдлийн Мандах бригадын ямаачин, аймгийн депутат С.Дугар ямааны ноолуурыг бүрэн авч ноолуурын чанарыг сайжруулах талаар санаачилга гаргасан тэргүүний малчин юм.

Энэ малчин ямааг 3 дугаар сарын 20 ноос эхлэн самнаж 4-р сарын 20 гэхэд бүрэн дуусгадаг байна.

Ноолуурын гарцыг сайжруулахын тулд зун намрын улиралд ус, бэлчээр тэгширсэн нутаг сонгон авч ямаандаа дээд зэргийн тарга хүч авахуулаад ямаа самнах хугацаа болохын өмнө агь, шаваг эрт нүдэлдэг, говь сайтай нутагт нутаглаж, ямааныхаа ноолуурыг хөндийрүүлдэг. Хялгас багатай ноолуур авахын тулд самнахыг урьд хягасны ээдрээг урьдчилан санаж гаргаад жирийн самаар бүх биеийг нь самнаж ноолуураа авсны дараа хоорондоо 4 мм зайтай, 26 нарийн шүдтэй, эсвэл үсний жижиг самаар самнаж ноолуурыг нь бүрэн авдаг. Ямааны шил бүдүүн хүзүү, хонго, цавь, гэдсэнд их хэмжээний ноолуур үлдэж үрэгддэг. Түүнийг нь чигжүү шүдтэй нарийн самаар самнахад бүрэн авагддаг ажээ. Ноолуурын хялгасыг саманд нь байхад бүрэн түүж чанарыг сайжруулдаг байна.

Үүний тулд нэг ямаа самнахад хэд хэдэн ээлжийн сам хэргэлдэг байна. Ямаачин С.Дугар ямааг нэг барилтаар л самнаж дуусгадаг. Самнах ямааныхаа хөлийг 2.2-оор нь боож тэлэх байдлаар хэвтүүлж, эврээс нь оосорлон халзад нь хүзүүг сунгах байдлаар уяж самнахад ямааны гэдэс дүүрэх, тийчлэх явдал гардаггүй байна. Дээрх байдлаар гаж самнахад ноолуур чөлөөтэй, бүрэн гүйцэд гардаг байна. Ямаа самнах үед өглөө эрт босож самнаад 10-аад ямаа авч дэж бусдыг нь бэлчээрт явуулдаг. Ингэж өдөрт ямааг цөөн цөөнөөр нь самнахад ямааны бэлчээрлэлт тарга хүч авалтанд нөлөөлдөггүй байна.

Ямаачин С.Дугар нь ямааны ноолуурыг бүрэн авах арга ажиллагааг эзэмшсэнээр 1966 оноос хойш гол эм ямаа нэг бүрээс 270-320 гр ноолуур авч нэг ямаанаас авах ноолуурыг 20-50 гр –аар нэмэгдүүлж сумын ноолуурын олон удаагийн аварга болжээ. Ямаачин С. Дугарынх энэ жил төллөх 200 шахам ямааныхаа төлийг

хүлээж авах бэлтгэлээ бүрэн хангаж Хавцалын хэцэд сайн өвөлжиж байна.

Ч.Цэндоо

91. Моторчин, Малчин // Говийн мэдээ.- 1973 оны 3-р сарын 22.- №22.- 3-р нүүр.

Моторчин, Малчин

Одоогоос 17 жилийн өмнө Зөвлөлтийн нэгэн мэргэжилтэн ирж яг энд ухахад маш элбэг ус гарна гэж заажээ. Буяхан талд ус гаргана гэхэд хавь нутгийн буурлууд нь гайхаж, залуучууд нь баярлаж байв. Удсан ч үгүй ган өрмийн эрчээр газрын гүнээс ус ориглож, атаршиж байсан энэ уужим тал адуу малын бэлчээр болжээ.



1962 оны 5-р сард уг худгийг Н.Лувсанд хүлээлгэн өгөв. Энэ үеэс эхлэн явал моторт худгаа гэмтэл сааталгүй ажилуулж, мал сүргийг усаар таслахгүй, хүлээлэгсэн үүргийг нь нэр төртэй биелүүлэх вэ? Гэдэг бодол санаа Лувсангийн бодол санааг эзэмджээ. Мод төмөр оролддог багын авъяас, уйгагүй нямбай ажилч чанар нь тус болж төдөлгүй курст явж мэргэжил эзэмшсэн нь түүний бодол санаа биелэх үндэс болов. Өндөр Лувсан өрөмдмөл худгийн моторчноор 11 жил ажиллаж байгаа. 4-р зэргийн мэргэжилтэй моторчин төдийгүй сайн малчин хүн. Лувсан энэ худгийг 11 жил ажиллуулахдаа гэмтэл саатал гаргаж, мал сүргийг усаар гачигдуулж байсангүй. Өөрийн ажил мэргэжилд өдрөөс өдөрт өсөж худгийнхаа ойр зуурын засварыг бүрэн хийж чаддаг бол бүх механизмд нь үзлэг үйлчилгээг тогтмолжуулсан явдал худаг ямар

нэгэн гэмтэл сааталгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Энэ худаг 6 тоннын багтаамж бүхий сантай, онгоцонд нь 4 тонн ус ордог юм.

Лувсан өдөрт 8-10 цаг мотороо ажиллуулж зуны цагт шөнийн харанхуй болтол ирсэн бүх малыг услаж гаргаад, онгоцоо дүүргэж орхиод өглөө эрт босч мал услах ажилдаа гарна. Энэ завсар ирсэн мал онгоцтой уснаас уугаад хүлээж зогсолгүй бэлчээртээ гардаг байна. Харин өвлийн цагт бол өөр юм. Хүйтэн онгоцонд ус хийж орхих аргагүй учир мал ирэхийн тоогоор босч усалдаг байна. Өвөл онгоцныхоо сүүдэр талыг хааж наран талыг ашигласан нь мал тав алдахгүй, тохитой ундлах нэг нөхцөл болжээ. Худгийнхаа оройд гэрэл тавьснаар шанийн цагт адуу мал айж цочиж, хальтарч унахгүй, ханатлаа сайн ууж чаддаг ач холбогдолтой зүйл болсон байна.

Лувсан гуай ярихдаа: Энэ өвөл хэд хэдэн сумын олон тооны адуу үхэр уруудан иржээ. Өдөр бүр 500-800 адуу тогтмол услаж байв. Өнөө жил урьд урьдаас их хөдөлгөөнтэй, усны маш их гүйлгээтэй өвөл байлаа. Холоос уруудан ирсэн адуу андаш байдаггүй. Гэдэс хээл муутай, сүүл нь бөөнтсөн байдаг.

Нутгийн биш уруудан ирж ууж байгаа малын им тамга, содон тэмдгийг сайн ажиг салхи жаврыг нь сөргүүлэн залдаг. Манай усыг уусан мал заавал дахин эргэж ууж, бэлчээршдэг юм гэж байна. Үнэхээр зуу зуун мал эндээс ундалж, энэ бэлчээрт тогтож, олон хүн Лувсангаас малынхаа сургийг дуулан олж, баярлаж гялайснаа илэрхийлээд буцдаг байна.

Лувсан гуайтай уулзахад худгаа магтана, усыг нь рашаан, ундагыг нь далай, хөрсийг нь чандмань эрдэнэтэй зүйрлэнэ. Ус байсан газар ургамал ургахгүй

хөрс гэж алга юм. Сүүлийн 5 жил турших байдлаар идэшний янз бүрийн ногоо тарьж үзсэн, тун сайн ургасан. Талбайгаа нэмэгдүүлж малын тэжээлийн ургамал таривал овоо ургац авч болно гэж боддог. Нэгдэл маань бас л бодож байгаа байх гэж хэлнэ. Ийнхүү Баян-Овоо сумын Бунхан талын ерөмдмөл худгийн моторчин Лувсан гуай хичнээн олон мал ууж л байвал сэтгэл нь ханаж, ажил нь бүтэж байгаа нь тэр. Энэ чанараараа малчин олны хайр хүндэтгэлийг хүлээж байна.

Б.Тогтох

92. Малчны нэг өдөр // Говийн мэдээ.- 1973 оны 4-р сарын 16.- №29.- 2-р нүүр.

Малчны нэг өдөр

Уул талын цас хаврын уринд аль эрт гол горхи болон урсч, ши нэ төлийн шингэн дуу малчны хотонд хаджээ. Хаврын урь, малчны баясгалан ингэж ирдэг билээ.

Урин салхи зөөлөн сэвэлзэж байсан тэр нэгэн орой бид сумын төвөөс гарч Өгөөмөр бригадаар орж, бригадын дарга Бадамгаравтай уулзаж чиг заалгаж



үдшийн шар гэгээ алдархын үед зүүн зүгийг чиглэн явлаа. Биднийг шинэхэн хом зам хөтлөн явсаар нэгэн хар толгойн араар ороож хос хороотой малчны суурьт хүргэв. Шөнийн харанхуйгаар дэнлүү барьсан малчид хотондоо төл хөхүүлж мал тэжээж явна. Гэрт оруул урьдын таних Гончиг, Мүнсэл гуай нар угтан мэндэлж сайхан зантай Мүнсэл хол ойрын сониныг асууна. Залуу байхад өөрийн хүүхдүүдэд дарагдаж байлаа. Одоо зээ

нарт дарагдаад л байна даа хүү минь. Их хүүхэн суманд ажиллаж байгаа. Сумъяа маань 1963 онд 8-р ангиас мал дээр гарч ажилласан. Энэ хугацаандаа 4 хүүхэд төрүүлсэн, бага охин Гүндмаа 1971 онд 7-р ангиа төгсөж эвлэлийн илгээлтээр ирсэн. Гаднаас дэнлүү барьсан нэгэн охин орж ирээд бидэнтэй мэндлээд, төлд тэжээл өгөхөөр сүү, төлийн угж аваад гарав.

Энэ өдөр өрхийн тэргүүлэгч Гончиг гуай Нүдэнгийн худагт хонио услаж Цагаан хамрын зоонд хонь хариулж яваад иржээ. Гүндмаа адуу тэмээгээ цуглуулж услаад цагаан ингэ ботголох төлөвтэй байсан учир гаднаа авчирч, эгч Сумъяатайгаа хамтран хурганд өвс тэжээл өгөлцөөд, ус авч хургандаа дараагийн өдөр өгөх 10 литр тэжээл чанаж боловсруулав. Орой нь хургаа бага, дэнд, их хөрвөөр нь ялгаж байранд нь хийж, хонинд явсан ааваа тосож авч, ингэний сүүтэй нэмэгдэл тэжээл хургандаа өгчээ.

Ханхонгор сумын Өгөөмөр бригадын хоньчин О.Гончигийн суурийн малчид ийнхүү ажлын хуваарьтай ажилладаг. Хөдөөгийн суурийн малчдын нэг өдрийн ажил шөнийн 22 цаг өнгөрч байхад дуусч, халуун ам бүлээрээ цугларав. Гүндмаа, Сумъяа нар завчилж шинэ сонины дугаарууд уншиж “Монгол орны бэлчээрийн мал маллагааны арга туршлага” гэсэн ном уншиж байв. Эднийх нийгмийн 442 хонь хариулан малладаг. Үүнээс энэ жил 337 нь төллөж Төл бүрэн гэсэн бяцхан улаан дарцаг дэрвэж байна. Хараатын хар овооны бууцанд хаваржиж байгаа хоньчин Гончигийнхны нэгэн өдрийн ажлыг сурвалжлан тэмдэглэхэд ийм буюу.

Ч.Цэндоо

93. Туршлагатай тэмээчид // Говийн мэдээ.- 1973 оны 4-р сарын 19.- №30.- 3-р нүүр.

Туршлагатай тэмээчид

Ханхонгор сумын Өлзийт нэгдэлийн Өгөөмөр бригадын тэмээчин Самбуу түүний гэргий Д.Манхай нар 1959 оноос хойш нийгмийн тэмээн сүрэг хариуцан ажиллаж үзэмж туршлага хуримтлуулсан малчид юм.



Эднийх өвлийн улиралд тэмээнийхээ хэвтрийг хөлдөөхгүй хуурай байлгахын тулд өглөө бүр торомтой ингээ босхоос нь өмнө тормыг нь босгож түмпэн саванд шээлгэж, дараа нь ингээ босгож зэлнийхээ гадна

аваачиж шээлэгдэг байна. Мөн тэмээний хэвтрийн хорголыг өдөр бүр хамж хурааж хатаагаад аргал бэлтгэх үйлдвэрлэлийн даалгавартаа өгдөг заншилтай юм.

Тэмээнийхээ ноосыг тушааж дуусмагц бэлчээрийн соргог дагаж отор нүүдэл хийж тэмээн сүргээ байнгын маллагаанд байлгаж хүч тарга сайн авахуулдаг ажээ. Ботголох ингийг гаднаа ботголуулаад ботгыг эхтэй нь хамт 7-8 хоног бэлчээрт явуулж торниулаад уяж номгоруулан 6-р сарын 20 хүртэл эхийн сүүгээр махлуулж тарга сайн авхуулдаг байна. Эднийх өнгөрсөн өвөл бололцоо бүхий нутагт өвөлжиж хариуцан маллаж байгаа 200 гаруй тэмээгээ онд бүрэн оруулж энэ жил ботголох ингэ бүрийн төлийг хоргдолгүй бойжуулж байна.

Ч.Цэндоо

94. Ямаачин Нарангийн туршлага // Говийн мэдээ.-
1973 оны 4-р сарын 19.- №30.- 4-р нүүр.

Ямаачин Нарангийн туршлага

Цогт-Овоо сумын Жаргалант нэгдлийн Бортээг бригадын ямаачин Л.Наран 1964 оноос эхлэн ямаан сүрэн хариуцан маллаж байна. Ямаачин Наран хариуцсан ямаан сүргийнхээ ноолуурын үйлдвэрлэлийн даалгаврыг жил дараалан давуулан биелүүлж сумын ноолуурын аваргаар 4 удаа шалгарчээ. Эднийх ноолуурын төлөвлөгөөг зөвхөн давуулаад зогсохгүй чанарыг сайжруулж ямагт нэгдүгээр зэрэгт тушаадаг юм. Наран энэ жил бүх ард түмний социалист уралдаанд авсан үүрэгтээ ямааны ноолуурын үйлдвэрлэлийн даалгавраа давуулан биелүүлж бүх ноолуураа нэгдүгээр зэрэгт тушаах зорилттой ажиллаж байна.

Нарангийн ямаа самнадаг гол арга нь ямаагаа 4-р сарын 1-ээс 5-р сарын 1 хүртэлх хугацаанд багтаан самнаж дуусгадаг. Самнах бүх ямаагаа эхлэх хугацаанаас дуусах хугацаа хүртэлх хоногийн тоонд хувааж, өдөрт самнах ямааныхаа нормыг тогтоож түүндээ уялдуулан төлөвлөгөө гаргаж энэ төлөвлөгөөгөө хатуу баримтлан ажилладаг юм. Ямааны ноолуурын чанарыг сайжруулахын тулд ямааг сөрмөж хяргаад хатуу үстэй сойзоор сойздоод 3 хоногийн дараа самнадаг байна. Сөрмөж хяргасан ямааг 3 хоногоос илүү удаавал ноолуур хаягддаг ажээ.

Ямааг эхлээд самнахдаа хол шүдтэй самаар самнаж дараа нь ямаа нэг бүрийн ноолуурыг бүрэн авахын тулд шигүү жижиг шүдтэй самаар ямааны суу булчин, ар шил, чихний ар, их биеийг дахин самнаж ямаанаас авах ноолуурын хэмжээг нэмэгдүүлдэг байна. Ямаагаа аль нөмөртэй хашаа, пүнзтэй газар самнадаг.

Ямааг самнаж байх үедээ ямаа тус бүрээс гарч байгаа ноолуурыг дор бүрд нь хэмжиж аль нь бага

ноолуур өгч байгааг нарийн мэдэж их ноолууртай ямаагаа цаашид үржүүлэх байдлаар малладгаас Нарангийн хариуцсан ямаан сүрэг нь ноолуур сайтай шилмэл суурь болсон байна.

Ж.Жаалбаатар

95. Ботго бойжуулахад // Говийн мэдээ.- 1973 оны 5-р сарын 17.- №37.- 3-р нүүр.

Ботго бойжуулахад

Тэмээн сүргийг өсгөн, ашиг шимийг арвижуулахын үндэс нь ботго бүрийг мал болгох явдал юм. Энэ нь ингэ бүрт тарга хүч сайн авахуулж, бүрэн хээлийг хамгаалах, ботго хүлээн авах бэлтгэлийг хангах ажлаас эхлэх хэрэгтэй. Ингэ хээлээ 13-14 сар тээж 3-5 дугаар сарын хооронд ботголдог учраас одоо ботго бойжуулах ажил ид явагдаж байна.

Хээлтэй ингийг бударгана, багалуур, шар мод, шаваг, цагаалжтай нөмөрлөг бэлчээрт хариулбал зохино. Хээлтэй ингийг ширүүн хөөж тууж болохгүй. Бэлчээр ус хэвтрийг сайн тохируулан дулаан зөөлөн хөрстэй нутаг сонгон бууж ингээ ботоглуулах хэрэгтэй. Ядарч доройтсон ингийг шимт болон шорвог тэжээлээр тэжээж, хот бууцыг цэвэрлэх, ботгоны нэмнээ, зулайн оройвч, уяа, ногт, угж зэргийг урьдаас бэлтгэсэн байвал зохино. Ботголох дөхсөн ингэ нь тогтворгүйтэж шилрэх, хүнхрээ бууж нүдэнд нь нулимс гүйлэгнэж, гунганаж буйлах, алсыг харан зогсох, дэлэн, гуяны дотор талын үс нь халцрах зэрэг шинж тэмдэг илэрнэ. Төрөлтийн үеэр ботгоны урд хоёр хөл толгой нь цухуйсан даруйдаа эхийнхээ хөдөлгөөнд гэмтэж болзошгүй байдаг.

Иймд малчин хүний туслалцаа хамгийн шаардлагатай. Ботголж байгаа ингийг босгохгүй

хөдөлгөөн багатай байлгаж хажуулдуулан хэвтүүлж чадвал ботгоо саадгүй гаргана. Ботгыг гармагц нь бүрхүүл хальсыг хагалж, амьсгал авахгүй байвал чих хамар руу нь үлээнэ. Тэгээд үсий нь хатаагаад дулаан хучна.

Ботгыг эхэд нь хөхүүлэхээс өмнө 100-200 гр давстай бүлээн хар цайгаар амлуулбал ботгоны хар зунгаг хөөгдөн гарч чацарайлхаас хамгаална. Амлуулахын өмнө эхийн хөхний бөглөөг шувтарч гаргаад цагаан уураг гартал сааж дараа нь ботгоо хөхүүлнэ. Ботго бусад төлийг бодвол нилээд бээрэг бөгөөд гэдэс нь өвчилж чацага алдах, уушигны хатгалгаа тусах нь цөөнгүй тул түүнийг хөл дээрээ тэнцсэний дараа олон удаа хөхүүлж байх шаардлагатай.

Ботгыг уяанд сургахдаа эргүүлэгтэй уяагаар өвдөгнөөс дээхнүүр уяна. 10 хоносоны дараа ногтоор уяж сургана. Хагас сар хиртэй болсон хойно ботгыг өглөөний нарнаар эхтэй нь хамт ойр бэлчээгээд хурааж уяна. Ногоо жигдэрч гарах хүртэл ботго эхийн сүүгээр хооллодог. Өвсөнд орсон үеэс эхтэй нь ойр бэлчээх, өвстэй газар аргамжиж байх хэрэгтэй.

Ботгыг ханиах чацага алдахаас сэргийлж гоёоны ханд давстай ус өгч байвал эрдсийн дутагдлаас сэргийлж эхийнхээ үс ноосыг зулгаах, шүд нь өвчлөхөөс хамгаалагддаг. Ботгыг багаас нь усалж сургах, зуны халуунд наршуулахгүйн тулд өндөрлөг, салхитай буюу сүүдэр газар аргамжиж зулай зоогий нь хүйтэн усаар шавших хэрэгтэй. Ботгоны өсөлт торинолт эхийнх нь тэжээллэг, арчилгаа, маллагаанаас шалтгаална.

Ботголсон ингэ нэг хоёр долоо хоног ботгондоо хоргодож бэлчээрт чавахгүй өлдөж сүү шим нь мууддаг. Энэ үед ингийг зориуд тууж бэлчээх, усалж хужирлах,

нэмэгдэл тэжээлээр тэжээх хэрэгтэй. Хөрвөжсөн ботгыг зун, намарт хээрийн нялх ногоотой сэрүүн газар хариулах хэрэгтэй.

Өвлийн цагт ботго тормыг эр сувай тэмээнээс тусгаарлаж эхийнх нь хамт дулаан нөмөр, ус, бэлчээр сайтай нутагт идээшүүлж хэвтэр бууцыг нь тогтмол засч, хашаа саравчинд өвөлжүүлэх нь чухал байна.

Х.Давгадорж

96. Говийн тэмээчин // Говийн мэдээ.- 1973 оны 6-р сарын 4.- №42.- 3-р нүүр.

ГОВИЙН ТЭМЭЭЧИН

Хүрмэн сумын “Сүхбаатарын зам” нэгдлийн Жанжин бригад манай өмнөд хэсэг говийн говьд оршдог. Х.Чулуун ажил хөдөлмөрөөрөө тодрон аймгийн нэгдлийн 3 бага хуралд оролцсон юм.

Энэ тэмээчин эмэгтэй ярихдаа: Би 1961 оноос эхэлж 13 жил тасралтгүй тэмээ маллаж байна. Тэмээг өвлийн улиралд нөмөртэй дулаан газар бэлчээрлүүлж, цастай байсан ч тогтмол усалж байвал бээрч даардаггүй тогтвортой байдаг юм. Хаврын улиралд тэмээг заг, бут, бударгана, голлосон модлог, хужирлаг бэлчээрт хариулна. Хавар ноосны цагаар хашаа хороотой байвал ноослоход хялбар байдаг.

Намрын улиралд тэмээг ширүүн хөөж тууж зүдрээхгүй, ногооны сөлтэй газар бэлчээрлүүлж хариулж байвал тарга хүчээ бүрэн авдаг сайн талтай. Манайх хүний хөдөлмөр хөнгөвчлөх, олон тэмээг богино хугацаанд услахын тулд 1964 оноос эхлэн мэлхий насос ашиглаж тэмээгээ услаж байна. Өвөл хаврын улиралд хивэг багсармал тэжээлийг онгоцонд хийж тэмээ усалдаг

болсон. Энэ нь тэмээний тарга хүчийг тогтоох, ингэний хээлийг хамгаалах, ботготой ингийг сүү оруулах зэрэгт зохих үр нөлөө үзүүлж байна.

Энэ жил манай нутагт өнгөрсөн жилүүдийг бодвол эрт бороо орж ногоо гарч байна. Олон жил ган зудад нэрвэгдсэн малаа эртнээс бэлчээрийн соргогийг дагуулан маллахгүй бол бүрэн тарга авч чадахгүйд хүрч магадгүй учир отор нүүдлийг урьд урьдаас илүү сайн хийх нь зүйтэй юм. Х.Чулуун сүүлийн 3 жилд дунджаар тэмээ бүрээс 5-5,3 кг ноос, саалийн ингэ бүрээс 60-75 литр сүү сааж ашигласнаар сумын ноос сүү ашиглалтын 1971-1972 оны аваргын болзол биелүүлжээ.

Одоо 258 тэмээ маллаж байгаа ба ээлжийн 35 ингэнээс 35 ботго бойжуулж, тэмээний эр ноосны төлөвлөгөөг биелүүлээд байна. Цаашид үйлдвэрлэлийн даалгавраа бүрэн биелүүлэх зорилттой ажиллаж байна. Тус аймгийн нэгдэлч малчдын дундаас ажил хөдөлмөрөөрөө тодорсон Х.Чулууныг аймгийн нэгдлийн 3-р бага хурлаас нэгдлийн холбооны 4-р их хуралд төлөөлөгчөөр оролцуулахаар санал нэгтэй сонгов.

Н.Насандолгор

97. Мал аж ахуйн хөдөлмөр зохион байгуулалт хийсэн дүн // Говийн мэдээ.- 1973 оны 10-р сарын 11.- №75.- 3-р нүүр.

Мал аж ахуйн хөдөлмөр зохион байгуулалт

хийсэн дүн

МАА-н хөдөлмөр зохион байгуулалтыг тус аймагт, шинэчилэн хийх бэлтгэл ажилыг 8-р сарын 1-ээс 10 хүртэл бүх нэгдлүүдэд хөдөлмөр зохион байгуулалт хийх түүний ач холбогдлыг сайн ойлгуулахаар ухууллагын

ажлыг өргөн явууллаа. Мөн нэгдэл, бригадын ажиллах хүчний судалгаа гаргаж хүн хүчиндээ малаа зохицуулах, бригадын хооронд зарим малыг шилжүүлэх зэргээр жигдрүүлж хэн хэнийх нэг суурь болох, ямар сууриудаар хэсэг болох, суурь хэсгийн ахлагчаархэнийг болгох вэ? Гэдгийг нарийн боловсруулсаны гадна аймгийн намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас зохион байгуулалтын олон чухал арга хэмжээ авч сум бригадын удирдлагуудыг хөдөлмөр зохион байгуулалт хийх талаар тодорхой семинараар хангалаа.

Эдгээр ажилуудын үр дүнд МАХН-ын Төв хороо, Сайд нарын Зөвлөлийн 1963 оны 210/330 дугаар тогтоолыг үндэслэн хэсэг суурийн зохион байгуулалтыг 8-р сард багтаан бүх нэгдлүүдэд хийж дуусгалаа. Аймгийн хэмжээгээр нийгмийн бүх малыг 1409 суурь, 180 хэсэг 844 бригадад зохион байгуулаад байна. Хөдөлмөр зохион байгуулалтыг Ханхонгор, Цогт-овоо, Хүрмэн, Ханбогд сумын нэгдлүүд жинхэнэ боловсруулсан удирдамжийн дагуу хийж, нэг суурийн айлуудыг айл суулах, малын хөдөлгөөнийг бүрэн хийж дуусгах, хэсгийг дүрмийн дагуу зохион байгуулах талаар нэлээд сайн ажилласан байна. Гэтэл зарим сум, нэгдэл суурь хэсгийн зохион байгуулалтыг цаасан дээр хийгээд жинхэнэ амьдралд муу хэрэгжүүлж байгаа дутагдал байна.

Мандал-Овоо сумын Хөдөлмөр нэгдэл суурийн айлуудыг айсуулах, малын хөдөлгөөнийг хийж дуусаагүй байна. Тэрч байтугай энэ оны төл малыг ялган суурилаагүй эхлээр хэвээр байна. Мөн манлай сумын “Хоёр Өлзийт” нэгдлийн удирдлагууд мал олон, хүн хүч цөөхөн учраас хөдөлмөр зохион байгуулалт хийхэд олон малын хөдөлгөөн гарган, нэг хүнд ногдох мал нормоос олон тоогоор дээгүүр оногдох бэрхшээл гарч байна гэдэг

тайлбар тавьж байснаараа тус сум хөдөлмөр зохион байгуулалтыг хангалтгүй хийсэн байна.

Мөн Манлай сумын “Хоёр Өлзийт нэгдлийн удирдлагууд мал олон, хүн хүч цөөхөн учраас хөдөлмөр зохион байгуулалт хийхэд олон малын хөдөлгөөн гарган, нэг хүнд ногдох мал нормоос олон тоогоор дээгүүр оногдох бэрхшээл гарч байна гэдэг тайлбар тавьж байснаараа тус сум хөдөлмөр зохион байгуулалтыг хангалтгүй хийсэн байна.

Сэврэй сумын “Социализмын зам” нэгдэл суурь хэсэг зохион байгуулалтыг бие дааж хийсэн боловч малын хөдөлгөөнийг бүрэн хийгээгүй зөвхөн төлийг хагас дутуу ялгасан байна. Эдгээр байдлаас дүгнэж үзэхэд манай хийсэн суурь, хэсгийн зохион байгуулалт нь мал аж ахуйн үйлдвэрлэл дээр хэрэгжиж чадахгүй хоосон ажил болж өнгөрдөг урьдын дутагдал дахин давтагдаж болзошгүй байна.

МАА-н үйлдвэрлэл, хэсэг, суурийг зөвхөн эхлэж хийснээр хангагдахгүй юм. Байгууллагдсан хэсэг, суурийг цаашид улам бэхжүүлэх үргэлжийн тогтмол ажиллагаатай болгох нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн ажиллагааг улам боловсронгуй болгож нэгдэлч олны хөдөлмөрийг зөв хоршоолох нэг үндсэн арга болж байна. Суурь, хэсэг бол малчдын хүчийг нэгтгэн зохион байгуулж, тэдний дунд үзэл суртал хүмүүжлийн ажил зохиох, нийгмийн өмч хөрөнгийг хамгаалах, малын арчилгаа маллагааг сайжруулах, бүртгэл тооцоог нэвтрүүлэх олон талын ач холбогдолтой юм. Тийм ч учраас ХАА-н нэдлийн хөдөлмөр зохион байгуулалтыг бэхжүүлэх талаар аймгийн Намын хорооны товчоо, саяхан олон чухал заалт бүхий тогтоол гаргалаа.

Б.Цэрэг

98. Хоньчин Норовсамба // Говийн мэдээ.- 1973 оны
11-р сарын 1.- №81.- 3-р нүүр.

Хоньчин Норовсамба

Жар эргэм насны хөрслөг бор царайтай эелдэг даруу зантай энэ хүнийг хэн ч харсан дадлага туршлагатай малчин гэдгийг ойлгоно. Норовсамба бага залуу наснаасаа эхлэн мал маллаж сурсан олон жилийн дадлагатай манай тэргүүний малчны нэг юм. Анх 1958 онд нэгдэлд элсэж орсноос хойш эхнэр Цогзолын хамт 15 жил нийгмийн хонин сүрэг маллаж сүүлийн 11 жилд хариуцсан малаа онд бүрэн мэнд оруулж, төлийг нь сайн бойжуулж, ноос сүүний үйлдвэрлэлийн даалгаврыг тогтмол биелүүлж иржээ.

Хоньчин Норовсамба: Мал сүргийг сайн маллаж амжилтанд хүрэхийн гол нь зун намрын улиралд отор нүүдлийг сайн хийж малдаа дээд зэргийн тарга хүч авахуулдаг явдал юм. Тийм учраас жил бүрийн 4,5-р сараас эхлэж тэмээн хөсгөөр хөнгөн авсаар гэр оронтой говь тал хосолсон ургамалтай, ургац ногоо сайтай газар дагаж ойр ойрхон олон нүүх замаар оторлож хонио таргалуулдаг. Хонийг зун намрын улиралд өдөр бүр услаж, бэлчээрт байх цагийг аль болохоор уртасгаж, өглөө эрт бэлчээж, үдийн халуунд усны орчим амрааж үдэш орой ботол бэлчээж, зарим үед хоньтойгоо хамт бэлчээрт хоноглох удаа ч олонтой тохиолддог.

Хонийг саах, хяргах ажлуудыг үдийн амралт услалтын үед нь хийж байвал бэлчээрлэхэд нь саад болдоггүй юм. Бэлчээрийг өдөр бүр сольж сэрмүүн соргог бэлчээрт хариулах нь ашигтай байдаг.

Зуны цагт олж авсан тарга хүчийг намрын цагт чамбайруулах, тогтоож авах хамгийн хариуцлагатай үе учраас намар хонийг уулын энгэр бэл, жалга судаг, голын

захын сал ногоотой газар дагуулж хариулна. Тэгэхдээ үргээж цочоолгүй зөөлөн тогтуун хариулах нь чухал. Хонио эмнэлгийн тарилга, туулга, угаалга зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд цаг тухай бүрд нь бүрэн хамруулж байвал ширх, шалз хорхойд баригдахгүй өвчин эмгэг тусахгүй сайн байдаг.

Өвлийн болон төл бойжуулах бэлтгэлийг эртнээс сайн хийх. Хавар өвөлжөөнөөс гарахдаа бууцаа цэвэрлэж сэндийлэн хөх хорголоо тусгай байранд хурааж хашаа хороондоо засвар хийж, зун намар өвс цахилдаг түүж өвөлжөөндөө хурааж авах, хөмүүл, таана гоёо зэргийн шимт тэжээл түүж бэлтгэж авдаг. Намар эртхэн их гэрээ бууцандаа буулгаж 11 дүгээр сарын сүүлч хүртэл отрын журмаар явж, өвөлжөөнд аль болохоор орой орвол ашигтай байдаг. Өвлийн бэлчээрийн цаг улирлын байдал, хээлийн хугацаа, мал төллөлтийн үе зэрэгт тохируулж нарийн хуваарьтай ашиглаж цастай ч байсан амь усаар хонийг тогтмол услаж хужраар байнга хангах хэрэгтэй. Тарга хүчээр дутмаг тэжээх шаардлагатай хонь байвал намар 10,11 дүгээр сараас эхлэж нэмэгдэл тэжээлээр тэжээх нь зүйтэй. Тэжээхдээ гурил буюу хивгийг бусад нарийн шимт тэжээлтэй хольж бөмбөрүүш хийж бэлтгээд хонинд өдөрт 4-5 ширхгийг өгвөл хэмжээ алдахгүй, тэжээл үрэгдэхгүй сайн талтай байдаг. Ингэж зун намрын цагт авсан тарга хүчийг өвөл хаврын цагт аль болохоор муудуулахгүй зохих хэмжээнд байлгаж чадвал жил дараалан хонь хур хүчээ хадгалж цагийн хатууг сайн давж, төл сайн бойжиж, ноос сүү сайтай гэж ярив.

Хоньчин Норовсамба жил бүр 250-300 хонийг ган зудын хүнд нөхцөлд хорогдуулалгүй онд бүрэн оруулж сүүлийн гурван жилд 348 хониноос 380 хурга бойжуулж авчээ. Даланзадгад сумын Хондот бригадын хоньчин МАХН-ын гишүүн Норовсамба 1972 онд сумын аварга

цол. 1973 онд төрийн дээд шагнал хөдөлмөрийн хүндэт медаль хүртэв.

Н.Доржсүрэн

99. Мал өсгөх нөөц бололцоо // Говийн мэдээ.- 1974 оны 2-р сарын 11.- №12.- 1-р нүүр.

Мал өсгөх нөөц бололцоо

МАХН-ын Төв хорооны 7-р бүгд хурал, БНМАУ-ын Ардын Их Хурлын чуулганаас мал аж ахуйн тогтвортой өсөлтийг хангах чухал хүчин зүйл болсон малын зүй бус хорогдлыг эрс багасгахыг нэн тэргүүний зорилт болгон дэвшүүлэв. Энэ талаар БНМАУ-ын Төв хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл чухал тогтоол гаргаж малын зүй бус хорогдлыг багасгах талаар социалист уралдаан зарласныг тус аймгийн нэгдэлч малчид баяртай хүлээн авав. Манлай сумын Хоёр өлзийт нэгдлийн

Далай бригадын малчдын уриалгыг манай бүх сум, нэгдэл, бригад, хэсэг, суурь дэмжиж малын зүй бус хорогдлыг багасгах, төл бойжуулах өндөр үүрэг амлалт авч малын хариуллага маллагааг сайжруулж, мал хорогдуулахгүй төдийгүй тарга хүчийг нь алдуулахгүй хээл хамгаалж гарсан төл бүрийг бойжуулахын төлөө идэвхийлэн шамдаж байна. Том мал, төлийн хорогдол, сувайрах, хээл хаях зэрэг зүй бус шалтгаанаар сүүлийн жилүүдэд мал өсгөх ихээхэн нөөц бололцоо алдсан явдалдаа хүн бүр дүгнэлт хийж байна.

Зүй бус хорогдлын дээрх шалтгаанаар тус аймаг сүүлийн гурван жилийн дунджаар жилд 200 гаруй мянган малын нөөцийг алдсаны зонхилох нь том мал, төлийн хорогдол байв. Ялангуяа тэмээ, адуу, үхэр зэрэг бод малын өсөлт удаан байгаа нь бод малын зүй бус хорогдол илүү их байсныг харуулах юм. Иймд бод малын

хариуллага маллагааг онцлон анхаарах шаардлагатай байна. Манай аймаг энэ жил цаг агаарын үнэхээрийн аятай нөхцөлд байгаа нь нэг ч мал хорогдуулхагүй, хамгийн олон төл байжуулах бололцоо юм.

Мал хариулах, услах, хужирлах, тэжээх ажлыг тогтмол хийж, өвчтэй малын эмчилгээнд, туранхай малын тэжээлд яаравчлан оруулах нь том малын хорогдлыг багасгах гол зүйл юм. Хээлтэгч мал тутмаас төл хүлээн авч гарсан төл бүрийг бойжуулахын тулд хээл хамгаалах ажлыг сайн хийж, төлийн бэлтгэлээ бүрэн хангаж төлийг заавал хөрвийн аргаар бойжуулдаг байх нь чухал. Мал онд оруулах, төл бойжуулах явцад малчидтай тодорхой ажиллаж, тэдэнд ажиллах хүчээр туслах, тэжээл байраар хангах, худалдаа, соёл ахуйн үйлчилгээгээр үйлчлэх үүрэг хариуцлага сум, бригадын удирдлагын өмнө тавигдах болно.

Малын зүй бус хорогдолтой тэмцэх аймаг, сумын онцгой комисс, бригадын төлийн штабууд хөнгөн шуурхай ажиллаж ардын хянан шалгах групп, постууд ажлын эхлэлт явцад байнга тогтмол үзлэг шалгалт явуулж, гарч болох дутагдлыг арилгаж байхын дээр аймаг, сум, бригадын удирдлага шеф байгууллага, хүмүүсийн туслалцааг суурь, хэсэгт төвлөрүүлж даалгасан ажил хариуцах хүмүүсийн хариуцлагыг эрс дээшлүүлэх хэрэгтэй.

Ганц нэг ч гэсэн мал, төл хорогдож, хээл хаясан тухай бүрд түүний шалтгааныг шалган тогтоож, хорогдлыг зогсоох тууштай арга хэмжээ авдаг байвал зохино.

Баяндалай, Номгон, Хүрмэн, Сэврэй,
Даланзадгад сумд сүүлийн жилүүдэд зүй бус
шалтгаанаар олон тооны малын нөөц алдсан

дутагдалдаа онцгой дүгнэлт хийж ажиллах ёстой. Аймаг, сумдын нам, улсын байгууллагын чухал зорилт бол мал онд оролт, төл бойжуулалтын явцыг өдөр тутам анхааралдаа байлгаж, улс, олон нийт, хөдөө аж ахуйн бүх байгууллагын хүчийг малын зүй бус хорогдол багасгах, төл бойжуулахад чиглүүлж, энэ ажлыг бүх нийтийн хэрэг болгоход оршино. Урьд онуудад мал хорогдуулаагүй, төл бүрэн бойжуулсан малчдын арга туршлагыг нийтийн хүртээл болгох нь маш чухал ажил юм. Намын үүр, хэсгээс мал онд оруулах, төл бойжуулах үед малчдын дунд улс төр, соёл хүмүүжлийн өргөн ажил хийж, сонин хэвлэл тараалтыг шуурхай болгож, удирдах ажилтан, мэргэжилтэн, тэргүүний малчдын ухуулагч болгон тодорхой үүрэгтэй тогтмол ажиллуулах хэрэгтэй. Үнэн зөв бүртгэл мэдээлэл нь удирдлагын чухал үндэс учраас мал төлийн хорогдол, хээл хаялт сувайралтыг бүртгэх, мэдээлэхийг эрс сайжруулах нь чухал юм.

Сум нэгдэл, тэдгээрийн бригад, суурийн малын сүүлийн жилүүдэд зүй бусаар хоргдсон шалтгааныг судалж, дүгнэлт хийх, уг хоргодлыг багасгах арга хэмжээг төлөвлөх явдал сумдын нам улс хөдөө аж ахуйн байгууллага, удирдах ажилтан мэргэжилтний ойрын үед хийх нэн хариуцлагатай үүрэг мөн.

Сайтар боловсруулсан ийм иж бүрэн арга хэмжээг тууштай хэрэгжүүлсний дүнд л малын зүй бус хорогдлыг багасгаж, мал өсгөх үлэмж нөөц бололцоог гүйцэд ашиглаж, мал аж ахуйн тогтвортой өсөлтийг хангаж чадах болно.

100. Хоньчин Шадав // Говийн мэдээ.- 1974 оны 2-р сарын 11.- №12.- 3-р нүүр.

Хоньчин Шадав

Нам засаг малын зүй бус хорогдлыг багасгах, тэмээн сүрэг өсгөх зэрэг хэд хэдэн чухал тогтоол гаргасан гэж дуулж мэдлээ. Одоо ч малын хорогдол



гарахын ч аргагүй болж дээ. Тэр их өвс энэ их тэжээл авч ирж өгөөд л үгүй тэгээд хашаа саравч худаг ус гээд ер нь дутуу юм алга байна. Ганцхан малчин бидний ажиллагаанаас л шалтгаална.

Би 73 нас хүртлээ тийм их хэмжээний тэжээл авч ирж, малыг машинаар нүүлгэж оторт гаргаж байхыг үзэх нь байтугай санаж байгаагүй шүү. Манайх 1973 онд нэг ч мал хорогдуулаагүй, 166 эм хониноос 166 хурга бойжуулж хонины ноосны үйлдвэрлэлийн даалгавраас 22 кг ноос илүү тушаасан. Үүнийг нам засаг минь өндөр үнэлж хөдөлмөрийн хүндэт медалиар шагнасан. Энэ жил 1 настай мал 257 г авч маллаж байна. Үүнээс хүч тарга муутай царайгаа харуулах мал байхгүй.

Гэсэн ч хүч таргыг нь бууруулахгүй онд оруулах зорилготой. Одоо хагас заримыг тэжээж байна гэж Ханхонгор сумын “Өлзийт” нэгдлийн хоньчин Д.Шадав ярьж байна. 73 настай энэ өвгөн 1974 оны социалист уралдаанд нэгч мал хорогдолгүй онд оруулах, ноосны үйлдвэрлэлийн даалгаврыг 101 хувь биелүүлэн нэгдэлдээ 10 хангал тэмээ уналгад сургаж өгөхөөр үүрэг авч, тавыг номгоруулаад, түүгээрээ хургаа хариулж байна. Шадав гуайнх ийнхүү өнтэй сайхан өвөлжиж байна.

101. Бэлтгэл сайтай төлчин // Говийн мэдээ.-
1974 оны 3-р сарын 21.- №22.- 3-р нүүр.

Бэлтгэл сайтай төлчин



Ноён сумын “Гучин таван жил” нэгдлийн Сайран бригадын ямаачин С.Чимэд нэгдэл нийгмийнхээ ямаан сүргийг 10 гаруй жил маллаж үлэмж туршлага хуримтлуулсан тэргүүний малчин юм. Эднийх зун намрын улиралд отор нүүдэл сайн хийж малдаа тарга хүч авахуулж төл бойжуулах бэлтгэлээ эртнээс хангадаг ажээ.

Ямаачин Чимэд мал төллөхийн өмнө төллөх малаа хужирлаг ургамалтай ялангуяа бор бударгана сайтай бэлчээрт хариулдаг байна. Бор бударгана идэж байгаад төллөсөн малын төл товир биетэй торнилт сайтай байдаг.

Тэрчилэн муудсан мал, чацага алдсан төлд туулайн мах өгөхөд хамгийн сайн тэжээл болдог гэж Чимэд гуай ярьж байна. Туулайн арьсыг хуулж аваад бүтнээр нь ясыг мултартал чанаад тамир тэнхээ муутай бог малд өдөрт цайны дунд шаазангаар гурван удаа, бие султай, сүү хоол нь зохихгүй байгаа төлд хоолны халбагаар өдөрт 3 удаа өгөхөд амархан тэнхэрч эдгэрдэг байна. Мөн хайлсны навчийг хандлаад бага зэрэг сүлээд муудсан малд өдөрт нэг шанагыг өгөхөд чанар сайтай тэжээл болдог гэнэ.

Мөн бор бударганыг таана, чихэр өвстэй холиод төлд тавьж өгөхөд хамгийн сайн тэжээл болдог ажээ. Төл хөрвөжөөд ирэхэд эхий нь сүү муудаж, цатгац муутай болж өргөхөд хөнгөн, хэвтэж босохдоо удаан,

хэвтээгээрээ шээгээд ирдэг. Энэ үед төлд нэмэгдэл тэжээл заавал өгөх хэрэгтэй. Төлийн нэмэгдэл тэжээлд манайх гурилан зутан хийж хөрвөжсөн төлд сүүгээр сүлээд өдөр бүр өгдөг гэж Чимэд гуай ярьж байна.

Ямаачин Чимэдийнх төлийн бэлтгэлдээ зориулж өнгөрсөн намар таана зоодой 1600 ширхэг, багалуур, хөмүүлээр хийсэн дарш хоёр тулам, хайлсны навч 25 кг, таана сүүтэй ногооны навч, чихэр өвс 100 шахам кг, бор бударгана 50-иад кг, бүдүүн тэжээл дөрвөн тонн, айраг 30 литрийг бэлтгэж авчээ.

Одоо эдний ямаа ид төллөж өнөө жил төллөх 205 ямааны 170 гаруй нь төллөж Нүдэн шавагтайн Нүдэнгийн амна усны бууцанд нэг ч төлийн хорогдолгүй тохитой хаваржиж байна.

Ч.Цэндоо, С.Буяндэлгэр

102. Даржаагийн Равжир // Говийн мэдээ.- 1974 оны 6-р сарын 3.- №42.- 3-р нүүр.

Даржаагийн Равжир

Булган сумын “Туяа” нэгдэлийн гишүүн, адуучин энэ эмэгтэй 1957 оноос эхлэн нэгдлийнхээ адуун сүрэг маллаж, адуун сүрэг маллаж, адуу маллах арга туршлага багагүй эзэмшжээ. Энэ хугацаанд жил бүр 700-1000 гаруй адуу хариуцан маллаж үйлдвэрлэлийн даалгаврыг жил дараалан биелүүлж иржээ. Эднийх адуугаа байнгын хариулгатай байлгаж услах, хужирлах зэргээр бэлчээрийг сайн тохируулж чаддагаас адуугаа жил бүр өсгөж иржээ. Азарганд гарах байдсаа адуугаа хөөвөрлөх үеэр үндсэн сүргээс нь ялган өөр азарганд тавьж хураалгадаг. Малчин бүрт мал маллах өвөрмөц арга барил байдаг. Адуучин Д.Равжир унага тэжээхдээ туршлагатай хүн юм.

Равжир ярихдаа: Зарим хүн унага тэжээл авдаггүй амьтан. Яаж ч тэжээсэн гэдэс нь томорч, мах нь шуугдсаар байгаад үхдэг гэдэг. Тэгвэл тийм биш. Унагыг бусад малын төлтэй адил өдөрт 3-4 удаа тэжээл өгөх юм бол ер тэжээл авахгүй. Харин тэжээлийг нь ойр ойрхон олон удаа өгвөл амархан тэжээл авч гэдэс нь бага болж мах боож ирдэг юм. Би өдөрт 16-гаас доошгүй удаа угжиж, унагаа ус өвсөнд бүрэн орсны дараа арай цөөрүүлэх замаар тэжээдэг. Анх унагалж байгаа байдсан гүү унагаа цатгахгүй тал байдаг. Мөн адуу хөөвөрлөх, чийг бороо орсон үеэр унага эхээсээ салж төөрдөг гэм бий. Ийм үед унагыг зөв тэжээх хэрэгтэй. Ер нь адуучин хүн гүү унагалах үеэр адуунаасаа өчүүхэн төдий ч хөндийрч болохгүй.

Манайх энэ жил 200 гаруй гүү унагална. Түүнийхээ унагыг бүрэн бойжуулж, МАХН-ын Төв Хорооны 9-р бүгд хурлын заалтыг хэрэгжүүлнэ гэв.

Д.Равжирын суурь энэ жил 732 адуугаа нэгийн ч хорогдолгүй онд оруулж, одоогоор 110 гүү унагалж, унага нь бүрэн сайн бойжиж байна. Хөөвөр хялгас бэлтгэх үйлдвэрлэлийнхээ даалгаврыг 100,2-114,4 хувь биелүүлсэн амжилтаар аймгийн намын 17-р бага хурлыг угтжээ. Олон жилийн тогтвортой ажиллагаагаараа сум, аймагтаа алдаршиж яваа, МАХН-ын гишүүн адуучин Д.Равжир аймгийн намын 17-р бага хуралд төлөөлөгчөөр сонгогдож ирээд оролцож байна.

Б.Тогтох

- 103.** Мал маллах сайхан // Говийн мэдээ.- 1974 оны 7-р сарын 4.- №51.- 3-р нүүр.

Мал маллах сайхан

Би 1970 онд ерөнхий боловсролын сургуулийн 8-р ангийг сайн дүнтэй төсч МХЗЭ-ийн илгээлтээр хөдөө аж ахуйн нэгдлийн үйлдвэрлэл дээр гарч дөрвөн жил хонь маллаж байна. Мал маллах сайхан ажил. 1971 онд сааль ашиглалтаар сумын ХЗЭ-ийн гишүүд залуучуудын дундаас шалгарсан, 1972-1973 онуудад манай суурь ноос сүү ашиглалтаар сумын аваргын болзлыг биелүүлсэн. Сумын нам эвлэлийн байгууллага, хамт олон миний ажлыг өндрөөр үнэлж Баянхонгор аймагт болсон “Мал маллах сайхан” чуулга уулзалтад оролцуулсан юм.

1974 онд манайх нийгмийн төллөх 260 эрлийз хонь хариуцан маллаж гарз хохиролгүй онд оруулан 265 хурга бойжуулан аваад байна.

Цаашид ноос сүү ашиглах үйлдвэрлэлийн даалгаврыг бүрэн биелүүлэх бололцоотой байна. Би мал ахуй дээр ажиллаж мал маллагааны арга ажиллагаанд суралцахын гадна цаашид суралцаж мэргэжил эзэмших зорилготой байна.

Н.Жаргал

- 104.** Өвс түүж байна // Говийн мэдээ.- 1974 оны 9-р сарын 12.- №69.- 1-р нүүр.

Өвс түүж байна

ӨВС ТҮҮЖ БАЙНА

Ж.Авгийн нэгдсэн болон 40 гаруй ажилчин, албан хаагчид шөф Банидалай сумын «Гурвансайхан» нэгдлийн Нарин бригадын малчдад 35 мянган кг өвс түүж өгөв.

Эмнэлгийн ажилтан, ажилчид 2000 ширхэг таанам хүмүүн зоодой хийж байгууллагын хэмжээгээр бэлтгэх өвс хадлангийн төлөвлөгөөг 127—132 хуви

биедүүлав. Их эмч Лхаасүрэн, жолооч Сэдийв, ажилчин Будханд, Найдмид, Цэрэндумва нар өвс түүх, тэжээл бэлдэх ажилд бусдыг хошуучилж ажиллав.

Т. БОЛД

«Гурвантэс сумын» намын түүр, АДХ-ийн тусгагч эмчиргаа, сумын хадлангийн төлөвлөгөөг биедүүлэхэд хүн бүрийн оролцуулах зорилгоор сумын ажилчин, албан хаагчид, сурагчдын дунд «Хүн нэг гавшгайч болох вэ» гэсэн болзол зарлан өвс түүх ажилд гаргав. Энэ ажилд 80 гаруй хүн гурван цагийн дотор 16 тонн өвс хадлав. Хадлангийн ажилд Дорж, Нямсүрэн, Гэндэн, Батгаа, Цэмээд, Аюун, Г. Дорж, сурагч Суурь, Оюунцэцэг нар идэвхтэй ажиллан болзол биедүүлжээ.

ОЙДОВ




Ханхонгор сумын «Гэрэлт» замы нэгдлийн Мандах бригадын үзэрчин Д. Доржсүрэн үхэр малчид онд оруулах, тугал бойжуулах ажилдаа ихэд туршлагажиж яваа хүн юм. 1974 онд тугаллах 40-өөд үнээ бүрээс тугал бүрэн хүлээн авснаар 100 хэвээс 100 тугал бойжуулж МАХН-ийн Төв Хорооны IX бүгд хурлын завлыг гүйцэтгэжээ. Д. Доржсүрэн ноосны үлдэвэрлэлийн даалгаврыг зугацаанд нь бүрэн биедүүлэв.

Д. Доржсүрэн үхэр маллахдаа хаврын улиралд бэлчээрийн соргониг дагуулан харигууж тогтмол услаж, өвөл хаврын хүнд үед муудах төлөвтэй үхрийг эртнээс тэжээлд оруулдаг заншилтай юм.

Эднийх малын тэжээлд зориулан таанам, хүмөл, нарийн ногоогоор 500 гаруй зоолой хийж өвс нилээд түүж бэлдэж хийж байна.

Д. Доржсүрэн тэргүүний үхэрчин төдийгүй хэсгийн ахлагчийн үүргийг сайн гүйцэтгэж хэсгийнхээ айд өрхөөр тогтмол ииж мөл оторлон таргалуулах, өвлийн бэлтгэл хангах ажилыг жигд хийлгэж байна. Д. Доржсүрэн хэсгийнхээ хэмжээнд цаг үеийн ажлыг төлсрөй цөөн хонот багтаан хийхээр зохион байгуулдаг юм.

Зураг дээр: үхэрчин Д. ДОРЖСҮРЭН
Т. ЦЭДЭВИЙН авсан гэрэл зураг

105. Халтар хомоол сайн тэжээл // Говийн мэдээ.- 1974 оны 10-р сарын 7.- №76.- 3-р нүүр.

Халтар хомоол сайн тэжээл



Орон нутгаасаа бэлтгэх хадлан тэжээлийн нөөц багатай говийн нөхцөлд намрын улиралд халтар хомоол түүж тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх явдал хойшлуулшгүй чухал

зорилт юм. Дундговь Ховд аймгийн малчид халтар хомоолыг намрын улиралд их хэмжээгээр түүж аваад хаврын улиралд эх мал, төлийг тэжээж амжилт олж

байна. Халтар хомоолын тэжээллэгийн чанарыг судалсан дүнгээс үзвэл найрлагадаа 82,2 хувийн органик бодис байдгийн 10,0 хувь нь уураг, 6.47 хувь нь азотгүй хандлага бодис 17,78 хувь нь үнс байх бөгөөд өөрөөр хэлбэл нэг кг халтар хомоол нь 0,35 тэжээлийн нэгжтэй тэнцэж 200гр шингэцтэй уурагтай байна.

Халтар хомоол нь тэжээллэг чанараараа үйлдвэрийн аргаар бэлтгэж байгаа багсармал, холимог тэжээлээс 41,7 хувь ногоон өвснөөс 12,5 хувь дутмаг боловч сүрэл, зэгснээс 16,6 хувиар илүү юм. Эрдэм шинжилгээний ажилтнуудын тооцоолсноос үзвэл нэг адуу хоногт хуурай жинд шилжүүлснээр 5,0 кг хомоол гаргах бөгөөд зөвхөн нэг адуунаас дунджаар 300 кг хомоол ашиглаж болох юм.

Үүнээс үзэхэд аймгийн хэмжээгээр 22,0 мянган тонн, адуу олонтой Баяндалай, Булган, Ханхонгор, Баян-Овоо, Цогтцэций, Цогт-Овоо сумдад 1500-3200 тонн, адуу цөөнтэй Ноён, Гурван тэс сумдад 200-430 тонн халтар хомоол бэлтгэж болох байна. Дээрх тэжээлийн нөөцийг бүрэн ашиглана гэж үзвэл аймгийн, жилд гаднаас авах бүдүүн тэжээлийн хэрэгцээг хангах бололцоо байна. Намрын халтар хомоолыг малд дангаар нь өгөхөөс гадна үр тариа, арвай 38 хувь, давс хужир 2 хувь, хомоол 60 хувиар хольж багсаран мал тэжээхэд илүү тохиромжтой.

Т.Уламбаяр


106. Илгээлтийн эзэн залуу малчид // Говийн мэдээ.- 1974 оны 10-р сарын 7.- №76.- 3-р нүүр.

Илгээлтийн эзэн залуу малчид



107. Аварга малчин // Говийн мэдээ.- 1974 оны
10-р сарын 31.- №86.- 3-р нүүр.

Аварга малчин



Алсаас цэнхэртэн харагдах Хоёр луусын уудам хөндий, агь таанын үнэр хамар цоргин сэнгэнсэн Бунхан тал зэрэглээтэн униартана. Түүнээс урагш Баянгийн хэц шаргалтан малчдын цагаан гэр ярайна. Тэдний нэг “Говийн хөгжил” нэгдлийн Могойт бригадын тэргүүний хоньчин, аймгийн аварга малчин Ц.Пүрэвийн суурь юм. Энэ малчин өсөх

бага наснаасаа эх эцгийн малч арга ажиллагаанаас уйгагүй сурч, дадлага туршлага хуримтлуулан туршлага хуримтлуулан ажилласны үрээр аймаг сумын аварга малчин болж, 16 жил нэгдлийн хонин сүрэг хариуцан маллаж үйлдвэрлэлийн даалгаврыг 100-103,6 хувь биелүүлж сүүлийн гурван жил дараалан 100 эхээс 95-аас дээш төл бойжуулжээ.

Ц.Пүрэвийн энэ ажил нь МХЗЭ-ийн илгээлт өвөртлөн гарсан мянга мянган залуусын бахархал болж байна. Пүрэв зун намрын цагт ургац сайтай ус бэлчээрийг сонгон нүүдэллэж малдаа дунд, дундаас дээш тарга хүч авахуулан өвөл хаврын хатуу цагт малаа хорогдолгүй онд оруулж ирлээ. Эднийх өвлийн бэлтгэлийг гурван үе шат болгон хийдэг заншилтай.

Эхний үе нь хавар бууцнаас гарахдаа хар хорголоо хамж өвөлжөөндөө нөөцлөөд хашаа пүнзний засварыг хийж өвөлжөөний орчны хогийг цэвэрлэж оторт гардаг. Дараа нь 6-р сард бууцны хөрзөнг ховхлон бууцаа сийлж ариутган ойр орчны хог ургамлыг зайлуулах, пүнз хашаандаа усны хамгаалалт шуудуу татах зэрэг ажил хийдэг. Гуравдугаар үе нь ховхолсон хөрзөнгөөрөө хороо пүнзээ сэлбэж, өвс, түлш хүрэлцэхүйц хэмжээгээр бэлтгэдэг. Өвлийн бэлтгэлээ ийнхүү 9-р сар гэхэд бүрэн хангадаг байна.


Ингэснээр отор нүүдлийг чанартай хийж, өвөжөө бууц засна гэхгүй зөвхөн төлийн бэлтгэл хангах ажил хийх бололцоотой болдог байна. Түүнчилэн суурийн доторх хүмүүс хөдөлмөрийн нарийн хуваарь баримталдгаас төл хөхүүлэх, тэжээх, малаа услах, хариулах зэрэг ажилд хүн хүч самгардахгүй ажил хугацаандаа биелдэг байна.

Ц.Пүрэвийнх БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Д.Аюурзанын бэлчээрээр мал таргалуулдаг, талийг хагас эхлээр бойжуулдаг туршлагыг ажилдаа хэрэгжүүлж байна.

Тэргүүний хоньчин Ц.Пүрэвийнх 1974 онд 415 эм хониноос 421 хурга бойжуулж, ноос бэлтгэх үйлдвэрлэлийн даалгаврыг 74 кг ноосоор давуулан биелүүлж энэ оны социалист уралдаанд тэргүүлж явна.

108. Намын гишүүн адуучин // Говийн мэдээ.- 1974 оны 10-р сарын 31.- №82.- 3-р нүүр.

Намын гишүүн адуучин



МАХН-ын гишүүн Д.Шархүү 1956 онд ХАА-н нэгдэлд элсэн орсноос хойш нийгмийн адуун сүргийг 20 шахам жил хариуцан маллаж байгаа туршлагатай адуучны нэг юм. Адуучин Шархүү энэ жил 600 гаруй адуу хариуцан маллаж бойжуулах унага, хөөвөр хялгасныхаа үйлдвэрлэлийн даалгаврыг бүрэн биелүүлэв. Шархүү өвлийн улиралд адууг байнгын маллагаанд байлган хоргдолгүй онд оруулж энх сүрэгний болзол биелүүлэхээр амлалт үүрэг аваад ажиллаж байна. Шархүү 1963 онд 6 өрхийн 13 адуучны хамт социалист хөдөлмөрийн бригад байгуулан ажиллаж амлалт үүргээ жил дараалан амжилттай биелүүлж одоо “СХ-ийн алдар-2” медалийн төлөө үүрэг аваад амжилттай биелүүлж байгаа юм. Намын гишүүн адуучин Шархүү адуугаа байнгын хариулга маллагаанд байлгаж нутаг бэлчээрийг тохируулан, тарга хүч авахуулан цагийн мууд ямар ч доройтсон адуугаар ялган тусгаарлаж

Говийн мэдээ сонин

сүүлийн хоёр жилийн өвөл хаварт 100 шахам адуу тэжээж онд хорогдолгүй оруулсан туршлагатай адуучин юм.

М.Аюуш

109. Залуу малчны ажил үйлс // Говийн мэдээ.- 1974 оны 11-р сарын 26.- №88.- 3-р нүүр.

Залуу малчны ажил үйлс

Сэврэй сумын “Социализмын зам” нэгдлийн ямаачин А.Санжийнх нэгдлийн ямаа 17 жил маллаж байгаа туршлагатай малчных. Эднийхэн удмаараа малч



ажилч, нямбай улс. Санж мал маллах арга ухааныг арван хуруу шигээ мэддэг шинийг санаачлагч хүн. Гэргий Лхамхүү нь сум нэгдлийн саалийн аваргыг олон жил хамгаалж нутаг усандаа алдаршиж явна. Охин С.Доржирвэгийг эцэг эхийгээ дуурайсан ажилсаг охин, сум нэгдлийнхээ нэрийг улсад алдаршуулах малчин болно гэж

нутаг усных нь ярьдаг. Доржирвэг хамт олны итгэл найдварыг биелүүлэхийн төлөө чармайн ажиллаж тэргүүний ямаачдын туршлагыг ном сониноос уншиж арвин туршлага хуримтлуулж байна. Малаа хааш нь яаж хариулах, ямар ургамал хэдийд хаана ургадгийг аав нь байнга зааж зөвлөнө. Төл бойжуулах, цагаан идээ хийх аргыг ээж нь охиндоо заана. Мал тарган тавтай, үйлдвэрлэлийн даалгавар биелж, цаг агаар сайхан байвал хоёр хөгшин минь баярлан сэтгэл нь тэнэгэр явах юм.

Харин ган гачиг болохоор олигтой ч амарч, цай хоол ч тавтай идэж уухгүй маргаашийн өдөр ямар байх нь вэ гэж тэнгэрийн хаяа ширтэн хоттой мал нэг бүрийнхээ төлөө санаа тавьж, зун намрын цагт отрын мөр хөөж, багалуур бударгана таана хөмүүл түүж өвлийн бэлтгэлээ хангах гэж борив бохисхийлгэхгүй явдаг. Тэгснийхээ ачаар өвөл хаврын хатуу тарчиг цагийг малын хорогдолгүй даван туулдаг. Долоо найман жил ямаа маллахдаа аав ээжээсээ их зүйлийг сурсан. Би Жамц баатар шиг ямаачин болохыг хүсдэг гэж Доржирвэг ярьж байна.

Энэ зорилтоо биелүүлэхийн тулд их зүйлийг хийж говь нутагт сүүлийн хэдэн жил дараалан тохиолдсон ган зудад Доржирвэг сайн ямаачин болохоо харуулж 1971 онд аймгийн тарга хүчний аварга, 1972 онд саалийн залуу аварга болж, 1973 онд мал маллах сайхан улсын 3-р зөвөлгөөн, илгээлтийн эздийн чуулга уулзалтад шалгаран оролцож МХЗЭ-ийн Төв Хорооны “Тэргүүний малчин” алтан медалиар энгэрээ мялаажээ. Залуучуудын эвлэлийн 50 жилийн ой угтаж зарласан социалист орнуудад жуулчлуулах уралдааны болзлыг биелүүлж ЗХУ-д жуулчилсан.

Эднийх хавар үндэс хөөхөөс эхлэн ногоо соёолон ургаж байгаа газрыг дагуулж ямаагаа оторлон 11 дүгээр сарыг дуустал явдаг. Ямаа таргалах үеийг усан цочиргооны үе, өөх мах цацалтын үе, өөх мах хослосон таргын үе гэж хуваана. Энэ үе бүхэнд арчилгаа маллагааг нь тохируулан маллах нарийн ажиллагаа шаардагддаг. Зун намрын маллагаа нь хамгийн эгзэгтэй. Мал тарга хүчээ авах энэ үед л мэрийвэл дулаан өвөлжөө, бэлэн тэжээл дээрээ өвөл хаврыг ядралгүй өнгөрөөнө.

Зун намар ямаагаа өдөрт дунджаар 15 цаг бэлчээрлүүлэн хоёроос дөрвөн цаг услаж амраах хугацаандаа сааль сүүгээ авч үйлдвэрлэлийн даалгавраа биелүүлнэ. Үдийн халуунд ялаа шумуулаас хамгаалж утаа май тавихад сайн байдаг. Ямааны тарга хүчийг 11 сард тогтоож өвөл хаврын бэлчээрийг хол ойрын, нөөц гэж гурав хуваах нь хамгийн ашигтай. Малчин хүнд өвс ургамал, цаг уур, малынхаа талаар гаднаас ажиглан нэлээд зүйлийг мэддэг байх хэрэгтэй. Өглөө малын ам хамар цантан нустаж, шовх үзүүртэй хатуу хатуу хорголоор баасан байвал малын хоол тэжээл арчилгаа нь тохироогүй байгаа нь тэр. Аавын анх санаачилж олны хүртээл болсон хушуувчаар мал тэжээх арга, ямаагаа зүс зүсээр нь ялган тэжээх зэрэг нь хөдөлмөр хөнгөвчилсөн ашиг тустай зүйл юм. Мөн ямаагаа төллөхөөс нь гурван сарын өмнөөс эхлэн долоогоос арван хоногт нэг удаа давс гурил самарсан усаар усалж заншсан маань малын хээл хамгаалахад сайн нөлөө үзүүлдэг. Ишигний хэвтрийг 30см ухаж үнэс, хөх хоргол, өвс дэрсний үндэс дэмбүүл давхарлан дэвсэж хуурай дулаан байлгах нь тун чухал гэж ярьсан юм. Сүүлийн гурван жилд 649 ямаанаас 672 ишиг бойжуулж, ямаа бүрээсээ дунджаар 338 грамм сайн чанарын ноолуур самнаж, 36 литр сүү саасан. Ямааныхаа хаврын амьдын жинг намар 49,9 кг –д хүргэж, 17,7-25,2 кг –аар нэмэгдүүлсэн амжилтаар түүхт ой, хүндэт зочноо угтлаа. Жамц баатрын эчнээ шавь, МХЗЭ-ийн гишүүн С.Доржирвэг ийнхүү эцгээ дууриасан сайн малчин болж үеийн нөхөддөө үлгэр дууриал болж явна.

А.Цоож

110. Галбын говьд // Говийн мэдээ.- 1977 оны
1-р сарын 17.- №5.- 3-4-р нүүр.

Галбын говьд

/Ханбогд сум/

Бид Жавхлант бригадын төвөөс эртлэн гарч



Галбын говийг зорих од тэмээн сүрэг суурь сууриар бэлчээрлэн. говийн хар сүүлт зээр хурдаа гайхуулах мэт хурдлан өнгөрөх агаад,баг багаараа бараа сүртэй сүглийх хайлаас,алсад цэнхэртэн дүнхийх Номгон уул нүдний хараа булааж явлаа.Энэ бүхэнд нүд бэлчээн Хөтөл шанд, Хачивчийн хярыг

энгэрлэн явсаар бага үдийн алдад Шаваг гэдэг газар өвөлжиж байгаа тэмээчнээд буулаа.

Суурийн ахлагч Б.Ухнаа: -Манайх Б.Лхамсүрэнгийнхтэй нэг суурь. Сууриараа нийгмийн 260 гаруй тэмээ малладаг.Өнөө жил 50 ингэ ботголж, 57 ингэ бууранд гарна.Энэ жил тэмээний тарга хүч сайн байна гэж ажлаасаа танилцууллаа. Тэмээчин Б.Ухнаагаас ингэ хээлтүүлэгийн талаар нилээд зүйл асууж сонирхоход:

- Ингийг бууранд гаргах үед нь сувай тэмээнээс тусгаарлан маллаж нийлүүлэгт оруулдаг. Хээл авсан ингэний хугарсан буйлыг солих, хаврын хавсарганаар тайлаг голдуу тэмээтэй хамт байлгах,ботгыг нь амиллахаас өмнө унаж байгаад өлөн услах зэрэгт ингэний хээл цуцран ботго хаядаг юм. Эхийн хэвлийд байгаа ботгыг амилах хүртэл ингэний хээлийг сайн хамгаалах шаардлагатай. Тэмээчин хүн хээлтэй ингийг ширүүн тууж, өлөн үед нь услах,ботгыг нь амилахаас өмнө унаж эдлэхийг цээрлэх хэрэгтэй гэж яриw.Энэ

суурьд 1971- онд сурагчийн ширээнээс намын уриа,эвлэлийн илгээлтээр гарсан МХЗЭ-ийн гишүүн Л.Сайнхүү аав ээжийн хамт тэмээ маллаж байна Элгээлтийн эзэн Л.Сайнхүү: -Манайх 1977-онд хариуцсан тэмээгээ 98% онд оруулж, 48 ингэнээс 48 ботго бойжуулан, 8 ингэ саалинд, 10 эмнэг уналга эдэлгээнд сургаж,үйлдвэрлэлийн даалгавраа төрөл бүр дээр нь давуулахаар социалист уралдаанд үүрэг аваад ажиллаж байна гэж ярилаа. Бид цааш явж шигүү загтай өргөн хоолой гатлан Номгон бригадын төвд очиход бригадын хариуцлагатангууд цаг үеийн ажлаар суурь, малчдаараа явсан байлаа. Бид тэмээчин У.Чулуунхүүгийн бригадын дарга Ц.Мижид, сумын ардын хянан шалгах хорооны дарга Ц.Пүрэв нартай тааралдав. –Манай бригад мал өсгөх улс, аймгийн төлөвлөгөөг 5 төрөл дээр нь биелүүлсэн. Бригадын хэмжээнд тэмээний 18 суурьд 6300 гаруй тэмээ маллагдаж байна. Энэ жил 919 ингэ хээлтүүлэгт орж, 1300 ингэ ботголго. Манай бригадад улсын аварга тэмээчин У.Чулуунхүү, аймгийн аварга тэмээчин Ш.Арван, Ц.Содномжамц, сумын аварга малчин үхэрчин Д.Тангад, хоньчин С.Төмөр, тэмээчин Дүгэрсүрэн, Б.Ван, Л.Дашдорж гээд тэргүүний малчид олон бий.манай тэмээчин 18 сууриас 1976-онд 16 суурь үйлдвэрлэлийн даалгавараа давуулж Б.Цэдэн-иш, Д.Тогтох, У.Чанцалдулам нар ингэний сүү саах талаар бригаддаа тэргүүлж явна. Саальчин У.Чанцалдулам өнгөрсөн онд нэг ингэнээс 104 летр сүү сааж үйлдвэрлэлийн даалгавраа давуулж биелүүлсэн амжилтаараа бригаддаа тэргүүлж яваа гэлээ.Бидний ярианд сумын хянан шалгах хорооны дарга Ц.Пүрэв оролцож ингэ саах талаар олигтой ахиц гарахгүй байгаа талаар ярихдаа:- манай сумын хэмжээнд жилд бүх малаас 20-иод мянган летр сүү авч байна.Зөвхөн саавал зохих бүх ингээ сааж чадвал сумын хэмжээгээр 300-гаад летр сүү сааж

болохоор байна. Ингэний сүүг муу ашиглаж байгаагийн нэг гол шалтгаан нь олонх ингэ эмнэг, нэг хүнд оногдох ингэ олон саальчдын чадвар муугаас болж байна. Бидний бодож байгаагаар ингэний саальчин 60-иад хүн шаардлагатай байна. Одоо нэг ингэнээс жилд 80 л сүү саах үйлдвэрлэлийн даалгавар өгч байгаа юм аа. Зарим тэргүүний саальчдын ажиллагаанаас үзэхэд 80 дээш л сүү саах бүрэн боломж байна. Ингэний ид саалийн үед тэмээ ноослох, ботго бойжуулах ажил давхцаж хүн бүл тарамдаж байна. Номгон бригадад мэмээнд зориулсан моторт худаг 13 байдаг. Эдгээр худгуудыг түшиглүүлж ингэний саалийн фрем байгуулах, сувай тэмээг ялгаж тусад нь маллах, ингэ бүрийг саалинд сургах тодорхой арга хэмжээ авч, залуу малчдыг сааль сааж сургах, ингэний сүү борлуулах ажлыг тодорхой зохион байгуулах зэрэг ажил зохион байгуулах юм бол ингэний саалийн ашиглалтад ахиц гарч болохоор байна гэлээ. Ханбогд сум бол 56,1 мянган малтай бүх малын 37,3 хувийг нь тэмээн сүрэг эзэлдэг аймагтаа олон тэмээтэй сумын нэг билээ. Тус сум нь 1976-онд бүх малаа дүнгээр нь 103,9 хувь, ямаанаас малын төрөл дээр нь 102,1-113,1 хувь өсгөж, мал өсгөх улсын төлөвлөгөөг биелүүлсэн 10 сумын нэг юмаа. Ганган улаан тэмээгээрээ улсад алдартай Галбын говиор явж тэмээчидтэй уулзаж байхад тэд жавар сэнгэнсэн жиндүү өвлийг мал сүргээ тарган тавтай өвөлжүүлэн МАХН-ынхаа 17-р их хурлын шийдвэрийг ажил амьдралдаа хэрэгжүүлэн биелүүлэх зориг эрмэлзэл дүүрэн байна.

Ч.Цэндоо

111. Овоогийн говийн тэмээчин // Говийн мэдээ.- 1977 оны 1-р сарын 20.- №6.- 3-р нүүр.

Овоогийн говийн тэмээчин

/Ханбогд сум/



Ханбогд сумын Галбын хөгжил нэгдлийн Номгон бригадын тэмээчин улсын аварга малчин У.Чулуунхүүгийн Овоогийн говийн Хулгарын усанд тохилог сайхан өвөлжиж байна. Эднийх өнгөрсөн зун намар Булан цагаан, Цууриа, Даравгайгаар отор хийж тэмээн сүрэгтээ тарга хүч сайн авахуулжээ. 1960-оноос хойш

нийгмийн тэмээ маллаж үйлдвэрлэлийн даалгавраа ирсэн энэ тэмээчин VI таван жилийн төлөвлөгөөний эхний жилийг гараа сайтай эхлэж ээлжийн 24 ингэнээс 24 ботго бойжуулж, ноос сүүний үйлдвэрлэлийн даалгавраа давуулжээ. Эднийх одоо 240 гаруй тэмээ маллаж байна. Энэ жил төллөх 31 ингэнийхээ ботгыг хүлээж авах бэлтгэлээ бүрэн хангаж, 30 ингэ нийлүүлэгт оруулаад байна. Тэмээчин У.Чулуунхүү хээлтэй ингээ 2-р сарын дундаас эхлэн сувайгаас нь ялган байнгын маллагаанд оруулж ботголуулдаг. Нутаг солиход тэмээ сэтгэл санааны хувьд тавгүй тогтворгүй байдал гаргаж хүч тарга авахдаа муухан байх шиг байдаг. Өвлийн улиралд сайтай говь хоолой хослосон модлог ургамалтай газар маллавал тарга хүчээ алддаггүй юмаа. Өвлийн улирлын тэмээг бэлчээрт нь нөмөр сайтай газар хотлуулаад өглөө салхи сөргөн бэлчээрлүүлэхэд уруудах нь бага байдаг. Тэмээг зөөлөн тууж тарга хүчийг нь хайлгахгүй өнжөөд тогтмол усалж байвал эцэж муудахгүй гэлээ. Аварга тэмээчин ийнхүү арга туршлагаасаа бидэнд танилцуулаад 1977 –онд хариуцсан тэмээн сүргээ онд бүрэн оруулж үйлдвэрлэлийн даалгавраа төрөл бүр дээр

нь биелүүлж ажиллахаар социалист уралдаанд үүрэг аваад ажиллаж байгаа ярьж байна.

Ч.Цэндоо

112. Тэргүүн туршлагын сангаас // Говийн мэдээ.- 1977 оны 1-р сарын 20.- №6.- 3-р нүүр.

Тэргүүн туршлагын сангаас

/ Аваргын барианд Цогт-Овоо сум/

Цогт-овоо суманд аймгийн аварга малчин, ямаачин Л.Наран,хоньчин Г.Гэлэгпэл гээд л аварга сайчууд олон бий.Түүний



нэг нь арав гаруй жил нэг настай мал маллаж онд бүрэн мэнд,царигтай оруулж нутгийнхандаа Нэг настын Балдорж гэж нэрлэгдсэн энэ хүн юм.Хүний нэрэнд хачир орох тал бишгүй л байдаг

даа.Чухам энэ хүн яаж ажиллаад ийнхүү эрхэлсэн ажлаараа нэрлэгдсэн юм бол хэмээн бодож түүнтэй зориуд уулзвал: -Хэдийгээр анхныхаа өвөлтэй,тэр дундаа хүйтэн өвөлтэй уулзаад байгаа гэхэд нас гүйцсэн малаас доргүй тарга хүчтэй өнгө зүс сайтай 800 гаруй төлөг хотондоо малч эзнийхээ уйггүй хөдөлмөрийг илтгэх мэт налайн хэвтэж,зарим нь хотны захаар тонгочин наадна. Нэг настай малыг хэрхэн онд бүрэн, тарга хүч сайтай оруулдаг талаар М.Балдоржоос асуухад тэр:

-Намар хүлээж авангуутаа төлөгт үзлэг хийж давжаа жижиг,хүч муутайг 11-р сараас эхлэн тэжээхээр тэмдэглэж аваад нялх ногоо,сөл сайтай зайдуу нутгийг сонгон тарга нэмэх оторт гардаг. Өдөр бүр услах нь тарга

хүч тогтоох гол арга мөн. Гэхдээ зарим нь ууж сураагүй бадаг. Үүнийг нэг бүрчлэн ажиглаж бүгдийг услах хэрэгтэй. Саяхан эхээс салсан төл ус уухгүй удвал тарга хүч бүрэн авч чадахгүй хайтар давжаа мал болдог. Бусад малын хөлөөс зайдуу алс гарах нь ижил буруу төлөг ижилсэж дасах нь амар, бэлчээр элбэгтэй байдаг. Ингэж намар орой болтол отор хийж малынхаа тарга хүчийг чамбайруулаад бэлчээр сайтай, нөмөрлөг, ус хужиртаа ойр бууцанд өвөлждөг. Төлөг жавар үзээгүй учир дааруулахыг л гол анхаардаг. дулаан өдөр тал руу, хүйтэнд хяр толгодын энгэрээр хариулдаг. Хүйтэн өдөр салхи руу хөдөлгөн хэсэг идэшлэсний дараа усалдаг. Усалсаны дараа салхи ташуулан хариулж уламаар салхи сөргүүлэн бэлчээрлүүлсээр орой нь бууц хөрөхөөс өмнө уруудуулан хотлуулахад шөнө тавлаг хонодог юм. Хоньчин Балдорж мал тэжээхдээ хошуу будаа, хивэг, багсармал зэргийг таана хөмүүлийн ханд яс махны шөлөөр дэвтээж исгээд дорой муу малд нь хошуувчаар, царигтай сайнд нь онгоцонд хийж өгдөг байна. Хэвтэрээр нь дааруулахгүйн тулд өдөр бүр хөлдүү хорголыг нь савардан авч хорооны ар салхины доод талдаа хорготой газар хамарлан асгаад хөх хоргол бууц асгаж хуурайлдаг байна. Жавартай хүйтэнд хотныхоо салхин дээр талд нь утаа май тавьдаг ажээ. Ажилд дадлага, ачаанд татлага гэгчээр малыг онд сайн оруулахад бэлгэл хамгийн чухал гэдгийн тэр дахин давтан өгүүлж байгаа нь малчин М.Балдорж олон жилийн мал маллагаандаа энэ талаар дадлагажсан өолохыг нь илтгэнэ. Өнгөрсөн зун гэргий Х.Хүүхэнийхээ хамтаар өвөлжөөндөө 20 тн багтаамжтай тэжээлийн агуулах барьж 4 тн шимт ногоон өвс, нэг мянга гаруй ширхэг зоодой хийж авч, хужир шүү хүрэлцээтэй бэлтгэжээ. Ингэж өөрийн бэлтгэсэн болон нэгдлийнхээ татаж өгсөн өвс тэжээлээр малаа сайн тэжээж байгаагаас эднийх нэгч малын хорогдолгүй тарган

Говийн мэдээ сонин

тавтай өвөлжиж байна. Цогт-Овоо сумын Жаргалант нэгдлийн Замын шанд бригадын хоньчин аймгийн аварга малчин М.Балдорж олон жилийн тогтвортой амжилтаараа улсын аваргын байранд хүрээд байна.

Т.Цэдэв

113. Малчидтай уулзахад урамтай // Говийн мэдээ.- 1977 оны 1-р сарын 24.- №7.- 3-р нүүр.

Малчидтай уулзахад урамтай

/Сурвалжлага/

Баян-Овоо сум

Дагжир хөрстэй талын хар зоо дамжин дардан замаар давхисаар үдэшийн бүрийд тохилог хашаа бууцтай айлд хүрэв. Баян-овоо сумын говийн хөгжил нэгдлийн налх бригадын ямаачин Н.Цэдэн-ишийнх ажаа. 20 шахам жил ямаа малласан хашир малчин Н.Цэдэн-иш ярихдаа:

-Өнгөрсөг жил төл бойжуулах,ноос ноолуур бэлтгэх үйлдвэрлэлийн даалгавараа биелүүллээ. 2730 л сүү нийлүүлэх даалгавраа давуулсан Одоо төллөх 300 ямаа маллаж байна. 2-р сарын дундаас эхлэж төллөх юм.Төл хүлээн авах бэлтгэл хангасан. Бэлчээрээ хуваарьтай ашиглаж хүйтэн өдөр Ханан, Дугуй хонд, Шаваг овоот,нөмөр сайтай бэлчээрт,дулаан өдөр тал газар хариулдаг. Манай өвөлжөөнд ойрхон 2 худаг бий. Нэгийн нь амны усанд, нөгөөг нь мал услахад ашигладаг. Хүйтэн өдөр худагны салхин талд утаа тавьж,уутанд хужир хийж онгоцны дэр тавьж мал услахад малын бээрээ гарч ус сайн уудаг юм гэв. Цэдэн-ишийнх малын сэвсийг хужиртай хольж хөлдөөгөөд хотны захад тавих, тусгай саванд хужир хийж өгөх зэргээр малаа байнга

хужирлаж,зун бэлтгэсэн 1600-гаад таанан зоодойноосоо усанд чанаж хандлан доройтох төлөвтэй малд өгдөг байна. 1976-онд ямаа бүрээс дунджаар 297 гр хялгас авч сумын аварга болсон. Ямаачин Жаалайнд бригадын даргатай уулзлаа. С.Отгон малчдын сууриар явж төлийн бэлтгэл үзэж дутууг хангуулах, 1977-оны социалист уралдаанд үүрэг авахуулах ажлаар явж байгаа гэж бидэнд танилцуулахад: -Манай бригадын 50 гаруй өрхөөс 40 өвөлжөөндөө өвөлжиж байна. Ойрд хүйтний эрч чангарч зарим айлын бууц хөлдөх төлөвтэй. Гэхдээ мал зутраагүй байна. Бригадын хариуцлагатангууд малчдад МАХН-ын Төв Хорооны II бүгд хурал, Ардын их хурлын чуулганы шийдвэр таниулж явна гэв. Налих бригад энэ онд 6.2 мянга гаруй ямаа төллүүлэх бэлтгэлээ сайн хангажээ. Баян-овоо сум малчдынхаа 1976 оны ажлыг дүгнэж сумын аварга малчнаар 14 суурь шалгаруулснаас энэ бригадын адуучин Ө.Жигмэд, Ц.Балжир, Ц.Эрдэнэ, ямаачин Д.Батмөнх, Ж.Тэрбиш, Л.Мядаг, Б.Бөндөөн, үхэрчин Б.Даржаа нар нэг малаас авах ашиг шимийг сумын дунджаас дээгүүр амжилтаараа сумын аварга болжээ. Хар заг бригадын тэмээчин намын гишүүн Ж.Гомбожавынх Бударгана усанд өвөлжиж байна. Энэ суурь малч хичээнгүйгээрээ нэрд гарч яваа МХЗЭ-ийн гишүүн илгээлтийн эзэн Н.Балчинханд, түүний дүү илгээлтийн эзэн Дашбалжир нар ажилладаг. Нийгмийн 260 гаруй тэмээ малладаг энэ суурь өнгөрсөн оны үйлдвэрлэлийн даалгавараа төл бүр дээр нь биелүүлээд энэ жил төллөх 59 ингэний ботгыг хүлээн авах бэлтгэлээ бүрэн хангаж, 30 ингэ нийлүүлэгт оруулаад байна. Ингэний хээл хүндрэх үед сувай тэмээнээс ялгаж хариулан гаднаа ботголуулдаг. Ботгыг эхэд нь амлуулахын өмнө эхийн дэлэнг шар тостой бүлээн усаар угаавал сайн байдаг юм гэж Г.Балжинханд ярьж байна. Баян-овоо сум оны эхэнд байсан малын зүй бус хорогдлыг нэг хувиас хэтрүүлэхгүй байх үүрэг авч

Говийн мэдээ сонин

аймгийнхаа бүх сумыг уриалсныг малчид баяртай хүлээн авч мал сүргээ тарган тавтай өвөлжүүлж онд бүрэн оруулахын төлөө идэвхийлэн ажиллаж байна. VI таван жилийн төлөвлөгөөний 2 дах жилийн хөдөлмөрийн гараанд эрчимтэй орсон Баян-овоо сумын хөдөлмөрч малчидтай уулзаж урамтай үг сонсож явлаа.

Ч.Цэндоо

114. Цэций уулын Гимбээ // Говийн мэдээ.- 1977 он.- 1-р сарын 27.- №8.- 3-р нүүр.

Цэций уулын Гимбээ

/Сурвалжлага/

Цогт-Цэций сум

Шингэх нарны улаан туяан доогуур аргалын цэнхэр утаа хадган цэнхэр тэнгэрийг багандах мэт эгц дээшээ суунаглан, Хүрэн хурууны бууц өөд олон ямаан



сүрэг тайван дөхөж яваа харагдана. Тохилог сайхан хашаа саравчтай бууцанд өвөлжиж байгаа 3 гэрийн баруун урд захын том цагаан гэрийн гадаа ирж зогсоход гэрээс Цогт-цэций сумын Их шанхай нэгдлийн ямаачин Гимбэл

гауй гарч ирж биднийг угтан мэндэллээ.

Гэрт орж тогоонд цай үйж, галаа сэргээнгээ:

-Ойрдоо яггүй хүйтэн байна.Өглөө ямаагаа салхи уруу нь бэлчээн хөлийн чилээг нь гараг гэжжаахан явуулаад уулаад нь эргүүлж хариуллаа. Ууландаа нөмөртэй дулаан байлаа. Хүйтэн өдөр ямааг салхи руу

нь бэлчээж хөлийн чилээ, биеийн бээрээг гаргаад салхи сөргөж хариулвал бэлчээртээ тогтвортой байдаг юм гэж гимбэл гуай ярьж суутал цай буцалж, ямаа нь хотоллоо. Нийгмийн олон зуун ямаан сүрэг хариуцан маллангаа хутаг усныхандаа тус хүргэж явдаг. Гимбэл гуайг нутгийнх нь хүндлэн дээдэлж Гимбээ гэж нэрлэдэг энэ ахмад коммунистын энгэрт зүтгэл бүтээлийг нь илтгэх одон медалиуд, БНМАУ-ын аварга малчны тэмдэгийн хамт шаргалтан туяарах нарны хурц туяанд өнгө хоршин гялалзаж явдаг юм. Гимбэл гуай өөрийн амжилтыг ярихаас бусдын амжилтыг ярих дуртай. Манай бригадын ямаачин, илгээлтийн эзэн Дүүхүүхэн бидний үеийг залгамжлах малчин гарна даа. Малд ер нь нүдтэй охин шүү. Өнгөрсөн онд 100 эхээс 115 ишиг божуулсан юм. Аймагтаа дээгүүр орох байсан. Гэтэл Баяндалай сумын Халтар 100 эхээс 125 ишиг бойжуулсан байна билээ гэж өөрийн шавь Дүүхүүхэнийхээ амжилтаас өгүүллээ. Одоо нийгмийн 340 гаруй төллөх ямаа маллаж байгаа. Энэ аварга малчин О.Гимбэл:

-Ямаа их даардаг мал учир хээл хаяхдаа амархан байдаг. Тиймээс тогтмол услаж, хужиараар дутагдуулахгүй, хуурай дулаан хэвтэртэй байлгах хэрэгтэй байдаг. Ямааг нэг л шөнө дороос нь хайрсан хэвтэрт хэвтүүлчихээд хээл хяж эхэлнэ шүү. Ямааг шинэ бэлчээртэй хуурай бууцанд төллүүлэхэд ишиг хорогдоно гэж байхгүй. Манайх ямаагаа төллөх дөхөөд ирэхээр мал төллүүлдэг бууцандаа бууна. Ишгийг эхээс гармагц адууны шар хомоолоор үсийг нь эгштэл арчиж нэмнэх хэрэгтэй. Эхэд нь амлуулахын өмнө монгол архи бага хэмжээгээр өгөхөд гэдэсний нь ажиллагаа сайжирч барагтай бол чацга алдахгүй төл бүрэн бойжуулахад бүх асуудал бэлтгэлээс шалтгаална. Манайх 6-р сараас эхлээд төлийн бэлгэлээ хангадаг гэж яриу. Аварга малчны амжилт бүтээл өөдөө, арга туршлага нь

арвижсаар, өгөөж баян Цэций ууландаа ямаан сүргээ хариулж явна.

Ч.Цэндоо

115. Борзонгийн тэмээчин // Говийн мэдээ.-
1977 оны 1-р сарын 27.- №8.- 3-р нүүр.

Борзонгийн тэмээчин

Номгон сум

Энд тэндгүй хайлаас тоорой лүглийж заг, бүйлс багширсан, булаг горхи харзалсан, сэтгэл татам сонин байгальтай Борзонгийн говь бол тэмээн сүргийн үржилт нутаг нь билээ. Нутаг усандаа цуутай олон тэмээчин энэ их говьд олон бий. Борзонгийн тойром гэж хаа хүртэл цуутай уудам хөндийн хойд захаар идээшин тогтож бэлчээрлэн яваа зандан хүрэн тэмээ бол тэмээчин Цогбатын хариуцан малладаг сүрэг билээ. Цогбат угаасаа Борзонгийн говьд төрж өссөн унаган хүү нь болохоор энэ нутгийн цаг агаар, байгалийн байдал, бэлчээрийн ургамал, ус задгай бүгдийг гарын арван хуруу шигээ андахгүй мэддэг хүн юм. Цогбатын малладаг 200 гаруй тэмээн сүрэг Борзонгийн говийн сүргийн сор нь болсон хүрэн зандан зүстэй. Нутгийн шилмэл омгийн тэмээний эх суурь ч эндээс гарч магадгүй гэж бодогдмоор бие бялдар сайтай юм. Эднийх нутаг бэлчээрийг сонгон оторлох, тэмээнд тарга хүч авахуулах, ашиг шим ашиглах талаар бусад тэмээчдээ хошуучилж явдаг. Цогбат өөрөө сувай тэмээгээ хариулах, услах, гэргий Адьяа нь ботго бойжуулах, сааль сүү ашиглах зэрэг ажлыг хуваарьтай хийдгээс гадна тэмээ ноослох, буйллах, агтлах зэрэг ажлыг хамтран хийдэг байна. Цогбатын зун намрын улиралд алсын оторт гарч тэмээгээ тарга хүч авахуулдаг. Хөрхийн ар, Хачигийн энгэрт гарч оторлодог. Тэмээгээ бэлчээрээр хариулж, хээрээр

таргалуулдаг учраас эдний тэмээ Борзонгийн говийнхондоо гайхагддаг. Цогбат гуай тэмээ маллахын зэрэгцээ хэсгийн ахлагчийн үүргийг сайн хийдэг хүн билээ. Тэрээр хэсэгт хөтлөгдөх анхан шатны бүртгэлийг гүйцэд сайн хөтөлж суурь өрхөөрөө тогтмол явж эрэлт хүсэлтийг хүлээн авч бригадын зөвлөлдөө дамжуулдаг юм. Хариуцсан сууриудынхаа мал сүргийн тооцоо тогтмол хийж малчдад хэсгийн ахлагчийн хувьд, хашир тэргүүний малчны хувьд өдөр тутам сургаж байдаг нь үр дүнд хүрч байна. Хэсгийнхээ тэмээн сүргийг байнгын хариулгад оруулж, суурийн малчдын ажил хариуцах хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарч ажиллаж байна. Цогбат өөрөө отор нүүдэл, мал ноослолт, ботго бойжуулалт, өвлийн ба төлийн бэлтгэл хангах ажлыг хошуучлан хийж дараа нь хариуцсан сууриуддаа шаардлага тавьж хийлгэдэг нь үр дүнтэй болдог байна. Цогбат өөрийн хариуцсан хэсгийнхээ сууриудын тэмээг сайн таньдаг учраас бусад малчддаа сайн тусалж тэмээг байнгын хариулгад оруулахад чухалчлан анхаардаг байна. Нутаг усандаа нэрд гарсан энэ малчин бол Сангийн далай нэгдлийн Дэрсэнэ ус бригадын тэмээчин билээ.

Ж.Баатарцэрэн

116. Тэмээ тогтов уу // Говийн мэдээ.- 1977 оны 2-р сарын 7.- №11.- 2-р нүүр.

Тэмээ тогтов уу

/Тэмдэглэл/

Ноён сум

Тэнгэр цэлмэг тунгалаг атлаа цасан ширхэг хялмаалан, өвсний толгойд хуруу бамбарлаж, битүү цастай цаана нэг жиндүү хүйтэн. Аргагүй л мал аж ахуйн

бэлтгэл малчдын хариуцлагыг шалгах аж. Саяхан бид Ноён сумын мал аж ахуйн сууриудаар орж ажил байдалтай нь танилцаж явав. Энд малчин бүр цагийн хатууг хохиролгүй давах зориг эрмэлзэл дүүрэн ажиллаж байна. Цасанд найдвал цаг алдаж хүч тарга бууруулна. Улсын аварга малчин, тэмээчин Т.Бантгарын нэг гол анхаардаг зүйл бол малын усалгааны асуудал юм. Хэдий чинээ их хүйтэн цастай байх тусмаа малд тэр хирээр ус их хэрэгтэй байдаг. Хүйтэнд худгийн амь ус ханатлаа уусан тэмээ тэр өдөртөө биргэж даарч тух алдана гэж байдаггүй. Цастай гэж өнжөөвөл цас идэх гэж их хэмжээний цаг зарцуулж хооллох цагаа тэр хэмжээгээр гарздана. Түүний дараа цасаа хайлуулах гэж мөн тарга хүчээ илүү алддаг. Тиймээс манайх тэмээгээ өдөр болгон усалдаг юм. Газрын гарц малын өвс хоол хомс муу байгаа энэ жилийн хувьд малын бэлчээрлэх хугацааг аль болохоор уртасгахад цас идүүлэхгүй байх нь их ач холбогдолтой гэж Бантгар аварга ярьж байна. Аваргын тэмээ үнэхээр даарч биргэсэн шинжгүй гэдэс хээл сайтай тохь тух алдаагүй байгаа нь түүний арчилгаа маллагаа тохирсныг харуулж байна.

Хөшүүргэн ховоо Өглөө бүр наран мандахаас өмнөхөн Даравгайн усны аман дээрхи хөшүүргэ нэгэн хэмээр бөхөлзөнө. Нэг бөхийхэд 10 л, 10 бөхийхэд 100 л, 200 л бөхийхэд 2000л ус хөшүүргийн хүчээр татагдаж тэр тоолонгоор нь ховоотой усыг Бантгар аварга чадмаг шалмаг хөдөлгөөнөөр онгоцондоо юүлж 240 тэмээ 70-90 минутанд ханаж бэлчээрт гарна. Эдний тэмээ дунджаар 15 тн усыг худгийн гүнээс 1цаг 30 минутад гараар татаж гаргана гэдэг багагүй хүч хөдөлмөр орох нь мэдээж. Тэгвэл ус татах хөдөлмөрийг хөшүүргийн хүчээр хэмнэжээ. Ташрамд өгүүлэхэд хөшүүргэн ховоо анх Ноён суманд санаачлагдан гараад бага биш хугацаа өнгөрсөн боловч малчдын ажиллагаанд тэр бүр

нэвтрээгүй байгаа нь түүний ач холбогдлыг биер үзэж ойлгоогүй дээ болов уу. Бантгар аваргын ажиллагаанаас үзэхэд хөшүүргэн ховоог энгийн уурхайн худаг болгонд тавьж ашиглууштай зүйл болох нь харагдаж байна. Тэмээ тогтов уу? Бантгар аваргаас тэмээ бүрэн үү гэж асуувал илүү үг болно. Яагаад гэвэл арван наснаасаа тэмээ дагаж сүүлийн 21 жил нэгдлийнхээ тэмээн сүрэг хариулж яваа энэ хүн, нэг ч өдөр тэмээгээ дутуу байлгаж үзээгүй юм. Энэ ч учраас аваргаас тэмээ тогтов уу гэж биш тэмээ бүрэн үү гэж асуудаг хүн үгүй болсон нь санамсаргүй зүйл биш. Чухамхүү эндээс Бантгарын ажлын нэгэн гол гогцоо харагдаж байгаа юм. Бантгар өглөөнөөс үдшийн бүрий хүртэлх хуцааг тэмээтэйгээ хамт тэмээний бэлчээрт өнгөрүүлнэ. Тэгэж явахдаа тэмээ нэг бүрдээ ажиглалт хийж аль ямар тэмээнд ямар арчилгаа тэжээлэг хэрэгтэйг тогтоож авдаг байна. Бэлчээрийг нарийн хуваарь ээлж дараатай ашигладаг. Тэмээг нэг газраар олон өдөр дараалан хариулж, ургамлыг нь гишгүүлж их мөр гаргавал тэмээ тогтвор алдаж тааламжгүй болдог. Тиймээс тэмээний бэлчээрийг 1-2 хоноод ээлжлэн сэлгүүлж хариулж байх нь ашигтай. Бэлчээр нь тохирч бүрэн чадсан тэмээ хумж цуглуулахад амархан орой тийшээ гэрийн зүг тэмүүлж ирдэг гэнэ. Энэ үед нь түрүүг нь тогтоож сүүлийг нь хумх маягаар хариулгаар хотлуулдаг байна. Эднийхэн цөмөөрөө ажилсаг улс Аваргын гэргий Ш.Бүд тормоо ойрын бэлчээрт хариулж ингэ нийлүүлэгийн ажлаа голлоно. Сааль сүүгээ хариуцна. Эднийх ноос сүүний үйлдвэрлэлийн даалгавраа тасалж байсан удаагүй, энэ жил 1300л сүү саах үйлдвэрлэлийн даалгаврыг 1,5 хувь давуулахаар социалист уралдаант үүрэг авчээ. Энэ жил 34 ингэ ботголуулна. Ботгоныхоо нэмнээ, уяа, ногт, тэжээл зэрэг бүх бэлтгэлийг хангажээ. Хүү Цэвээндорж ааваа дагаж аварга болох чинь эрмэлзэлтэй. Энэ хүү эмнэгээ сургана, тормоо тэжээнэ. Эднийх 12 тэмээ

тэжээж байна. Амт оруулж дэвтээсэн багсармалыг бага багаар торомныхоо аманд хийж өгч тэжээлд дуртай болгодог байна. Тором тэжээж сургах бол Цэвээн хүүгийн ажил. Тэмээний хот, торомныхоо зэл хороог цэвэрлэх хуурайлах ажлыг бас хийнэ. Ийнхүү Бунтгар аваргынх Даравгайн усанд тавтай сайхан өвөлжиж байна. Ингээ ботголох болохоор Олон худагт очиж хаваржихаар бэлдсэн байна.

Б.Тогтох

117. Хошой аварга // Говийн мэдээ.- 1977 оны
2-р сарын 19.- №14.- 3-р нүүр.

Хошой аварга

Баян-Овоо сум

Баян-овоо сумын Говийн хөгжлийн нэгдлийн адуучин аймгийн хошой аварга, 20 гаруй жил адуу маллаж яваа Д.Шархүүд амжилт бүтээл, арга туршлага их бий. Гүү унагалах үер олон тасалгаатай хашаа барьж тасалгаа бүрд 2-3 гүү оруулж унагалуулаад уг тасалгаанд нь эхтэй нь хамт 7-14 хоног байлган тэжээл өгч унага бүрэн бойжуулдаг байна. Гүүг бэлчээрт сүрэгтэй хамт унагалуулахад унага адуунд дайруулж бэртэх зэргээр хорогдол гардаг учир дээрхи аргыг сүүлийн 2 жил хэрэглэж байгаа ажээ. Адуу их хужирсаг мал учир усан дээрээ хужрын цэг байгуулж байнга хужирладаг, гүү хээл авсаны дараа адуугаа үе үе таана багатай, улаан бударгана голлосон говьд оруулж говьлуулдаг, унагаа уях үед адуугаа азарга азаргаар нь ээлжүүлэн уяж унагаа новхруулдаг зэрэг туршлагатай адуучин юм. Дээрхи ажлын арга туршлагаа адуучин Ноов, Цэрэнпэл, Цэдэн-иш нарт эзэмшүүлж байгаа ажээ. Адуучин Шархүү 1977-онд урьдын ажлын амжилт арга туршлагаа бататган 100 эхээс 94 унага бойжуулах үүрэг авсны гадна жил

Говийн мэдээ сонин

дараалан тэмээний ноос дутаадаг Батмөнхийг шифлэн авч дутагдлыг нь засах үүрэг авсан байна.



Зураг дээр:
Аймгийн аварга адуучин Шархүү

118. Дөрвийн нэг // Говийн мэдээ.- 1977 оны 2-р сарын 19.- №14.- 3-р нүүр.

Дөрвийн нэг

Ханбогд сум



Галба нутгаас энэ жил 4 хүн аймгийн аварга малчнаар шалгарав. Тэдний нэг нь Ханбогд сумын Галбын хөгжил нэгдлийн Гавилууд бригадын хоньчин Сайнгэрлийн Ваанчиг юм. Ваанчиг 1959-онд хөдөө аж ахуйн нэгдэлд элссэнээс хойш нэгдлийн хонин сүргийг өсгөн олшруулах, ашиг шимийг нь бүрэн ашиглах талаар хүч хөдөлмөрөө дайчлан үр

бүтээлтэй ажиллаж байгаа тэргүүний малчин юм. Тэрээр сумын аваргаар 4 удаа, аймгийн аваргаар 2 удаа шалгарч байна. С.Ваанчиг зөвхөн сүүлийн 3 жилд нэгдлийн 448-475 төллөх эм хонь хариуцан маллаж 100 хувь онд

Говийн мэдээ сонин

оруулан,100 эх тутуамаас 103-108 хурга бойжуулж, суурын үйлдвэрлэлийн даалгаврыг төрөл бүр дээр нь 100,7-126,8 хувь биелүүлж иржээ. Нутгийн монгол хонь бүрээс1,6-1,7 кг ноос ашиглаж байна.С. Ваанчиг МАХН-ын ТХ-ы II бүгд хурлын шийдвэрийг хэрэгжүүлж, МҮЭ-ийн XI их хурал, Октябрийн социалист их хувьсгалын 60 жилийн ойг хөдөлмөрийн өндөр амжилтаар угтахаар 1977-оны бүх ард түмний социалист уралдаанд улсын хэмжээний бүх хоньчдыг уриалан, энэ жил хариуцан маллаж байгаа хонин сүргээ 100 хувь онд оруулан 100 эх тутмаас 106 хурга авах, эм хонь бүрээс 17-18 гр ноос ашиглах суурийнхаа хүчээр 3 доошгүй тн өвс, 0.5 тн гар тэжээл бэлтгэн суурийн аюулаас хамгаалах тэжээлийн 10 хоногийн нөөц байгуулах, суурийнхаа тохижилт, соёлжилтыг сайжруулан суурьд хөтлөгддөг анхан шатны бүртгэл тооцоог бүрэн нэвтрүүлэхээр үүрэг аваад ажиллаж байна.

Н.Банди

119. Галбын говийн тэмээчин // Говийн мэдээ.-
1977 оны 3-р сарын 14.- №20.- 2-р нүүр.

Галбын говийн тэмээчин

Ханбогд сум

Ханбогд сумын Галбын хөгжил нэгдэлд амжилт бүтээлээрээ алдараа өргөж яваа арвин баялаг туршлагатай тэмээчин олон бий. Тэдний нэг бол БНМАУ-ын Ардын Их Хурлын депутат Ш.Арван юм. Нийгмийн тэмээн



сүргийг 1959-оноос эхлэн маллаж байгаа энэ тэмээчин эмнэг тэмээг уналга эдэлгээнд сургах, ботго бойжуулах талаар үлэмж их туршлага хуримтлуулжээ. Ш.Арван, түүний гэргий Хүүхэн нар:

-Тэмээг бага наснаас нь эхлэн уналга эдэлгээнд сургах хэрэгтэй. Тэгэхдээ буйл бэлтгэх ажлаас эхлэх нь зүйтэй. Буйл хийх буйлсыг зөв сонгож авах хэрэгтэй байдаг. Хар хүрэн өнгөтэй, цагаан судалтай буйлс зориход зөөлөн, буйл хийхэд хамгийн тохиромжтой. Яр ихтэй зороход хатуу, сөрдөг буйлс буйл хийхэд муу байдаг. Бид ийм буйлсыг хэдэр хар гэж нэрлэдэг. Ийм буйлсээр буйл хийхэд тэмээний хамар хавдаж их баалдаг юм. Буйлыг гурвалжин шовх үзүүртэй зорж, шар тос түрхэж хатаагаад тэмээ буйлахад тэмээний хамар баалдаггүй. Тэмээг буйлахдаа зөв буйллах хэрэгтэй. Буйл нь хойгуурдвал ярдаг хэдэр, урдуурдвал хамар хатуутай болно. Дээгүүр буйлвал хамар нь сэтэрнэ. Тиймээс тэмээнд үүгээр буйлла гэсэн тэмдэг байдаг юм. Буйлын товхыг бог малын хар турууны өндгөн хэсгээр хийвэл бөх сайн болдог. Сургах тэмээгээ нэг өдөр уяж, сайн сойгоод унавал номхон дөлгөөн болдог юм гэж ярьж байна. Эднийх энэ жил 64 ингэ бууранд гаргаж, 78 ингэ ботголуулна. Ботголох ингээ байнгын маллагаанд байлгаж гаднаа ботголуудаг. Ботгыг гармагц зулайнаас нь дааруулахгүйн тулд толгойд нь зулайвч өмсгөж шар тостой хар цай өгөөд 20-30 минутын дараа эхийн дэлэнг шувтарч хөхний бөглөөг гаргаж амлуулна. Ингэж амлуулсан ботго чацрайлах нь бага гэнэ. Ботгоны ногт давчуудвал толгойдoo шигдэж өвс хоолонд орсоны дараа гүйцэд хивж чадахгүй байсаар хүмжтэй болдог байна. Ботгыг тэмээний ноос авч дуустал эхтэй нь хамт байлган эхийн сүүгээр махлуулаад 7-р сараас ботгоо уяж эхийг нь сааж үйлдвэрлэлийн даалгавраа биелүүлж эхэлдэг байна. Ботго чацрайлах явдал заавал байдаг тэгэхдээ богино хугацаанд болоод өнгөрөх ёстой. Удаан

Говийн мэдээ сонин

чацрайлсан ботго тарга хүч авахдаа муу хатайр гэм бий гэж Арван ярьж байна. Иэмээчин Ш.Арвангийн эмнэг тэмээг уналга эдэлгээнд сургадаг, ботго бойжуулдаг дээрхи арга туршлагыг нарийн аргачлан судлаж ялангуяа тэмээчин залуучуудад эзээмшүүлэх нь чухал юм.

Ч.Цэндоо

120. Тостын үхэрчин // Говийн мэдээ.- 1977 оны 3-р сарын 31.- №25.- 3-р нүүр.

Тостын үхэрчин

Гурван тэс сум

Өрхийн танилцуулгын буланд Баярын бичиг, Мэнд сүрэгтний гэрчилгээ тэргүүнтнийг он оноор нь тавьсныг харахад амьдрал нь тогтвортой айл болох нь



тодорхой. Эднийх сүүлийн хоёр жилд 46-52 үнээ тугаллуулан тугалаа бүрэн бойжуулж. Том малын зүй бус хорогдолгүй гаргаагүйгээр сумын мэнд сүрэгтний болзлыг хангажээ. Амжилтад хүрсний гол нь зун намрын улиралд үхэр бүрд зэргийн тарга хүч авахуулахаар соргог бэлчээр дагуулан маллаж тугалыг гарснаас эхлэн сайн махлуулдаг явдал юм.

Үхэрчин Г.Дарь гэртээ ажиллах хүч дутмаг хэр нь жил бүр 156-170-аад үхэр хариуцан маллаж онд тарган оруулж нэгдэл нийгэмдээ ихийг бүтээж байгаа ажээ. Энэ жил 161 үхэр хариуцан маллаж 60-иад үхэр тэжээж онд оруулаад одоо тугал бойжуулах ажилдаа ороод байна. Жил жилийн хавар их ажлын үе байдаг. Ийм нөхцөлд үхэрчин Дарь тугалаа, үхэрээ ноосолно, усалж хариулна, бас

дорой заримыг буюу улсын бэлтгэлд тушаах хэсгийг тэжээж тордоно. Энэ бүх ажил үхэрчин оногдох боловч ажлынхаа эв дүйг олж сурсан хашир малчин төдий л үүртэлгүйгээр өдөрт нь амжуулж дуусгаад дараахи өдрийн ажилтай золгодог. Гурван тэс сумын Соёл нэгдлийн Тост бригадын үхэрчин Г.Дарь олон жилийн дагнасан ажилдаа дадсан малчин.

Т.Цэдэв

121. Тэргүүний хоньчин // Говийн мэдээ.- 1977 оны 8-р сар 22.- №62.- 2-р нүүр.

Тэргүүний хоньчин

Цогт-Овоо сум

Цогт-овоо сумын Жаргалант нэгдлийн Замын шанд бригадын хоньчин намын орлогч гишүүн Ч.Бямбаа



10 жил дараалан төллөх хонь хариуцан маллаж сүүлийн 5 жил дараалан төл бойжуулах, ноос, сүүний үйлдвэрлэлийн даалгавраа хугацаанд нь давуулан биелүүлж V таван жилийн гавшгайч болсон байна. Хоньчин Ч.Бямбаа мал аж ахуйн өвөлжилтийн бэтгэл хангах тухай МАХН-ын ТХ-ы нэгдүгээр нарийн бичгийн дарга БНМАУ-ын Ардын Их

Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю.Цэдэнбалын албан даалгавар, аймгийн намын хорооны 3-р бүгд хурлын шийдвэрийг биелүүлж мал сүргийнхээ өвлийн бэлтгэлийг эртнээс бүрэн хангахын төлөө чармайн ажиллаж байна. Эднийх 5-р сарын 20 хойш өвөлжөөнөөсөө гарч ногоо сайн гарсан нутаг дагаж отор нүүдэл хийж мал сүрэгтээ тарга хүч авахуулж байна. Хоньчин

Ч.Бямбаагийнх энэ жил 362 хониноос 367 хурга бойжуулж уртын ноосны үйлдвэрлэлийн даалгавраа хугацаанд нь 10 кг ноосоор давуулж, одоо сүүний үйлдвэрлэлийн даалгаврынхаа ихэнхийг биелүүлээд байна.Эднийх одоо 730 гаруй хонь хариуцан маллаж бууцаа засаж,таана.борог хольж 500 кг дарш,зоодой 500 гаруй ширхэгийг хийж ,1 тн өвс түүж Хацарын гол,Хотгор, Билүүнээр нутаглаж байгаа аж. Хоньчин Бямбаа аймгийн аварга малчин Түнтээгийн туршлагаар төл бойжуулж мал сүрэгтээ тарга хүч авахуулдаг байна.Өнгөрсөн жил отор нүүдэл сайн хийсний үр дүнд хонь нэг бүр дунджаар 50 кг хүрч таргалжээ.Энэ амжилтаа энэ жил бататган ажиллаж 1977-оны социалист уралдаанд авсан амлалт үүргээ агуу их октябрийн социалист хувьсгалын 60 жилийн ойн өмнө биелүүлж, мал өвөлжүүлэх бэлтгэлээ үлгэр жишээ хангахаар шамдан ажиллаж байна.

Ч.Цэнддоо

122. Аварга малчин шалгаруулна // Говийн мэдээ.- 1977 оны 10-р сарын 31.- №81.- 2-р нүүр.

Аварга малчин шалгаруулна

Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаа саяхан аймгийн аварга малчдыг шалгаруулах зааврыг шинэчлэн баталлаа. Энэ заавраар мал сүргийн тогтвортой өсөлтийг хангах, мал аж ахуйн бүтээгдхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх малчдын хөдөлмөрийн идэвхи материалаг сонирхлыг улам дээшлүүлэх,мал маллагааны тэргүүний арга туршлагыг дэлгэрүүлэн нийтийн хүртээл болгох зорилгоор аймгийн аварга малчнаар жил бүр 24 хүнийг шалгаруулж байх болно. Үүнд өвөл хаврын улиралд малын тарга хүчийг хадгалж онд бүрэн оруулан зун намарт малдаа тарга хүч сайн авахуулсан тэмээчин, үхэрчин, адуучин, хоньчин, ямаачин тус бүр нэг, улсын бэлтгэлд тушаах малыг хорогдолгүй маллаж, хамгийн их жинтэй тушаасан

үхэрчин хоньчин, ямаачин тус бүр нэг буюу малын тарга хүч авахуулах ажлаар нийтдээ найман хүн, суурийн төллөх насны эх малаас хамгийн олон төл бойжуулсан тэмээчин нэг, адуучин нэг, үхэрчин нэг, нутгийн хонь маллагч нэг, каракуль хоньчин нэг, нутгийн ямаа маллагч нэг, Говь-гурван сайхан болон түүний эрлийз ямаа маллагч нэг буюу төл бойжуулах ажлаар нийтдээ 7 хүн, ялгасан төлөг борлонг зүй бусаар хорогдуулалгүй, тарга хүч сайтай онд оруулсан хоньчин ямаачин тус бүр нэгийг буюу өсвөр мал онд оруулалтаар 2 хүн, суурийнхаа мал бүрээс хамгийн их ноос ноолуур авч, хуулийн хугацаанд чанар сайтай тушаасан тэмээчин нэг, хоньчин нэг нутгийн ямаа маллагч нэг, говь гурван сайхан, түүний эрлийз ямаа маллагч нэг, хамгийн их сүү ашигласан тэмээчин нэг, адуучин нэг, үхэрчин нэг бүгд 7 хүнийг малын ашиг шим ашиглалтаар тус тус аймгийн аварга малчнаар шалгаруулна. Аймгийн аваргаар шалгарах малчин нь сүүлийн 3 жил дараалан тогтвортой амжилт олж суурийн малын тоо буюу нэг хүний хариуцах мал нь Намын Төв Хороо Сайд нарын Зөвлөлийн 1963-оны 210/330 дугаар тогтоолд заасан хэмжээнд хүрсэн суурийн үйлдвэрлэлийн бүхий л даалгавраа бүрэн биелүүлсэн байна. Төл бойжуулах ажлаар шалгарагчдыг дүгнэхдээ оны эхэнд байсан 100 хээлтэгч тутмаас бойжуулсан төлийн тоог гол үзүүлэлт болгох бөгөөд төллөх насанд хүрээгүй малын болон дахин хээлтүүлсэн малын төлийг тооцохгүй.

Ашиг шимийн аваргыг шалгаруулахад нэгж малаас ашигласан хонины ноосонд ахар хурганы ноосыг оруулахгүй. Аймгийн аварга малчныг шалгаруулахад суманд доорхи материалуудыг бүрдүүлэн аймгийн хөдөө аж ахуйг удирдах газарт жил бүрийн 11-р сарын 20 дотор ирүүлнэ. Үүнд : Шалгарсан суурийн ахлагчийн анкет ажлын үзүүлэлт

Н.Банди

123. Тэмээ маллах арга ухаан // Говийн мэдээ.-
1977оны 10-р сар 15.- №93.- 2-р нүүр.

Тэмээ маллах арга ухаан

/Тэргүүн туршлага/

Мандал-Овоо сум

Мандал-овоо сумын Хөдөлмөр нэгдлийн тэмээчин БНМАУ-ын Ардын Их Хурлын депутат МАХН-ын гишүүн Д.Хамар 20 жил тэмээ маллахдаа БНМАУ-ын хөдөлмөрийн баатар тэмээчин Д.Жижээгийн туршлагаар ажиллаж тэмээ маллах арга дадлагыг сайн эзэмшжээ. Хамарынх ханын хэцийн шилмэл омгийн тэмээ малладаг. Энэ тэмээ хүрэн улаан зүстэй галбир төрх сайхан, ноос нь маш шигүү арвинаараа онцлогтой. Ийм тэмээг өсгөж олшруулах, чанарын нь улам сайжруулах талаар Д.Хамар, гэргий Адьяадорж нар өнөөгийн малчин хүний нийгэмч сайхан сэтгэлээр хандаж их зүйлийг хийж байна. Үржлийн ажил: Эднийх ашиг шим сайтай тэмээний удам гарлыг харгалзан буур тавьж тэмээний ашиг шимийг нэмэгдүүлэх үржлийн ажил хийдэг. Буур тавих ботгоны эхийн удмыг ашиг шим галбир төрх зэрэг бүх талын тэгш сайн шинж чанарыг сонгодог. Буур тавих тэмээг багаас нь барьж тавьж унаж сургахад бүдүүн болоод номхон буур болдог ажээ. Буур тавих тайлаг монхор хоншоортой байвал тэнхээтэй, хондлой урттай бол ачаанд сайн, борви махир байвал унахад сайн гэх мэт олон онцлогтой шинжтэй гэнэ. Ботго бойжуулах. Энэ ажил ингэ нийлүүлэгийг аль хир чанартай явуулсанаас шалтгаална. Ингэний нийлүүлэгийн үед хээлтүүлэгийн журналыг тодорхой хөтөлдөгөөс ямар ингэ аль бууранд, хэдийд гарсан,хэзээ ботголохыг яг мэдэж байдаг. Ингэний хээлийг хамгаалахын тулд сувай тэмээнээс эрт ялгаж тусад нь хариулан хөөж тууж хөлөргөх, үргээж цочоохоос сэргийлж унаж эдлэхээс чөлөөлдөг. Ботголох

дөхсөн ингээ гаднаа авчирч ботголуулаад ботго гармагц давстай бараан цайгаар угжиж зунгаг түгжирэхээс сэргийлдэг. Мөн үсий нь эгшээж байж нэмнэдэг. Ботгыг 21 хоногтойгоос бэлчээрт идэшлүүлж сургадаг. Гэхдээ эхний үед өдөрт нь бэлчээж шөнө нь хурааж ирнэ. Тавдугаар сарын дунд үеэс шөнийн сэрүүнд эхээр явуулж идээшлүүлээд өглөө эрт хурааж үдийн халуунд хэвтэж амраахад ботго сайн махалдаг. Өвөл болоход зарим тэмээчин тормоо зэллэж уядаг нь буруу юм. Учир нь торомны хүзүү толгой удаан хугацаагаар тонгойж ядаргаатай байхаас гадна хоорондоо их шахалдсанаас болж бөөрний үс элэгдээд царай зүс муутай болдог. Тиймээс тормыг хаших нь илүү тоиромжтой арга гэж Д.Хамар ярьж байна. Ингэний сааль: Ботго бойжуулж махлуулах ажлын зэрэгцээ ингэ саах ажлыг зөв хослуулсанаар сааль сүүний даалгаврыг тогтмол давуулан биелүүлж иржээ. Эднийх тэмээгээ багаас нь бүгдийг буйллаж гунжин ингийг ботголмогц саалинд сургадгаас бүх ингээ саадаг. Гэхдээ өдөрт 2 удаа сааж их сүү авдаг. Энэ жил эднийх үйлдвэрлэлийн даалгавраар 1889 л сүү саахаас 200 гаад л сүү илүү өгөөд байна. Ер нь тэмээг уналга эдэлгээнд, ингийг саалинд сургахдаа зөөлөн гараар эв дүйгээр ажилладаг. Хариулага маллагаа: Тэмээ гүжир хичнээн ч хоног ус хоолгүй байж чаддаг мал мэтээр зарим хүн ярьдаг нь буруу юм. Тэмээг өвөл олон хоног усалгүй байлгаад уславал бана уудаг. Үүнийг зарим малчин цангаагүй болоод ус уухгүй байна гэж үздэг. Тэгвэл их цангасан учраас ус ууж чадахгүй байгаа юм. Харин өдөр бүр услаад байвал уух усны хэмжээ ихсээд ирдэг байна. Ингийг ботголсны дараа 4-5 хоног сойж байгаад усалвал ноос нь бэхжиж эрт зулгарч нүцгэрдэггүй гэнэ. Цаашдаа ботготой ингийг өдөр бүр услах шаардлагатай байдаг ажээ. Ботготой ингэ их цангаг учраас усаар дутагдвал сүү сааль ноос тарга хүчинд муугаар нөлөөлдөг. Тэмээнд эрт ногоо

идүүлэхийн тулд намар орой болон хавар эртийн чийгтэй газраар нүүж бут бударгана идүүлдэг. Ингэхэд тэмээ шууд махалж дараа нь өөхөлж ирдэг. Тарга хүчийг нь гүйцэд авахуулахын тулд нам дор газар хариулж өдөр бүр усалж цуглуулж намар болохтой зэрэг борог таана сөлтэй газраар хариулахад тарга нэмэгдэж тогтдог байна. Тэмээг өвлийн улиралд тарга хүчийг нь бүрэн хадгалахын тулд ялангуяа тормыг тэжээхэд тэжээл амархан авдаг. Харин тэжээж байгаа үедээ сайн услах нь чухал. Тэмээг хариулж маллахдаа шивээгүй газар сонгохын зэрэгцээ мотоциклоор хөөж тууж хөлөргөн хайлгаж эцээж улмаар өвчлүүлэхээс болгоомжлох хэрэгтэй гэнэ. Туршлагатай тэмээчин Д.Хамарынх тэмээ маллагааны ажил дээрхи арга барилыг хэрэглэж ажилладгаараа нэртэй тэмээчин болжээ. Д.Хамарынх энэ жил 267 тэмээ маллаж ээлжийн 49 ингэнээс 49 ботго бойжуулж үйлдвэрийн даалгавраас 30-иад кг ноос илүү тушаасан амжилтаар шинэ онтойгоо золгох гэж байна.

Д.Цэвэгмид

- 124.** Мал аж ахуйн өвөлжилт,төл бойжуулах ажлыг зохион байгуулах // Говийн мэдээ.- 1977 оны 11-р сарын 21.-№86.- 2-3-р нүүр.

**Мал аж ахуйн өвөлжилт,төл бойжуулах
ажлыг зохион байгуулах**

/Аймгийн АДХ-ын 11 дэх удаагийн V чуулганд, Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны нэгдүгээр орлогч дарга, депутат Ж.Даргахүүгийн тавьсан илтгэл/. Депутат нөхөд өө.

Манай эдийн засгийн онцгой чухал салбар мал аж ахуйг бүх талаар хөгжүүлэх нь улс ардын аж ахуйн нийт салбарын хөгжлийн хурдцыг улам түргэтгэх хөдөлмөрчдийн материалаг аж байдал соёлын хэмжээний гуйвалтгүй өсөлтийг хангах нэн чухал үндэс

юм. МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс энэ жил мал аж ахуйн үйлдвэрлэлийн удирдлага зохион байгуулалтыг сайжруулахтай холбогдсон олон чухал тогтоол гаргаж өнгөрсөн өвөл хаврын улиралд мал аж ахуйд учирсан хохирлыг богино хугацаанд нөхөхийг төв орон нутгийн нам, улс, олон нийт. Хөдөө аж ахуйн бүх байгууллагын нэн тэргүүний зорилт болгон тавьлаа. Намын Төв Хорооны Х бүгд хурал дээр мал өсгөх таван жилийн хөдөлшгүй төлөвлөгөөг биелүүлээгүй, үүний дотор бод мал өсгөх төлөвлөгөөг тасалсан дутагдлын талаар шүүмжлэгдсэн манай аймгийн хувьд мал аж ахуйн өвөлжилт, төл бойжуулах бэлтгэлийг бүрэн хангах. Тус бүгд хурлын түүхт шийдвэр, түүний дайчин үзэл санаа, зарчимч үзэл шаардлагыг амьдралд бүтээлчээр хэрэгжүүлэн биелүүлэхэд бүхий л талын нөөц бололцоогоо шавхан дайчилж, ажлын салбар бүхэнд хариуцлага сахилга батыг сайжруулах явдал чухал байна. Аймгийн намын хорооны III, IV бүгд хурлаар малын хорогдлын шалтгаанд дүгнэлт хийж мал аж ахуйн өвлийн бэлтгэл хангахад аймгийн намын байгууллагын хойшлуулшгүй зорилтын тухай хэлэлцэж чухал заалт шийдвэр гаргасан билээ. Эдгээр шийдвэрийг хэрэгжүүлэх мал сүргийн тогтвортой өсөлтийг хангах бодит гол үндсийн нэг бол мал аж ахуйн өвөлжилтийг бүрэн хангах явдал юм. Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангах тухай нөхөр Ю.Цэдэнбалын 14 дүгээр албан даалгаварт дурдсанчлан энэ өвөл хаварт мал сүргийг онд мэнд оруулах, төл бүрэн бойжуулах аж ахуй зохион байгуулалтын бүх бэлтгэлийг бүрэн хангаж ажиллах нь манай ажлын гол чиглэл, цаг үеийн үндсэн зорилт болж байна. Мал аж ахуйн өвлийн бэлтгэлийг хангах талаар Цэдэнбал даргаас өгсөн энэ даалгавар нь цаашдаа байнга мөрдөгдөж мал өсгөж махны нөөцийг нэмэгдүүлэх, мал аж ахуйн материалаг баазыг бэхжүүлэх ажлын үндсэн удирдамж болох ёстой. Мал

сүргийг өвөлжүүлэх, төл бойжуулах ажлыг удирдан зохион байгуулах талаар ялангуяа сүүлийн жилүүдэд зарим ахицтай өөрчлөлт гарч байгаа боловч төдий л үр дүнд хүрч чадахгүй байна. Цаг агаарын онцгой бэрхшээл тохиолдоогүй манай аймаг энэ жил зүй бусаар 116.1 мянган мал хорогдож өнөгөрсөн жилийн мөн үеийнхээс 47 хувиар өссөний дотор том малын хорогдол 1,4 хувь, хээл хаялт 2,1 дахин төлийн хорогдол 15 хувь ихэссэн нь мал аж ахуйн өвөлжилт, төлийн бэлтгэлийг нэн хангалтгүй хийж уг ажлыг цаг үеийн нөхцөл шаардлагад зохицуулан оновчтой удирдан зохион байгуулж чадаагүйгээс болжээ. Гурвантэс, Булган, Сэврэй, Ханхонгор, Мандал-овоо, Баяндалай сум оны эхэнд байсан малынхаа 3,1-4,5 хувийг гарсан төлийнхөө 10,9-16,9 хувийг хорогдуулсаны гадна 1,1-3,1 мянган эх мал хээл хаясан нь өвлийн бэлтгэл хангахад хүмүүсийн ажлын хариуцлага сул, нам улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх талаар тэмцэл санаачлага муу байсаны нотолгоо юм. МАХН-ийн Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю.Цэдэнбалын 14 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэхэд аймаг сумын нам улс хөдөө аж ахуйн байгууллага нилээд анхаарч ажилсны үр дүнд мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангах талаар энэ жил багагүй зүйл хийсэн боловч өвлийн бэлтгэлийн үзлэгээр 4 сум, 13 бригад, 327 суурь буюу бүх суурийн 21,5 хувь нь бэлтгэл хангаагүй байв. Баян-овоо сумын Могой бригадын дарга Ёндон бүх суурийн 42,5, Манлай сумын Далай бригадын дарга нь Бадамгэрэл суурийн 48,9, Ханхонгор сумын Жаргалант бригадын дарга нь Цогбадрах бүх суурийн 44 хувь нь өвлийн бэлтгэлээ хангаагүй дээр зарим суурьд өвлийн бэлтгэл хангах талаар юу ч хийлгүй зун намрын боломжтой цагийг өнгөрөөжээ. Иймээс өвлийн бэлтгэлийн дутууг 12 дугаар сарын нэгний дотор бүрэн гүйцээхийг бэлтгэл хангаагүй

буюу дутуу хангасан сумдын удирдах нөхдөд тус чуулганаас шаардаж байна. Энэ жил манай аймаг 7700 тн байгалийн хадлан, 510 тн ногоон тэжээл бэлтгэж өвс хадлангийн төлөвлөгөөг 108,8 хувь биелүүлсэн боловч гар тэжээл бэлтгэх төлөвлөгөөг 80,7 хувь, үүний дотроос манай говьд хамгийн шим тэжээл чанар сайтай тэжээл зоодой бэлтгэх төлөвлөгөөг 58,9 хувиар тасалж энэ оны зун намар хур бороо элбэг гарын гарц арвин байсан цагийн хамгийн аятай нөхцлийг муу ашиглаж Ханбогд, Цогт-Овоо, Хүрмэн, Манлай, Гурвантэс сум зоодой бусад гар тэжээл бэлтгэх талаар үлэмж бага анхаарсныг зориуд шүүмжилж байна. Одоо гаднаас авах тэжээлийн 65,8 хувь өвсний дөнгөж 33 хувийг тээвэрлэж олонхи суурьд энэ өвөл хаварт шаардагдах өвс тэжээл буугаагүй байгаагийн гадна бүх суурийн 34,3 хувь нь аюулаас хамгаалах тэжээлийн 10 хоногийн нөөцгүй байна. Орон нутгийн нөөц болоцоог ашиглан малын тэжээлийн нөөцийг арвижуулан нэмэгдүүлэхэд нийт сум нэгдлүүд тодорхой анхаараагүй байна. Булган сумын хоньчин Буджав бэлчээрийн шимтэй өвс ногоог түүж тус бүр нь 40-50 кг жинтэй 80 гаруй боодол өвс бэлдсэн, Баяндалай сумын тракторчин Цэдэв гэр бүлийнхээ хамтаар 184 кг таанан зоодой хийж нэгдэлдээ тушаасан зэрэг нь идэвхи санаачлага гаргавал малын тэжээлийн нөөцийг арвижуулах бололцоо орон нутагт байгааг харуулж байна. Малын тэжээл бэлтгэлийг цаашид нэмэгдүүлэх, шимт чанар сайтай тэжээл бэлтгэж байхын тулд төлөвлөгөөний биелэлтийг тэжээлийн нэгжээр тооцдог журам тогтоовол зүйтэй. Энэ өвөл хаварт мал сүргийг онд оруулах төл бойжуулахад тэжээл, тэжээллэгийн талаар тавих гол шаардлага бол нэгдүгээрт бүх болоцоог дайчлан өвс тээвэрлэлтийг шуурхайлан хувиарт өвсөө ойрын үед татаж суурьд хүргэх нядалсан малын сэвс, цус, элэг хээл зэргийг ашиглах, төв суурин газрын ажилчин албан хаагчдад хүн амын хүнсний зүйлийн

болон амьтны гаралтай тэжээл бэлтгэх, даалгавар өгч бэлтгүүлэх замаар тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх, хоёрдугаарт дунд дундаас доош тарга хүчтэй бүх мал, хээлтэгч нэг настай малыг зохих жор нормын дагуу тэжээх, гуравдугаарт мал тэжээх зөв зохистой технологийг малчдад эзэмшүүлэх, дөрөвдүгээрт: -мал тэжээх материалаг баазаар суурь, эмчилгээ тэжээлийн цэг бүрийг хангах явдал юм. Говийн цаг уурын байдал, олон жилийн ажиглалт, судалгаа тэргүүний малчдын арга ажиллагаанаас үндэслэн манай аймгийн хувьд бог малыг эрт төллүүлэх нь ашигтай гэж үзэж бог малын нийлүүлэгийг энэ жил урд жилүүдээс эрт эхэлсэн бөгөөд ирэх онд мал эрт төллөх онцлогийг харгалзан хээлтэй болон төллөсөн мал нэг бүрийн тэжээлэг арчилгааг урд жилүүдээс эрс сайжруулж төлийг сэнсрэлтээс хамгаалахад онцгой анхаарвал зохино. Энэ бол мал өвөлжилт, төл бойжуулах ажилд шинэ шаардлагаар тавигдаж байгаа онцлог гэдгийг зориуд анхааруулж байна. Өвс тэжээлийн зориулалтад тавих хяналт шалгалтыг хүчтэй болгох шаардлагатай байна. Манай олонх суурь тусгай хаваржаа байхгүй нэг бууцанд өвөл хаврын 6-7 сарын турш сууж, хавар мал бэлчээрээс авах тэжээлийн хэмжээ багассанаас жилбэгүй төллөх буюу сүү шим нь буурдгаас төл харангадаж сэнсэрч хорогдогийг анхаарч бэлчээрийг нарийн хуваарьтай ашиглах хэрэгтэй. Хужир бэлтгэх төлөвлөгөө дөнгөж 33,6 хувьтай. Хүрмэнээс бусад сум төлөвлөгөө биелээгүй байгаагийн дотор Баян-Овоо, Номгон, Мандал-Овоо сумд 8,0-8,9 хувийн гүйцэтгэлтэй байна. Одоо сум бригадын төвийн хүмүүсийн хүчийг ашиглан хужир бэлтгэх ажлыг нэгдсэн зохион байгуулалтаар хийж суурь, сум, бригадын фондод 12 дугаар сарын 1 ний дотор татаж дуусгах нь зүйтэй. Хөх хоргол хуурай бууцыг шаардагдах хэмжээгээр нөөцөлсөн сум нэгдэл алга байна. Хэвтэрийн хөлдүүгээс ямаа олноор хээл хаядгийг

анхаарч юуны урьд төллөх ямааны суурь бүрт эхний ээлжинд хуурай бууц бэлтгэх хос хороо барих нь зүйтэй. Нялх төлтэй ба ядарч доройтсон малыг жаврыг нь гаргасан усаар услах явдал онцгой ач холбогдолтой билээ. Гэтэл гар усалгааны төхөөрөмжийг суурь бүрт бий болгох, түүнийг ашигладаг болгоход сум нэгдлийн удирдах нөхөд, мал аж ахуйн мэргэлжилтнүүд огтхон ч анхаарахгүй байна. Бараг бүх сум худаг засах, лайдах ажлыг ойртуулж Баяндалай, Манлай зэрэг сумд өвөл хаварт ашиглагдах худгийг одоо ч бүрэн засаж лайдаж дуусаагүй. Цэдэнбал даргаас өгсөн даалгаврыг биелүүлээгүй хөсөрдүүлж байна. Энэ жил хур бороо ихтэй байсны улмаас худгийн усны түвшин дээшилж амархан хөлдөх нөхцөлтэй болсон тул худаг дулаалах ажлыг урьд жилүүдээс эрс чанартай хийх хэрэгтэй. Аймгийн усны аж ахуйг удирдах газар худаг засварлах бригадыг нэмэн гаргаж, тодорхой график хугацаатайгаар ажиллуулан энэ өвөл хаварт ашиглагдах одоо эвдрэлтэй байгаа өрөмдмөл бетон хашлагт бүх худгийг 12 дугаар сарын 10 ны дотор ажилд оруулах арга хэмжээ авбал зохино. Бог мал үхрийн суурийн 94,6 хувь нь өвөлжөө хаваржаандаа дулаан хашаа саравчтай боловч хашаа саравч пүнзийг бүрэн засч дуусаагүй зарим суурьд төлийн байр пүнз дутагдалтай байна. Тус аймагт төлийн хорогдлийн 60-70 хуийг амьсгалын замын болон хоол боловсруулах эрхтэний өвчин эзэлж байгаа нь төлийн байрны шаардлага хангалтгүй хөрвийн аргаар бойжуулах технологийг мөрдөхгүй байгаатай холбоотой. Сууриуд өвөлжөөний хоёр пүнзний зөвхөн нэгийг төл бойжуулахад ашиглаж байна. Суурьд байвал зохих материалаг зүйлээр бүрэн хангагдсан суурь үнэн хэрэгтээ тун ховор байна. Иймд нэгдэл өөрийн санхүүгийн хүчин чадлын хэмжээгээр жил бүр 10-15 өвөлжөөг мал тэжээж арчлахад бүх зүйлээр иж бүрэн тоноглож суурьд актаар хүлээлгэн өгөх замаар бүх

суурийн мал өвөлжүүлэх, төл бойжуулах материалаг баазыг бэхжүүлэн сайжруулах арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзэж байна. Мал аж ахуйн өвөлжилтийн нэг гол ажил бол зун намрын дэлгэр цагт бүх малд дээд зэргийн тарга хүч авахуулах явдал юм. Гэвч энэ жилийн цаг агаарын таатай байдлыг муу ашигласанаас бүх малын 10 шахам хувь нь бүрэн тарга хүч авч чадсангүй. Манлай, Гурвантэс, Баян-овоо сумын бүх малын 10,9-12,6 хувь нь дунд дундаас доош тарга хүчтэй байна. Хөдөлмөр зохион байгуулалтыг төгөлдөр сайн хийх нь малчдын хөдөлмөрийг хөнгөвчилж малын арчилгаа маллагааг сайжруулан онд бүрэн оруулах нэг үндэс болдог. Тэгтэл ялгавал зохих төлийг ялгахгүй суурьд орхих, төллөх мал, нэг наст малыг хольж суурилах тэрч байтугай нэг суурьд 2-3 төрлийн мал өгөх явдал Цогтцэций, Манлай, Мандал-овоо суманд байсаар байна. Ирэх жилийн төл бойжилт, энэ жилийн хээлтүүллэгийг хэр сайн зохион байгуулснаас шууд шалтгаална. Энэ жил бог мал нийлүүлгийн ажилд Цогтцэций, Манлай, Баяндалай сум хариуцлагагүй хандсан явдлыг тус чуулганаас эрс буруу шааж байна. Жил бүр 20-иод мянган мал сувайрч байгаа нь нийлүүлэгийн ажлыг шинжлэх ухааны үүднээс зөв зохион байгуулж чадахгүй урсгалаар явуулж байгаатай холбоотой. Малын хээл хамгаалах ажил ч тус аймагт хангалтгүй байна. Сүүлийн 5 жилд дунджаар жил бүр 27 мянган мал хээл хаясны зонхлох суурийг ямаа гүү эзэлж байна. Иймд нийт сум энэ жил ямаа, гүүний хээл хаялтыг буруулах талаар шийдвэртэй арга хэмжээ авах тодорхой зорилт дэвшүүлэн ажиллавал зохино. Адууны хариулга маллагааг сайжруулан унагалсан гүүг 7-14 хоног гадуураа тусгай маллаж унагыг хөрвөжүүлээд сүрэгт нь нийлүүлэн маллаж сүүлийн хэдэн жилд 100 гүү тутмаас 84-91 унага бойжуулж байгаа Цогт-овоо сумын Могой бригадын адуучин Д.Шархүүгийн туршлагыг нийт

адуучдад эзэмшүүлэх намар хээлийн эмзэг үеэр адууны хариулга маллагаа усалгааг сайжруулах талаар сумдын удирдах нөхөд мал аж ахуйн мэргэжилтнүүд онцгой анхаарах хэрэгтэй. Сүүлийн таван жилд тус аймгийн төлийн хорогдлын 55,4-62,4 хувийг ишигний хорогдол эзэлж байна. Ер нь ямааны зүй бус хорогдол илүү байна. Иймд ишиг бойжуулдаг бүх суурийн төлийн байрны нөхцлийг өөрчлөн сайжруулах шаардлагатай байна. Ишиг бойжуулах тараар тэргүүний хүмүүсийн арга туршлагыг ямаачдын суурьд өргөнөөр нэвтрүүлвэл зохино. Төлчин эмэгтэйчүүдийг семнарын чанарыг сайжруулах, харин бог малын төл бойжуулах талаар голлон яригдаж, бодын төл бойжуулахад анхаарал бага тавьдаг учир бод малын төл бойжуулагчдын чуулга уулзалт семнарыг тусгайд нь хоёрдугаар сарын сүүлчээр хийж байх нь ашигтай байна. Төл бойжуулалтын удирдлага зохион байгуулалтыг үйлдвэрлэлийн гүнд төвлөрүүлж хөнгөн шуурхай байлгах нэг арга бол мал төллүүлэх суурийн дунд төлийн штаб байгуулан ажиллуулах явдал юм. Төлийн штаб гэдэг бол төл бойжуулалтын явцыг сууриудад байнга шалгаж шаардагдах арга хэмжээг газар дээр нь түргэн шийдвэрлэдэг удирдлаг зохин байгуулалтын шуурхай төв байх ёстой. Өвчтэй төлийн эмчилгээний цэг байгуулан, бүх төлд эрүүл мэндийн үзлэг хийж өвчтэй төлийг цуглуулан эмчилдэг арга ашигтай болох нь амьдрал дээр нотлогдсон учир энэ жил өвчтэй төлийн эмчилгээний цэгийг, эмчилгээний байр, хашаа, төлийн дулаан байр болон мал тэжээж арчлахад шаардагдах бүх зүйл машин унаагаар бүрэн хангаж, малын эмч санитарч, малчин төлчинтэйгээр байгуулж ажиллуулах нь зүйтэй гэж үзэж байна. Төлийн штаб эмчилгээний цэгийг нэг зохион байгуулалттай хийж болох юм. Аймаг сумын төвийн албан байгууллагууд шиф сум нэгдэл, бригад, суурийн өвлийн бэлтгэл хангахад багагүй

туслалцаа үзүүллээ. Гэтэл хиймэл дагуул ашиглах станц, холбооны газар, аймгийн төвийн цэцэрлэгүүд шиф нэгдлийнхээ өвлийн бэлтгэл хангах ажилд бодитой туслалцаа үзүүлээгүй байна. Энэ ажилд бүх байгууллага анхаарч ажиллах нь зүйтэй. Мал сүргийг онд мэнд оруулах, төлийг бүрэн бойжуулахад мал аж ахуйн мэргэжилтнүүд хариуцлага сул, мал эмнэлэгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар муу байгаа явдал мал, төл их хэмжээгээр хорогдохын гол шалтгаан болж байна. Мал аж ахуйн мэргэжилтнүүд ажлын хариуцлагыг дээшлүүлэн идэвх санаачлагыг өрнүүлэх талаар хөдөө аж ахуйг удирдах газар, мал эмнэлэгийн газар, орон нутгийн засаг захиргааны байгууллага онцгой анхаарч тэдэнтэй тодорхой ажиллах явдал чухал байна. Энэ жил аймгийн төвт мэргэжлийн болоод мэргэжлийн бус ажил хийж байгаа мэргэжилтнүүдийг төлийн хорогдол ихтэй сумдад группээр явуулж ажиллуулсан нь үр дүнгээ өглөө. Малчдаар социалист уралдаанд тооцоотой өндөр үүрэг амлалт авахуулах, нэгдэл малчдын хооронд гэрээ байгуулах бригад хэсэг суурийн дунд болзолт уралдаанд зарлах зэргээр мал онд оруулах төл бойжуулах ажилд социалист уралдааныг эрчимтэй өрнүүлэх, уралдааныг өргөн сурталчлан таниулах, түүнийг богино хугацаанд дүгнэн шалгарагчдыг шагнаж урамшуулах зэргээр малчдын хөдөлмөрийн идэвхийг бүхий талаар өрнүүлэхэд анхаарч ажиллах ажил чухал байна. Бүх малчид тариаланчдаар таван жилийн хугацаатай үүрэг авахуулах ажил аймгийн хэмжээгээр зохион байгуулагдсан боловч малчид ямар үүрэг авсанаа мэдэхгүй байгаа явдал зарим суманд гарсныг Намын Төв Хорооны групп үзлэг шүүмжилж байна. 1978-оны социалист уралдааны үүрэг амлалтыг таван жилийн нь үүрэгтэй холбож авахуулах, таван жилийн үүргийн биелэлтийн явцыг дүгнэж таниулах ба нөөц боллоцгоо

дайчилж чадаагүй тооцоо үндэслэл муутай шахуу биш авагдсан үүргийг шинэчилж өөрчлөх ажил зохиох шаардлагатай байна. Тарга хүчийг тогтоох мал онд оруулах, хээл хамгаалах, төл бойжуулах талаар сумын намын үүр, АДХ-ын гүйцэтгэх захиргааны албан даалгаврыг суурь бүрт 12 дугаар сарын 15 ны дотор багтаан өгөх нь зүйтэй. Бэлчээр ашиглалт, мал тэжээж байгаа байдал, услалт, бэлчээрлэлтийн цагийн хуваарь зэргийг сууриудад тогтмол шалгаж зохих шаардлага тавьдаггүйгээс малын арчилгаа маллагааны гол чухал ажлуудын технологи зөрчигдөж, мал төл хорогдох нэг үндэс болж байгаа тул мал өвөлжилт төл бойжуулалтын үеийн хяналт шалгалтын ажлыг улам хүчтэй болгох шаардлагатай байна. Сум бригад хэсгийг тодорхой хүнд хариуцуулан тэдний хариуцлагыг өндөржүүлэх, хариуцсан газрын ажлын үр дүнгээр тэдний ажлыг дүгнэж зарчимч өндөр шаардлага тавьж ажиллахыг аймаг сумын АДХ-ын гүйцэтгэх захиргаад анхаарвал зохино. Аймаг сумын онцгой комиссыг мал өвөлжүүлэх, төл бойжуулах ажилд бүх нийтийн хүчийг зохион байгуулах шуурхай удирдлагын төв болгон ажлыг нь эрс сайжруулах явдал чухлаар шаардагдаж байна. Онцгой үеийн арга хэмжээний иж бүрэн төлөвлөгөөг боловсруулан дадлага сургууль хийж байнгын бэлэн байдалд байлгах нь зүйтэй. Цаг агаарын аюулгүй нөхцлөөс урьдчилан сэргийлэх мэдээллийн албыг шинэчлэн зохион байгуулж ажилд оруулах нь чухал байна. 12 дугаар сарын 20-ны дотор сум бүрт бинзеи шатхууны 20-30 хоногийн байнгын нөөцтэй болгохыг аймгийн тээврийн удирдах газарт зориуд үүрэг болгож байна. Өнгөрсөн өвөл хаварт мал онд оруулах, төл бойжуулах ажлын ид үед малчдыг гурал будаа, цай давс, лаа шүдэнз, тамхи зэрэг өргөн хэрэглээний бараагаар тасалдуулж байсан дутагдалд хийж агентуудыг сууриудаар явж үйлчлэх ажлын тусгай графиктай ажиллуулвал зохино. Малчдын хувийн

бэлтгэлийг хангуулах тэдэнд хөдөлмөр хамгааллалын хувцасыг бүрэн олгох, хөдөлмөрийн багаж хэрэгсэл, уналгаар хангах хэрэгтэй. Ердийн хөсгийн ашиглалтыг сайжруулах талаар дорвитой өөрчлөлт гаргахыг нийт сум нэгдлийн удирдлагуудад үүрэг болгож байна. Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийн дутууг дээр дурдсан хугацааны дотор бүрэн хангаж мал өвөлжүүлэх, төл бойжуулах ажлыг дээд зэргээр зохион байгуулан энэ жил гарсан малын зүй бус хорогдлыг ирэх жил 30 хувиар бууруулан 356,1 мянган төл бойжуулан авч энэ онд мал аж ахуйн үйлдвэрлэлд гарсан хохирлыг нөхөн 1978-оны мал өсгөх улсын төлөвлөгөөг төрөл бүр дээр нь давуулан биелүүлэх зорилтыг тус чуулганаас дэвшүүлж байна.

ДЕПУТАТ НӨХӨД ӨӨ. Манай аймгийн хөдөлмөрчид агуу их октябрийн хувьсгалын түүхт 60 жилийн ойг хөдөлмөрийн өндөр амжилтаар угтаж өөрийн үндэсний байр, Монгол-Зөвлөлтийн найрамдлын баяр болгон ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлэв. Октябрийн хувьсгалын 60 жилийн ой нь энэ оны бүх ард түмний социалист уралдааны эрин дуудлага болж манай нийт хөдөлмөрчдийн идэвхийг өрнүүлэн 1977-оны улс ардын аж ахуй соёлыг төлөвлөгөөг амжилттай чухал хүчин түлхэц болж байна. Энэ оны 10 дугаар сард аймгийн аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдхүүний үйлдвэрлэлийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеийнхээс 29.7 хувиар өсч 2 сая гаруй төгрөгний бүтээгдхүүнийг төлөвлөгөөнөөс давуулан үйлдвэрлэсэн байна. Хөдөө аж ахуйн нэгдэлч малчид малаа 98.2 хувиар онд оруулж төлөө 89.5 хувиар бойжуулан 1977 оны мал өсгөх улсын төлөвлөгөөг амжилттай биелүүлж мал сүргийг отроор таргалуулах, мал аж ахуйн өвлийн бэлтгэлийг хангах талаар их хүч чармайлт гарган хөдөлмөрлөж ажлын багагүй амжилт оллоо. Ийнхүү алдарт ойн жилд улс ардын аж ахуй соёлын төлөвлөгөөг биелүүлэх талаар багагүй амжилт олж байгаа боловч энэ оны үлдэж байгаа

хугацаанд улс, олон нийт, аж ахуйн байгууллага, хөдөлмөрийн хамт олны анхаарал хүчийг төвлөрүүлэн шийдвэрлэвэл зохих нилээд асуудал байгааг онцлон тэмдэглэж ярилцах нь зүйтэй юм. Юуны өмнө сум нэгдэл, үйлдвэрлэл аж ахуйн газар, соёл үйлчилгээний байгууллага бүр 1977 оны төлөвлөгөөт бүх зорилтуудыг социалист уралдааны үүргээр биелүүлэх тооцоо хийж үйлдэж байгаа сар хагасын хугацаанд ажлаа улам эрчимжүүлэн үр бүтээлтэй ажиллаж VI таван жилийн төлөвлөгөөний хоёр дахь оныг урьд олсон амжилтаа бататгаж улсын тэргүүний аймгийн зэрэгт хүргэхээр нам засагтаа амласан өндөр хариуцлагатай үүргээ бүрэн биелүүлсэн тодорхой үр дүн гаргах явдал мөн. Бид үнэхээр жигд сайн ажиллаж чадах юм бол амжилтад хүрэх ихээхэн бодит бололцоо байна. Үүний тулд сум нэгдэл бүр мал өсгөх талаар аймгийн Намын хороо АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас өгсөн үүрэг даалгавыг биелүүлэх өргөн санаачлага гарган бүтээлчээр ажиллавал зохино. МАХН-ын ТХ-ны 1975-оны X бүгд хурал, аймгийн намын хорооны энэ оны IV дүгээр бүгд хурлын дайчин шийдвэр, дээшлүүлсэн зорилтыг биелүүлэх, ажилдаа улам их эрч хүч нэмж ажлаа шинэ шаардлагын дагуу шинэ арга барилаар удирдан зохион байгуулах явдал хурц тавигдаж байна. Ажлын явц цагийн байдалд дутуу дүгнэлт хийх, тайвшрах хандлага арилахгүй байна. Хүйтний ид үе эхлэх болоогүй байхад олонх суманд цасан бүрхүүл тогтож цаашдаа цас нилээд орох төдийгүй ирэх өвөл хүйтэн, хахир, хатуу, хүйтэн болох төлөвтэй байна. Энэ нь мал өвөлжүүлэх, төл бойжуулахад малчдыг ажиллагааг хүндрүүлж болзошгүй юм. Цаг агаарын түр зуурын бэрхшээлийг гарз хохиролгүй даван туулах, бэлтгэлийг сайн хангах, ялангуй том малын хорогдол, хээл хаялтыг гаргуулахгүй байх бодитой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг нийт сумдын удирдлагуудад хандаж зориуд анхааруулж

байна. Өвчтэй муу малыг ялгах нэг настай болон дунд ба дундаас доош тарга хүчтэй мал бүрийг нэмэгдэл тэжээлд оруулах, эмчилгээ тэжээлийн болон тэжээлийн цэгийн ажиллагааг сайжруулж тэнд ажиллагсдын хариуцлагагүйгээс олон тооны мал хорогдуулдаг дутагдлыг арилгавал зохино. Мал аж ахуйн өвлийн бэлтгэлийн дутууг сум, бригад, суурь бүр яаралтай нөхөн хангах, төл хүлээн авах бэлтгэлийг эртээс чанар сайтай хийж малын хорогдолтой тэмцэх ажлыг хүчтэй болгох, улсын мал тооллогын ажилд одооноос эхлэн эрчимтэй бэлтгэх хэрэгтэй байна. Тус чуулганаас дэвшүүлсэн зорилтыг амьдралд бүтээлчээр хэрэгжүүлэхэд депутатууд та бүхнээс гүйцэтгэх үүрэг их юм. Юуны өмнө тавигдаж байгаа зорилт, биелүүлэх арга замыг хөдөлмөрчин олон түмэнд хүргэж тайлбарлан таниулах түүнийг хэрэгжүүлэхэд хөдөлмөрийн хамт олныг үлгэрлэн манлайлах хэрэгтэй. Мал аж ахуйн өвөлжилт, төл бойжуулах ажлыг зохион байгуулах арга хэмжээний талаар дэвшүүлж байгаа зорилт аймгийн аж ахуй соёлыг хөгжүүлэх төлөвлөгөөний үзүүлэлт нэг бүрийг тоо чанарын өндөр үзүүлэлт тэйгээр бүрэн ба давуулан биелүүлэхийн төлөө нөөц бололцоо бүхнээ дайчлан ажиллаж хөдөлмөрийн өндөр амжилт гаргахыг аймгийн ардын депутатууд, нийт хөдөлмөрчдөөс тус чуулган уриалж байна.

125. Аварга малчны ажил үйлс // Говийн мэдээ.- 1978 оны 2-р сарын 20.- №14.- 3-р нүүр.

Аварга малчны ажил үйлс

Ханхонгор сум

Ханхонгор сумын Гэрэлт зам нэгдлийн Өгөөмөр бригадын хоньчин аймгийн аварга малчин О.Дорж 20 шахам жил хонин сүрэг маллаж төл бойжуулалтын сумын 3 удаагийн аварга болсон хүн юм.Хоньчин Дорж өвөл

хаврын улиралд бэлчээрийг хуваарьтай ашиглаж хонио тэнгэр муухайрсан хүйтэн үед уулархаг нөмөртэй газар дулаан өдөр нам дор тал бэлчээрт хариулдаг байна.

Мал таргалуулах. Авсан тарга хүчийг чамбайруулан тогтоох талаар тэргүүний малчин юм. Хонин сүргээ таргалуулахдаа говь хужиртай нутгийг



сонгон авч, зун намрын улиралд хонио өдөрт 1-2 удаа усалдаг. Хонь тарга хүчээ 9 дүгээр сард бүрэн авдаг учир энэ үеийн маллагааг сайжруулж отор сайн хийж борог шарилж сайтай нутгийг сонгон авч нутагладаг байна. Мал нэг бүрийн тарга хүч хэр зэрэг авч байгааг өглөө оройд ажиглаж мал тайван биш байвал түргэн нүүж нутаг

сольдог. Хонь таргалах үед байнга усалж, үргээж цочоохгүй бэлчээрлүүлэх хугацааг аль болохоор уртачгаж ажилладаг байна. Хоньчин Дорж өвөл хаврын улиралд хонио услахын өмнө 1-2 цаг идээшлүүлж байгаад усалдаг. Малыг өлөн элгэн дээр нь услахад эцэж турах хээл хаяхдаа амархан байдаг байна. Төл бүрэн бойжуулж зүй бусын хорогдол гаргахгүйн тулд хонийг хээл нь томрох үеэс нэмэгдэл тэжээлд оруулдгаас хогь жилбэ сайтай төллөж төлийн хорогдол гардаггүй байна. Дорж малын тэжээлд зориулж задгай хатаасан өвс, таана, борог, шарилж, ээрэм, цахилдаг нөөцөлж авдаг. Мөн гүүний айраг исгэлэн цагаа адууны элэг цус зэрэг амьтаны гаралтай тэжээл бэлтгэж авдаг байна. Таанан зоодойг чанаж андлаад арвай багсармал овъёос зэрэг тэжээлтэй хольж малаа тэжээдэг. Ядарч муудсан малыг

гүүний айраг исгэлэн цагаагаар тэжээхэд тэнхрэлт нь илүү сайн болж онд сайн ордог байна. Амьтаны гаралтай тэжээл цус, өөх элэг гүүний айраг, исгэлэн цагаагаар тэжээсэн мал хавар ногооны үед хордолт болдоггүй сайн талтай ажээ. Хөрөв төлийг гол төлөв гүүний айраг цагаагаар тэжээж нялх төлийг гурлаар тэжээхэд төлийн хорогдол гардаггүй гэж Дорж ярьдаг юм. Мал нийллэгийн үед нялх ногоотой, сөл сайтай нутаг сонгож авдагаас малын хээл авалт сайн байдаг байна. Малд хээл авахуулахдаа байнга ашиглалт хийж ямар зүсмийн хонь хэдийд нийлүүлэгт оров гэдгийг нэг бүрчлэн бүртгэж түүнээсээ үндэслэж хонь хургалах хугацааг тодорхой тогтоодог байна. Мал төлөлтийн үед төллөх дөхсөн малыг ялгаж ойрын бэлчээрт явуулах нэмэгдэл тэжээл өгөх зэргээр хээлийг нь хамгаалдаг. Дорж төлийн байрны дулаан хүйтнийг тохируулах талаар онцгой анхаарч төлийг халуун байрнаас хүйтэн агаарт цочир гаргаж уушгины хатгалаг өвчин тусахаас сэргийлж өглөө эрт төлийн байранд надны агаар баг багаар оруулж дасгасны дараа төлөө гаргаж хөхүүлдэг байна. Төлийг эхээс гарсны дараа 20-30 минутанд багтаан эхийн уургаар амлуулж эхтэй нь хамт 3-5 хоног байлгадаг. Хурга эхээс гарснаас хойш 7 хоногт сүүллэж махалдаг. Энэ үеэс эхэлж багсармал тэжээл хивэг лууль таана зэргийг амьтаны гаралтай тэжээл хольж тавьж өгдөг. Намар шарлаж хатсан үед нь хадаж авсан зэрлэг цахилдаг төлийн сайн тэжээл болдог гэж хоньчин Дорж ярьдаг юм. Хонины саалийн үед хонио хотонд нь ирүүлэлгүй гэрийн ойролцоо хөдөө хурааж бэлчээрлэх хугацаанд нь саад болохгүйгээр богино хугацаанд саадагийн гадна саалийн хониныг шөнөн бэлчээрлүүлж идээшлүүлдэг байна. Хоньчин О.Дорж хонин сүргийг олон жил маллаж аваргын бариа алдахгүй явж байгаа туршлагатай малчин юм.

Д.Онхой

- 126.** Аварга хоньчид // Говийн мэдээ.- 1978 оны 2-р сарын 23.- №15.- 3-р нүүр.

Аварга хоньчид

Ханбогд сум

Ханбогд сумын Галбын хөгжил нэгдлийн Гавилууд бригад хоньчин аймгийн аварга С.Ваанчиг өвлийн болон төлийн бэлтгэлээ хавар бууцнаас гарахаасаа эхлээд хийдэг. Малд сайн тарга хүч авахуулах нь олон талын ач холбогдолтой байдаг. Жишээ нь: хонь хургаа голдоггүй цатгац сайтай хургаа сайн долоож үсийг нь эгшээдэг мэт олон онцлог талуудтай. Манайх өнгөрсөн жил алсын оторт эрт гарсны үр дүнд хонь бүр 66 кг-ын жинтэй отроос буусан одоо мал сайн байна. Малыг зутраахгүйн уруудуулж хол туухгүй байх, усаар цангаахгүй эрт бэлчээрлүүлж хуурай дулаан бууцанд хэвтүүлж байх явдал юм. Ингэснээр мал зутрахгүй мал хорогдолгүй бойждог юм нэж ярьж байна. Эднийх өвлийн болон төлийн бэлтгэлдээ зориулж өвс ногоо зоодой, ногоон тэжээл, төлийн нарийн өвс, хужир, хөх хоргол, хүрэлцээтэй бэлтгэдэг. Ваанчиг төлийг эхтэй нь хамт байгадаг 3 дулаан байртай. Аварга малчныд төлийн бэлтгэлийн үзүүлэх сургууль хийж төлчин эмэгтэйчүүд оролцон илгээлтийн эзэн МХЗЭ-ийн гишүүн П.Хүүхэндүү, Ж.Отгон, Жавхлант бригадын тэргүүний хоньчин Б.Долгорсүрэн нар ажлын арга туршлагаа ярьж сумын бүх төлчдийг уриалж амлалт үүрэг авлаа. Энэ бол төл бойжуулах ажлыг бүх нийтийн үйлс болгож байгаагийн нэгэн баримт билээ.

Д.Бямбаа, Б.Раднаа

- 127.** Манай зочин // Говийн мэдээ.- 1978 оны 3-р сарын 2.- №17.- 3-р нүүр.

Манай зочин

/Аваргын арга туршлагаас/

Сэврэй сум

Сэврэй сумын Социализмын зам нэгдлийн Сайн шанд бригадын ямаачин Намжилдорж сүүлийн жилүүдэд өсвөр мал хариуцан маллаж тогтвортой амжилт гаргаж



байна. 1973-оноос хойш борлон маллаж сүүлийн 3 жилд 2330 борлон хариуцан маллаж онд бүрэн оруулж 5360 кг ноолуурыг 100 хувь нэгдүгээрт тушаажээ. Энэ хүний ажлын амжилт туршлага нь борлонгийн арчилгаа маллагааг тохируулж авсан тарга хүчийг алдагдуулалгүй байлгаж огд бүрэн оруулдаг, ашиг шимийг бүрэн гүйцэд ашигладаг өвөрмөц

нэгэн арга юм. Малчин хүний эрхэмлэх зүйл бол малдаа тохирсон нутаг ус бэлчээрийг сонгож олох гэж үздэг. Өвөлжөөнийхөө бэлчээрийг нарийн хуваарьтай ашигладаг. Малаа өдөр бүр нэг бүрчлэн ажигланж муудаж байгаа малыг нэмэгдэл тэжээлд оруулж хяналтандаа авдаг байна. Муудаж байгаа борлонгийн үс нь бүрзийж гэдсээ татаж хавчийгаад хөдөлгөөн нь муудаж сэргэлэн биш, нус нь гоожих зэрэг шинжтэй болдог. Ийм байдалд орохоос нь өмнө тэжээх шаардлагатай борлонгоо ялгаж өдөрт 2 удаа тэжээдэг байна. Намжилдорж 200 борлонг исгэж тэжээсэн багсармалаар 30 минутанд тэжээж амждаг нь түүний шалмаг ажиллагааг харуулж байна. Тэжээлийг таана хөмүүлэн зоодой,задгай хатаасан таанаарт хандалсан халуун усаар зуурч 12-24 цаг дэвтээж өгөхөд мал маш дуртай иддэг шим тэжээл сайтай байдаг байна. Төл малыг намар эрт ялгаж тарга сайн авахуулахад анхаарч шар таана, цагаан шаваг багалуур бударганатай нутагт

маллах нь тохиромжтой. Өвөлжөөнд бууснаас хойш нэмэгдэл тэжээлд оруулах шаардлагатай тэжээх, гол нь бэлчээрийн тэжээлээр хангахад анхаарч ажилдагаас муудах нь бага тэжээх мал нь цөөн гардаг байна. Үүнээс гадна хотондоо усны замд, усан дээр хужир тавьж малаа тогтмол хужирлуулдаг нь зээргэний хордлогоос хамгаалах эрдэс бодисоор хангахад чухал нөхцөл болдог. Өглөө нар тусахын үед малаа хотноос гаргаж шээлгэдэг нь хот хөлдөхийг багасгах төдийгүй малын биеийн чилээг гаргах улмаар бэлчээрт явахад нь дасгал болдог байна. Өвлийн бэлтгэлд эднийх жилд өвс 4-10 тн, таана хөмүүлэн зоодойг 1000-2500 ширхэгийг бэлтгэн нөөцөлж ашигладаг юм. Ямаа самнах үед цаг агаар тогтворгүй байдгаас хашаа нөмөртэй газар байж малыг гэнэтийн хүйтрэлт, шуурганд нэрвэгдүүлэхээс сэргийлэн богино хугацаанд ноосолж дуусгадаг байна. Ямааг самнахдаа бүдүүн шүүрээр хялгасаны дайхийг нь сайн гаргаад дараа нь дунд зэргийн шүдтэй самаар зөөлөн эвтэйхэн самнаж хялгас багатай ноолуур авдаг байна. Эцэст нь нарийн шүүрээр шүүрдэж ноолуурийг бүрэн авч ашигладгаас ноолуур гоосны төлөвлөгөөгөө бүрэн биелүүлж ноолуураа 100 хувь нэгдүгээрт тушааж иржээ. Намжилдорж ямаачин Санжийн туршлагыг ажилдаа нэвтрүүлжээ. Ямааг таргалуулахдаа хаварт бут нүдэлсэн газраас эхлэн нялх ногоотой газраар товшин нүүдэллэж оторт эрт гарч малдаа тарга хүч гүйцэт авахуулдаг байна. Малаа жилд 2-3 удаа тогтмол угаалгадаг нь эрүүлжүүлээд зогсохгүй тарга хүч сайн авах, өт батгананд хоргоогдох нь бага, тайван идэшлэж, тохитой хэвтэж амардаг. Эднийх хот бууц бэлчээрийн ариун цэврийг сайжруулж бууцаа тогтмол кроли дүстээр ариутгаж байдгаас эрүүл сүрэгтний гэрчилгээг таван жил хадгалж байгаа юм. Ямаа бол даараг, дулаан байр, нөмөртэй бэлчээр, амтлага сэрмүүн ургамал, сайн хужир ус шаарддаг, хоол тэжээл, ус голомтгой дулаанд

амархан сэргэдэг, хад асганд харайж дүүлэмтгий онцлог чанрыг нь харгалзан тохиромжтой газар байлгах нь чухал байдаг. Хүйтний улиралд дулаан бууц хэвтэрт нь байлгаж өвөл хүйтэн бууц сэлгэхгүйг хичээдэг байна. Ямаачин Л.Намжилдорж ямаан сүргийн арчилгаа маллагааг тохируулан маллаж баялаг туршлага хуримтлуулж амжилт бүтээл нь арвижсаар БНМАУ-ын аварга малчин цол шагналаар шагнуулж VI таван жилийн төлөвлөгөөний туршлагаас шийдвэрлэх жил 1978-онд мал өсгөх, бүтээгдхүүн ашиглах төлөвлөгөөг бүтээгдхүүн ашиглах төлөвлөгөөг давуулан биелүүлж хариуцсан 687 борлонгоо онд бүрэн оруулахаар социалист уралдаанд үүрэг аваад МАХН-ын Төв Хорооны III бүгд хурлын үзэл санаагаар хариуцлага санаачлагаа улам өндөржүүлэн нэгдэлжих хөдөлгөөн ялсны 20 жилийн ой, нэгдэлчдийн 5 дугаар их хурлаа ажлын их амжилтаар угтахаар шамдан ажиллаж байна.

Л.Шоожуу

128. Ихэр олонтой // Говийн мэдээ.- 1978 оны 3-р сарын 2.- №17.- 3-р нүүр.

Ихэр олонтой

Булган сум

Булган сумын Туяа нэгдлийн хоньчин Д.Дагимаа нийгмийн төллөх 200-иад хонь ямаа хариуцан маллаж хорогдолгүй онд оруулан гарсан төлийг нь бүрэн бойжуулж байна. Эднийх ихэр төл олон байгийн дотор өнгөрсөн онд гурван ихэр хурга гаргасан бор нүдэн хонь энэ жил мөн гурван ихэр хурга гаргаад байна.

Л.Сугир



Ноён сумын «Гучин таван жил» нэгдлийн төлчдөөс өнгөрсөн ойд 30 гаруй төлчин 100 эхээс бойжуулах төлийн талаар МАХН-ын Төв Хорооны IX бүгд хурлын заалтыг биелүүлжээ.

ЗУРАГ ДЭЭР. (Зүүн гараас) 100 эхээс бойжуулах төлийн даалгаврыг давуулж биелүлдсэн ямаачин О.Энхээ, М.Жид, Н.Жанчив, Б.Янжинсүрэн, хоньчин Ш.Алтан цэцэг, ямаачин Г.Аварзэд нар.

Т.Цэдэвийн авсан гэрэл зураг.

129. Гүн худгийн хоньчин // Говийн мэдээ.- 1978 оны 3-р сарын 13.- №19.- 2-р нүүр.

Гүн худгийн хоньчин

Хүрмэн сум

Даланзадгад хотын 10 жилийн дунд сургуулийн 7-р ангийг 1974 онд төгсөгчдөөс 12 хүүхэд МХЗЭ-ийн илгээлтээр мал аж ахуйн үйлдвэрлэл дээр гарч малчин



болсны нэг нь Дуламын Энхтуяа билээ. Шалгалт өгч байх үед ээж нь өвчний улаас нас барьж өрх гөрийг толгойлох үүрэг 16- хан настай Энхтуяад оногдож амьдрал ах жйд нь байнга зөвлөж сургамжийн үгээ хэлж явдаг халамжит ээж нь үгүйлэгдэж ажлын эв дүй арга

ухаан дутагдаж байв. Гэвч Энхтуяа сэтгэлийн тэвчээр, олны дэмжлэгээр ээжийнхээ маллаж байсан 200 ямааг намрын сар гартал нутаг усыг нь тохируулан маллав. Энэ үед ээжийн дүү нь тэмээчин Сүхбаатар нутгийн малчин Сэнгэмижид Жагдал зэрэг хүмүүс хайр халамж тавьж Энхтуяагийн ажил амьдралд байнга тусалж дэмжиж

хөлийг дөрөөнд ,гарыг ганзганд хүргэжээ. Мал төллүүлэх арга туршлага дутмаг учир Энхтуяа сум бригадынхаа дарга нарт хүсэлт тавьж 1974-оны намар 500 гаруй төлөг борлон хүлээн авчээ. Малчин болсон эхний жилүүдэд цаг хүндэрч байгалийн бэрхшээл тохиолдсон боловч олны дэмжлэг хүлээсэн Энхтуяа уйггүй сэтгэл хөдөлмөрөөрөө мал өвөлжүүлэх бэлтгэлээ эртнээс бүрэн базааж зун намар нь отор нүүдэл сайн хийж малаа таргалуулах өвөл хавар нь хэвтэр бууцыг нь хуурай дулаан байлгах,тэжээл усаар тордох зэргээр нэг ч малын хорогдол гаргаагүй ажиллаж сайн малчин болохоо харуулжээ. Нутаг усныхандаа үнэлэгдэж ,ажилчин ээжийнхээ ажил амьдралыг залгамжлан яваа Энхтуяа 18 насандаа төрийн дээд шагнал Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнуулж ,1976-онд ЗХУ-д нэгдлийн зардлаар жуулчилжээ. Сүүлийн 4 жил нийгмийн 568-640 төлөг борлон хариуцан маллаж хорогдолгүй онд оруулан үйлдвэрлэлийн даалгавраа жил дараалан 100-гаас дээш хувь биелүүлж ирсэн амжилтаар энэ жил БНМАУ-ын *Аварга малчин залуу* цолоор шагнагдсан дуламын Энхтуяа: өнгөрсөн оны зун намар Хөтөлийн нуур, Даравгай,Хэвтээгээр отор хийж малдаа тарга хүч сайн авахуулсан. Одоо мал сүргийн хорогдолгүй сайхан хаваржиж байна. МХЗЭ-ийн XVII их хурал, БХЛКЗЭ-ийн 60 жилийн ой угтаж 1978-оны социалист уралдаанд одоогийн маллаж байгаа 495 төлөг борлонгоо онд 100 хувь оруулж ноосны үйлдвэрлэлийн даалгавараа төрөл бүр дээр нь давуулж ямааны ноолуураа 100 хувь нэгдүгээрт тушаах төлгийг 43 кг, борлонг 33 кг-д хүргэж таргалуулах өөрийн хүчээр өвс 3,5тн шимт тэжээл 1,2тн, 2,5тн бэлтгэж Булган сумын хоньчин БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Аюурзана гуайн мал тэжээдэг туршлагыг эзэмших зэрэг үүрэг аваад ажиллаж байна. Малыг услахын өмнө идээшлүүлж байгаад онгоцонд нь хужир хийж уславал мал тарга хүчээ алдахгүй юм аа. Нэг

настай малыг намар хүлээж аваад сөл дагуулж ус бэлчээрийг нь сайн тохируулж маллахад хоорондоо амархан ижилсэж, тарга хүч сайн авдаг. Хүйтэн сэрүүн унаад ирмэгц жижиг давжаа биетэй хүй таргаар тааруухныг нь нэмэгдэл тэжээлд оруулж тэжээлийг жигд хэмжээтэй тогтмол өгөөд, байнга усалж хэвтэр бууцыг нь хуурай дулаан байлгахад өвөл хаврын улиралд нэг их царай харуулаад байдаггүй гэж ярьж байна. Хүрмэн сумын Сүхбаатарын зам нэгдлийн хоньчин Д.Энхтуяа тэргүүний малчдын мал маллагааны арга туршлагыг эзэмшихийн төлөө байнга санаа тавьж ажилладгаас амжилт нь тогтворжиж алдар нэр нь түмэн олондоо цуурайтаж байна.

/Манай сурвалжлагч/

130. Манай зочин // Говийн мэдээ.- 1978 оны 3-р сарын 13.- №19.- 3-р нүүр.

Манай зочин

/Хөдөлмөрийн баатар зөвлөж байна./

Булган сум

Булган сумын Туяа нэгдлийн хоньчин БНМАУ-ын хөдөл мөрийн баатар Д.Аюурзаны 20 гаруй жил нийгмийн хонин сүрэг хариуцан малласан улс даяар нэрд гарсан туршлагатай хоньчин юмаа. Д.Аюурзана баатрын мал маллагааны онцлог туршлага нь жилийн дөрвөн улиралд малын хариулга маллагааг зөв тохируулж бэлчээрийг нарийн хуваарьтай ашиглан, хониндоо жигд сайн тарга хүч авахуулдаг явдал юм. Тарган мал тал бүрийн



ашигтай байдаг болохоор бүх ажил аяндаа бүтэмжтэй болж амьдрал нь тогтворжижээ. Эднийх урв жилүүдэд дан төллөх хонь маллаж арвин туршлага хуримтлуулж залуу малчиддаа үлгэр жишээ үзүүлж явсан. Харин сүүлийн үед нэг настай малын арчилгаа маллагаа жигд сайнгүй байгаагаас малын хорогдолын олонхийг нэг настай мал эзэлж байгаад Аюурзана түүний нөхөр Жимбийдоо нар дүгнэлт хийж энэ жил 1000-аад нэг настай мал хариуцан авч тарга хүч сайтай, хорогдолгүй онд оруулж байна. Энэ тухай Аюурзана гуай: -нэг настай малын хэвтэр бууцыг онцгой анхаарах нь чухал. Манайх шинэ барьсан саравч хороотой тохилог өвөлжөөтэй. Гэтэл хичнээн сайн барьсан хороо ч чулуунуудын завсараар салхи орж малыг бөөрнөөс нь жиндүүлж цан хүүрэг татуулж дааруулдаг. Тийм учраас завсары нь сайн шавж хэрзэнгөөр доторлосон. Шаардлагатай малд өгөх өвс хужраа бүгдийг өвөлжөөндөө татсан. Одоо хавар болж өвөл уртсаж байна. Иймд өдөр бүр хонио услах нь чухал. Тэгэхгүй бол цасны хайлмаг шар ус ууж эцэж турж эмгэг өвчин олж болзошгүй юм. Хаврын хавсарга салхитай өдөр нөмөр дулаан газар бэлчээж ядарсан доройтсон зарим малд борог өвсөнд их цацгалгүй өдөр бүр тогтмол хэмжээтэй өвс тэжээл өгдөг. Энэ нь малыг муудахаас хамгаалдаг. Гэхдээ амархан боловсорч шингэх хүчит тэжээл, шимт ногоон өвс өгч цөөн хоногт тэнхэрүүлэх нь чухал. Мөн зул сар ашиглаж байсан бэлчээрийг хавар тэнгэр дулаан сайхан өдөрт дахин ашиглах нь сайн байдаг. Тэнгэр бүрхэг салхи шороо шуургатай өдөр хонийг шаваг, тэсгэ, хотир сондуул харгана, дэрс суль бүйлс зэрэг бутлаг ургамалтай газар хариулвал тохиромжтой. Хаврын сүүл ч болоод ирэхээр урьд жилийн угтамж чийгтэй газрыг урьдчилан мэдэж тэр газарт 5 дугаар сарын нүүн очиж малаа ногоонд цатгах нь чухал. Хавар өвөлжөөнөөсөө нүүхдээ хороо бууцны засвараа хийгээд орчноо цэвэрлэж, түлшээ бэлтгэж

Өвлийг өнтэй давсан ямаачин

Говийн наран ээж, намхан хяр толгодын энгээр ямаан



сүрэг соргог бэл чээрт тархан идээшлэнэ. Сүргийн эзнийг Ханбогд сумын Жавхлант бригадын Тэргүүний ямаачин Ш.Батсүх гэнэ. Ямаачин Батсүхтэй уулзан ярилцав: Энэ жил өнтэй сайхан хаваржиж байна. Манайх 13 жил ямаан сүрэг хариуцан

маллаж жил бүр 200-500 ямаа төллүүлдэг. Өнөө жил сууриараа 553 ямаа төллүүлнэ. Манай суурь сүүлийн гурван жилд 997 ямаанаас 1027 ишиг бойжуулж, 100 эхээс дунджаар 103 ишиг бойжуулж, ноос сүү өвс тэжээлийн зэрэг даалгаврыг 100, 1-115 хувь биелүүлж ирсэн юм. Бид өвлийнхөө бэлтгэлийг сайн хангасан гурван хос хороотой өвс тэжээл хүрэлцээтэй зун намрын отрыг сайн хийснээс мал тарга хүч сайн авч онд бүрэн орж байна. Тарга тэвээрэг сайтай малаас ашиг шиг арвин авах боломжтой. Манай суурь ямаагаа эрт самнаж ноолуураа 100 хувь нэгдүгээр зэрэгт тушаадаг. Би тэргүүний ямаачдын туршлагаар ямааны хүзүүний ноолуурыг самнахад зориулж гантай төмөр утсаар жижиг сам хийж ашигласан нь их дүнтэй болсон. Мөн өвсийг гамтай ашиглахад зориулан төмөр утсаар торон сав сүлжин дотор нь өвс хийж малаан тэжээдэг. Бас төлийн хашааг өвсний боодол төмөр утсаар ашиглан хөнгөн хашаа хийж ашигласнаар мод төмөр зэрэг материал хэмнэдэг болсон. Манайх өвлийн бэлтгэл хангах малын ашиг шим ашиглах бойжуулах ажилын амжилтаар таван удаа сумын аварга боллоо гэж яриу. Ш. Батсүх 6-р таван

Говийн мэдээ сонин

жилд ажилдаан тооцоотой үүрэг авч эхний хоёр жилийн үүргийг амжилттай биелүүлжээ.

А. Сумъяа

133. Хошой аварга малчин // Говийн мэдээ.- 1978 оны 3-р сарын 20.- №21.- 1-р нүүр.

Хошой аварга малчин

/356,1 мянган төл бойжуулахын төлөө/

Баяндалай сум

Сүүлийн 2 жил дараалан 100 эхээс 113-122 төл бойжуулсан амжилтаараа сумын 2 удаагийн аварга болсон Баяндалай сумын



Гурвансайхан нэгдлийн Наран бригадын ямаачин Д.Гончигийн суурь өнөө жил 380 гаруй ямаа төллүүлж байна. Төл бойжуулах талаар өнгөрсөн жилүүдийн амжилтаа бууруулахгүйн

тулд төл хүлээж авах бэлтгэлээ бүрэн хангаж сүүнд 20 кг шар будаа агшааж 70л сүү, айраг бэлтгэсний гадна өвс 7тныг түүж 6000 ширхэг зоодой хийж өөрийн хүчээр шинэ хуучин 2 худаг гаргажээ. Эднийх ямааныхаа хээл хүндрэх үед бэлчээрээ хувиарлан малаа төллөсөн, төллөөгүйгээр нь хариулж услахын өмнө идээшлүүлж онгоцонд нь урьдчилан найруулж бэлдсэн гурил хайлгасан жамц давс хийж усалдгаас ямаа хээл хаядаггүй байна. Тэгэхдээ гурилтай усаар 7 хоногт 2 удаа усалдаг ажээ. Эднийх VI таван жилд 1120 ишиг бойжуулах, 18467 л сүү сааж нэгдэлдээ нийлүүлэх зэрэг тодорхой тооцоотой үүрэг аваад ажиллаж байна.

Ч.Цэндоо

134. Хоньчин аварга // Говийн мэдээ.- 1978 оны 5-р сарын 29.- №40.- 1-р нүүр.

Хоньчин аварга

Сэврэй сум

Сэврэй сумын социализмын зам нэгдлийн Хоолт бригадын хоньчин БНМАУ-ын аварга малчин Х.Шархүү нийгмийн хонин сүрэг хариуцан малласан 20 гаруй жилийн хугацаанд ажлын арвин туршлага хуримтлуулжээ. Тэрээр мал сүрэгтээ өдөр тутам ажиглалт хийж гэдэс хээл муутай, нод нь нуухтсан зэрэг ядарч доройтсон малыг ялган нэмэгдэл тэжээлд оруулж ойрын бэлчээрт



хариулан арчилгаа маллагаа тордолтыг цаг алдалгүй хийдэг юм. Хоньчин Шархүү: Мал нэг бүрээ нүдэлж, тохирсон арчилгаа маллагаа хийхгүй бол малчин хүн улс нийгмийнхээ өмнө хүлээсэн хүндтэй үүргээ бүрэн биелүүлж чадахгүйд хүрнэ. Жишээ нь: арчилгаа маллагааны муугаас хариуцсан сүргээсээ нэг охин төл хорогдуулах юм бол тэр их гарз юм. Нэг эм мал 10 жилд хамгийн багаар бодоход 50 толгой болтол өсч үрждэг юм нэж ярьж байна. Шархүүгийнх хот бууцаа өвлийн ямарч үед хөлдөөдөггүй ямарч үед хуурай дулаан цэвэр цэмцгэр байлгадаг үлгэр жишээч туршлагатай айл. Саравч хашааныхаа гадна талд хөрзөнгөөр 3-4 хос хороо барьж малаа ээлжлэн хотлуулах, хээлтэй, сувай мал, төлөг гэж хэсэгчлэн сайн муугаар нь ялган хотлуулж сургадаг. Малын бэлчээрийг өдөр тутмын нарийн хуваарьтай ашиглан малаа хариулахдаа түрүүчийг нь тогтоож хооллож байгаа байдалд нь ажиглалт хийж хариулдаг манай тэргүүний малчны нэг юм.

С.Хумба

135. Аваргын туршлагаар // Говийн мэдээ.- 1978 оны 5-р сарын 29.- №40.- 2-р нүүр.

Аваргын туршлагаар

Манлай сум

МХЗЭ-ийн XVII их хурлын төлөөлөгч Манлай сумын Хоёр өлзийт нэгдлийн ямаачин Л.Мөнхбаяр ажилч хичээнгүй чанараараа нутаг усандаа алдаршиж яваа малчин юм. Тэр мал сүргээ сайн таргалууж ашиг шимийг нь бүрэн ашиглахад гол анхаардаг. Мөнхбаяр юуны урьд аав ээжтэйгээ ярилцаж ямаагаа хэрхэн самнаж дуусгах ноолуурыг чанартай бэлтгэх талаар тодорхой төлөвлөгөө гаргаж ажилладаг юм. Ямааг хэднээс хэдний дотор хэд хонгийн хугацаанд өдөр хэдээс доошгүй ямаа самнах эхний өдөрт цөөн өдөр ахих тусам ямааг хэд хэдээр ахиулж самнахаар төлөвлөдөг байна. Гэхдээ цаг агаарын байдал тавгүйтэж мал услах боломжгүй үе, мал услах өдөрт хэдэн ямаа самнах тэжээх шаардлагатай малыг өдөрт ямар ямар хугацаанд тэжээж байх, цагийн хуваарийг өдөр өдөрт нь яаж баримтлах өдөр малаа хааш нь бэлчээж ямар унаагаар хэн хариулах, өөрсдийн хооллох ундаалах амрах хүртэл нарийн төлөвлөж өдөрт төлөвлөсөн ажлаа заавал хугацаанд нь биелүүлж болсон нь цаашаа дадаж ажил жигдэрдэг. Ингэснээр бага ч гэсэн ажиллах цагийн нөөц нэмэгддэг байна. Мөн цагаан, шарга, цэнхэр, улаан, бор, цоохор зэрэг цайвар зүсмийн буюу тоймог ямааг эхний ээлжинд самнадаг. Учир нь ийм зүсмийн ямаа ноолуураа амархан гээж хаядаг онцлогтой. Ер нь хавар эрт самнасан ямаа цагийн байдалд дасаж аажимдаа тэсвэр хатуужилтай болж гэнэтийн цас бороо болон ширүүн шуурга салхинд, халуун хүйтэнд уруудаж зутрах нь бага байдаг. Гэхдээ самнасан ямааны арчилгааг сайн байлгах хэрэгтэй. Ямаачин Мөнхбаяр ийнхүү ажиллахдаа БНМАУ-ын хошой аварга малчин Ц.Бандийн арга туршлагаас байнга сурч ажилладаг байна. Банди аваргын ямааг малтаж самнах хэлбэрээр самнадаг ажиллагааг яг эзэмшиж өдөрт олон ямааг

самнахдаа биш гагцхүү уйггүй аажуу махчлан сайн самнаснаар ноолуурыг бүрэн самнаж авдаг юм. Зарим нэг үнэхээр ноолуур нь гарахгүй байгаа ямааг сайн чанрын тэжээлээр тэжээж байгаад хэд хонгийн дараа эргэж самнахад ноолуур нь бүрэн гардаг байна. Үүнээс үзэхэд эцэж доройтсон малыг сайн чанарын тэжээлээр тэжээхэд хичнээн үр дүнд хүрдэг нь тодорхой юм. Одоо байгаа нөөц бололцоогоо дайчлан ажиллаж зарим ямаагаа дахин самнаж ноолуур бэлтгэх талаар социалист уралдаанд авсан үүргээ майн баярын өмнө давуулан биелүүлсэн байна. Л.Мөнхбаяр аварга багшийнхаа ажлын нэг гол арга болсон, ямаагаа самнаж дуусангуут бэлчээрийн соргогыг дагуулан малаа отроор таргалуулж эхэлдэг, шахаж бордож улсын бэлтгэлд сайн чанарын цөөн мал бэлтгэдэг ажиллагааг ажилдаа нэвтрүүлж оторт гарах бэлтгэл ажлаа эрт хангадаг болсон нь энэ залуу малчны эрхэмлэдэг зүйл болжээ.

Ц.Сумьяа

- 136.** Отроор мэргэжсэн хоньчин // Говийн мэдээ.- 1978 оны 7-р сарын 10.- №51.- 3-р нүүр.

Отроор мэргэжсэн хоньчин

/Сурвалжлага/

Цогт-Овоо сум

Говь гурван сайхан зочид буудлын нэг жижигхэн тасалгаанд нутаг нутгаас ирсэн бололтой хэдэн хүн байна. Хүмүүсийн дунд хөдөлмөрийн тухай шударга, ариун цагаан хөдөлмөрийн тухай яриа ид өрнөж байна. Тэний нэг нь ам өрсөн : манай аймагт улс аймагтаа нэр цуутай ажилч хүн олширчээ. Аймгийн намын бага хуралд төлөөлөгчөөр ирээд байгаа энэ махлагдуу эрийг Гэлэгпэл гэдэг юм. Цогт-овоо сумын Жаргалант нэгдлийн хоньчин хүндээ. Түүрүүхэн үед аймагтаа нэртэй бөхийн нэг байсан юм. Харин түүний дүү Дэмүүл улсын арслан

болоод бас ч хэдэн жил боллоо. Эднийхэн бөхийн удамтай улс юм даа. Гэлэгпэл гуай ч одоо барилдахаа болиод хоньчноор нэр нь мандаад байгаа хүндээ. Тэдний хот хороо, тал аж ахуйн хөдөлмөр зохион байгуулалт, мал оторлуулах ажилд гарч байгааг харахад ёстой ажилч хүн ийм л байдаг байх гэхээс өөр яах вэ. Адаглаад л жил болгон өвөлждөг Хүрэн толгойн бууцан дээрээ бууцаад байхад нь очиход нэг л жижигхэн сууринд хүрээд ирчихвий гэмээр болдог юм. Хот хороогоо янзалсныг нь харахад л өөр шүү дээ. Өвөлжөөндөө 4 пүнз, 5 хороотой л айлдаа. Ямартаа алс замын тээвэрчин Цогт-овоогийн олон хороотын дээр уулзъя гэж газрын болзоо ч тавьдаг гэж тэр хоньчны тухай хүүрнээн болж байна гэв. Үнэхээр ч Цогт-овоо сумын Жаргалант нэгдлийн Бор тээг бригадын хоньчин Г.Гэлэгпэл амжилт нь ахиж яваа тэргүүний хоньчны нэг юм. Тэр ажилд ажилт олохын уг сурвалж нь отор гэж үздэг. Отор бол нэг ёсны тарга ашиг шимийн эрэл юм. Эрлийн үзүүрт олз гэдэг. Гэлэгпэл энэ олзыг олохын тулд эрлийг эртээс эхэлдэг малчин юм. Эднийх жил бүрийн 5 дугаар сараас өвлийн дунд сар хүртэл гэр майханаар отор хийж малдаа дээд зэргийн тарга хүч авахуулдаг уламжлалтай юм. Гэхдээ отор сайн хийснийг олон нүүснээр биш бэлчээр тохируулснаар хэмжих ёстой. Хонийг зуны улиралд өглөө орой шөнийн сэрүүнийг ашиглан олон төрлийн нарийн өвс ургамалтай нутагт бэлчээрлүүлж өдрийн цагаар усалж амраахыг гол болгодог байна. Отрын сүүлийн үе буюу 9,10,11 дүгээр сард гашуун ургамал говь цагаалж хослосон газрыг сонгож нутаглахад хонины тарга чамбайрч ирнэ. Энэ үе хонь сайн таргалсны шинж нь гэвэл хонины хөдөлгөөн удаан тайван болж ноос нь өтгөрч үс нь шаргалтаж эхэлдэг байна. Ийнхүү хоньчин Гэлэгпэлийг мал таргалуулах отроор мэргэжиж яваа малчин гэж болно. Өнгөрсөн жил эдний эм хонь дунджаар 63,6 кг татаж байсан нь отор хийсний олз

байжээ. Эднийх сүүлийн таван жилд 2000 гаруй хурга, 3,5тнн ноос, арвин сүү бэлтгэж нэгдэл нийгэмдээ өгсөн нь мөн л отрын олз гэлтэй. Эмч мэргэжилтний туслалцаатайгаар малдаа эрүүл мэндийн үзлэг эрүүлжүүлэлтийг цаг хугацаанд нь хийдэгээс мал нь бүрэн сайн тарга хүч цагийн ямарч нөхцөлд царай харуулах мал гардаггүй юм. Ирэх өвлийн бэлтгэл отор хоёрыг зэрэгцүүлэн хийдэг нв цаг хожих таатай арга болжээ. Зусланд гармагц бууцныхаа хэрзэнг ижил хэмжээгээр хүрдэн гишгэж хатааж ариутгаад пүнз хороо барьж ашигладаг байна. Өвс ногоо түүх малын тэжээл бэлтгэх ажлаа отрын хугацаанд хийж заншжээ. Өнгөрсөн онд өвс 6 тнн хайлаасны навч ,төрөл бүрийн ургамлын үр жимс 1000кг, сүү айраг 260л, сүүнд агшаасан будаа 170 кг-ыг бэлтгэж авсан нь өвөл хаврыг хохиролгүй давах төлийг бүрэн бойжуулах үндсэн нөхцөл болж өгсөн байна. Г.Гэлэгпэл мал төлөлтийн үед хонио төллөсөн төллөөгүйгээр нь зусаг хонь, ажиллах хүчээ хоньчин төлчин гэрийн ажилтай гэх зэрэг хэдэн хэсэг болгоод зусаг хонинд гол анхаарал төвлөрүүлдэг хүн нь юм. Зусаг хонийг хөдөө хургалахаас болгоомжилж заавал гадаагаа төллүүлдэг. Энэ бол эх нь хургаа голдоггүй хүнд дасамтгай болдог сайн талтай гэнэ. Г.Гэлэгпэл тэргүүний хоньчин төдийгүй нутаг усандаа олон давхар ажил хариуцан гүйцэтгэж манлайлалаа өндөрт өргөж яваа коммунист юм. Түүнийг нутгийнх нь аваргах, ахлагчийнх, ухуулагч, депутатых гэлцэнэ. Малч маллагаа махрангуй зүтгэл бол малчин хүнд хамгийн чухал гэж хорин жил хонь малласан Г.Гэлэгпэлийн энгэрт төрийн дээд шагнал *Алтан гадас* одон, 6 дугаар таван жилийн гавьшгайчийн тэмдэг гялалзан байна. 1977-онд түүнд аймгийн хошой аварга малчин цол хүртээсэн нь хонины зүтгэл бүтээлд нөр их хүч нэмжээ.

Т.Цэдэв

- 137.** Ямаачдын зөвлөлгөөнд оролцогчдод баяр хүргэе // Говийн мэдээ.- 1978 оны 9-р сарын 04.- № 66.- 2-3-р нүүр.

Ямаачдын зөвлөлгөөнд оролцогчдод баяр хүргэе
/Аварга болгон өвөрмөц туршлагатай/

Манлай сум

Манлай сумын Хоёр өлзийт нэгдлийн Далай бригадын ямаачин БНМАУ-ын хошой аварга малчин Ц.Банди нийгмийн нэг настай болон эр сувай ямаа хариуцан маллахдаа ноолурын үйлдвэрийн даалгаврыг үлэмж хэмжээгээр давуулж иржээ. Ц.Банди ямааны ноолуурыг хаягдалгүй бүрэн авдаг өөрийн арга туршлагатай болж шүдлэн ямаа бүрээс 260-357г ноолуур ашигласан байна. Ноолуур арвин авахын тулд ямааг самнах ажлыг 3 үе шаттай явуулдаг.

Нэгдүгээр үе:- гуравдугаар сарын 10-наас 30-ны хооронд бүх ямааны гэдэс хонго булчингийн ноолуурыг самнадаг.

Хоёрдугаар үе:- дөрөвдүгээр сарын 1 нээс 25 дотор биений ноолуурыг самнана.

Гуравдугаар үе:- дөрөвдүгээр сарын 25 наас хойш бүх ямаанд ноолуурын үлдэгдэл байгаа эсэхийг шалгаж самнадаг. Энэ үе шатыг баримтлан ямаагаа хугацаанд нь самнаж дуусгахын тулд нэг өдөр самнаж дуусгах ямааны тоог тогтоож суурийн доторхи хөдөлмөрийн чадвартай хүмүүс хуваарийн дагуу ажилладаг.Тодорхой үе шаттай арга хэрэглэснээр эрт хөөрдөг гэдэсний ноолуурыг бүрэн авч, нуруу, их биед ноолуур үлдээж хавар эртний хавсарга хүйтэнд ямааг даарч турахаас хамгаалдаг. Мөн энэ дараалалаа баримтлан самнахад ноолуурын хялгас бага байдаг байна. Ингэж ажилсанаар жил бүр ноолуурыг 95-100 хувь нэгдүгээр зэрэгт тушааж заншжээ. Арвин их ноолуур авах

эх үүсвэр нь ямаанд зун намар тарга хүч сайн авахуулах явдал гэж үзэж энэ талаар бусад тэргүүний ямаачдыг нэг адил ажилдаг юм.

138. Ямаачдын зөвлөлгөөнд оролцогчдод баяр хүргэе // Говийн мэдээ.- 1978 оны 9-р сарын 4.- №66.- 2-3-р нүүр.

Ямаачдын зөвлөлгөөнд оролцогчдод баяр хүргэе

/Мал нэг бүрийг ашиглаж чадвал/

Сэврэй сум

Сэврэй сумын Социализмын зам нэгдлийн Сайн шанд бригадын ямаачин БНМАУ-ын аварга малчин Л.Намжилдорж жил бүр 700-800 борлон маллаж онд бүрэн оруулж ирсэн тугшлагатай малчин юм. Нэг настай малыг хорогдолгүй онд оруулахад мал нэг бүрээс хараа салгалгүй ажиглаж байх хэрэгтэй гэж Намжилдорж ярьдаг. Өсвөр малыг хүлээн авсан өдрөөс эхлэн ижилсүүлэх бэлчээр хотонд нь тогтвортой байлгаж сургах, хорт ургамлыг ялгаж чаддаг болгох өлчиржүүлэх зэрэг ажлыг хийдэг. Үүний тулд намар отор хийх нутгаа урьдчилан олон талаар судладаг. Өвөлжөөнд эрт буухыг цээрлэдэг. Энэ нь борлонг өлчиржүүлж байгаа хэрэг. Өвөлжөөнд бумагц малдаанэг бүрчлэн үзлэг хийж тохирсон арчилгаа тэжээлэгийн горим баримталдаг. Өвөл хаврын бэлчээрийг нарийн хуваарьтай ашигладгаас бэлчээрийн өвс байнга элбэг байдаг. Нэг настай малын бэлчээрт байх хугацаа аль болох уртасгахад анхаарахын зэрэгцээ өвөлд бүлээн усаар усалж хэвтэрийг нь хуурай дулаан байлгаж тогтмол хужирлуулдаг. Малыг тарга хүчээ алдаагүй үед нэмэгдэл тэжээлд оруулж ганц өдөрт тасалдуулахгүй өгдөг байна.

139. Ямаачдын зөвлөлгөөнд оролцогчдод баяр хүргэе // Говийн мэдээ.- 1978 оны 9-р сарын 4.- №66.- 2-3-р нүүр.

Ямаачдын зөвлөлгөөнд оролцогчдод баяр хүргэе

/Улиралд тохируулж маллах/

Булган сум

Булган сумын үржил фермийн ямаачин БНМАУ-ын аварга малчин Г.Базарсүрэн 22 жил ямаа маллаж эрлийз нэг ямаанаас дунджаар 619 гр ноолуур ашиглан 100 хувь нэгдүгээр зэрэгт тушаажээ. Хавар угтамж чийгтэй ногоо эрт гардаг уулын энгэр бэл, нөмөр жалга судаатай агь, шаваг, бут, модлг ургамалтай газарт ямааг хариулах нь тохиромжтой. Бороо ус муутай зуны улиралд уул хадтай сэрүүн газар маллаж модлог ургамал идүүлэх нь ашигтай. Намар нам дор уулын ар энгэрт агь шаваг, тэсэг бор элгэнэ, таана хөмүүл зэрэг орой ганддаг чийгтэйд хэнзэлдэг бэлчээрийг сонговол малын тарга хүч гүйцэд, ноос ноолуур нь арвин болдог байна. Базарсүрэнгийн суурийн эм ямаа намар дунджаар 40,5-45,5кг эхээс ялгах үед ишиг 19,5-23,5кг жинтэй байдаг. Өвлийн улиралд өвөлжөөний бэлчээрийг нөөцлөн 11,12 дугаар сард өвөлжөөнд буудаг. Арвин их ноолуур авахын тулд өвөл хашиж шахцалдуулахгүй байх төрөл бүрийн шимэгчдээс сэргийлж угаалга ариутгалд байнга оруулж байх хэрэгтэй. Ямааг 4-5 дугаар сард самнаж дуусгадаг. Өдөрт 10-12 ямаа самнахаар тооцож ажилладаг. Гурван төрлийн самаар самнахдаа хамгийн жижиг шигүү шүдтэй самаар ямааны чихний уг, дагз шанаа, нарийн шилбэ, гэдэс, омлуур, цааны ноосыг самнадаг. Нөгөө хоёр төрлийн самаар биеийг самнахад хэрэглэдэг. Түүнээс гадга ямаа нэг бүрийн хяналтын самналтын бүртгэлийг жил бүр хийж, ямааны анги чанар, дугаар, нас ноолуурын гарцыг хөтөлдөг. Ийм хөтөлгөө Базарсүрэнгийн 15 жилээр бий.

140. Ямаачдын зөвлөлгөөнд оролцогчдод баяр хүргэе // Говийн мэдээ.- 1978 оны 9-р сарын 4.- №66.- 2-3-р нүүр.

Ямаачдын зөвлөлгөөнд оролцогчдод баяр хүргэе

/Отор бүхнийг шийднэ/

Цогт-Цэций сум

Цогтцэций сумын Их шанхай нэгдлийн Сийрт бригадын ямаачин БНМАУ-ын О.Гимбэл ямаа малласан хугацаандаа ишиг бойжуулах, ноос сүү ашиглах талаар арвин туршлага хуримтлуулжээ. О.Гимбэл ишиг бүрэн бойжуулахын тулд бэлтгэлийг сайн хийхийн зэрэгцээ зун намарт тарга хүч бүрэн авахуулахын тулд отрыг чанар сайтай хийдэг. Ямааг оторлуулахдаа төрөл бүрийн цэцэг навч элбэгтэй хяр газрын бэлчээрийг сонгодог. Талын таана хавар эрт малыг дотроос нь хайрдаг. Намар орой бол малд өөхөн тарга тогтоох нь ашигтай, хяр газрын ногоо малд махан тарга суулгахдаа сайн байдаг. Отрын үед худгийн болон булаг задгайн тунгалаг усаар өдөрт 1-2 удаа усалж хээлтүүлэгийн үеэс сөл дагуулан хариулах нь ашигтай. Өвөлжөөний бэлчээрийг хуваарьтай ашиглан салхин дээд талынхаа бэлчээрийг нөөцлөн, бусад бэлчээрээ гаднаас нь дотогшлуулан ашиглаж орой хонио хотлуулахдаа шууд хотонд нь хураахаар тааруулж авчирах хэрэгтэй. Эс тэгвэл ойрын бэлчээрийг идэж муудуулдаг муу талтай. Гимбэлийнх өвөлжөө хаваржааны хоёр бууцтай Эндээ суурийн хүчээр хөрзөнгөөр хоёр хороо барьсан. Эднийх төлийн бэлтгэлд зориулж хэдэн тасалгаа бүхий байр бэлтгэж түүндээ эх, төлийг 5-7 хоног байлгасны дараа нхийг ойрын бэлчээрт хариулж төлийг өдөрт 2-3 удаа хөхүүлдэг. Ишгийг амлуулахын өмнө хоолны халбагаар шимийн архи өгвөл уураг зангирах, ходоод гэдэсний элдэв өвчнөөс сэргийлдэг. Ишгээ тоглуулахад зориулж хотныхоо нэг хэсэгт шар бууцыг хамж хөрзөн талбай засдаг. Ишгэнд 10-14 хоногтойд нь өвс тавьж өгч 20 хоногтойгоос ойрын бэлчээрт хариулдаг. Цатгац муутай малын төлийг гурил самарсан юм уу малын сүү болон сүү орлох тэжээлээр сүлсэн загсгалын хандаар тэжээхэд төл сэнсэрдэггүй.

Гурил багсармал тэжээлийг шороо чулуугүй, хужир мөсөн шүүдэй хольж загсгалын юм уу таанан зодойн хандаар зуурч долооц бэлтгэн бэлтгэн төлийн байранд энд тэндгүй зүүхэд төл дуртай иддэг. Ингэж эрдэс тэжээлээр сайн хангадаг болохоор эдний төл элдэвийн үс ноос идэх зэргээм бөөнтөх явдал гардаггүйн зэрэгцээ цаашид үс ноос нь сайн ургадаг ажээ. Гимбэл өвлийн бэлтгэлийг хавар бууцнаас гарахаас эхлэн хийдэг байна.

141. Ямаачдын зөвлөлгөөнд оролцогчдод баяр хүргэе // Говийн мэдээ.- 1978 оны 9-р сарын 4.- №66.- 2-3-р нүүр.

Ямаачдын зөвлөлгөөнд оролцогчдод баяр хүргэе
/Говь гурван сайхан ямаа/

Булган сум

Говь гурван сайхан үүлдэрийн ямааны гол ашиг шим нь ноолуур юм. Улсын хэмжээгээр ноолуурын чиглэлийн цэвэр ба эрлийз ямаа 135 мянга орчим болж, говийн бүсийн 9 аймаг хөдөө аж ахуйн 70 гаруй нэгдэлд үржүүлж байна. Одоо манай аймагт улсын бүх ноолуурын чиглэлийн ямааны 39,5 хувь байгаа юм. Говь гурван сайхан ба түүний эрлийз ямааг аймгийн бүх нэгдлүүдэд үржүүлж байна. Говь гурван сайхан ямаа нутгийн монгол ямааны адил байгаль орчныхоо цаг уур, бэлчээрийн маллагааны нөхцөлд сайн зохицсон тэсвэр хатуужил сайтай бусад төрлийн мал бараг ашиглаж чадахгүй бэлчээрийг сайн ашигладаг онцлогтой. Энэ үүлдэрийн ямаа галбир бие цогцос физиологийн хувьд нутгийн монгол ямаанаас онцын ялгаагүй, зөвхөн зарим төрлийн ашиг шимээр илүү юм. Ноолуурын гарц нутгийн монгол ямаанаас 73,9 хувь илүү, бусад ашиг шимээр ойролцоо. Говь гурван сайхан ямаа өвөл хаврын хатуу ширүүн улирлуудад намрын амьдын жингийнхээ 25-35 хувийг алдаж алдсан тарга хүч амьдын жингээ зун

намрын отрын үед 25-37 хувиар нэмэгдүүлж чадна. Энэ үүлдэрийн ямааны амьдын жин дунджаар ухна 55 кг, эм ямаа 40кг, махны нядалгааны гарц 45,5-47,3 хувь, мах нь амт чанар сайтай. Говь гурван сайхан ямааны шилмэл анги 0,7-0,8 дээд тал нь 1,4 кг эм ямаа шилмэл анги 0,6-0,7 кг дээд тал нь 1.0 кг ноолуур өгч байна. Эн нь энэ нь нутгийн монгол ямааны ноолурын гарцаас хоёр дахин илүү юм. Энэ үүлдэрийн ямаа сүүлэг чанартай. Саалийн хугацаанд дунджаар 70л сүү ашигладаг. Ямааны сүү нь 3,2-9,2 хувийн тослогтой, 7 дугаар сараас сүү нь өтгөрнө. Харин бэр дэлэн багатай, сүүг хуримтлуулж үлдээдэггүй учир саахдаа ишгэнд заавал учиг үлдээж байх хэрэгтэй юм аа. 100 эхээс 100-115 ишгийг өгдөг ихэрлэлт сайтай. Говь гурван сайхан ямаа өайгаль орчиндоо дасамтгай бэлчээрийг сайн ашигладаг, эрс тэс уур амьсгалд тэсвэртэй нутгийн ямааны хэв шинжийг хадгалж чадсан боловч дээд зэргийн арчилгаа маллагаа шаардана. Энэ нь түүний өсөлт хөгжилт бүхий л сайн чанар нь хариуцаж байгаа малчид мэргэжилтний ажиллагаанаас шалтгаална гэсэн үг. Булган сумын үржлийн фермийн ямаачин З.Хасаа, Б.Цагаан, Хавцгайт бригадын ямаачин Г.Цэвэгмэд, Сэврэй сумын ямаачин А.Санж, Гурвантэс сумын ямаачин Ш.Гаадан нарын зэрэг 100 эхээс 105-115 цэвэр ба эрлийз ишиг бойжуулсан ямаачид олон бий. Гэтэл Булган сумын үржлийн фермийн ямаачин Р.Гэндэндаш, Баяндалай сумын Баян бригадын ямаачин Долгор, Сэврэй сумын Сайншанд бригадын ямаачин Шатарбат зэрэг зарим малчид 100 эхээс 44-55 ишиг бойжуулсан нь малчдын хариуцлага, ажиллагаа жигд бишийг харуулж байна. Иймээс мал аж ахуйн төлийн ба өвлийн бэлтгэлийг иж бүрэн хангаж, төл бойжуулах ямаа маллах арга технологийн зөвлөмжийг суурь нэг бүрт нэвтрүүлж тэргүүний малчдын туршлага эзэмшүүлэх ажлыг өргөн зохиох хэрэгтэй байна. БНМАУ-ын аварга малчин Г.Базарсүрэн Говь гурван сайхан үүлдрийн эм

ямаа нэг бүрээс 602-619 гр ноолуур авч 100 хувь нэгдүгээр зэрэгт тушаадаг. Сэврэй сумын ямаачин БНМАУ-ын аварга малчин Намжилдорж нутгийн болон эрлийз борлонгийн хаврын амьдын жинг сүүлийн гурван жилд дунджаар 23,0-24,6кг жинтэй онд оруулж нэг ч мал хорогдуулаагүй зэрэг бахдам туршлагыг судалж эзэмшүүлэх ажил зохиох нь зүйтэй. Цаашид аймгийнхаа бүх ямааг *Говь гурван сайхан* үүлдрээр сайжруулах ажлыг эрчимжүүлж, түүнд мал аж ахуйн мэргэжилтний зүгээс тавих анхаарал хяналтыг сайжруулвал зохино.

Ц.Цэдэнбалжир

- 142.** Ямаачдын зөвлөлгөөнд оролцогчдод баяр хүргэе // Говийн мэдээ.- 1978 оны 9-р сарын 4.- №66.- 3-р нүүр.

Ямаачдын зөвлөлгөөнд оролцогчдод баяр хүргэе

/Тэргүүн туршлагын цомирлог/

Цогт-Овоо сум

Бэлтгэлээс бүтээл: Цогт-овоо сумын Жаргалант нэгдлийн Бор тээг бригадын ямаачин Л.Наран өвлийн болон төлийн бэлтгэлийг эртнээс чанартай хангаж мал сүргээ хорогдолгүй онд оруулан арвин их ашиг шим авдаг туршлагатай хүн юм. Эдний суурь саравчны чулуун ханыг хөрзөнгөөр доторлож 300 төлийн багтаамжтай гэр хэлбэрийн пүнз барьжээ. Жил бүр 10 тн оос доошгүй хуурай бууц нөөцлөн адууны намрын хомоолыг жилд 200-300кгыг бэлтгэн гурваас доошгүй тн өвс, 2000 ширхэг таана хөмүүлэн зоодой, 200кг шимт тэжээл, 150-200л сүү айраг бэлтгэж авдаг байна. Малыг орой ирэхэд нь хотны гадна хужир идүүлж шээлгээд өглөө эрт босгож хашаанаас гаргаж шээлгэдэг ба хос хороо барьж ашигладаг нь хот хөлдөхөөс найвдартай хамгаалдаг байна. Эцэж муудсан малын тэнхрүүлэхэд загасгал таана хөмүүлэн зоодойн хандыг өдөрт 1 летр өгөх

тэжээлийг дэвтээж адууны өөх цагаан идээний зүйлтэй холж тэжээх тэжээлийг нэг хэмжээтэй тогтмол өгөх нь ашигтай ажээ. Л.Нарангийн бэлтгэл нь бүтээлийн үндэс болж аймгийн аварга малчин болсон юм.

- 143.** Ямаачдын зөвлөлгөөнд оролцогчдод баяр хүргэе // Говийн мэдээ.- 1978 оны 9-р сарын 4.- №66.- 3-р нүүр.

Ямаачдын зөвлөлгөөнд оролцогчдод баяр хүргэе
/Тэргүүн туршлагын цомирлог/

Сэврэй сум

Ямааны онцлогт тохирсон маллагаа: Сэврэй сумын Социализмын зам нэгдлийн Бүйлсэн бригадын ямаачин аймгийн хошой аварга малчин Э.Гомбожав Говь гурван сайхан үүлдрийн төллөх ямаа хариуцан маллах хугацаандаа 100 эхээс 100-112 ишиг бойжуулж эм ямааг намрын жингээр 42-45кг-д хүргэжээ. Гомбожав ямааг онцлогт нь тохируулан малладаг. Ямааг бэлчээр ашиглах чадвар сайтай өвс тэжээлийн амт чанарыг их үгүйлдэг хариулга маллагааны дэг журамд амархан дасдаг мал Ямаа бээрэг мал боловч тарга хүч бүрэн авахуулсан л бол тийм ч амархан бээрч эцэж доройтдог мал биш. Тэжээл их амархан авдаг онцлогтой. Бэлчээрийг улирал бүрд хуваарьтай ашиглаж бэлчээрийн хүрэлцээ байнга хангалтай байдгаас нэгдлээс их тэжээл авч үргүй зардал гаргадаггүй байна. Хорт ургамлаас сэргийлж 11 дүгээр сараас эхлэн хужиртай ус хивэг гурилан зутангаар ямаагаа усалж хээлийг бэхжүүлдэг. Ургамлаар хордсон малд үнээний сүү өгөх суль идүүлэх үнсийг хандалж өгөх зэрэг арга хэрэглэдэг нь үр дүнд хүрчээ.

- 144.** Ямаан сүргээ өсгөж ашиг шимийг нь нэмэгдүүлье // Говийн мэдээ.- 1978 оны 9-р сарын 4.- №66.- 3-р нүүр.

Ямаан сүргээ өсгөж ашиг шимийг нь нэмэгдүүлье

/Тэргүүн туршлагын цомирлог/

Номгон сум

Төлийн хэвтэр: Номгон сумын Сангийн далай нэгдлийн ямаачин аймгийн хошой аварга малчин Ж.Бат-Очир төл бойжуулахдаа нарийн арга ажиллагаа хэрэглэдэг. Пүнзний чигжрийг газрын хөрсийг гартал ухаж зуны улиралд хаалга цонхийг онгойлгон нар салхинд эрүүлжүүлдэг. Төлийн хэвтэрт хамгийн дор нь 10см зузаан үнс асгаад түүн дээрээ хөх хоргол 15-20см зузаантай хийж нялх төлд өвс сүрэл дэвсч өдөр бүр сольдог нь төл хорогдолгүй бойжихын үндэс болж байна. Бат-очир ямааны хээл хаяхын гол нь худаг дээр чихцэлдэн эр сувай нь хээлтэй ямаагаа дарж хээл гэмтээдгийг ажиглаж онгоцоо тойруулан гурван тал модон хашилга хийж ямаагаа цөөн цөөнөөр тасалж усалдаг болсон нь хээл хамгаалах нэг арга болжээ.

- 145.** Ямаан сүргээ өсгөж ашиг шимийг нь нэмэгдүүлье // Говийн мэдээ.- 1978 оны 9-р сарын 4.- №66.- 3-р нүүр.

Ямаан сүргээ өсгөж ашиг шимийг нь нэмэгдүүлье

Ханхонгор сум

Дулаан байр: -Ханхонгор сумын гэрэлт зам нэгдлийн ямаачин аймгийн аварга малчин А.Дорж эрдэмтэн Дашгүнсэнгийн зөвлөгөөгөөр төлийн модон байр хийсэн юм. Энэ байрны урт өргөн нь 180х160см, өндөр нь нүүрэн талдаа 60см, ар талдаа 70см, дөрвөн хана гурван хэсэг таглаанаас бүрдэнэ. Хануудыг нугасаар холбоно. Нүүрэн талын хананд агаар сорох сараалж бий. Таглааг гурван хэсэг хийж дундхыг нь шиллэн хоёр талынхыг наамал банзаар /фанер/ хийж дээр нь агаар солилцооны яндан байрлуулжээ. Ийм байранд 1-10 хоногтой 50 ишиг багтана. Чалх сайтай

ишгийг 2-3 хонуулаад ч гаргаж болно. Өглөө ишгийг тавьж хөхүүлэхдээ гэнэт ийм дулаан байрнаас гадны хүйтэн агаарт цочимог гаргахгүйн тулд урдаар шилэн таглааг авч орчны агаарт аажмаар дасгасны дараа ишгийг гаргаж хөхүүлдэг ач холбогдолтой юм. Ишиг хэт халууцах янзтай бол тагийг дутуу хаана. Энэ байрыг голдуу чулуун байрны дотор байрлуулах боловч хавар дулаарсан үед саравчинд байрлуулж болдог байна.

146. Ямаан сүргээ өсгөж ашиг шимийг нь нэмэгдүүлье // Говийн мэдээ.- 1978 оны 9-р сарын 4.- №66.- 3-р нүүр.

Ямаан сүргээ өсгөж ашиг шимийг нь нэмэгдүүлье

Баяндалай сум

Эхийг анхаарах нь чухал: -Баяндалай сумын Гурван сайхан нэгдлийн ямаачин аймгийн аварга малчин А.Халтар төллөснөөс хойш мал маш амархан эцдэг тул ишигтэй ямаагаа сайн муу гэлгүй цөмийг нь тэжээдэг. Ер нь малыг яаж арчилж сурна тэгэж л сурдаг амьтан гэж ярьж байна. Халтарын суурь хашаа саравчгүй задгай бууцанд бууж малаа төллүүлдэг.Төлийн нь эхийн хамт гадаа бойжуулдаг. Эхийн сүү муудахаар төл сэнсэрдэг тул эхийн нь сайн тэжээх хэрэгтэй. Манай зарим малчид төл хорогдож байна гээд хамаг анхааралаа түүнд хандуулах боловч хорогдуулсаар л байдаг. Тиймээс төлөө сайн бойжуулъя гэвэл эхэд нь их анхаарах хэрэгтэй юм шиг санагддаг гэж тэр ярьж байна. Багсартал тэжээлийг загсгалын хандаар дэвтээж малаа хошуувчаар тэжээдэг. Ихэр ишигтэй ямаанд илүү тэжээл өгч ойрын бэлчээрт хариулдаг. Загсгалыг нүдэж бяцлаад хар цай шиг болтол буцалгаад сүү орлох тэжээл болон сүү цагаагаар сүлэн ишгэнд 150-200 гр-ыг өдөрт нэг удаа өгдөг.

- 147.** Ямаан сүргээ өсгөж ашиг шимийг нь нэмэгдүүлье // Говийн мэдээ.- 1978 оны 9-р сарын 4.- №66.- 3-р нүүр.

Ямаан сүргээ өсгөж ашиг шимийг нь нэмэгдүүлье

Сэврэй сум

Малын тарганы үеийг мэдэх: Сэврэй сумын социализмын зам нэгдлийн ямаачин аймгийн аварга малчин А.Санж зөвлөхдөө: -малын тарганы үеийг хамгийн хялбараар дөрвөн ангилалд хувааж болох юм. Эхний үе нь усан цочиргооны үе: Энэ үе нь мал бүр жигд гэдэс хээл сайтай болж тогтмол хуучин сэвс нь дуусч шинэ шимтэй сэвс тогтож ирэх үе юм. Дотор өөхөн цацалтын үе: Энэ үе нь малын үе мөч чангарч тавар тэнхээ нэмэгдэн өнгө зүс өөрлөгдөн өнгө сууж ирэх зэрэг нилээд олон шинж тэмдэг тодорно. Өөх мах хосолсон таргын үе : -Энэ үе бол хамгийн үнэн жинхэнэ чанартай таргын үе байдаг. Чөмгөн тарга авах үе: Энэ үед мал тарга хүчээ бүрэн авч гүйцэнэ. Ингэж тарга хүчний байдлыг ажиглаж мэдснээр түүнд хариулга маллагаа тохируулдаг байна. Мал хариулна гэдэг бол бараадаж дагахын нэр биш ямагт малынхаа түрүүг тогтоож, ажуу тайван байлгаж бэлчээрлүүлэх хэрэгтэй. Малын бэлчээрт байх хугацааг аль болохоор уртасгах нь гол зүйл мөн гэж ярьж байна.

- 148.** Ямааны аж ахуйн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлье // Говийн мэдээ.- 1978 оны 9-р сарын 4.- №66.- 3-р нүүр.

Ямааны аж ахуйн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлье

/Сэврэй, Гурвантэс, Булган сум/

Манай аймаг ямаан сүргийн тоогоор улсад хоёрдугаар байранд ордог бөгөөд аймгийн хэмжээгээр

улсад бэлтгэж байгаа махны 29 хувь, ноос ноолуурын 14 хувийг ямааны аж ахуйгаас нийлүүлж байна. Бүх ямааны 83 хувь нь нийгмийн аж ахуйд хамрагдаж хөдөө аж ахуйн нэгдлийн үйлдвэрлэж байгаа махны 25 хувь, ноосны 15 хувь, сүүний 55 хувийг эзэлж байна. Одоо хөдөө аж ахуйн нэгдлүүд 50 шахам цэвэр ба эрлийз ямаатай болж нийт нэгдлүүд үржүүлж байгаагийн дотор Булган сумын Туяа нэгдлийн ямааны 47 хувь, Сэврэй сумын Социализмын зам нэгдлийн ямааны 21 хувь нь эрлийзжээд байна. Нам засгаас говийн хөдөө аж ахуйн нэгдлүүдийн эдийн засгийг бэхжүүлэх олон чухал арга нэмжээ авсны нэг нь улсад бэлтгэж байгаа ямааны мах, ноолуур арьс ширний үнийг удаа дараа нэмэгдүүлж новийн бүсийн нэмэгдэл тогтоосны үр дүнд мал аж ахуйгаас орох мөнгөн орлогын 30 гаруй хувийг ямааны аж ахуй өгч нэгдлийн эдийн засагт чухал байр эзэлж байна. Ямаачдын хөдөлмөрийн хөлс жил дутам нэмэгдэж одоо нэг ямаачин жилдээ дунджаар 1770 төрөг авч материалаг сонирхол нь дээшилсээр байна. Ямаа тоо өсч үүлдэр угсаа нь сайжирч байгаа боловч бүтээгдхүүний үйлдвэрлэлтийн хэмжээ түүний чанар нэгэн адил өсч эдийн засгийн үр ашиг нь дээшилж чадахгүй байна. 1970 оныг 1977 онтой хариуцуулахад ямааны нийт тоо 36 хувь өссөн байхад үйлдвэрлэсэн мах ноос ноолуурын хэмжээ 8,8-27,7 хувь өсчээ. Аймгийн дүнгээр сүүлийн гурван жилд ямаанаас дунджаар 271-27гр ноолуур авч нэгжийн гарц нэмэгдэж байна. Гэтэл Гурвантэс сумын Соёл нэгдлийн ямааны ноолуурын гарц нэгдлүүдийн дунджаас 18-36граммаар бага байгааг анхаарах хэрэгтэй. Тэрчилэн Гэрэлт зам, Гучин таван жил, Хөдөлмөр нэгдэлд ноолуурын чанар аймгийн дунджаас доогуур байгаа юм. Хөдөө аж ахуйн нэгдлүүдээс улсын бэлтгэлд хавар нийлүүлж байгаа ямааны амьдын жин бага ялангуяа өсвөр насны малыг 18-21 кг жинтэй тушааснаас махны их нөөц бололцоо алдаж байна. Сүү сүүн бүтээгдхүүний орлого нь ямааны

аж ахуйн бүх орлогын 1,8-3 хувийг эзэлж байгаагийн гадна нэгжээс ашиглах сүү бага хэмжээтэй байна. Сүүлийн 2 жилийн байдлаар Хөдөлмөр, Галбын хөгжил, Сангийн далай, Жаргалант нэгдлүүд нэг ямаанаас 7-9летр сүү ашиглажээ. Зөвхөн ноолуурын чанар, сүү сүүн бүтээгдхүүний ашиглалтаас жилдээ сая гаруй төгрөгийн орлого орох нөөц алдагдаж байна. Хөдөө аж ахуйн нэгдлүүд нэг ямаанаас 24 төгрөгийн орлого олж 34 төгрөгийн зардал зарцуулж бүтээгдхүүний борлуулалтаас жилд 600-700 гаруй мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж байна. Ялангуяа мах сүү сүүн бүтээгдхүүний ашиглалтыг нэмэгдүүлж энэ үндсэн дээр тухайн бүтээгдхүүний алдагдлыг багасгах явдал шаардлагатай байна. Ямааны аж ахуйн шууд зардлын 24-25 хувийг тэжээлийн зардал эзэлж жилдээ 3,5-4,1 төгрөг зарцуулж байгаа нь бусад төрлийн малаас олон дахин илүү байна. Тухайлбал тэжээлийн зардлыг 1970 онтой харьцуулахад 9,2 дахин нэмэгдснээс үзэхэд тодорхой юм. Ямааны аж ахуйн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд олон хүчин зүйл нөлөөлнө. Ямааны тоо толгойг өсгөж үүлдэр угсааг сайжруулан эрчимжүүлэх замаар нэг малаас ашиглах бүтээгдхүүнийг нэмэгдүүлэх нь онцгой нөлөө үзүүлнэ. Энэ үндсэн дээр хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж өөрийн өртөгийг хямдруулах бололцоог нээнэ. Гаднаас авах тэжээлийг багасгаж өөртөө үйлдвэрлэх бололцоо бүхий тэжээлийг нэмэгдүүлэх нэгэнт бэлтгэсэн тэжээлийг арвич хямгач тооцоотой зарцуулах нь гол арга мөн. Суурь бүрт оны эхэнд жилдээ зарцуулах тэжээлийн хэмжээг тогтоон өгч хэмнэсэн нөхцөлд материалаг урамшуулалтай болгон бүх малд дээд зэргийн тарга хүч авахуулж бүтээгдхүүний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх хэрэгтэй.

Д.Жумдаан

149. Малд ээлтэй малчных // Говийн мэдээ.-
1978 оны 10-р сарын 23.- №79.- 3-р нүүр.

Малд ээлтэй малчных

/Сурвалжлага/

Цогт-Цэций сум

Үнэгэн зоо шиг шаргалтаж өтгөн өвстэй талд Жамьяншарав гуай ишгээ хариулан явна. Сүргийн бэлчээрт түүнтэй уулзахад: өнгөрсөн жил 205 ямаа төллүүлж 231 ишиг авсан. Өсөх мал төлөөсөө гэгчээр 3 ямаа хүртэл гурав гурван ишиг гаргасан шүү гэж тэнүүн талд таваараа идээшлэн яваа буянт сүргийнхээ зүгт ажиглан харахадтүүний хашир өгөөж баян Цэций уул цэнхэртэн байв. Ухаан зарвал үйлс бүтнэ гэгчээр энэ нийгмийнхээ малыг өсгөж үржүүлэх ашиг шимийг нь бүрэн сайн авахын тулд их л ухаан зарж таараадаа. Түүний хүчин л арвин амжилтын эзэд болсон биз. Авгай Жуумаа Аймгийн Ардын Хурлын депутат аварга малчин. Эднийх мал малласан сүүлийн 20 аад жилд гаргаагүйн гадна ноос ноолуур сүүний үйлдвэрлэлийн даалгаварыг ямагт давуулж байжээ. Өнгөрсөн жил борлон бүрээс 200 гр, эм ямаа бүрээс 310гр ноолуур авч бүх ноолуураа сайн чанартай тушаасан. Тэр ч байтугай малчдын маллагааг хатуухан шалгасан байгалийн бэрхшээлтэй 1942 онд төлийн хорогдолгүйн дээр 50 ихэр төлтэй байсан нь уул шалгалтыг сайн өгсөн гэхээс яах вэ. Энэ бол Цогтцэций сумын Их шанхай нэгдлийн сийрст бригадын малчин хүн. Ямаачин Жамьяншарав гуай яриан дундаа мал ямар байх нь малчнаас л болно. Муу малчин гэж байхаас биш муу мал гэж байх биш дээ. Манайх энэ жил айл айлаас цугласан 320 гаруй ишиг хүлээж авсан. Анхандаа ч зүс буруу малыг ижилсүүлэх, ус, бэлчээр тохируулах гээд их л ажилтай байлаа. Энэ нь малаа таргалуулах отортой хамт хийдэг ажил юм. Энэ жил хур бороо багатай, ургац ногоо ховор ч гэсэн

энүүхэндээ эрх биш сайн шүү. Манайх тэр уулыг нар зөв тойруулж 8 удаа нүүгээд ирсэн дээ гээд зэрэглээн дунд цэнхэрлэн харагдах уулыг заав. Мал маллахад учир бий гэгчээр хамгийн гол нь өвөлжөө бууцаа дулаалж, өвс тэжээл, хужир усаа бэлтгэж өвлийн бэлтгэлийг сайн хийх нь зүйтэй. Манайх тэр хойд энгэрт байгаа Бичигтийн бууцанд өвөлжинө. Бүх бэлтгэлээ хийчихсэн. Одоо өвөлжөөгөө хамгаалаад намрын отор хийж явна. Гэхдээ малын ажилд хүн бүр нэг хүн шиг санаж ажиллаж чадахгүйгээс малын өсөлт ашиг шитийн дээшлэлтэд муу нөлөө үзүүлэх шиг санагддаг. Хариулага маллагаа муугаас алдаж үрэгдүүлэх, ус бэлчээр тохирохгүй байх, ус ундаар сойх тал гардаг. Энэ жил гэхэд л бог малын зохиомол нийлүүлэг оройтож байх шиг байна. Орой гарсан төл ядахдаа тэсвэр муутай байдаг. Ийнхүү бид сүргийн бэлчээрт уулзсан цөөн мөчид мал маллагааны талаар олон эхтэй яриагаа дуусаад босоход биднийг нөмрөн идээшилж байсан ишиг мал саахалтын орчим байсан гүвээ давах дөхсөн байв. Ингээд Жамьяншарав гуай явдалтай жижиг харлаг мориндоо мордож тархан идээшилж яваа малынхаа зүг алхуулахад урт аяны бид өргөн шар замдаа орж алсыг зорив.

Т.Цэдэв

150. Тэмээчдийн хариуцлагыг сайжруулъя // Говийн мэдээ.- 1978 оны 12-р сарын 4.- №90.- 3-р нүүр.

Тэмээчдийн хариуцлагыг сайжруулъя

Номгон сум

Номгон сумын Сангийн далай нэгдлийн Дэрсэнэ ус бригадын төвд тус сумын бүх тэмээчдийн зөвлөгөөн өдөрлөг болж *Тэмээний аж ахуй ашиг шим орлогыг өндөржүүлж хариулга маллагааг тогтмолжуулъя* гэсэн асуудал хэлэлцэв. Сангийн далай нэгдэл орлогынхоо 40 шахам хувийг тэмээний аж ахуйгаас олж, тэмээн сүрэг

сүүлийн жилүүдэд тогтвортой өсөж нэг тэмээнээс ашиглах ноос сүүний дундаж хэмжээ жил дараалан нэмэгдэж байна. Сүүлийн жилүүдэд тэмээний хариулга маллагаа сайжирч алдаж үрэгдүүлэх эзний хариуцлагагүйгээс зүй бусаар хорогдуулах асуудал багасч тэмээн сүрэгт тавих анхаарал сайжирч тамга тэмдэгийг бүх тэмээний 80 хувьд хийжээ. Тэмээ маллах арга ажиллагаанд тэргүүний тэмээчдийн арга туршлагаар ажиллаж амжилтанд хүрч байгаа Жаргалхүү, Лувсансодов, Ц.Адьяа, С.Шархүү зэрэг тэргүүний тэмээчдийн тоо нэмэгдэж байна. Тэмээний аж ахуйд тавих материалаг арга хэмжээ сайжирч хашаа уст цэгийг олшруулж өвөл хаварт тэмээ тэжээх цэг байгуулан ажиллуулсан нь амжилтанд хүрч байна. Гэвч тус суманд тэмээний хариулга маллагаа жигд сайжраагүй, жил дараалан 200-500 кг ноос дутагдуулж, олон тооны тэмээ алдаж үрэгдүүлж байдаг тэмээчин цөөнгүй байна. Дэрсэнэ ус бригадын тэмээчин Галсандорж сүүлийн 3 жилд 27 тэмээ алдаж, 1,4 тн ноос, Мөнхдорж 87 тэмээ алдаж 1,4тн ноос, Жамбалдагва 37 тэмээ алдаж 1,1тн ноос, Төхөм бригадын тэмээчин Ц.Дорж 50 тэмээ алдаж 725 кг ноос тус тус дутагдуулж байжээ. Үүнээс гадна тэмээчин Галсан, Мөнхчулуун Тогооч нар жил дараалан ноос дутагджжлж нийгмийг хохироож байгаа зэрэг дутагдлыг тус зөвлөгөөнд оролцсон тэмээчид анхааралтай хэлэлцэв. Намын шинэ лоозонгийн шаардлагыг тэмээчин бүр бүтээлчээр хэрэгжүүлж, тэмээний хариулга маллагааг тогтмол байлгаж ус хужир тэгш бэлчээрийг сонгон нүүдэллэж тэмээнд тарга хүч сайн авахуулан тэмээн сүргийн үржлийн ажлыг эмх цэгцтэй болгож, буур сонгон тавихыг мэргэжилтний оролцоотойгоор хийж байх, тэмээ маллагч илгээлтийн эздийг тогтвор суурьшилтай ажиллуулах нь чухал гэж зөвлөгөөн үзэв.

Ж.Баатарцэрэн

151. Отрын малчдын зүтгэл // Говийн мэдээ.-
1978 оны 12-р сарын 18.- №94.- 3-р нүүр.

Отрын малчдын зүтгэл

Сэврэй сум

Их Номгон уулын хэцэд малын идэш хоол сайтай, өвс ургамал нь үнэгний зоо шиг шаргалтан энд тэндгүй мал сүрэг суурь сууриараа налайн бэлчих нь отроор яваа малчдын сэтгэл тэнгэр өвөлжиж байгааг харуулж байна. Сэврэй сумын оторчид энэ сайхан нутагт өнтэй сайхан өвөлжиж өвлийн болон төлийн бэлтгэлээ сайн хангаж малаа онд бүрэн оруулах төлөө сайн бойжуулахаар шамдан ажиллаж байна. Бүйлсэн бригадын малчин Э.Гомбожавынх гэр бүлээрээ нэг суурь болж 800 гаруй малыг Тосонгийн усны зүүн баруун бууцанд хээлтэй сувайгаар нь хоёр таслан тохилог сайхан өвөлжиж байна. Эдний суурь өнгөрсөн 6 жилд нэг ч том мал, төлийн хорогдол гаргаагүй малаас авах ашиг шимийн үйлдвэрлэлийн даалгавраа давуулан биелүүлж ирсэн юм. 1978-онд төллөх 361 ямаанаас 368 ишиг, 177 хониноос 190 хурга бойжуулж ноос ноолурын даалгаварыг чанарын дээд үзүүлэлтэйгээр 101 хувь биелүүлсэн юм. Эднийх энэ жил урьдах амжилтаа бататган 480 эх малаас төлийг бүрэн бойжуулах нэг настай 300 гаруй эр малыг хорогдолгүй онд оруулахаар чармайн ажиллаж бүх малдаа үзлэг хийж тарга хүч муутай малыг нэмэгдэл тэжээлд оруулаад байна. Гомбожавынхны ажлын нэг онцлог бол гэрийн дотор хүн бүр тус тусдаа мал нүдлэн хариуцаж Гомбожав өөрөө хүн бүрийн ажлыг нэгтгэн дүгнэж ажиллаж байгаа нь нийгмийн өмч хөрөнгийг нүдлэн хамгаалж байгаа чухал арга хэлбэр мөн. Гомбожавынхаас холгүй Улаан толгой, Хадан бууцанд Сайн шанд бригадын ямаачин С.Дамдингийх өвөлжиж байна. Энэ суурь өнгөрсөн жил

Говийн мэдээ сонин

700 гаруй ямаагаа хорогдолгүй онд оруулж 224 ямаанаас 247 ишиг бойжуулж ноос ноолуурын даалгаврыг давуулжээ. Энэ онд 483 ямааныхаа төлийг бүрэн бойжуулахын тулд төлийн бэлтгэлд зориулан зөөлөн өвс 4тн, хужир 400кг, бүх төлд хүрэлцэх хэмжээний хөх хоргол бэлтгэж отрын нутагт нэг ч малын хорогдолгүй төлөө бүрэн бойжуулж цагийн бэрхшээлийг гарз хохирол гаргалгүй даван туулахаар бусад малчдаа хошуучлан ажиллаж байна.

Р.Жамсранжав

152. Хөдөлмөрийн баатаар Д.Аюурзана // Говийн мэдээ. 1979 оны 2-р сарын 8.- №11.- 3-р нүүр.

Хөдөлмөрийн баатаар Д.Аюурзана

Булган сум



153. 143.Аваргад хүрсэн арга // Говийн мэдээ.- 1979 оны 2-р сарын 8.- №11.- 3-р нүүр.

Аваргад хүрсэн арга

Булган Сум



Дон үүлдрийн эрлийз 300 охин ишиг 1960 онд авч малла сан. Энэ хар ямааг авах хүн олдохгүй

сүрэнгийнхэн ямаа самнахдаа их туршлагатай хүмүүс юм. Сахлаг бишчигжүү өгтөн богинооостой, хүрэн бараан зүстэй ямаа ноолуур ихтэй байдаг гэнэ. Ноолуурыг арвин авах нь самналдад биш, гагцхүү

идэшлэх, мөн хээл хаяхгүй өдчир ч байдаг. Манай сумын Төрөгийн хуужир гэж нэг гурил шиг сайхан юм бий. Манай малчид үүнийг сайн ашиглаж байгаасай гэж боддог юм. Манайх ямааг гуравдугаар сарын 20-ноос эхлэн самнадаг. Үүнээс оройт-волноолуур нь хөөрч гээлдэг. Ямааг самнахдаа эхлээд суу, цавь, хэвлий-өвчүний ноолуурыг жижиг шүдтэй самбар самнаж дуусгаад, хүзүүний хоёр тал, хоолой, чихийг угсөөр хооронд, дагз, залаа, шаан чөмөгний үзүүрийг самнана. Дараа нь дагнаас сүүдний уг хүртэл эвст нь хоёр бөөрний ноолуурыг авна. Самнаж дуусвал шүүрэлд хийнэ. Ямаанд эхлээд нарийхан зооталж хяргах нь нуруунаасаа дараахгүй, халуунд наршихгүй байдаг гэж Базарсүрэн ярьж байна.

Эдний суурь төл бойжуулах, ноолуур ашиглах ажлаар сумын хоёр, аймгийн гурван удаагийн аварга болж 1974 онд ямаа бүрээс 602 грамм ноолуур ашиглаж, БНМАУ-ын аварга малчин болжээ. Сүү-

санд өнхрүүлэн царцаасны дараа ядарч доройтсон ямаанд өдөрт нэгийг өгөхөд хэдхэн хоноод тэнхэрдэг ажээ.

Мөн загсгалын үндэс, хожуулыг чанаж хандлаад сүлж, төл мэлд өдөрт 100 мл-ээр 1-2 удаа өгөөд байхад хоол нь шингэхдээ сайн гэнэ.

Ийнхүү Булган сумандах улсын үржлийн фермийн ямаачин БНМАУ-ын аварга малчин Г.Базарсүрэн гуайнх тавлаг сайхан өвөлжиж, өөрийн мал маллагааны арвин туршлагаар залуу малчдад зөвлөлтөө өгч байна.

Манай залуу малчид ийм ажилсаг ахмадаасаа ихийг сурч, мал маллах арвин туршлагыг өвлөн авч ажил амьдрал дээр хэрэгжүүлэхэд оюонтой алхарч ажиллах нь чухал байна.

М.Дамдясүрэн

АВАРГАД ХҮРСЭН АРГА

байхад нь авгайтайгаа ярьж байгаад авсан юм. Энэ ямааны ноолуур гэдэг торгон утас л гэсэн үг.

Айдаа мөнч сайхан ноолуур шүү. Манайд 1.9 кг ноолуур өгдөг ямаа байсан.

Таван жилд 11 ишиг өгсөн 907 номерийн хар ямаа бий. Одоо нас нь хөгширч байгаа ч бид хайрлаж тордсоор л байдаг. Мелчин хуи маланхаа ашиг шин, үр төлийг жил бүр судалж байх нь ашигтай байдаг гээд олон зуван дэвтэр гаргаж ирээ. Түүнд Базарсүрэн гуайн 1961 оноос эхлэн ямааныхаа нас, анги, дугаар, ашиг шин, үр төлийн чанарыг хөгжсөн гэмдэглэл нь байв. Базар-

ямаанд тарга хүч сайн авахуулж арчилгаа маллагааг тохируулсанд байдаг.

Ноолуур нь зөөлөн учраас хашаа хороонд бөөнөөр нь шажаж хэвтүүлэхэд ноолуур их үрэгддэг.

Ямааны ноолуур сайн ургах нэг нөхцөл нь ус хуужир, ялангуяа шорвог ургамал, бударгана идүүлэх явдал байдаг. Мөн бороо цасанд норох, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх угаагчдад тогтмол оруулахад ноолуур сайн ургана.

Хужир давсыг өдөр бүр долоологж цастай ч байсая өдөр бүр усалж байх нь тарга хүчээ тогтоох, даарч бэрэхгүй

гаар сарын 20-ноос эхлэн самнадаг. Үүнээс оройт-волноолуур нь хөөрч гээлдэг. Ямааг самнахдаа эхлээд суу, цавь, хэвлий-өвчүний ноолуурыг жижиг шүдтэй самбар самнаж дуусгаад, хүзүүний хоёр тал, хоолой, чихийг угсөөр хооронд, дагз, залаа, шаан чөмөгний үзүүрийг самнана. Дараа нь дагнаас сүүдний уг хүртэл эвст нь хоёр бөөрний ноолуурыг авна. Самнаж дуусвал шүүрэлд хийнэ. Ямаанд эхлээд нарийхан зооталж хяргах нь нуруунаасаа дараахгүй, халуунд наршихгүй байдаг гэж Базарсүрэн ярьж байна.

лийн зургаан жилд 1591 ямаанаас 1050,5 кг ноолуур авч төлөвлөгөөнөөс 257,6 кг ноолуур илүү тушааж улсад 45150 төгрөгийн цэвэр ашиг оруулж, аварга малчин Г.Базарсүрэн гуайнх тавлаг сайхан өвөлжиж, өөрийн мал маллагааны арвин туршлагаар залуу малчдад зөвлөлтөө өгч байна.

Ямааг их ноостой болгоё гээл ишиг байхаас нь эхлэх хэрэгтэй гэнэ. Ишгийг 10 хоногтойгоос нь дастай усаар усалж зөөлөн өвсөнд оруулж эхтэй нь хамт байлгаж байгаа хөвч хууж байснаар өдчиржих төвөр болдог байна.

Ядарч доройтсон мэлд ногоон цай, цайны шарыг идээд шөлдөд дэвтэж бөөрөнхийлөн хужир дав-

154. Сумын аварга // Говийн мэдээ.- 1979 оны 2-р сарын 22.- №15.- 6-р нүүр.

Сумын аварга

Номгон Сум

Номгон сумын Төхөм бригадын адуучин Батхуягийн суурь 897 адуутай адуу нь тарган цатгалан тавтай өвөлжиж байна



эдний суурь өнгөрсөн жил дунджаар адуу бүрээс 425 гр хялгас, 265 гр хөөвөр авч үйлдвэрийн даалгавараа давуулж 9000литр айраг тушаахаар 9700литр – ийг тушааж, 100 гүүнээс 72 унага бойжуулжээ. Сумын аварга Ч.Батхуяг өдөр болгон усалж хужирладаг. Усан дээр хужир байнга

байлгахаас гадна онгоцонд хужир хийж усалдаг нь адуу даарч бэргэх, эцэж зутрах нь бага байдаг байна. Хамгийн шийдвэрлэх хүч бол тарга хүч юм. Гүйцэт таргалсан адуу хөөвөр хялгас нь их ургадаг. Хээл авах нь сайн сүү жилбэ сайтай унагалдаг, унага нь сэргэлэн цовоо эрүүл чийрэг товир байдаг. Иймээс адууны бэлчээрийг сайн тохируулж ус хужиараар дутаахгүй байхыг л гол болгодог. Хавар эцэж муудах төлөвтэйг гадуураа авч тэжээдэг, тэнгэрийн муухай шороо шуургатай үед заавал манаж байх ялангуяа уналгах дөхсөн байдсан гүүг байнгын хараа хяналтанд байлгахгүй бол унагаа орхих төөрч сарних зэргээр унага үрэгддэг. Үүнийг би их л анхаардаг даа гэж Ч.Батхуяг ярьж байв. Эдний суурь гүүгээ азрага азрагаар нь ээлжлэн уяж унага махлуулах, сааль сүү ашиглах ажиллаа зэрэг хийдэг байна. Сумын 2- удаагийн аварга Батхуяг өнөө жилийн ажлын гараа сайн байна.

155. БМАУ-ын Залуу аварга малчин // Говийн мэдээ.- 1979 оны 2-р сарын 26.- №16.- 3-р нүүр.

БМАУ-ын Залуу аварга малчин

Ханбогд сум



Ханбогд сумын малчин залуучуудаас энэ жил 32 нь МХЗЭ-ийн төв хорооны 6-р 5 жилийн гавшгайч залуу алтан медиалаар шагнагджээ. Ажил үйлсээрээ тэргүүний малчин залуучуудын дотороос МХЗЭ-ийн илгээлтийн эзэн, МХЗЭ-ийн төв хорооны “тэргүүний малчин залуу” алтан

медалт Хоньчин Х.Бадамцэцэг 1978 онд 543 хониноос 621 хурга бойжуулсан хөдөлмөрийн гарамгай амжилтаар БНМАУ аварга залуу малчин цо лоор шагнагдав.

Говийн мэдээ сонин

156. БМАУ-ын Залуу аварга малчин // Говийн мэдээ.- 1979 оны 2-р сарын 26.- №16.- 4-р нүүр.

БМАУ-ын Залуу аварга малчин

Ханбогд сум

Номгон сумын “Сангийн далай” нэгдлийн ямаачин Аймгийн аварга сумын 6 удаагийн аварга малчин Ц. Сосорынх гурав дахь жилдээ нэг настай 800 гаруй мал маллаж байна. Эднийх намар ишигийг хүлээж аваад нутаг бэлчээрийг тохируулан намрын сөл дагаж өвөлжөөндөө буутал отор хийтэл отор хийж өвөлийн бэлтгэлийг бүрэн хангадаг байна. Ишигийг сайн дунд муу гэж ангилж тарга хүч муутайг нь эртээс нэмэгдэл тэжээлд оруулж өдөр бүр загсгалын ханд өгч тэнхрүүлдэг туршлагатай малчин юм. Зураг дээр аймгийн аварга малчин



Ц.Сосорын гэргий сумын аварга малчин
Д.Ганганжуужаа
Гэрэл зургийн Ч. Цэндоо

157. Алтан медальт хоньчин // Говийн мэдээ.- 1979 оны 3-р сарын 8.- №19.- 2-р нүүр.

Алтан медальт хоньчин

Ханбогд сум

Улсын аварга малчин Жамбалын охин Отгон МХЗЭ-ийн илгээлтээр малчин болоод 4 жил болж байна.

Говийн мэдээ сонин

6-р таван жилийн төлөвлөгөөний эхний гурван жил 100 эхээс 101-113 хурга бойжуулж, үйлдвэрлэлийн бусад даалгаврыг 100-103,3 хувь биелүүлж энэ жил МХЗЭ-ийн төв хорооны 6-р таван жилийн гавшгайч залуу алтан медиалаар шагнуулсан юм. Хоньчин Отгон малч эцэг эхийнхээ хойчийг залгамжлан сайн малчин болохоо ажил үйлсээрээ харуулж явна. Ханбогд сумын галбын хөгжил нэгдлийн гавлиуд бригадын хоньчин Ж. Отгон энэ жил төллөх 571 хониноос бойжуулах төлийн бэлтгэлийг бүрэн хангаж олон улсын хөдөлмөрчин эмэгтэйчүүдийн



уламжлалт баяр мартын 8-ний 69 жилийн ойг угтаж мал сүргийн хорогдолгүй өвөлжиж гарсан төлийг бүрэн бойжуулж байна.

Зураг дээр: хоньчин Ж.Отгон

158. Ямаачин Б.Сосор // Говийн мэдээ.- 1979 оны 3-р сарын 15.- № 20.- 2-р нүүр.

Ямаачин Б.Сосор



Сүхрэй сумын «Соцгализми зам» нэгдлийн ямаачин Б. Сосор, нийгмийн ямаан сүргийг зорь шахам жид маллахдаа аун намарт тарга хүч сайн авахуулж, хорогдолгүй онд оруулж туршдаг ажээ. Тэр сүүдийн таван жилд (615—70) эр ямаа малдаж үйлдвэрлэлийн даалгаврыг ямагт давуулж биелүүлдснээр 1978 онд БНМАУ-ын энх сүрэгтэн аварга малчин цол хүртлээ.

ЗУРАГ ДЭЭР: Ямаачин Б.Сосор.Гэрэл зургийг Т.Цэдэв.

159. Туршлагатай тууварчин // Говийн мэдээ.- 1979 оны 3-р сарын 15.- №20.- 3-р нүүр.

Туршлагатай тууварчин



160. Говийн мэдээ.- 1979 оны 3-р сарын 26.- №23.- 3-р нүүр.



161. Одонтой хоньчин // Говийн мэдээ.- 1979 оны 3-р сарын 29.- №24.- 1-р нүүр.

Одонтой хоньчин

ОДОНТ ХОНЬЧИН

Ханбогд сумын «Галбын хөгжил» нэгдлийн Гавиууд бригадын хоньчин Жамбал арван жилийн өмнө 398 хоньноос 431 хурга бойжуулсан зэрэг хөдөлмөрийн амжилтаар БНМАУ-ын аварга малчин болсон амжилтаа алдаагүй айна.

Эднийх 1969 оноос хойш суурийн ажилдаа нарийн тооцоо хөтөлж, жил жилийн ажлын судалгаатай юм. Сүүрсөн арван жил 4126 төл бойжуулж, 7000 кг ноос, 9637 литр сүү бэлтгэжээ. VI таван жилийн эхний гурван жил 100

эхээс 101—113 төл бойжуулж, ноос, сүүний үйлдвэрлэлийн даалгаврыг 100-103 хүн биелүүлсэн амжилтаар Жамбал өөрөө «Алтан гадас» одонгоор, охин Отгон нь МХЗЭ-ийн Төв Хорооны «VI таван жилийн гавигайч залуу» алтан медалиар энэ онд шагнуулжээ.

Эднийх хэд хэдэн хос хороотой, хонио төлөсөн төлөөгүйгээр нь ялгаж, хургыг хөрвөжлтийн үе шатаар бойжуулдаг юм. Төлөх хонийг төлөхийн өмнө болон төлөсний дараа нэмэгдэл тэжээл өгч,

хүч таргыг нь аадагуудадгүй учир сүү жилдээ сайтай төлөж цагцартай байдаг. Энэл, хаврын бэлчээрийг нарийн хуваариж, нөмөр өгтөө бүхий газрын бэлчээрийг эртээс төлөсөн хонид нэмэгдэл төлөх болоогүй хонийг алсын бэлчээрт явуулж, хонио төлөсөн төлөөгүйгээр нь тусгай нь хэргүй байна. Аварга малчин Жамбалын суурьд 570 гаруй хонь, төлөж, гарсан төл нь бүрэн бойжиж тохлог хаваржиж байна.

Ч.Цэнлоо



ЗУРАГ ДЭЭР: Хоньчин Жамбал сургийн бэлчээрт.
Зохлогчийн авсан гэрэл зураг

162. Тэмээчин баатар // Говийн мэдээ.- 1979 оны 4-р сарын 30.- №33.- 3-р нүүр.
Тэмээчин баатар

Тэмээчин баатар



орсноос хойш, нийгмийн гэмээн сургийг тасралтгүй 23 жил маллахдаа нэгч мал, төлийг хорогдуулалгүй, бүрэн энх сүрэтгэн болж, ноос сүүнийхээ даалгаврыг жил дараалан давуулан биелүүлж, төлөө бүрэн бойжуулж иржээ.

Х.Гомбосүрэн хувцас оёх, мал саахаас эхлээд мал маллах, уналга эдэлгээнд сургах талаар хөнгөн шуурхай ажилладаг, манай залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч юм.

БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Х.Гомбосүрэн тэмээ малласан хугацаанд 815 ингэжээс 816 богто бойжуулж, 18,9 тонн ноос, 42,7 мянган литр сүү нэг-

дэл нийгэмдээ бэлтгэн өгч 300 гаруй тэмээг уналга эдэлгээ, саалинд сургажээ. Х.Гомбосүрэнгийн ажлын баялаг туршлагаас тус сумын 20 шахам тэмээчин эзэмшиж амжилтад хүрч байна. Мөн үйлдвэрлэлийн даалгаврыг удаа дараа тасалж байсан тэмээчин Бадамцэцгийг халамжлан хүмүүжүүлж байна. Х.Гомбосүрэн гуайнх одоо Хөрх уулын зүүн үзүүрт «Хашаат»-ын соргог сэрмүүн бэлчээрт хаврын отор хийж, ингээд богтодуулж төлийг нь бүрэн бойжуулан тавтай сайхан хаваржиж байна.

Ж.Бадам

163. Тэмээ маллах арга ухаан // Говийн мэдээ.-
1980 оны 01-р сарын 03.- №2.- 3-р нүүр.

Тэмээ маллах арга ухаан

Ханбогд сум

Ханбогд сумын “Галбын хөгжил” нэгдлийн Номгон бригадын тэмээчин Б.Вангийн тэмээ маллагааны онцлог нь: Цаг улирлын байдлаар нутаг усаа сонгон отор нүүдэл хийж, заг бударгана, багалуур зэрэг бутархаг ургамалтай боргиодуу нам дор тал хөндий хосолсон газраар хариулдаг

ЗУН: Тэмээг тогтож нутагшсан газраас нь: хурааж туулгүй идээшсэн газар нь алгуур эргүүлэн тогтоож, цатгалан байлгавал тогтвортой байна. Баглуур өргөст хамхаг тэмээг сайн таргалуулна. Ус бэлчээр сайн тохирч байвал тэмээг заавал гаднаа хураах хэрэггүй.

Намар: 9-р сарын нэгнээс 11-р сарын эхэн хүртэл шаваг,гашуун баглуур шар мод голлосон бэлчээрт салхи сөргүүлэн зөөлөн эргүүлж хариулна.Тэмээг хурааж хэвтүүлэх газар нь: дагжир байх нь: тэмээ сойлго авах нэг арга болдог. Сойлго нь: тэмээний тарга хүчийг тогтолж, ул тавгыг бэхжүүлэхэд сайн нөлөөтэй. Баглуур шар мод идсэн тэмээ таргалах үс ноос ургах нь онцгой байдаг байна. Намар шивээ зангуу ихтэй газар бэлчээхээс сэргийлэхийн хамт ширүүн хөөж тууж хөлөргөхгүй аяар нь идэшлүүлэн задгай ус уулган тарга хүч сайн авахуулдаг байна. Ногоо гандаж эхлэх үед тэмээ сөл хөөж салхидах зэргээр хол явуулахгүйн тулд ойр ойр хугацаанд нутаг сэлгэх нь чухал. Хэрэв нутаг бэлчээр нь тохирч байнаа бол үс ноос ургаж өнгө знсээ олж гуяны дотор талд хужир сууж хөлс дааварлан ирдэг. Хүйтэн сэрүүн болоход тэмээ бэлчээрээсээ шөнө уруудаж холддог. Иймд өглөө эрт очиж салхи сөргүүлэн эргүүлж өдөр дунд усалж, салхи сөргөн бэлчээнэ.

Өвөл: 11-р сарын дундаас эхлэн нөмөр дулаан бэлчээр сонгон авч заг монгол өвс сахилдаг бор улаан бударганатай зөөлөн элсэрхэг хөрстэй говь газар тохиромжтой. Идэр есийн хүйтэн эхэлсэн үед заг элбэгтэй газар тэмээнд тохиромжтой байдаг. Говьд өвөлжсөн тэмээ барагтай бол тарга хүчээ алддаггүй. Сувай тэмээг алсын бэлчээрт гаргаж өдөр бүр эргүүлж хураах юм уу нөмөр сайтай газар хэвтүүлж торомтой ингэ хөгшин тэмээг ойрын бэлчээрт хамруулан хүч тамир муутайг ялгаж наднаа тэжээдэг. Тэмээг тэжээж сургахдаа аманд нь ёотон хийх, исгэсэн тэжээл зажлуулах 1-2 хоног хоолгүй байлгаж байгаад сайн исгэсэн тэжээлийг өвстэй идүүлдэг арга байдаг. Өвлийн тэмээний бэлчээр тохирч байнаа шинж нь шөнө тайван хивж хэвтэх хоргол нь олон том бөөрөнхий байдаг.

ХАВАР: Алсаас нөмөртэй заг, товцогтой хоолой хөндийд хариулан бор харгана, бударгана, лавай, агь зэрэг эрт нүдэлдэг ургамалтай бэлчээрийг сонгон авч тэмээний арчилгаа маллагаа ингэ ботголох тэмээ ноослох ажлыг зөв зохион байгуулах хэрэгтэй болдог.

Ботго бойжуулахдаа: хоёр хашааны нэгэнд ботгонд өвс тавьж өгч нөгөөд нь: шилэрч болзошгүй ингэ, ботголох ингээ байлгадаг. Ботгоны өвсний хашаа нь: 7*9-ийн хэмжээтэй 35-40 ботгоны багатаамжтай байна. Ингийг ойр байлгаж гаднаа ботголуулна. Ботгыг гармагц 1-2 цагийн дотор нэмнэж, давстай бараан цайгаар амлууулж эхийн хөхний бөглөөг авч уургийг цадтал хөхүүлдэг. 15-хоноогоос өвс тасдаж эхэлдэг тул ботгыг хашаанд хийж өвсийг дээр уяж идүүлж сургана. Заг, бор бударгана ботго махлахад сайнаас гадна хужирсуулдаггүй байна. Чацрайлсан ботгонд зэрлэг гоёо нүдэж хандлаад өдөрт 1удаа 200мл-ээр 2-3 дараалан өгч эмчилдэг.

Тэмээ ноослох: Гуравдугаар сарын 1-ээс 20-ны дотор эр ноосыг бүрэн авч дуусгана. Гуравдугаар сарын сүүлчээс тэмээний хүзүү, хэдлийн ноосыг шууж авна. Зургаан сард

тэмээний бүх ноосыг авч дуусгана. Ботголсон ингэний ноос 4-р сарын 15-ны орчим хөндийрч гээгдэнэ. Дулаараад ирэхэд тэмээг усалж байхдаа ноослох нь: бэлчээрлэхэд саад болдоггүй сайн талтай. Б.Вангийнх 1978-онд нэг тэмээнээс 5997грамм ноос ашиглаж сумын аварга болсон амжилтаа бататгаж 1979 оны социалист уралдаанд авсан үүрэг шүйлдвэрлэлийн даалгавраа төрөл бүр дээр нь: 101,1-124% -иар биелүүлсэн юм.

М.Дамдинсүрэн

164. Төлчдын ажиллагаанд тэргүүн туршлага нэвтрүүлье // Говийн мэдээ.- 1980 оны 2-р сарын 25.- №15.- 3-р нүүр.

Төлчдын ажиллагаанд тэргүүн туршлага нэвтрүүлье
/Баатар хоньчдын баялаг туршлагаас эзэмшье/

“Тэргүүн туршлагыг нарийн нягт судалж атга чимхээр нь шилж цуглуулан улмаар цаашдаа практикт өргөнөөр нэвтрүүлбэл зохино...” Ю. Цэдэнбал

Гал уургаар нь цатга:

БНМАУ-ын хөдөлмөрийн баатар С.Цогтгэрэл хаврын улиралд малын хүч тэвээрэг буурч, ядаргаа ихтэй байдаг тул гэрийн унийг гурав хуваасны эхний хэсэгт нар тусахад малаа бэлчээгээд орой гэрийн нар тоононоос давж байхад хотлуулна. 6-р сараас 9-р сар хүртэл өглөө үүр цайхад бэлчээгээд үдшийн бүрэнхий болтол идэшлүүлдэг. Мал төллүүлэх бэлтгэл ажлыг зун намрын улиралд хийдэг. Зузаан бууцтай, мал төллүүлж дуустал ашиглах бэлчээрийн нөөцтэй мал төллөхөд бүх талаар тохирсон ихэр бууцтай газрыг сонгоно. Мал төллөөд эхлэхэд хонио төллөх, төллөөд гурав хоноогүй, гураваас дээш хоносноор нь гурав хуваан малладаг. Энэ нь малчдын хөдөлмөрийг зохистой ашиглах малын бэлчээрлэх хугацааг уртасгах, төл эх малд малчдаас тавих анхаарал хариуцлагыг өндөржүүлэх ач

холбогдолтой. Хургыг гармагц эхлээр байлгаж эхний гурван өдөр уурагт нь хангалттай цатгаж махан тарга авахуулахыг хамгаас чухалчилдаг. хургыг уургийн үед нь таваг сүүлтэй болгож таргалуулахад арьс нь тэлж сунаад тэр чигээрээ зузаан таргатай тарга сайнтай хонь болно. Хургыг ингэж уургийн үед нь таргалуулж чадаангүй бол нэг хэвийн дорой өсөлт хөгжилттэй уушгин сүүлтэй хонь болно. Иймээс малчид уургандаа цадаагүй хурга төлгөндөө майлна гэдэг шүү дээ. Эхийн уураг сүү шингэрч ирэх үед хурга өвсөнд орох болно. Сайн малтай байя гэвэл хургаа сайн бойжуулах хэрэгтэй. 2-р төлийг тураахгүй байвал малын өсөлт буурахгүй. Өсөлт нь гүйцээгүй малын ашиг шим нь муу байдаг байна.

Саахалт эхлээрийн арга: БНМАУ-ын хошой аварга малчин, хөдөлмөрийн баатар хоньчин Л.Бэгз мал төллүүлэхдээ үндсэн байр саахалт бууц буюу нэг дор барьсан хос хашаа ихэр бууцны аль нэгийг ашигладаг. Нэг суурийн малчин ашигладаг ийм бууцанд төллөсөн төллөөгүй хонио тус тусад нь хотлуульж хургыг эхтэй нь хамт байнга байлгаж эртнээс нөөцөлсөн ойрын бэлчээрт цуг хариулан бойжуулдаг. Энэ нь хүний хүч хөдөлмөр материал малын тэжээл хэмнэн ашиг шим ихтэй тэсвэр сайтай хонин сүрэгтэй болох шалгарсан арга юм. Энэ аргыг хэрэглэхэд бэлчээрийг маш сайн гамнаж өдөр өдрөөр хэсэглэн хуваарилж ажиллах нь чухал. Хургыг гармагц эхэд нь сайн долоолгож үсийг нь: хөх бууц үнс адууны хомоолоор арчиж элгэвчтэй нэмнээгээр нэмнэдэг. Эхээснь ялгасан төл нэг удаад удаан хугацаагаар гэнэт их хөхсөнөөс сүүгээ шингээхгүй өвчилдөг. Өвсөнд ороогүй төлийн гүзээ хэрхнэг сархинаг нялхынхаараа ажиллаж эхлээгүй байх тул хөхсөн сүү шууд ходоодонд орж шимэгддэгээс шингц түргэн өлсөх нь хурдан байдаг. Энэ шаардлага биелэхэд эхлээрийн арга үнэхээр тохирдог юм. Үс ноос элдэв юм идэж бөөнтөх гэдэг бол сүү эрдэс бодисоор дутагдаж байгаа

зүйл гэдгийг анхаарах хэрэгтэй. Малчин хүн малаа будгаар биш нүдээр таниж сурах хэрэгтэй гэж Бэгз баатар зөвлөж байна.

Хөхүүлэхийн өмнө эхийг тэжээнэ: Хөдөлмөрийн баатар хоньчин Д.Аюурзана хонийг 2-р сарын дунд үеэс төллүүлэхийг хамгийн тохиромжтой хугацаа гэж үздэг. Д.Аюурзаных төлөө хөрвийн аргаар бойжуулах эхний үе буюу 3 хоног эх төл хоёрыг хамт байлгадаг аргыг хэргэлэдэг. Хургаа тавиж хөхүүлэхийн өмнө бүх хургатай хонио тэжээдэг учраас хонины зан нь сайжирч ивэлгээн ааривжиж төлийн цатгалтад сайн нөлөө үзүүлнэ. Гурав хүртэл хоногийн настай нялх хургыг 3-4 цагийн зайтайгаар цатгацыг нь нэг бүрчлэн шалгаж муу цадсан юм уу эхээ хөхөж чадаагүйг дахин хөхүүлдэг Ингэснээр нялх хургаа хэвийн жигд цадацтай бойжиж хоолнь зохистой чацага алдах элдэв явдалгүй байдаг. Хургандаа 7 хоногийн настайгааснь өвс уян хэцлэн хужир ус тавиж өгдөг. Мөсөн хужрыг цоолж хэлхээд байранд нь тогтмол байлгадаг. Мөн хүчит тэжээлийг эсгээд саванд хийж тавина. Гурав хоногийн настайгаас дээшхи төлийг өглөө орой өдөрт хоёр удаа хөхүүлээд өдөр дунд нэг удаа тэжээдэг. Төлийн байрны хэвтэрийг засахдаа бууцыг цөмийг зайлуулж доод талд нь үнс дэд талд нь хөх хоргол хийж төлөө хэвтүүлээд чийгтсэн хэсгийг 2-3 хоногт сольдог. Хургаа 20-иод хоногийн настайгаас нь ойрын нөөцөлсөн бэлчээрт явуулж сургадаг. Өглөө хургаа хөхүүлэхдээ 3-7 хоногийн настайг эхлэн хөхүүлж дуусаад дараань 7-оос дээш настайг тавьж хөхүүлнэ. Хургаа тавьж байх үед сувай хонь бэлчээрт явдаг. Хургалах дөхсөн хонио өглөө бүр ялгаж үлдээдэг учраас бэлчээрт мал төллөдөггүй. Хургыг 7 хоногийн настайгаас ялгаж сургадгаас өдөр тутмын хөдөлмөрийг хөнгөвчилж байна. Хургыг дулаан өдөрт аль болохоор цэвэр агаарт байлгахад бойжилт нь түрэгсэж бие нь чийрэгждэг учир даарахааргүй үед гадаа байлгаж, дураар нь тоглуулдаг.

Эх нь сүү жилбэ муутай хургыг ойрмог төллөсөн бусад сүү ихтэй хониноос саасан уураг сүүг эхний 3-7 хоног тэжээгээд тэр хугацаанд эхэд нь: нэмэгдэл тэжээл өгч услах замраах зэргээр зутан чанаж өгөх зэргээр сүү жилбэ оруулдаг. Их сүүтэй хонины хурганы цатгацыг тохируулж хөхүүлээд үлдсэн сүүг сааж хураагаад хавар хөрөвжсөн төлөө тэжээх зэргээр ажилладаг

Тарган малын төл торниун.

БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Ш.Нанзад төл эсэн мэнд бойжихын эх сурвалж нь эх малын тарга хүч юм. Тарган цатгалан эхээс төл төвөг багатай түргэн торнидог ба өвчин эмгэгт тэсвэр хатуужилтай байдаг. Хүч тамир сайтай эх малын төл сайн байх төдийгүй эх малын сүү шимтэй уураг өтгөн чанарлаг төлдөө өөриймсөг байна. Иймд хаврын цагт хонио аль болох өвсний соргог сэмүүнд нөөцөлсөн бэлчээрт хариулж зун намрын отрыг зөв хийх хэрэгтэй. Хонийг төллүүлэхдээ эхний ээлжинд хамгийн залуу анх удаагаа төллөх хонио дараагийн ээлжинд хижээл хонийг дараагийн ээлжинд хамгийн сүүлийн ээлжинд зусаг хонио хургалахаар бодож нийлүүлэгийг зохион байгуулдаг. Хонио хур хүчтэй төллүүлэхэд их анхаарч ажилладаг. Эднийх хонь хургалуулах тал саравчтай хашаагаа 4 таслан голын 2 тасалгаанд нялх, дунд, хөрвийн хажуугийн 2 тасалгаанд нэгд их хөрвийг нөгөөд нь: хургалах хонио оруулдаг.

165. Найм дахь буудал дээрээ // Говийн мэдээ.-
1980 оны 12-р сарын 11.- №92.- 2-рнүүр.

Найм дахь буудал дээрээ

/Сурвалжлага/

Тоосрон цайрах нарийн хоолойн дунд Цагаан хайрханы ноёлог өндөр алсаас бараатай. Түүний эргэн тойронд заг сондуулт элсэн товгуудаар тэмээн сүрэг идээшлэн бэлчинэ. Энэ нутаг баруун талын сумдын

нутгийн уулзвар газар зуун зуун тэмээн сүргийн таатай бэлчээр. Армаг тармаг загт далангийн ээвэр хонхорт малчны цагаан гэрүүд хүрээнд ургасан мөөг мэт бөмбийн цайна. Тэр хот айлд аяны бид түрхэн саатахдаа нутгаасаа халуун намраар гарч 100 гаруй километр



замыг туулан өвлийн отор хийж яваа Гурван тэс сумын “Соёл” нэгдлийн Баясах бригадын тэмээчин С.Дэмбэрэлийнтэй тааралдав. Гурван тэс сумын малчид хөдөлмөрчид

цагийн гачаалалтай удаа дараа тулалдаж ялж гарч давж сурсан баатерлаг хүмүүс билээ. Эднийх түүний л нэг байв. Энэ залуу хосынх айл болж тэмээ маллаад удаагүй ч гэсэн өнгөрсөн онд 32 ингэнээс 32 ботго бойжуулан тором шилбэ хөгшин хөвөө далаад тэмээ тэжээж онд оруулжээ. Одоо эднийх 240-өөд тэмээгээ отроор өвөлжүүлж онд оруулахаар Баяндалай сумын “Гурван сайхан” нэгдлийн Наран бригадын нутаг Зүүн халзанд тохилог сайхан өвөлжиж байна. Гэрийн эзэгтэй Д Долгоржав: -Манайх нутгаас гараад найм дахь буудалдаа энд ирсээр сүрэг мал зүс цариа ороод сайхан л байна. Тэмээ мал идэш хоолоор алзахгүй хаашаа л бол бут мод заг бударгана элбэгтэй. Харин тэнгэр газар харсаар байнаад нүүдлээ жаахан оройтуулсан байна. Гэхдээ цаг дулаан хоол элбэгтээ байхад учир бий.энэ жил тэжээл горьдох тэмээ олон л болох байх даа. Тэгэхдээ муудах төлөвтэйг нь онож олоод эртнээс тэжээж чадвал тэжээл ч бага ордог тэмээч хүчээ барьдаг сайн юм шиг байдаг. Хэдэн тормоо үсэнд нь: жавар орохоос өмнө нэмнэж өгөх л зүгээр дээ. Торомны

нэмнээг заавал шинэ эдээр зузаан хийх шаардлаггүй. Үсийг нь хагалахгүй дан даавуугаар хийсэнч тором даардаггүй юм. Одоогоор манай нөхөр аймгийн төв яваад эзгүй байна гэхдээ бид хэд /хүүхдүүдтэйгээ/ тэмээгээ нутаг руу нь гүйлгэчихгүйг л бодож байна. Дулаан болоод тэрүү зарим тэмээ ханиаж магадгүй байх юм. Энэ л мал муудуулж ажил удаж мэднэ гэж ажил амьдарлаа ярьж байлаа. Тэмээчин залуу Дэмбэрэлийн ус нь дэргэдээ бэлчээр нь ойрхон мал нь тогтвортой байгааг харахад тохитой өвөлжих суурийнх мөн байлаа. Аяны бид алсын замаа үргэлжлүүлэхээр тэднийхээс гарахад гадуур байдаг цөөн ямаа нь “очиж чадалгүй гадуур хоносныг бүү зэмлээрэй Бидний хойноос санаа зоволтгүй тухтай дулаан амарч хоолоо” гэсэн шиг өглөөний нар туссан Хайрхан уулын оройгоос бараа өгч харагдав.

166. Залуустаа захиж хэлэхэд // Говийн мэдээ.-
1986 оны 3-р сарын 10.- №20.- 3-р нүүр.

Залуустаа захиж хэлэхэд

Ямааны дөрвөн төрлийн зүй бус хорогдлын үндсэн шалтгаан юунд байна гэж та боддог вэ? Өвөл хаврын улиралд байнгын усалгаа дутдаг, даарахаас үргэлж сэргийлж хужир үргэлж идүүлэхгүй байгаа бэлчээрт байх хугацааг уртасгахгүйгээс өдрийн идэх хоолоо бүрэн авч чадахгүй байгаа явдал юм. Энэ хэдэн шалтгаан нь: зөвхөн малчны хариуцлагаас болж байна Харин удирдлагын зүгээс нэг малчны хариуцах мал хэтэрхий олон байгааг анхаарах хэрэгтэй. Хорогдлыг багасгаж зогсоход юуг анхаарах хэрэгтэй вэ? Юуны урьд ямааны хорогдлыг багасгах тухай аймгийн намын

хороо захиргааны тогтоол нь: малчны санал бодлыг тусгасан учраасэнэ ажлын үндсэн удирдамж боллоо гэж үзэж байна. Нэг настай малын үзэж дасаагүй байгаа бэрхшээлийг малчин хүн л шургуу хөдөлмөрөөрөө арилгаж чадна. Үүнд малчны хариуцлага онц чухал. Өвөл бараг бүх малчин гэндэхгүй. Харин өвлийн эхэн сар,



хаврийн дунд адаг сард гэндэж салхи шуурга түр зуурын гэнэтийн хүйтрэлтэд нэг хүртэлх насны мал олноор хорогдож байна. Энэ үед ахмад малчдын сургаал халамж удирдлагын

байнгын хяналт шалгалт анхааруулга чухал. Борлонг дулаан хэвтэр нүхэн байр олон тасалгаа бүхий пүнз бэлчээрийн даац багатай манай говьд өвөл хаварт нэг суурьд сэлгэж буух, 2-3 ээлж хороо бууц чухал. Ер нь эцсийн эцэст малчны хариуцлага шиг шийдвэрлэх хариуцлагатай зүйл үгүй. Малчин хичээвэл ямарч эцэнхий төл авлаа өвөл хавар яаж ч бэрхшээл тохиолдлоо гэхэд даваад гарна. Намар ишиг авмагц тойр хоолоо мартан отор шургуу хийсэн сөлийг байгаа газарт нь тасартал идүүлсэн малчин аяндаа өвөл хавар, намарт зарцуулсан хөдөлмөрийнхөө үр шимийг үзэж мал нь онд бүрэн орно шүү. Та залуу малчдад юуг онцлон зөвлөх вэ? – Малчин хүн малаа ерөнхий хүрээгээр нь хараад байхад үр дүн гарахгүй. Мал нэг бүрийг өдөр бүр ажиглаж, аль нь ууж идэхдээ муу байна өвчин эмгэгтэй байж магадгүйг харж ажиглаж сур. Малыг ямарч зорилоггүй дагаад байх биш өдөртөө хэдэн малыг зүслэж ажиглаж муудсаныг тэжээж тэнхрүүлэх тэмдэг тавьж ирж бай.

Яриаг тэмдэглэсэн Д.Хүүхэнгаа

167. Бичигдээгүй номын зохиолч // Говийн мэдээ.- 1986 оны 5-р сарын 12.- №37.- 3-р нүүр.

Бичигдээгүй номын зохиолч

Монгол Алтайн сүрлэг уулс говьд шувтрахдаа Хөрхийн уулаар дуусдаг. Түмэн атираат мянган үрчлээт хад асгат уулын завсараар явсаар нэгэн өвөлжөөнд ирвэл хороо, бууц,пүнз хайс нь: чухам л хүүхдийн төөрдөг байшинг санагдуулна. Энэ олон тасалгаа хашаа пүнзэнд хаа сайгүй л сэргэлэн ишиг язагнаж байна. Гэтэл түүнд нурж унасан шар хог бууцтай зүйл таарсангүй. Энэ ажилсаг айлын эзэн МАХН-ын гишүүн аймгийн хошой сумын 13-н удаагийн аварга Ж.Баточир байлаа. Би хорь гаруй жил ямаа маллахад оносон нь олон байсан. Харин өнгөрсөн онд 30 ишиг хорогдуулж радио дохиогоор шүүмжлүүлээ. Энэ бууцны орчимд бэлчээр тун муу болохоор хойхоно нэг бууцанд ямаа ишиглүүлсэн чинь алдаа болж ямаа хужир говиор дутаад би тэгэж гэндсэн. Энэ жилийн хувьд төл бүрэн эх нь жилбэ төл цатгац сайтай хаврын адаг сар гэхэд зун шиг л байна гэж Ж.Баточир ярина. Бууцны зүүн хадан овоонд ишиг их л тухлаг идээшилж зарим нь нарлаж хэвтэнэ. Энэ өдөр нүцгэн уулын оройд ямар ургамал ургаа юм бол гэж ажиглавал төрөл бүрийн нарийн өвс, бударгана, шарилж, божмог хадны үе дагуулан тавьж саванд гүүний айргаар сүлсэн ус тавьжээ. Ишгээ бууцнаас гаргаад энд өвс усыг тавьж өгдөг юм. Ишгэндээ хээрийн бэлчээрт л байгаа гэсэн үг. Ингэх нь ишиг элдэв хог, ноос, үс, даавуу идэж бөөмтөх, хоолойгоо хагалах гэж байхгүй, бас эрхэлж тонгочин нарлаж унтахад их тохиромжтой Ийм нөхцөлд ишгийг амархан хөрвөжүүлж ус өвсөнд оруулдаг. Манайх жилдээ гүүний айраг 80л бэлтгэж аваад ишгэндээ ус сүлж өгдөг Айрагны цийдэм уусан ишиг сэнсэрч давжаарна гэж байхгүй гэнэ. Эднийх

ямаагаа төллөхөөс 45 хоногийн өмнөөс угтуулан тэжээж ишиг тэжээх айраг сүү бударгана цахилдаг нутгийн бусад ургамал хүрэлцхүйц бэлдэж авсан. Төл нь товиор сайхан цатгац сайтай бойжиж байлаа. Ажилсаг коммунист Ж.Баточир нарийн тооцоотой хүн. Түүний ажлын хөтөлгөөний дэвтэрийг сөхвөл 25 жилд 6000 гаруй ишиг бойжуулжээ. Тэр нь одоогийн тус нэгдлийн ямаан сүргийн 6,1-тэй тэнцэж байна. Ж.Баточир, түүний гэргий Жаргал олон хүүхдийн аав ээж юм. Арван нэгэн хүүхэдтэй энэ айлаас ажил хөдөлмөрт хайнга, сурлага хүмүүжлээр сул, хэрэг зөрчилд орсон доголдолтой хүүхэд байхгүй байгаа нь: хүүхдүүд аав ээжийн ажилсаг төлөв дарууг уламжилсанг гэрчилнэ. Охин Өлзийхорол, Хоролмаа, хүү Отгондүү нар нь ямаачин Б.Өлзийхорол нь аймаг сумын аварга Баточирын хүү Отгондүүд хийж чадахгүй юмгүй шүү гэж бригадын дарга нь ярьж байсныг санаж ээжээс нь асуувал: Миний хүү ч дээлээ хийх ингээ саахаас аваад хөдөөний бүх ажлыг хийнэ. Чухам манай гэрийн хувьд багана маань Энэ жил эр цэргийн албанд мордоно. Ирээд ямаагаа л маллана гэж ярьдаг гэнэ. Амжилт бүтээл арвин, арга туршлага ихтэй, ажилсаг энэ өнөр бүлийнхэн бол “Сангийн далай” нэгдлийн эмгэн булаг бригадын ямаачин Ж.Баточирынх. Ахмад ямаачин Ж.Баточир нас сүүдэр дал шахсан ч нутаг усныхаа залуус үр хүүхэддээ мал маллах талаар “хамгаалаагүй эрдэмийн цол, бичигдээгүй номоо” зааж сургаж үе залгамжилсан ямаачдаа бэлтгэж явна. Аварга малчин Ж.Баточирын арга туршлага, амьдарлын ур ухааныг энэхэн сурвалжлагад багатаахийн аргагүй. Чухам л бичигдээгүй их туршлагын нэгэн зохиолч гэлтэй.

Д.Хүүхэнгаа

168. Отрын аян өгөөжтэй // Говийн мэдээ.
1986 оны 7-р сарын 3.- №51.- 3-р нүүр.

Отрын аян өгөөжтэй

Аман ус, Дөрвөлж, Бумбат, Хашаат, Бударган ус зэрэг ногоо сайтай газраар 600 гаруй хонио оторлон яваа “Гэрэлт зам” нэгдлийн Өгөөмөр бригадын хоньчин ардын хурлын депутат сумын хадлан сааль сүүний аварга Г.Чимэддоржтой уулзлаа. Тэр гучаад жил хонь маллаж сүүлийн цилүүдэд тарга хүчийг нэмэгдүүлэн малын зүй бус хорогдол гаргаагүй 100 эхээс төл бүрэн бойжуулж үйлдвэрлэлийн даалгаварыг 102-127,2% биелүүлж иржээ. Г.Чимэддорж отор нүүдлийг бэлчээр сонгон хэд хэдэн үе шаттай хийж заншжээ. Зуны улиралд нарийн ногоо элбэгтэй ус сайтай нутгаар оторлон хонийг өдөрт хоёроос гурван удаа усалж гишгэлтийг нь тааруулан маш тайвуун тогтоож хариулна. Хонь халуунд хурган зогсох нь их байдаг тул өглөөний бэлчээрлэлтийг аль болох эрт болгож үдийн халуунаас өмнө цатгах хэрэгтэй. Харин үдийн халуунд сэрүүн салхитай дов дэнж газар амраахыг хичээх нь чухал. Нарны илч буурахын хамт дөрөвөөс таван цагт бэлчээж шөнө орой болтол нь идээшлүүлдэг. Хонийг бэлчээрт аль болох тогтоож хариулах нь зүйтэй. Намарт тарга хүчийг нэмэгдүүлэхийн дээр авсан тарга хүчийг тогтооход анхаарна. Харин намар хонийг эрт бэлчээхийг чухалчилахгүй. Хонийг хол тууварлахгүй ойр ойрхон нүүж шинэ бэлчээр сольж байх нь чухал. Намар ногоо хуйраашин шаралдаг тул тогтмол усалж, хужирлаж өдөрт дунджаар 13-15 цаг бэлчээрлүүлэх ёстой гэж малчин Г.Чимэддорж ярьж байна. Малчин бүр тэргүүний малчдын туршлагаас суралцаж, отрын өгөөжийг дээшлүүлж чадвал нэг хүнд ноогдох мах, сүү зэрэг хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нэрийг нэмэгдүүлэх боломжтой байна. Бид ийм нарийн тооцоо, тодорхой зорилттой ажиллаж байж намынхаа их хурлын түүхт шийдвэрийг амьдралд бүтээлчээр хэрэгжүүлж чадна.

169. Отрын өгөөж // Говийн мэдээ.- 1987оны 8-р сарын 24.- №64.- 3-р нүүр.

Отрын өгөөж

Энэ жил манай аймаг нилэнхүйдээ гантай байгаа хэдий ч олон сумын малчид соргог бэлчээр даган өөр сумын нутагт оторлож отор, сааль хоёрыг хослуулан



амжилт арвинтай явна. “Тарган мал тал бүрийн ашигтай” гэж монголчууд ярьдаг. Зуны улиралд малдаа ногоо сайн идүүлбэл оны тарга төдий чинээ сайн авна.

Тарга хүчнээс л бүх зүйл шалтгаална. Хаана ногоо байна тэнд отрийн нутаг байна гэж малчид маань үзэж ногоо даган оторлож явна. “Өгөөмөр нэгдэл энэ жил бүх адуучдаа гуравт, тавтын системд хамруулж төвлөрүүлэн ферм байгуулж ажилласанаар ихэнх адуучид нь: саалийн даалгавараа биелүүлээд байна. Цогтцэций, Ханбогд, Манлай, Ханхонгор сумын нутгаар явж мал сүргээ отроор таргалуулж байгаа олон малчидтай уулзаж, ололт амжилтынх нь талаар фото сурвалжлага хийлээ.

“Сангийн далай нэгдлийн адуучин Н.Жавзан. Б.Сайнгэрэл, Ганбаатар нарынх Ханхонгор сумын нутаг Талын толгойд оторлож явна. /Зураг дээр: Саалийн дараа Аймгийн хоёр удаагийн аварга адуучин А.Сэдваанчиг адуу маллах арга ажиллагаа нь: тогтворжсон нутаг усандаа хүндтэй адуучны нэг юм. Энэ зун А.Сэдваанчиг саалийн ферм байгуулж С.Цэдэнжав. Б.Хорлоо нарын адуучдын хамт арвин сааль сүү сааж байна. Тэд 7000литр айраг бэлтгэхээс 5000 орчим литр

айраг тушаагаад байна. /Зураг дээр А.Сэдваанчиг С.Цэдэнжав нар -- --- Манай 14-н суурийн 900 гаруй мал алсын оторт гарч энэ нутагт найман суурь ирээд ногоо түшиж малаа таргалуулаад байна. Цаашдаа шанхайн хэц давж нутаглах бодолтой. Эхний ээлжинд М.Ценцэнмядаг, М.Содхүү, Ө.Чулуун нарын суурь нүүдэллэн ирж манай нийт малчид отор нүүдэлд хамрагдаж байна гэж хэсгийн дарга Ц.Мижид, дамжин өнгөрүүлэх цэгийн дарга С.Бандиа нар ярьж байв.

“Галбын хөгжил” нэгдлийн Жавхлант хэсгийн дарга Ц.Мижид, МАХН-ын гишүүн хоньчин Ө.Чулууны отрын майханд ирж оторчидтой уулзан санал бодолыг нь авч байхад энэ зургийг авлаа. /Зураг дээр баруун гараас: Ц.Мижид, Ө.Чулуун түүний эхнэр Ц.Банди, ямаачин А.Бодьхүү, Ч.Цогт 3 Говийн хөгжил нэгдлийн адуучин Б.Бүрэнтөгс нар.

Зурагчин Ж.Баярсайхан

170. Тэмээчин баатар // Говийн мэдээ.- 1988 оны 10-р сарын 17.- №79.- 1-р нүүр.

Тэмээчин баатар



“Тэмээтэй холбоогүй юм. Миний говьд байхгүй.

Тэнхлэгт их амьдарлын Хувь заяа ч Энэ Тэмээ гэдэг малтай эгнэгт мөнхийн холбоотой.

Манай нутгийн Гомбосүрэн гуайч Манхан говьдоо

Тэмээгээ өсгөж явсаар Алтан соёмбоор

Энгэрээ мялааж баатар болсоныг

Ард олноороо эрхмэлэн хүндэлж бахархдаг болсоныг

Тэмээний буян гэхээс өөрөөр хэлж би мэдэхгүй.

Хишиг буяны тэнгэр Тэмээнийхээ тухай

Хэлж ярих үгэнд минь ч төгөсгөл гэж байхгүй ээ

Сар хээр хонодог Баян тэнүүн говьдоо.

Сайн тэмээчин явахаас илүү Бахархал бидэнд байхгүй ээ?

Сангийн далай нэгдлийн тэмээчин БНМАУ-ын хөдөлмөрийн баатар

Тэмээчин Х.Гомбосүрэн гуай 32 жил буянт мал сүргээ түшиж аль хэдийн тэтгэвэртээ гарсан ч тэмээний бэлчээрээсээ холдоогүй явна.

Шүлгийг Э.Хархүү

171. Соёл үйлчилгээ малчны суурьд // Говийн мэдээ.- 1989 оны 1-р сарын 19.- №5.- 1-р нүүр.

Соёл үйлчилгээ малчны суурьд

Цогт-Овоо сумын нам, захиргаа, олон нийтийн байгууллага МАХН-ын Төв Хорооны 5-р бүгд хурлын шийдвэрийг хэрэгжүүлж, малчид хөдөлмөрчдөөс судалгаа, санал хүсэлт авсны үндсэн дээр үзэл суртал хүмүүжлийн ажлыг явуулж эхэллээ. Үзэл суртал хүмүүжлийн ажлыг хөдөөгийн өрх суурьд хүргэх нэгдсэн график төлөвлөгөө боловсруулаад ухуулга, урлаг, сурталчилгаа, үйлчилгээний анхны бригадыг Бортээг бригадын малчдын суурьд ажиллуулав. Өнгөрсөн оны шилдэг дууны цоморлигт бичигдсэн сүүлийн үеийн ардын болон зохиолын дуунууд оруулсан концерт тоглосон нь малчдын таашаалыг хүлээв.

Х.Давааням

172. Мянган борлонтынх // Говийн мэдээ.- 1989 оны 1-р сарын 19.- №5.- 2-р нүүр.

Мянган борлонтынх

Баяндалай суманд Агваан нэртэй хүн олон бий. Түүний нэг нь Баян бригадын ямаачин Б.Агваан юм. Эднийх жил жилд доод жингийн ишиг хүлээн авч онд



сайн оруулж туршлагажсан билээ. Тэр сүүлийн жилүүдэд өсвөр насны 874-895, заримдаа мянга дөхсөн мал хариуцан маллаж байна. Малаа цариг тэнхээ тарга хүчийн байдлаар ялган маллаж тэжээж арчилдаг онцлог

аргатай. Нэмэгдэл арчилгаа тордолт шаардлагатай хэсгийг 11-12 дугаар сараас эхлэн ялган гадуур авч ойрын бэлчээрт хариулан таанын уусмалаар усална. Муудаж болзошгүй заримд нь өдөрт таанын зоодойн талыг үмхүүлнэ. Заримдаа будаатай цай чанаж өгдөг. Ийм нарийн арчилгааг ямаачны эхнэр МАХН-ийн гишүүн Ц.Сэржмядаг гардаж хийнэ. Цаг хүндэрч цас ихтэй болсон үед малаа цөөлж хоёр бууцанд байлгах явдал ч таардаг байна. Энэ бол малаа гэсэн малчин хүний сэтгэл зүтгэлийн нэгэн билээ. Жинд хүрээгүй өсөлт багатай болохоороо унд хоол муудахыг андахгүй муудах гээд байдаг юм. Ноднин өвөл хавартаа сүрхий байсан. Өвс хоол муутай бараг цагаан далайд өвөлжсөн. Манай борлон арван сараас хойш хар газар гишгэж үзээгүй байсаар хаваржсан юмдаг. Намар овоо тэнхэрсэндээ тэссэн юм. Өнгөрсөн жилийг бодвол энэ жил дулаан сайхан өвөл болж байна. Нүүрэвчтэй саравчтай, хот хотоороо дулаан болхоор айх юмгүй байна гэж тэд ярив.

173. Тэмээчин // Говийн мэдээ.- 1989 оны 1-р сарын 23.- №6.- 3-р нүүр.

Тэмээчин

Аймгийн нийт малын 16 хувийг тэмээ эзэлдэг боловч мал аж ахуйн нийт бүтээгдэхүүний 34,



нэгдлүүдийн мөнгөн орлогын 33,2 хувийг тэмээний аж ахуйгаас оруулж, тэмээ бүрээс 40 төгрөгийн ашиг олж байна. 1988 онд 100 эхээс 41 ботго бойжуулсан нь урьд оноос хоёроор

нэмэгдэж, тэмээ өсгөх төлөвлөгөө биелүүллээ. Ханхонгор сумын “Гэрэлт зам” нэгдлийн тэмээчин Д.Цэдэв мал маллагааны олон жилийн туршлага эзэмшсэн ахмадуудын нэг юм. Охин Наранчимэг нь ерөнхий боловсролын арван жилийн боловсролыг эчнээгээр эзэмшиж аав ээжийн халамжид нийгмийн тэмээн сүрэг хариуцдаг. Аав охин хоёр нэг зуун дал орчим тэмээ хариуцан тарган тавлаг өвөлжиж байна.

174. Үхэрчин // Говийн мэдээ.- 1989 оны 1-р сарын 26.- №7.- 1-р нүүр.

Үхэрчин

Хөдөлмөр нэгдлийн “Өтгөн бригадын үхэрчин, илгээлтийн эзэн О.Будсүрэн үхрээ 100 хувь хошуувчаар тэжээж тарган тавтай өвөлжиж байна. Эх Жигдэнрашийнхаа малч удмыг залгамжлах охин гэж нутгийнхан нь түүнийг магтана. Цасгүй өнтэй дулаахан өвөл үхэр сүрэгт ус л чухал байдаг. Ер нь үхэр үргэлж л унд үгүйлж байдаг амьтан шүү дээ гэж Будсүрэн ярьж



байлаа. Будсүрэн өнгөрсөн онд саалийн үйлдвэрлэлийн даалгавраа 118 хувь биелүүлсэн амжилтаар сар шинийн баяраа угтаж байна.

175. Адуу ад үзэгдэх мал биш // Говийн мэдээ.- 1989 оны 2-р сарын 16.- № 13.- 2-р нүүр.

Адуу ад үзэгдэх мал биш

Унах морьгүйгээр бэлчээрийн мал аж ахуй эрхлэхийг төсөөлөх аргагүй. Манай улс адуугаараа бахархан, малчин ардууд мориороо таван хошуу адуулж, албан



өртөө ажил үйлсээ залгуулж байсан. Гэтэл сүүлийн жилүүдэд олон суманд адуун сүргийн тоо цөөрч, цаашдаа хэд хүрэх бол гэсэн сэтгэл түгшүүрэлсэн бодол төрүүлэх боллоо. Малчид мал аж ахуйн мэрэгжилтний уялдаа холбоо муу, адуу тэмээндээ тавих анхаарал хангалтгүй нэг

бодлын “гүжир” мал гэж хараанаасаа хөндий байлгаснаас энэ сүргийн бүтэц алдагдхад хүрч, тогтвортой өсөхгүй байна гэж үзэж болох уу? Энэ талаар 1988 оны ажлаар аймагтаа 1-р байр эзэлсэн Цогт-Овоо сумын малын эх эмч Даваажаргалтай санал солилцсон юм. Тэр энэ асуудлаар өөрийн бодлоо хэлэхдээ: Адууг эзнийг нь олж маллуулахгүйгээс алдаж үрэгдүүлэх, хорогдуулах үүд нээгдэж байна. Унаганд нь уяж даагнаас нь эхлэн номхруулаагүйгээс адуу эмнэгшиж, ашиг шим авах, унах эдлэхэд их цаг хүч ордог. Шилдэг удмаасаа

азрага авч тавих, шилж тохируулах сонгож үржүүлэх ажил үндсэндээ мартагджээ. Жилд ганц удаа авдаг хөөврийн адуу нэг бүрээс авахаа больж, хавар нэг хоёр өдөр бөөн хүчээр дайран цөөн тооны даага шүдлэн хяргаж, төлөвлөгөө хаадаг боллоо. Үүнээс болж өсвөр насны мал даарч турдаг, өсөлт нь саатаж мал давжаарах нэг үндэс болж байна. Нэгдэл бүр адууны бүс нутагтай болж, тэнд адуучдынхаа амьдрах аятай нөхцөлийг бүрдүүлж, адууны хашаа хороо барьж, нэг суурьд байх сүргийн тоог цөөрүүлэн, ажиллах хүчнээр хангахад л анхаарч ажилламаар санагдана гэж Даваажав эмч ярьж байна. Үнэхээр л бид хаа хаанаа л адууг гүжир мал хэмээн анхаарлаасаа хөндийрүүлж ад үзэж ирсэний баримт адууны тоо цөөрснийх гэж дүгнэж болхоор. Адуу ад үзэх мал биш ээ Адуу зөвхөн унаж эдэлсний ашгийг тооцоход л үзэмж их. Ачилга уналгад өргөн ашиглахаас гадна дэл, сүүл, хөөвөр, айраг, мах нь үнэт бүтээгдэхүүн болдог. Гэтэл хурдан хөнгөнийг нь бодож “машинсах” сэтгэлгээндээ хэт хөтлөгдөн унах унаагаа мартдаг нь дэндүү харалган бус уу?

Б.Оуюнцэцэг

176. Тэмээчин // Говийн мэдээ.- 1989 оны 2-р сарын 23.- №15.- 3-р нүүр.

Тэмээчин



Гуч гаруй жил тэмээ маллаж байгаа Т.Туулайхүү гуай энэ жил 60 шүүрч яваа гэхэд тэнхлүүн ажээ. Эднийх 340 гаруй тэмээ маллаж “Сайрын бууц” гэдэг газар тохилог сайхан

Говийн мэдээ сонин

хаваржиж байна. “Жаргалант” нэгдлийн замын шанд бригадын тэмээчин Т.Туулайхүү хөдөлмөрч хичээнгүй ажиллагаагаараа өнгөрсөн онд БНМАУ-ын энх сүрэгтэн улсын аварга цол хүртсэн билээ.

177. Залуу малчин // Говийн мэдээ.- 1989 оны 4-р сарын 20.- №31.- 3-р нүүр.

Залуу малчин

Гэрэлт зам нэгдлийн Жаргалант бригадын малчин У.Батбаясгалан нэгдэлтэйгээ энгийн гэрээ байгуулан 439



эр ямаа хариуцан маллаж онд бүрэн оруулаад, одоо отрын бэлтгэлээ хангаад байна. Тэр 14 настайгаасаа малч удмаа даган өөрийн хүслээр мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж эхэлсэн байна. Арав шахам жил сувай

мал дагнан хариуцаж, тарга хүч сайтай жил дараалан 100 хувь онд оруулж иржээ. Батбаясгалан малыг бэлчээр тохируулан тарга хүч авхуулах, чамбайруулах талаараа ахмад малчдаас дутуугүй ажиллаж, өөрийн гэсэн арга туршлагатай болсон залуу.

Омноговь аймгийн Төв номын сангаас
Ходов аж ахуй, үйлдвэржилтийн
жилд зориулан бүтээв.

ДАЛАНЗАДГАД
2019 он

